



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2025





ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮЗҮҮЛЭЛТ
2025

© 2026 Эрүүл мэндийн хөгжлийн төв

Энэхүү бүтээлийн бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энэхүү хэвлэлийг эх сурвалжийг дурдсан тохиолдолд хэсэгчлэн ашиглахыг зөвшөөрнө.

Энэхүү номонд орсон мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг зөвхөн судалгаа, сургалт, бодлого боловсруулах зорилгоор ашиглана.

Эрхэлсэн: М.Одгэрэл, ЭМХТ-ийн захирал
Хянасан: Г.Дамба, ИӨСА-ны дарга
Эмхэтгэсэн: С.Даваажаргал, ИӨСА-ны ахлах мэргэжилтэн
Ч.Мичидмаа, ИӨСА-ны ахлах мэргэжилтэн
Д.Сумъяа, ИӨСА-ны мэргэжилтэн
Г.Ган-Эрдэнэ, ИӨСА-ны мэргэжилтэн
Х.Дэлгэрмаа, ИӨСА-ны мэргэжилтэн
Ж.Ундрал, ИӨСА-ны мэргэжилтэн
Ч.Батчингис, ИӨСА-ны мэргэжилтэн
Б.Үүрцайх, ИӨСА-ны мэргэжилтэн
Б.Солонго, ИӨСА-ны мэргэжилтэн
Д.Уранчимэг, ИӨСА-ны мэргэжилтэн
Б.Алтантулга, ЭШСҮАЗА-ны дарга
И.Ариунаа, УХТЭ, АЗО-ны ахлах мэргэжилтэн
Б.Түмэн-Өлзий, ГССҮТ, СТСА-ны дарга
Б.Баянзул, ГССҮТ, СТСА-ны Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн
Т.Ундармаа, ХСҮТ, СТСА-ны дарга
Л.Өнөрбаяр, ЦССҮТ, эдийн засагч, статистикч
С.Нэргүй, ЭСҮТ, Эс судлаач

Хэвлэсэн: Эрүүл мэндийн хөгжлийн төв

Энэхүү эмхэтгэлийн талаарх саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж
Улаанбаатар-210648
Факс: 976-11-320633
Утас: 70111485
Э-шуудан: admin@hdc.gov.mn
www.hdc.gov.mn

Улаанбаатар хот
2026 он



ГАРЧИГ

Зургийн жагсаалт	7
Хүснэгтийн жагсаалт	15
Товчилсон үгийн тайлбар	18
Өмнөх үг	19
БҮЛЭГ 1. ХҮН АМ	
1.1. Хүн амын тоо, өсөлт	24
1.2. Хүн амын нас, хүйсийн бүтэц	24
1.3. Хүн ам зүйн ачаалал	25
1.4. Хүн амын нягтрал	27
1.5. Хүн амын дундаж наслалт	28
БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ	32
2.1 Бодлогын баримт бичгүүд	32
2.2 Тогтвортой хөгжлийн зорилтын гүйцэтгэлийн индекс	33
2.3 Эх, хүүхдийн эрүүл мэнд	35
2.3.1 Эхийн эндэгдлийн харьцаа (ТХЗ 3.1.1)	35
2.3.2 Эмнэлгийн ажилтан эх барьсан төрөлт (ТХЗ 3.1.2)	37
2.3.3 Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (ТХЗ 3.7.2)	38
2.3.4 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (ТХЗ 3.2.1)	39
2.3.5 Нярайн эндэгдэл (ТХЗ 3.2.2)	42
2.4 Халдварт өвчин	44
2.4.1 ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүнд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо тхз 3.3.1	44
2.4.2 Сүрьеэгийн өвчлөлийн тохиолдол (тхз 3.3.2)	46
2.5 Халдварт бус өвчин	49
2.5.1 30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал (тхз 3.4.1)	49
2.5.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (тхз 3.4.2)	51
2.5.3 Зам тээврийн ослын шалтгаант нас баралт (тхз 3.6.1)	52
2.6 Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт	54
2.6.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь (тхз-ын 3.8.1)	54
2.7 Орчны эрүүл мэндтэй холбоотой тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүд	56
2.7.1 Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин (тхз-ын 3.9.1)	57
2.8 Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин (тхз-ын 3.9.2)	59
2.8.1 Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үнэлгээ	60
2.9 Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (ТХЗ-ын 3.9.3)	64

БҮЛЭГ 3. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД	68
3.1 Эхийн эрүүл мэнд	68
3.1.1 Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	68
3.1.2 Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	69
3.1.3 Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн хүндрэл	72
3.1.4 Эхийн эндэгдэл	74
3.2 Хүүхдийн эрүүл мэнд	76
3.2.1 Төрөлт	76
3.2.2 Хүүхдийн өвчлөл	77
3.2.3 Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	79
3.3 Үр хөндөлт	80
3.4 Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгсэл (жсах)	81
БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	86
4.1 Эрүүл мэндийн байгууллага	86
4.2 Эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний орны хүртээмж	87
4.3 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ	90
4.4 Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	93
4.5 Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ	97
4.6 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээ	103
4.7 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн тусламж, үйлчилгээ	107
4.8 Хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	110
БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ	116
5.1 Эрүүл мэндийн байгууллагын нийт ажиллагчид	116
5.2 Эрүүл мэндийн ажиллагчид байршлаар	117
5.3 Эрүүл мэндийн ажиллагчдын шилжилт хөдөлгөөн	119
5.4 Их эмч	119
5.5 Сувилагч, эх баригч	123
5.6 Их эмч, сувилагчийн харьцаа	125
БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН	134
6.1 Бодлогын баримт бичиг	134
6.2 Халдварт өвчин	134
6.3 Амьсгалын замын халдварт өвчин	139
6.3.1 Салхин цэцэг	141
6.3.2 Улаанбурхан	142
6.3.3 Менингококкт халвар	143
6.3.4 Сүрьеэ	143
6.3.4 Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл	145



6.4	Гэдэсний халдварт өвчин	145
6.4.1	Цусан суулга өвчин	146
6.4.2	Гепатит вирус	147
6.5	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	148
6.5.1	Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвар	148
6.5.2	хдхв/дох-ын халдвар	150
6.6	Зоонозын халдварт өвчин	151
БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН		156
7.1.	Хүн амын амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	156
7.1.1.	Амьсгалын тогтолцооны өвчин	162
7.1.2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	165
7.1.3	Зүрх судасны тогтолцооны өвчин	167
7.1.4	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	171
7.2	Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	173
7.3	Мэс заслын үйл ажиллагаа	177
7.4	Хорт хавдар	178
7.2.1.	Хорт хавдрын тэргүүлэх шалтгаан	179
7.2.2	Хүүхдийн хорт хавдар	181
7.2.3	Хорт хавдрын хяналт	181
7.5	Осол гэмтэл ба зарим гадны шалтгааны үр дагавар	182
7.3.1.	Уналтын шалтгаант осол гэмтлийн шинэ тохиолдол /w00-w19/	189
7.3.2.	Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл /V01-V99/	193
БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ		200
8.1	Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	200
8.1.1	Нас баралтын ерөнхий коэффициентийн өөрчлөлт	200
8.1.2	Нас баралтын насны бүтэц, хүйсээр	202
8.2	Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	203
8.3	Зайлсхийж болох нас баралт	205
8.4	Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	205
8.5	Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан зүрх судасны өвчний шалтгаант нас баралт	209
8.6	Хорт хавдрын шалтгаант нас баралт	211
8.7	Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт	212
8.7.1	Зам тээврийн ослын шалтгаант нас баралт	213
8.7.2	Амиа хорлолт	214
8.7.3	Бусад ослын шалтгаант нас баралт	215
8.8	Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	216
8.9	Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	217

БҮЛЭГ 9. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	220
9.1 Цусны донор элсүүлэлт, урамшуулал, алдаршуулалт	222
9.2 Цус сэлбэлт судлалын салбарын лабораторийн тусламж үйлчилгээ	226
9.3 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ	226
9.4 Цусны салбар төвүүдийн үйл ажиллагаа	229
БҮЛЭГ 10. ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	232
10.1 Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа	232
10.2 Тархины үхэлтэй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа	233
10.3. Тархины үхэлтэй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалт	236
10.4 Гадаад улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа	237
10.5 Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эмнэлгийн мэргэжилтний сургалт	238
БҮЛЭГ 11. ДУУДЛАГА ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГ ТОВЛОЛЫН “1800-0119” ТУСГАЙ ДУГААРЫН ДУУДЛАГЫН УТАСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	240
11.1 Нийт хүлээн авсан дуудлагын бүтэц	241
11.1 Эмчийн үзлэгийн цаг товлосон дуудлагын бүтэц	242
БҮЛЭГ 12. ЭМГЭГ СУДЛАЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ	246
12.1 Амьд сорьцын шинжилгээний үзүүлэлт	246
12.1.1 Амьд сорьцын шинжилгээгээр хорт хавдар оношлогдсон тохиолдол	247
12.1.2 Амьд сорьцын шинжилгээгээр хоргүй хавдар оношлогдсон тохиолдол	247
12.2 Эсийн эмгэг судлалын шинжилгээний үзүүлэлт	248
12.3 Эмгэг судлалын задлан шинжилгээний үзүүлэлт	249
12.4 Үндсэн оношийн зөрүү	250
БҮЛЭГ 13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СҮҮЛИЙН 10 ЖИЛЭЭР	251-262
БҮЛЭГ 14. ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД	264-298



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.	Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, сонгосон онуудаар	23
Зураг 1.2.	Хүн амын нас хүйсийн суварга, 2000, 2025 он	25
Зураг 1.3.	Хүн амын насны бүтэц, сонгосон оноор	26
Зураг 1.4.	Хүн ам зүйн ачаалал, сонгосон оноор	26
Зураг 1.5.	Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2025 он	27
Зураг 1.6.	Хүн амын дундаж наслалт, 2016-2025 он	29
Зураг 2.1.	Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн индекс, 2025 он	33
Зураг 2.2.	Төрөлтөөс тооцсон хүн амын дундаж наслалт, дэлхийн дундаж, бүс нутгийн дундажтай харьцуулахад, 2021 он	35
Зураг 2.3.	Дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар	35
Зураг 2.4.	ТХЗ 3.1.1 Эхийн эндэгдлийн харьцаа, 100 000 амьд төрөлтөд	36
Зураг 2.5.	Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, ДЭМБ-ын тооцооллоор, 2023 он	36
Зураг 2.6.	ТХЗ: 3.1.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	37
Зураг 2.7.	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, 15-19 насны 1000 охидод	38
Зураг 2.8.	ТХЗ 3.7.2 Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад	38
Зураг 2.9.	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, 15-19 насны 1000 охидод, 2016-2025 он	39
Зураг 2.10.	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, аймгаар, 2025 он	39
Зураг 2.11.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад	40
Зураг 2.12.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад, 1000 амьд төрөлтөд (ТХЗ: 3.2.1)	40
Зураг 2.13.	Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2016-2025 он	41
Зураг 2.14.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2016-2025 он	42
Зураг 2.15.	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилийн дундаж, аймгаар	42
Зураг 2.16.	Нярайн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд	43
Зураг 2.17.	ТХЗ: 3.2.2 Нярайн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад	43
Зураг 2.18.	Нярайн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилийн дундаж, аймгаар	44
Зураг 2.19.	ТХЗ 3.3.1 ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүнд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо	45
Зураг 2.20.	ХДХВ-ийн шинэ тохиолдол, нас баралтын тоо, бүртгэгдсэн оноор	46
Зураг 2.21.	Бүртгэгдсэн ХДХВ-ийн шинэ тохиолдол, хүйс, насны бүлгээр	46
Зураг 2.22.	ТХЗ 3.3.2 Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин /100 000 хүнд/	47
Зураг 2.23.	Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин, 100 000 хүнд, 2016-2025 он	48
Зураг 2.24.	Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин, 100 000 хүнд, сүүлийн 10 жилийн дунджаар	48
Зураг 2.25.	ТХЗ 3.4.1 30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал, 2021 он	49

Зураг 2.26.	30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, тухайн насны 10 000 хүнд, 2016-2025 он	50
Зураг 2.27.	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)	51
Зураг 2.28.	ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)	52
Зураг 2.29.	ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо), 2016-2025 он	52
Зураг 2.30.	ТХЗ 3.6.1 Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)	53
Зураг 2.31.	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	53
Зураг 2.32.	ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	54
Зураг 2.33.	ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	55
Зураг 2.34.	ТХЗ 3.9.1 Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин	56
Зураг 2.35.	Баталгаагүй үндны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин, 100 000 хүнд, ДЭМБ-ын тооцооллоор	59
Зураг 2.36.	Баталгаагүй үндны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин, 100 000 хүнд	59
Зураг 2.37.	Монгол болон Зүүн өмнөд Азийн зарим орнуудын эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшин	63
Зураг 2.38.	Санамсаргүй хордох, хордлогын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд харьцуулахад	64
Зураг 3.1.	Цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь, 2025 он	68
Зураг 3.2.	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2025 он	69
Зураг 3.3.	1000 хүнд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2025 он	70
Зураг 3.4.	Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2025 он	70
Зураг 3.5.	Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр, 2025 он	71
Зураг 3.6.	Улаанбаатар хотод орон нутгаас ирж амаржсан эхчүүд, бодит тоо, 2025 он	71
Зураг 3.7.	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2025 он	72
Зураг 3.8.	Төрөлт, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2025 он	72
Зураг 3.9.	Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, байршлаар, хувь, 2025 он	73
Зураг 3.10.	Жирэмсний хүндрэлд манас таталт ба манас таталтын урьдлын эзлэх хувь, аймгаар 2025 он	73
Зураг 3.11.	Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар, 2025 он	74
Зураг 3.12.	Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, аймгаар, 2025 он	74
Зураг 3.13.	Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2025 он	75
Зураг 3.14.	Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2025 он	76
Зураг 3.15.	Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд, аймгаар, 2025 он	77
Зураг 3.16.	Нярай хүүхдийн өвчлөл амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, аймгаар, 2025 он	77



Зураг 4.1.	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор ашиглалтын хувь, тасгаар, 2025 он	89
Зураг 4.2.	Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн тоо, 2016-2025 он	91
Зураг 4.3.	Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчийн тоо, 2016-2025 он	91
Зураг 4.4.	Өрхийн хүн амын эрүүл мэндийн байдал, хувиар, 2025 он	91
Зураг 4.5.	Өрхийн эрүүл мэндийн төвийн жирэмсний эрт хяналтын хувь, 2016-2025 он	93
Зураг 4.6.	Хүн амын эрүүл мэндийн байдал, 2025 он	94
Зураг 4.7.	Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он	94
Зураг 4.8.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он	95
Зураг 4.9.	Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он	96
Зураг 4.10.	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн их эмчийн тоо, 2016-2025 он	98
Зураг 4.11.	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сувилагчийн тоо, 2016-2025 он	98
Зураг 4.12.	Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо, 2016-2025 он	99
Зураг 4.13.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2016-2025 он	99
Зураг 4.14.	Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он	100
Зураг 4.15.	Аймгийн нэгдсэн эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он	101
Зураг 4.16.	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн орны ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он	101
Зураг 4.17.	Хоног болоогүй нас баралтын хувь, 2016-2025 он	102
Зураг 4.18.	Аймгийн нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралт, шалтгаан, хувиар, 2025 он	102
Зураг 4.19.	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралт, шалтгаан, хувиар, 2025 он	103
Зураг 4.20.	БОЭТ-ийн хүний нөөцийн үзүүлэлт, 2016-2025 он	103
Зураг 4.21.	БОЭТ-ийн их эмч мэргэшлийн төрөл, хувиар, 2025 он	103
Зураг 4.22.	БОЭТ-ийн сувилагч мэргэшлийн төрөл, хувиар, 2025 он	104
Зураг 4.23.	БОЭТ-д хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, дундаж ор хоног, тасгаар, 2025 он	105
Зураг 4.24.	Аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он	107
Зураг 4.25.	Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он	107
Зураг 4.26.	Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн их эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он	107
Зураг 4.27.	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн дундаж ор хоног, 2016-2025 он	108
Зураг 4.28.	Хоног болоогүй нас баралтын хувь, 2016-2025 он	109
Зураг 4.29.	Амбулаторид үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүнээр 2016-2025 он	109
Зураг 4.30.	Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2016-2025 он	112
Зураг 5.1.	Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд ногдох, 2016-2025 он	116
Зураг 5.2.	Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлгээр, хүйсээр, 2025 он	116
Зураг 5.3.	Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлэгт эзлэх хувь, мэргэжлийн төрлөөр, 2025 он	117
Зураг 5.4.	Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд, бүсээр, 2025 он	118
Зураг 5.5.	Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд, аймгаар, 2025 он	118
Зураг 5.6.	Эрүүл мэндийн ажиллагчид, эмнэлгийн төрлөөр, 2025 он	119

Зураг 5.7.	10 000 хүнд ногдох их эмчийн тоо, ДЭМБ тооцооллоор	120
Зураг 5.8	10 000 хүнд ногдох их эмчийн тоо, дэлхийн дундаж болон бүсийн улс орнуудтай харьцуулахад, ДЭМБ тооцооллоор	120
Зураг 5.9	Их эмч, насны бүлэгт эзлэх хувь, хүйсээр, 2025 он	121
Зураг 5.10.	10 000 хүнд ногдох их эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он	121
Зураг 5.11.	10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, сонгосон онуудаар	121
Зураг 5.12.	10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, сонгосон онуудаар	122
Зураг 5.13.	10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2025 он	122
Зураг 5.14.	10 000 хүнд ногдох их эмч, бүс нутгаар, сүүлийн 5 жилээр	123
Зураг 5.15.	10 000 хүнд ногдох сувилагч/эх баригчийн тоо, ДЭМБ-ын тооцооллоор	123
Зураг 5.16.	10 000 хүнд ногдох сувилагч/эх баригчийн тоо, дэлхийн дундаж болон бүсийн улс орнуудтай харьцуулахад, ДЭМБ тооцооллоор	124
Зураг 5.17.	10 000 хүнд ногдох сувилагч, бүс нутгаар, сүүлийн 5 жилээр	124
Зураг 5.18.	Эх баригчийн тоо, 10 000 хүнд, 2016-2025 он	125
Зураг 5.19.	Эмч, сувилагчийн харьцаа, Ази-Номхон далайн бүсийн орнуудаар харьцуулснаар	125
Зураг 5.20.	Эмч, сувилагчийн харьцаа, бүс нутгаар, 2025 он	126
Зураг 6.1	Халдварт өвчний бүтэц (хувиар), төрлөөр, 2025 он	134
Зураг 6.2.	Тэргүүлэх халдварт өвчнүүдийн бүтэц, 2025 он	135
Зураг 6.3.	Халдварт өвчний тохиолдол насны ангилал, хүйсээр (хувиар), 2025 он	136
Зураг 6.3.	Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), 2016-2025 он	115
Зураг 6.4.	Тэргүүлэх халдварт өвчний тохиолдол, нас баралтын эрэмбэ, өвчний ангилал, аймгаар, 2025 он	137
Зураг 6.5.	Халдварт өвчин, 10 000 хүнд, төрлөөр, 2016-2025 он	139
Зураг 6.6.	Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), 2016-2025 он	139
Зураг 6.7.	Амьсгалын замын халдварт өвчний бүтэц (хувиар), 2025 он	140
Зураг 6.8.	Салхин цэцэг (бодит тоо, 10 000 хүнд), 2016-2025 он	141
Зураг 6.9	Салхинцэцэг өвчин бүртгэгдсэн сараар (бодит тоо), 2025 он	142
Зураг 6.10.	Улаан бурхан (10 000 хүнд), 2016-2025 он	142
Зураг 6.11.	Улаан бурхан өвчин бүртгэгдсэн сараар (бодит тоо), 2025 он	143
Зураг 6.12.	Менингококкт халдварын түвшин (10 000 хүнд), 2016-2025 он	143
Зураг 6.13.	Сүрьеэ өвчний түвшин (10 000 хүнд), 2016-2025 он	144
Зураг 6.14.	Гэдэсний халдварт өвчний тохиолдол, 10 000 хүнд), 2016-2025 он	145
Зураг 6.15.	Цусан суулга халдварын тохиолдол, 10 000 хүнд, 2016-2025 он	146
Зураг 6.16.	Цусан суулга халдварын тохиолдол (бодит тоо), сараар, 2025 он	147
Зураг 6.17.	Гепатит вирусийн бүртгэгдсэн тохиолдол, төрлөөр, 2016-2025 он	147
Зураг 6.18.	Гепатит вирусийн бүтэц (хувиар), 2025 он	148
Зураг 6.19.	Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол (10 000 хүнд), 2016-2025 он	149
Зураг 6.20.	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин (10 000 хүнд), төрлөөр, 2016-2025 он	149
Зураг 6.21.	Нийт халдварт өвчинд бэлгийн замаар дамжих халдварын эзлэх хувь, 2016-2025 он	150
Зураг 6.22.	Бэлгийн замын халдварт өвчин (хувиар), төрлөөр, 2016-2025 он	150



Зураг 6.23.	ХДХВ/ДОХ-ын халдварын тохиолдол (бодит тоо, 100 000 хүнд), 2016-2025 он	151
Зураг 6.24	Зоонозын халдварт өвчин, 10 000 хүнд, 2016-2025 он	151
Зураг 6.25.	Зоонозын халдварт өвчний бүтэц (хувиар), 2025 он	152
Зураг 7.1.	Хүн амын өвчлөлийн тохиолдол, 1000 хүнд, 10 жилийн дундаж, 2016-2025 он	156
Зураг 7.2.	Амбулаторид бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүнд , хүйсээр, 10 жилийн дундаж, 2016-2025 он	156
Зураг 7.3.	Халдварт бүс өвчний бүтэц (хувиар), 2025 он	157
Зураг 7.4.	Амбулаторид бүртгэгдсэн тэргүүлэх 10 өвчлөл, насны ангилал , хүйсээр (хувиар), 2025 он	158
Зураг 7.5.	Амбулаторид бүртгэгдсэн тэргүүлэх 10 өвчлөл, насны ангилал , хүйсээр (хувиар), 2025 он	159
Зураг 7.6.	Амьсгалын тогтолцооны өвчин, бүсээр, 10000 хүнд ногдох, улсын дундаж, 2016, 2025 он	163
Зураг 7.7.	Амьсгалын тогтолцооны өвчин, насны бүлгээр, тухайн насны 10000 хүнд ногдох, 2016, 2025 он	163
Зураг 7.8.	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, улс, хот, бүсээр, 10 000 хүнд, улсын дундаж, 2016, 2025 он	166
Зураг 7.9.	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, насны бүлгээр, 10 000 хүнд ногдох, 2016, 2025 он	166
Зураг 7.10.	Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтэц, 2025 он	168
Зураг 7.11.	Зүрх судасны өвчлөл, 10000 хүнд ногдохоор, бүсээр, улсын дундаж, 2016, 2025 он	169
Зураг 7.12.	Зүрх судасны тогтолцооны өвчлөл, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2016, 2025 он	170
Зураг 7.13.	Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, бүсээр, улсын дунджаар, 10000 хүнд ногдох, улсын дундаж, 2016, 2025 он	172
Зураг 7.14.	Зүрх, судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, 10 000 хүнд, эзлэх хувь, 2016-2025 он	175
Зураг 7.15.	Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтэц, 2025 он	176
Зураг 7.16.	Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бүртгэгдсэн тархинд цус харвалт (цус алдалттай, (I60-I62), 10 000 хүнд, эзлэх хувь, 2016-2025 он	177
Зураг 7.17.	Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2025 он	179
Зураг 7.18.	Зонхилон тохиолдох 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2025 он	180
Зураг 7.19.	Зонхилон тохиолдох 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2025 он	181
Зураг 7.20.	Хорт хавдрын хяналт, амьдарч буй хугацаагаар, 2025 он	182
Зураг 7.21.	Хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсийн 5 ба түүнээс дээш жил амьдарч байгаа хувь, 2025 он	182

Зураг 7.22. Осол гэмтлийн шинэ тохиолдол, 10 000 хүн амд, 2021-2025 он	182
Зураг 7.23. Осол гэмтлийн шинэ тохиолдол, насны бүлэг, хүйсээр, 2025 он	183
Зураг 7.24. Осол гэмтлийн шинэ тохиолдол, насны бүлгээр, 10 000 хүн амд	184
Зураг 7.25. Осол гэмтлийн шалтгаан, хүйсээр, 2025 он	185
Зураг 7.26. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл бүртгэгдсэн улирал, сараар, хувиар 2025 он	186
Зураг 7.27. Осол гэмтлийн тохиолдлын түвшин, аймгаар, 2025 он	188
Зураг 7.28. Осол гарах үеийн байршил, 2025 он	188
Зураг 7.29. Эмнэлгийн тусламж хэрхэн ирж авсан байдал, 2025 он	189
Зураг 7.30. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, 10 000 хүнд, 2021-2025 он	189
Зураг 7.31. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, хүйсээр, 2025 он	189
Зураг 7.32. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, насны бүлгээр, 10 000 хүнд, 2025 он	190
Зураг 7.33. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, бүртгэгдсэн харьяаллаар, 2025 он	192
Зураг 7.34. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, осол гэмтэлд өртөх үеийн байршил, 2025 он	193
Зураг 7.35. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, 10 000 хүнд, 2021-2025 он	193
Зураг 7.36. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, хүйсээр, 2025 он	193
Зураг 7.37. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, насны бүлгээр 10 000 хүн амд, 2025 он	194
Зураг 7.38. Сүүдлын бүс хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар, 2025 он	194
Зураг 7.39. Хамгаалах малгай хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар, 2025 он	194
Зураг 7.40. Зам тээврийн ослын согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, хувиар, 2025 он	195
Зураг 7.41. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн улирал, хувиар, 2025 он	195
Зураг 7.42. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн сар, хувиар, 2025 он	195
Зураг 7.43. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн гараг, хувиар, 2025 он	196
Зураг 7.44. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, бүртгэгдсэн харьяаллаар, 2025 он	196
Зураг 8.1. Нас баралтын ерөнхий коэффициент, хүйсээр, 2016-2025 он	200
Зураг 8.2. Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, 2025 он	201
Зураг 8.3. Нас баралтын түвшний хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2025 он	201
Зураг 8.4. Насны бүлэг дэх нас баралтын хувь, хүйсээр, 2025 он	202
Зураг 8.5. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2016-2025 он	203
Зураг 8.6. Хүн амын нас баралтын түвшин, 10 000 хүнд, 2025 он	204
Зураг 8.7. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин, нийт нас баралтад эзлэх хувь, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	206
Зураг 8.8. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, бүсээр, 2025 он	206
Зураг 8.9. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, аймгаар, 2025 он	207
Зураг 8.10. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, насны ангиллаар, хувь, 2025 он	207
Зураг 8.11. Зүрхний шигдээсээр нас баралтын түвшин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025Он	208



Зураг 8.12.	30-70 насны хүн амын дундах зүрх судасны өвчин, тухайн насны 10 000 хүн амд, 2016-2025 он	210
Зураг 8.13.	Зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралтын түвшин, 25 ба түүнээс дээш нас, тухайн насны 100 000 хүн амд, 2016-2025 он	210
Зураг 8.14.	Тархинд цус харвалтын шалтгаант нас баралтын түвшин, 25 ба түүнээс дээш нас, тухайн насны 100 000 хүн амд, 2016-2025 он	211
Зураг 8.15.	Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10 000 хүнд амд, хүйсээр, 2016-2025 он	211
Зураг 8.16.	Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, хүйсээр, 2016-2025	212
Зураг 8.17.	Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, 2016-2025 он	212
Зураг 8.18.	Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, 2016-2025 он	213
Зураг 8.19.	Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, 2025 он	214
Зураг 8.20.	Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, шалтгаанаар, хувь, 2016-2025 он	214
Зураг 8.21.	Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, хүйсээр, 2016-2025 он	215
Зураг 8.22.	Архи, спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдол, 10 000 хүн амд, хүйсээр, 2016-2025 он	215
Зураг 8.23.	Нас баралтын бусад ослын шалтгаан, хувь, 2025 он	216
Зураг 8.24.	Хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, хүйсээр, 2016-2025 он	216
Зураг 8.25.	Элэгний циррозын шалтгаант нас баралт, хувь, хүйсээр, 2016-2025 он	217
Зураг 8.26.	Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2016-2025 он	217
Зураг 8.27.	Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2016- 2025 он	218
Зураг 9.1.	1000 хүнд ногдох цус өгөлтийн тоо	220
Зураг 9.2.	Цусны салбар төвүүдийн байршил	221
Зураг 9.3.	Цусны донор алдаршуулалтын төрөл	223
Зураг 9.4.	Донорын төрөл	223
Зураг 9.5.	Цус сэлбэлт судлалын салбарын цус цуглуулалт 2015-2025, 2030 он хүртэлх төлөв	225
Зураг 9.6.	Цус цуглуулалтын хэлбэр, 2015-2025	225
Зураг 9.7.	Цусны доноруудын насны ангилал, 2025 он	225
Зураг 9.8.	ЦСДХ илрүүлэх шинжилгээгээр хасагдалт, 2015-2025	226
Зураг 9.9.	Цус сэлбэлт судлалын салбарын ЦЦБ-ий үйлдвэрлэл 2015-2025, 2030 он хүртэлх төлөв	227
Зураг 9.10.	Цус сэлбэлт судлалын салбарын ЦЦБ-ий хэрэглээ 2015-2025, 2030 он хүртэлх төлөв /нэгжээр/	227
Зураг 9.11.	ЦЦБ-ий хэрэглээ, өвчний төрлөөр, 2025 он	228
Зураг 9.12.	ЦЦБ-ий хэрэглээ, эмнэлгийн төрлөөр, 2025 он	228
Зураг 9.13.	ЦЦБ-ийг хүнгүй агаарын хөлгөөр тээвэрлэсэн нислэгийн тоо, 2025	228

Зураг 9.14. Хүнгүй агаарын хөлгөөр тээвэрлэсэн ЦЦБ-ний тээвэрлэлтийн төрөл, 2025 он	229
Зураг 9.15. ЦСТ-үүдийн бүтэц, зохион байгуулалт	229
Зураг 9.16. ЦСТ-үүдийн нийт цус цуглуулалт, 2015-2025 он	230
Зураг 9.17. ЦСТ-үүдэд үйлдвэрлэсэн ЦЦБ (нэгж), 2015-2025 он	230
Зураг 10.1. Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Тархины үхэл тодорхойлох баг	234
Зураг 10.2. Нийт тархины үхэлтэй донор илрүүлэх үйл ажиллагаа явуулж буй Тархины үхэл тодорхойлох багийн тоо, 2018-2025 он	234
Зураг 10.3. Амьд болон тархины үхэлтэй донороос хийгдсэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо, 2006-2025 он	235
Зураг 10.4. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2025 он	236
Зураг 10.5. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2025 он, хувиар	236
Зураг 10.6. Гадаадад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд орохоор бүртгэн, тодорхойлолт авсан иргэдийн тоо, 2019-2025 он	237
Зураг 10.7. Гадаадад эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд явсан иргэдийн тоо, 2019-2025 он	237
Зураг 11.1. Дүүдлагын чанарын үзүүлэлт, 2025 он	241
Зураг 11.2. Нийт хандсан дүүдлага, 2020-2025 он	241
Зураг 11.3. Нийт үйлчилсэн дүүдлага 2020-2025 он	242
Зураг 11.4. Эмчийн үзлэгийн цаг товллын дүүдлагын бүтэц 2020-2025 он	243
Зураг 11.5. Эмчийн үзлэгийн цаг товлал, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв тус бүрээр, 2020-2025 он	243
Зураг 11.6. Эмчийн үзлэгийн цаг товлал /Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр, 2020-2025 он	243
Зураг 11.7. Эмчийн үзлэгийн цаг товлал, аймгаар, 2021-2025 он	244
Зураг 12.1. Амьд сорьцын шинжилгээ, 2025 он	247
Зураг 12.2. Умайн хүзүүний эсийн эмгэг судлалын шинжилгээ, улсаар 2015-2025 он	248
Зураг 12.4. Эмгэг судлалын задлан шинжилгээ, улсын дүнгээр, 2015-2025 он	249
Зураг 12.5. Үндсэн оношийн зөрөө, зөрөөний хувь, аймгаар, 2025 он	249



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2025 он	28
Хүснэгт 1.2	Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар, 2025 он	30
Хүснэгт 2.1	ТХЗ-ын эрүүл мэндийн үзүүлэлтийн үнэлгээ, чиг хандлага, 2025	34
Хүснэгт 2.2	Эхийн эндэгдлийн түвшин, 100 000 амьд төрөлтөд, сонгомон онуудаар	37
Хүснэгт 2.3	Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, сонгосон онуудаар	41
Хүснэгт 2.4	Нярайн болон перинаталь эндэгдлийн түвшин, 2015-2024 он	44
Хүснэгт 2.5	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 100 000 хүнд, сонгосон онуудаар	47
Хүснэгт 2.6	30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, тухайн насны 10 000 хүнд, 2016-2025 он	50
Хүснэгт 2.7	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүчин чадал, хүртээмжийн үзүүлэлт, сонгосон онуудаар	55
Хүснэгт 2.8	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин, ДЭМБ-ын тооцооллоор	57
Хүснэгт 2.9	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалах нас баралтын түвшин, Эрүүл мэндийн статистикаар	58
Хүснэгт 2.10	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалах өвчлөлийн шалтгаант баралтын түвшин, тухайн насны 100 000 хүнд, 2015-2024 он	58
Хүснэгт 2.11.	Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшингийн ангиллын тодорхойлолт	60-61
Хүснэгт 2.12.	ЭМБ-ын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшин, хувиар, 2023 он	62
Хүснэгт 3.1	Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2025	75
Хүснэгт 3.2	Төрсөн хүүхдийн тоо, бүсээр, 2025 он	76
Хүснэгт 3.3	Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Амбулатор), 2025 он	78
Хүснэгт 3.4	Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Стационар) 2025 он	78
Хүснэгт 3.5	Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, (Амбулатор), 2025 он	79
Хүснэгт 3.6	Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, (Стационар), 2025 он	79
Хүснэгт 3.7	Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувь, 2025 он	80
Хүснэгт 3.8.	Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Стационар) 2025 он	80
Хүснэгт 3.9.	Үр хөндөлт, эмнэлгийн төрлөөр, хувь, 2025 он	81
Хүснэгт 3.10.	ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүд, хувь, байршлаар, 2025 он	81
Хүснэгт 4.1	Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2025 он	86
Хүснэгт 4.2	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эмнэлгийн орны тоо 10 000 хүнд, 2016-2025	87
Хүснэгт 4.3	Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ашиглалтын хувь, аймгаар, 2025 он	87

Хүснэгт 4.4	Эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний орны эзлэх хувь, 2025 он	88
Хүснэгт 4.5	Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног, аймгаар, 2025 он	89
Хүснэгт 4.6	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо, 2016-2025 он	90
Хүснэгт 4.7	Нэг өрхийн эмчид ногдох үзлэг, нэг иргэний үзүүлсэн тоо, 2016-2025	92
Хүснэгт 4.8	Өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн эмчийн үзлэгийн тоо /мян.үзлэг/, 2016-2025 он	92
Хүснэгт 4.9	Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он	95
Хүснэгт 4.10	Сумын эрүүл мэндийн төвийн жирэмсний эрт хяналтын хувь, 2016-2025 он	96
Хүснэгт 4.11	Сумын эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэг, 2016-2025 он	96
Хүснэгт 4.12	Аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он	100
Хүснэгт 4.13	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт	101
Хүснэгт 4.14	БОЭТ-ийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025	105
Хүснэгт 4.15	БОЭТ-ийн хоног болоогүй нас баралтын хувь, дундаж ор хоног, 2016-2025	106
Хүснэгт 4.16	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, (мянга), хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2016-2025	108
Хүснэгт 4.17	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2025 он	110
Хүснэгт 4.18	Хувийн хэвшлийн эмнэлгийн тоо, 2016-2025 он	110
Хүснэгт 4.19	Хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх орны тоо, 2016-2025 он	111
Хүснэгт 4.20	Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2016-2025 он	111
Хүснэгт 4.21	Хувийн эмнэлгийн орны хүчин чадлын үзүүлэлт, 2025 он	112
Хүснэгт 5.1	Их эмч, сувилагчийн харьцаа, бүсээр, 2019-2025 он	127
Хүснэгт 5.2	Их эмч, сувилагчийн харьцаа	128
Хүснэгт 5.3	Их эмч, сувилагчийн хүртээмжийн үзүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр, 2019-2025 он	129
Хүснэгт 6.1	Халдварт өвчин (бодит тоо, хувь, 10 000 хүнд), төрлөөр, 2025 он	138
Хүснэгт 6.2	Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), төрлөөр, 2016-2025 он	140
Хүснэгт 6.3	Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), бүсээр, 2020-2025 он	141
Хүснэгт 6.4	Сүрьеэгийн өвчний түвшин (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он	144
Хүснэгт 6.5	Нийт сүрьеэ (бодит тоо), Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол (бодит тоо, хувиар), 2016-2025 он	145
Хүснэгт 6.6	Гэдэсний халдварт өвчин (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он	146
Хүснэгт 6.7	Бэлгийн замаар дамжих халдвар (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он	149
Хүснэгт 7.1	Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны түвшин ба дундаж, 2016-2025 он	160
Хүснэгт 7.2	Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, байршлаар, дунд эзлэх хувиар, сонгосон онуудаар	160
Хүснэгт 7.3	Хүн амын амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйс, байршлаар, 10 000 хүнд, 2025 он	161



Хүснэгт 7.4	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүнд, байршлаар, 2016-2025 он	162
Хүснэгт 7.5	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	163
Хүснэгт 7.6	Амьсгалын тогтолцооны өвчлөлд эзлэх хувь, хүйсээр, 2016, 2026 он	164
Хүснэгт 7.7	Амьсгалын тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, 2016-2025 он	164
Хүснэгт 7.8	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, байршлаар, 2016-2025 он	165
Хүснэгт 7.9	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	165
Хүснэгт 7.10	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, эзлэх хувь, хүйсээр, 2016, 2025 он	166
Хүснэгт 7.11	Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	167
Хүснэгт 7.12	Зүрх судасны тогтолцооны өвчин, тэргүүлэх шалтгаанаар, 10 000 хүнд, 2016-2025 он	168
Хүснэгт 7.13	Зүрх судасны тогтолцооны өвчлөл, насны ангилалд эзлэх хувь, 2025 он	169
Хүснэгт 7.14	Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшинд, 10 000 хүнд, байршлаар, 2016-2025	169
Хүснэгт 7.15	Зүрх судасны тогтолцооны өвчнүүд, дунд эзлэх хувиар, 2016, 2026 он	170
Хүснэгт 7.16	Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүнд, 2016-2025 он	171
Хүснэгт 7.17	Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он	171
Хүснэгт 7.18	Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, дунд эзлэх хувиар, 2016, 2025 он	172
Хүснэгт 7.19	Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2025 он	173
Хүснэгт 7.20	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүнд, 2016-2025 он	174
Хүснэгт 7.21	Зонхилон тохиолдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц, хувиар, 2016-2025 он	174
Хүснэгт 7.22	Хэвтэн эмчлүүлэгчдэд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчин, тэргүүлэх шалтгаанаар, 10 000 хүнд, 2016-2025 он	176
Хүснэгт 7.23	Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2025 он	177
Хүснэгт 7.24	Зонхилон хийгдсэн мэс засал, төрөл хувиар, 2025 он	178
Хүснэгт 7.25	Зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөл, хүйсээр, 2025 он	179
Хүснэгт 7.26	Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), 2025 он, хувиар	180
Хүснэгт 7.27	Хорт хавдрын хяналт, Эхний 5 байрлалаар, 2025 он	181
Хүснэгт 7.28	Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн, хувиар, 2023-2025 он	183
Хүснэгт 7.29	Осол гэмтлийн шалтгаан, хувиар, 2021-2025 он	184
Хүснэгт 7.30	Гэмтсэн эрхтний байршил, хувиар, 2025 он	185
Хүснэгт 7.31	Осол гэмтлийн шалтгаан, оношоор, 2025 он	186
Хүснэгт 7.32	Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан, аймгаар, 2025 он	187
Хүснэгт 7.33	Уналтын шалтгаант шинэ тохиолдлын тэргүүлэх шалтгаан хувиар, 2025 он	188
Хүснэгт 7.34	Уналтын шалтгаант шинэ тохиолдол, насны бүлэг тэргүүлэх шалтгааны матриц, 2025 он	191
Хүснэгт 7.35	Уналтын шалтгаант шинэ тохиолдол, гэмтлийн байршил, 2025 он	192
Хүснэгт 7.36	Зам тээврийн ослын шинэ тохиолдол, бүртгэгдсэн газар, 2025 он	196
Хүснэгт 8.1	Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүнд, 2025 он	204
Хүснэгт 8.2	Зайлсхийж болох нас баралтын эзлэх хувь, 2025 он	205

Хүснэгт 8.3	Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он	208
Хүснэгт 8.4	Артерийн даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он	209
Хүснэгт 8.5	Зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он	209
Хүснэгт 8.6	Хүн амын нас баралтын хэлбэр, хувиар сонгосон онуудаар	212
Хүснэгт 9.1	Харьцуулсан үзүүлэлт	220
Хүснэгт 10.1	Шилжүүлэн суулгасан бөөр, элэг, ясны чөмгөний үүдэл эсийн мэс засал / хувиар/, 1996-2025 он	233
Хүснэгт 10.2	Тархины үхэлтэй донорын үйл ажиллагааны тоон үзүүлэлт, 2018-2025 он	235
Хүснэгт 10.3	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах чиглэлээр сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо, 2018-2025 он	238
Хүснэгт 11.1	Дуудлагын чанарын үзүүлэлт, 2025 он	240
Хүснэгт 11.2	Дуудлагын бүтцээр, 2020-2025 он	242
Хүснэгт 12.1	Амьд сорьцын шинжилгээгээр зонхилон тохиолдох хорт хавдар оношлогдсон тохиолдол, 2025 он	247
Хүснэгт 12.2	Амьд сорьцын шинжилгээгээр зонхилон тохиолдох хоргүй хавдар оношлогдсон тохиолдол, 2025 он	248

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн Төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн Төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн Төв
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
НБТК	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ТТК	Төрөлтийн тусгай коэффициент
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ХДХВ	Хүний дархлал, хомсдлын вирус
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
ҮОУА	Үйлдлийн олон улсын ангилал
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
БЦЖ	Сүрьеэгийн эсрэг вакцин
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
БНЭМХ	Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт
ТББ	Төрийн бус байгууллага
ЦССҮТ	Цус сэлбэлт судлалын үндэсний Төв
ЦЦБ	Цус, цусан бүтээгдэхүүн



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээнд үндэслэн “Эрүүл мэндийн үзүүлэлт 2025” эмхэтгэлийг эрхлэн боловсруулж, олон улсын аргачлалд нийцүүлэн тооцоо, дүгнэлт хийж мэдээлэл хэрэглэгч танд хүргэж байна. Уг эмхэтгэл нь жил бүр салбарын гол үзүүлэлтүүд, Тогтвортой хөгжлийн зорилт, мөн “Алсын Хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэн танилцуулж, эрүүл мэндийн бодлого боловсруулахад үнэтэй эх сурвалж болдог билээ.

Энэхүү эмхэтгэл нь хүн ам зүй, ТХЗ-ын гүйцэтгэл, эх хүүхдийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүний нөөц, халдварт болон халдварт бус өвчин, нас баралт зэрэг 14 бүлгийн мэдээллийг олон улсын аргачлалд нийцүүлэн нэгтгэн боловсруулсан болно.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 3-р зорилт болох “Эрүүл, аж амьдрал ба сайн сайхан байдлыг хангах”-ын хүрээнд 2030 он хүртэл бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг (УНС) хангах, эхийн болон хүүхдийн эндэгдлийг бууруулах, халдварт болон халдварт бус өвчний эсрэг тэмцлийг эрчимжүүлэх зорилт тавигдаад байна.

ДЭМБ-ын тайланд дурдсанчлан УНС-ийн хамралтын индекс 2000 оны 54-өөс 2023 онд 71 оноонд хүрсэн ч дэлхийн хэмжээнд 4.6 тэрбум хүн бүрэн хамрагдаагүй хэвээр байна. Халдварт бус өвчин дэлхий нийтийн нас баралтын 74 хувийг эзэлж, ТХЗ 3.4.1-ийн шалгуурын дагуу 30–70 насны хүн амын зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчнөөс нас барах магадлалыг бууруулах нь дэлхийн болон манай улсын тэргүүлэх бодлогын чиглэл болжээ.

“Эрүүл мэндийн үзүүлэлт 2025” эмхэтгэлд тусгагдсан тоо баримт нь манай улсын эрүүл мэндийн салбарт гарч буй ахиц дэвшлийг тодоор харуулахын зэрэгцээ шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн асуудлыг нэн тодоор дурдаж байна.

Монгол Улсын хүн ам 2025 онд 3 591 120 болж өссөн бөгөөд дундаж наслалт 72.1 жил-д хүрсэн нь өнгөрсөн арван жилийн хугацаанд 2.5 жилээр уртасч, эрүүл мэндийн тогтолцооны дэвшлийг илтгэж байна. Гэвч эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77.3 жил, эрэгтэйчүүдийнх 68.2 жил байгаа буюу 9.1 жилийн зөрүү хадгалагдаж байгаа нь эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, эрт нас баралтын асуудал, хүйсийн тэгш бус байдлыг шийдвэрлэх цаашдын зорилтыг тодорхойлж байна.

“Алсын хараа–2050” бодлогын хүрээнд нялхсын эндэгдлийн түвшинг 2025 он гэхэд 1000 амьд төрөлтөд 9.0, эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 20.0 болгохоор зорьсон. 2025 оны байдлаар нялхсын эндэгдэл 13.6, эхийн эндэгдэл 31.4 байгаа нь зорилтот түвшинд хүрэхэд үлдсэн хугацаанд оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэнэ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралтын үзүүлэлтүүдээс харвал нэг эмнэлгийн оронд ногдох хүн амын тоо 116, нэг их эмчид ногдох тоо 213 байна. 10,000 хүн тутмын 2,658 хүн давхардсан тоогоор хэвтэн эмчлүүлж, жилд нэг иргэн дунджаар 7.1 удаа амбулаторийн тусламж авсан нь үйлчилгээний эрэлт, хамралт тогтвортой нэмэгдэж буйг харуулж байна.

Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны хувьд статистик мэдээлэл илүү боловсронгуй, хүртээмжтэй, цахим хэлбэрт шилжих үйл явц эрчимтэй өрнөж байна. Эрүүл мэндийн их өгөгдлийг үүсгэх, судалгаа шинжилгээний хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор бүртгэлийн маягт, мэдээллийн журмыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт

бүрэн шилжүүлэх дэд бүтэц болон эрх зүйн орчныг бэхжүүлсэн нь салбарын мэдээллийн тогтолцооны хөгжилд чухал ахиц авчирлаа.

Цаашид их өгөгдлийн технологи болон хиймэл оюун ухааны хэрэгслийг нэвтрүүлэн урьдчилан таамаглах чадавхийг бэхжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Дэлхийн 2030 оны ТХЗ-ын хугацаа улам ойртож буй энэ үед нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, хамтын ажиллагаа улам чухал болж байна. Салбарын бодлого боловсруулагчид, судлаачид, олон улсын байгууллагууд болон иргэний нийгмийн төлөөлөгч та бүхэн энэхүү эмхэтгэлийг ашиглан нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Санал, зөвлөмжөө admin@hdc.gov.mn хаягт ирүүлэхийг урьж, хамтын ажиллагааг өргөжүүлэхийг уриалж байна.

Мэдээлэлд тулгуурлан оновчтой шийдвэр гаргаж буй та бүхэнд талархал илэрхийлж, эрүүл мэндийн салбарын цахим хөгжил, шинэлэг шийдэл бүхий хамтын үйлсэд амжилт хүсье.

ХҮНДЭТГЭСЭН,

ЗАХИРАЛ



М.ОДГЭРЭЛ



БҮЛЭГ 1

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ



Нийт хүн ам
3 сая
591.1
мянга

↑ +1.0%

ӨМНӨХ ОНООС



Монгол улсын хүн ам 2025 онд 3 сая 591.1 мянга болж өсөв.


Хүйсийн бүтэц



Эрэгтэй
1 758.5
мянга



Эмэгтэй
1 832.7
мянга



Хот, хөдөөгийн байршил



Хот суурин газар
71.2%



Хөдөө
28.8%



Төрөлтөөс тооцсон дундаж наслалт



улсын хэмжээнд
72.07
жил



Эмэгтэй
77.34
жил



Эрэгтэй
68.16
жил



Зөрүү
9.2
жил

Эрүүл мэндийн даатгал



3,283,576
даатгалд
хамрагдсан
хүний тоо



93.7%
хамралтын
хувь



2,051,480
эрүүл мэндийн
тусламж үйлчилгээ
авсан хүний тоо

БҮЛЭГ 1. ХҮН АМ


2025 оны байдлаар: Монгол Улсын хүн ам 3 сая 591.1 мянга болж, өмнөх оноос 36.6 мянган хүн (1.0%) нэмэгдсэн. Нийт хүн амын 71.2% нь хот суурин, 28.8% нь хөдөөд амьдарч байна. Улаанбаатар хотод нийт хүн амын 50.0% буюу 1796.0 мянган хүн оршин суудаг. Хүн амын 49.2% эрэгтэй, 50.8% эмэгтэй (100 эмэгтэйд 95 эрэгтэй). 15-аас доош насны хүүхэд 30.6%, 15–64 насны идэр хүн ам 63.7%, 65-аас дээш насны ахмад хүн ам 5.7% эзэлж байна.

1.1. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ

Монгол Улсын хүн ам 1921 оноос хойш тасралтгүй өсч, 2025 онд 3.591.1 мянган хүнд хүрч бараг 5.5 дахин нэмэгдсэн байна. Өсөлтийн хувь нь тухайн үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг тод тусгасан хэд хэдэн онцлог үеийг харуулж байгаа ба 1990-ээд онд өсөлтийн хувь огцом буурсан (~1.0% орчим) зах зээлийн эдийн засагт шилжсэний үеийн нийгэм, эдийн засгийн хүндрэл, төрөлтийн түвшин буурсантай холбоотой. 2000-аад оноос хойш өсөлтийн хувь харьцангуй тогтвортой 1.5–2.0% хэвээр байна

2020–2025 онд хүн амын тоо 3.300 мянгаас 3 591 мянга болж өссөн ч өсөлтийн хувь 1.5–1.8% орчим байгаа нь өмнөх үеийнхтэй харьцуулахад харьцангуй хэвийн түвшинд байна. Гэвч хүн амын нийт тоо нэмэгдсэн хэрнээ өсөлтийн хувь буурч байгаа нь хүн амын насжилт, төрөлтийн бүүралтыг харуулсан үзүүлэлт юм.

Зураг 1.1. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, сонгосон онуудаар



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Өрхийн тоо 2025 оны байдлаар 1011.1 мянга болж, 70.0 хувь нь хот сууринд, 30.0 хувь нь хөдөөд байна. Улаанбаатар хотод 490.5 мянган өрх, хангайн бүсэд 178.6, төвийн бүсэд 158.7, баруун бүсэд 111.4, зүүн бүсэд 71.7 мянган өрх байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.6 хүн ногдож байна.

1.2. ХҮН АМЫН НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Монгол Улсын хүн амын нас, хүйсийн бүтэц сүүлийн 25 жилд эрс өөрчлөгдсөн нь зураг 1.2-оос харагдаж байна. 2000 онд хүн амын суварга нь доод хэсэгт өргөн, дээш явах тусам нарийссан сонгодог гурвалжин хэлбэртэй байсан нь тухайн үед төрөлт өндөр, харьцангуй их нас баралттай нийгмийн бүтцийг харуулж байна. Харин 2025 оны байдлаар суварга нь доод хэсэгт нарийсч, дунд болон дээд хэсэгт тэлсэн "трапец" буюу доргионы хэлбэрт шилжсэн нь хүн амын насжилтын үйл явц эхэлсний илрэл юм.

Хүн амын нас хүйсийн суваргаас харахад 2000–2025 оны хооронд Монгол Улсын хүн




амын нас, хүйсийн бүтэц төрөлтийн түвшний бүүралт болон насжилт нэмэгдэж байгааг тусгасан хэлбэрийн өөрчлөлтийг харуулж байна. Цаашид ахмад насны хүн амын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай бөгөөд энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын асуудалд анхаарал хандуулах шаардлагыг бий болгож байна.

Залуу хүн амын эзлэх хувийн өөрчлөлт: 0–14 насны хүүхдийн тоо 2000 онд харьцангуй өндөр байсан бол 2025 он гэхэд мэдэгдэхүйц буурсан байна. Тухайлбал, 0–4 насны бүлэгт 2000 онд эрэгтэй 116 370, эмэгтэй 113 903 байсан нь 2025 онд эрэгтэй 164 322, эмэгтэй 155 739 болж өссөн хэдий ч нийт хүн амд эзлэх хувиар авч үзвэл залуу насны бүлгийн жин буурсан нь харагдаж байна.

Идэр болон дунд насны хүн амын өсөлт: 2025 оны суваргад 25–54 насны бүлэг хамгийн том хэмжээтэй байгаа нь онцлог юм. Тухайлбал, 35–39 насны бүлэгт эрэгтэй 151 809, эмэгтэй 154 166 хүн байгаа нь суваргын хамгийн өргөн хэсгийг бүрдүүлж байна. Энэ нь 1980-1990-ээд оны харьцангуй төрөлт өндөр байх үеийн хүүхдүүд өнөөдөр идэр насанд хүрсэнтэй холбоотой бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэж байгааг илтгэж байна.

Зураг 1.2. Хүн амын нас хүйсийн суварга, 2000, 2025 он




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Ахмад насны хүн амын өсөлт: Хүн амын насжилтын хандлага тод илэрч байгаа нь 2025 оны суваргын дээд хэсгээс харагдана. 70-аас дээш насны бүлэгт 2000 онд эрэгтэй 20572, эмэгтэй 29005 байсан нь 2025 онд эрэгтэй 39873, эмэгтэй 69706 болж тус тус өссөн байна. Ялангуяа ахмад насны эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад бараг 2 дахин илүү байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Хүйсийн харьцаа: Нас ахих тусам эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэх хандлага тод ажиглагдаж байна. Залуу болон дунд насны бүлгүүдэд эрэгтэй, эмэгтэйн тоо ойролцоо байхад, 55-аас дээш насны бүлгүүдэд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхийг давж гарч байна. Тухайлбал, 65–69 насны бүлэгт эрэгтэй 38390-д эмэгтэй 56821 байгаа нь хүйсийн харьцаа тэгш бус байгааг харуулж байна.

1960 аад оны дунд, сүүл үед 15 хүртэлх насны хүүхэд хүн амын бараг тэн хагасыг эзэлж байсан бөгөөд 1969 онд нийт хүн амын 44.5 хувийг 15 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байсан бол 2025 оны байдлаар 30.6 хувийг эзэлж байна.

Зураг 1.3. Хүн амын насны бүтэц, сонгосон оноор



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

1.3. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны бус (0–14 болон 65+ настай) хүн амын тоог хөдөлмөрийн насны (15–64 настай) хүн амын тоонд харьцуулсан хувь юм. Өөрөөр хэлбэл, **100 хөдөлмөрийн насны хүнд хэдэн хамааралт хүн** ногдож байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Хүн ам зүйн ачааллыг **хүүхдийн ачаалал** (0–14 нас) болон **ахмад насны ачаалал** (65+ нас) гэж хоёр хуваан авч үздэг.


Өөрөөр хэлбэл, 100 хөдөлмөрийн насны хүнд хэдэн "тэжээлгэгч" хүн ногдож байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт өндөр байх тусам нийгмийн нийт ачаалал нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн ам илүү олон хамааралт хүнийг тэжээх шаардлага тулгардаг бол бага байх тусам эдийн засгийн бүтээмж, хуримтлал нэмэгдэх таатай нөхцөл бүрдэнэ.

Хүн ам зүйн ачааллыг хоёр хэсэгт авч үздэг: хүүхдийн ачаалал (0–14 нас) болон ахмад насны ачаалал (65-аас дээш нас). Монгол Улсын хүн ам зүйн ачаалал 1990-ээд оны эхээр хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 85 ногдож байсан бол 2000 оноос буурах хандлагатай харагдаж байна.

Хүн ам зүйн ачаалал 2025 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 59.3 хүн ногдож байна. Хөгшрөлтийн индекс буюу 0-15 насны 100 хүүхдэд ногдох 65 ба түүнээс дээш настай хүний тоо 18.6 байна. (Зураг 1.4)

Монгол Улс 2010 онд хүн ам зүйн ачааллын хамгийн бага цэгт хүрч "хүн ам зүйн алтан үе"-ийг туулсан боловч цаашид ахмад насны хүн амын өсөлттэй холбоотойгоор ачаалал аажмаар нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Зураг 1.4. Хүн ам зүйн ачаалал, сонгосон оноор




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо



1.4. ХҮН АМЫН НЯГТРАЛ

Хүн амын нягтрал нь 1 км² газар нутагт хэдэн хүн ногдож байгааг илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинг харьцуулан үнэлэхэд ашиглагддаг.

Зураг 1.5. Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр, 2025 он



Улаанбаатар хот 1 км²-т 382.1 хүн ногдож байгаа нь улсын дунджаас 166 дахин их байна. Энэ нь Монголын нийт хүн амын 50 гаруй хувь нийслэлд төвлөрч хот, хөдөөгийн хүн амын зохистой хуваарилалт алдагдсаныг тодоор харуулж байна.

Хоёр дахь өндөр нягтрал нь Орхон аймаг 1 км²-т 139.4 хүн ногдож байгаа нь аймгуудын дунд хамгийн өндөр үзүүлэлт юм. Эрдэнэт хот аймгийн нутаг дэвсгэрт багтдаг бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотой хот суурин газрын нягтрал өндөр байгааг илтгэж байна.

Дархан-Уул аймаг 1 км²-т 33.7 хүн ногдож байгаа нь Улаанбаатар, Орхоны дараа гурав дахь өндөр нягтралтай нутаг юм. Баруун болон өмнөд аймгуудын нягтрал туйлын бага байна. Говь-Алтай 0.4, Дундговь 0.6, Өмнөговь 0.5 хүн/км² нягтралтай байгаа нь уудам говийн бүсийн сийрэг суурьшлыг тусгаж байна.

Хүн амын хүйсийн харьцаа Төв (109.8), Өмнөговь (105.3), Дорнод (102.0), Хэнтий (103.3), Булган (103.9), Дундговь (101.8), Дорноговь (110.1), Сэлэнгэ (103.9), Сүхбаатар (102.3), Увс (101.4), Архангай (101.4), Ховд (100.3) аймагт 100 эмэгтэйд 100-аас дээш эрэгтэй ногдож байгаа бол Улаанбаатар хот болон бусад аймгуудад 100 эмэгтэйд 100-аас цөөн эрэгтэй ногдож байна.

Хүснэгт 1.1. Хүн амын тоо, хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр, 2025 он

Аймаг, нийслэл	Монгол улсад оршин суугаа хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Үүнээс:		Хөгшрөлтийн индекс	Хүйсийн харьцаа
			Хүүхэд	Хөгшид		
Улсын дүн	3591120	59.3	49.8	9.5	18.6	96.0
Баруун бүс	426062	59.9	51.6	7.5	16.1	100.5
Баян-Өлгий	119344	66.8	59.3	8.8	12.6	100.4
Говь-Алтай	56831	53.3	44.5	10.0	19.8	101.2
Завхан	71049	53.3	43.3	7.6	23.1	99.4
Увс	85396	59.7	52.1	8.4	14.5	101.4
Ховд	93442	61.8	53.4	9.7	15.6	100.3
Хангайн бүс	607553	56.6	47.0	9.8	20.6	99.0
Архангай	92580	56.3	46.5	8.6	21.0	101.4
Баянхонгор	89339	58.1	49.5	12.1	17.4	97.2
Булган	60630	54.6	42.6	9.7	28.4	103.9
Орхон	111492	58.4	48.7	9.6	20.0	96.3
Өвөрхангай	115634	56.5	46.8	9.2	20.6	98.9
Хөвсгөл	137878	55.6	46.4	9.9	19.9	98.7
Төвийн бүс	529919	56.7	46.9	8.4	21.1	103.9
Говьсүмбэр	18758	62.1	53.7	10.6	15.6	100.3
Дархан-Уул	111244	60.4	49.8	7.9	21.3	95.6
Дорноговь	72515	52.5	44.6	11.6	17.8	110.1
Дундговь	46577	57.0	45.4	7.4	25.6	101.8
Өмнөговь	79055	57.7	50.3	10.4	14.7	105.3
Сэлэнгэ	107713	54.7	44.3	11.6	23.4	103.9
Төв	94057	56.5	44.9	9.8	25.9	109.8
Зүүн бүс	231541	59.2	49.3	9.8	19.9	102.6
Дорнод	84991	60.4	50.5	9.2	19.4	102.0
Сүхбаатар	66611	59.1	50.0	10.3	18.3	102.3
Хэнтий	79939	57.9	47.6	9.5	21.8	103.3
Улаанбаатар	1796045	61.0	51.5	9.5	18.4	93.9

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

1.5. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ


Дундаж наслалт нь тухайн жилийн нас баралтын түвшин өөрчлөгдөхгүй хэвээр үргэлжилнэ гэж үзвэл төрсөн хүүхэд дунджаар хэдэн жил амьдрахыг тооцсон үзүүлэлт бөгөөд эрүүл мэндийн тогтолцооны чанар, амьжиргааны түвшний цогц илэрхийлэл болдог.

Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2016 оны 69.6 жил байсан 2025 онд 72.1 жил болж өссөн нь арван жилийн хугацаанд 2.5 жилээр уртассаныг харуулж байна. Арван жилийн дундаж 70.8 жил байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулбал 0.27 жилээр нэмэгдсэн байна.

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2025 онд улсын хэмжээнд 72.1 болсон ба эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77.3, эрэгтэйчүүдийнх 68.2 жил байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 9.1 жил байна.



Зураг 1.6. Хүн амын дундаж наслалт, 2016-2025 он



*2022 оны дундаж наслалтын тооцоололд Үндэсний статистикийн хорооноос өөрчлөлт оруулсан

Эмэгтэй, эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү бүх жилүүдэд тогтвортой хадгалагдаж байна. Тухайлбал 2016 онд зөрүү 9.5 жил, 2025 онд 9.1 жил байгаа нь аажмаар багасч байгааг харуулна. Арван жилийн дундаж харьцуулалтаар эмэгтэйчүүд 1.1 жил, эрэгтэйчүүд 1.3 жилээр наслалт уртассан нь эрэгтэйчүүдийн хувьд арай илүү ахиц гарсан хэдий ч хүйсийн зөрүү хэвээр их байна.

Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 2025 онд 68.2 жил байгаа нь тэтгэврийн насны доод хязгаартай ойрхон буюу нөгөө талаасаа олон эрэгтэй тэтгэврийн насанд хүрэхийн өмнө эсвэл хүрмэгцээ нас барж байгааг илэрхийлж байгаа ба эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусгай бодлого, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шаардаж байна.

Дундаж наслалтын тогтмол өсөлт нь Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцооны дэвшлийг харуулж байгаа ч эрэгтэйчүүдийн наслалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад мэдэгдэхүйц богино хэвээр байгаа нь хүн ам зүй, эрүүл мэндийн бодлогын чухал сорилт хэвээр байна.

Хамгийн өндөр наслалттай аймгууд: Орхон аймаг нийт 73.9 жилийн дундаж наслалттай бөгөөд эмэгтэйчүүдийн наслалт 84.2 жил байгаа нь бүх аймаг, нийслэлийн дундаас хамгийн өндөр үзүүлэлт юм. Баян-Өлгий аймаг нийт 76.7 жилийн наслалттайгаар улсын дунджаас 4.6 жилээр өндөр байна. Харин Дархан-Уул аймаг нийт 68.6 жилийн наслалттайгаар хамгийн бага үзүүлэлттэй байна. Эрэгтэйчүүдийн наслалт 64.2 жил байгаа нь улсын дунджаас 4 жилээр бага бөгөөд бүх аймгуудын дотор хамгийн бага үзүүлэлт юм. Хөвсгөл аймаг нийт 70.3 жилийн наслалттай байгаа нь Хангайн бүсэд хамгийн бага үзүүлэлт юм.

Хүйсийн зөрүү: Хүйсийн зөрүү аймаг бүрт харилцан адилгүй байна. Хамгийн өндөр зөрүүтэй аймгууд нь Сэлэнгэ 11.2 жил, Орхон 11.4 жил, Дорноговь 10.5 жил, Дархан-Уул 10.3 жил, Сүхбаатар 10.4 жил байгаа бол хамгийн бага зөрүүтэй нь Архангай 3.2 жил, Ховд 3.9 жил, Өвөрхангай 4.0 жил байна. Зөрүү их байгаа аймгуудад эрэгтэйчүүдийн эрт нас баралтын асуудалд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Бүс нутгаар харуулбал баруун бүсийн аймгуудын дундаж наслалт харьцангуй өндөр байгаа бол Төвийн бүсэд Дархан-Уул зэрэг хот суурин газрыг хамарсан аймгуудад наслалт харьцангуй бага байгаа нь хотжилтын нөлөө, амьдралын хэв маягийн эрсдэлт хүчин зүйлстэй холбоотой байж болно. Нийслэл Улаанбаатар хотод дундаж наслалт 72.3 жил

байгаа нь улсын дундажтай ойролцоо боловч эрэгтэйчүүдийн наслалт 67.7 жил байгаа нь улсын дундаж болон бусад аймгуудтай харьцуулахад доогуур байна.

Хүснэгт 1.2. Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар, 2025 он

Аймаг, нийслэл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн зөрүү
Бүгд	72.1	68.2	77.3	9.1
Баруун бүс				
Баян-Өлгий	76.7	73.4	79.3	5.8
Говь-Алтай	73.3	68.1	78.0	9.9
Завхан	73.6	71.4	76.0	4.7
Увс	72.0	67.7	74.9	7.3
Ховд	75.9	73.1	77.1	3.9
Хангайн бүс				
Архангай	73.5	71.3	74.5	3.2
Баянхонгор	73.0	69.3	74.9	5.6
Булган	75.6	70.6	77.8	7.1
Орхон	73.9	72.8	84.2	11.4
Өвөрхангай	72.6	70.7	74.8	4.0
Хөвсгөл	70.3	67.1	75.0	7.9
Төвийн бүс				
Говьсүмбэр	74.3	72.3	77.7	5.5
Дархан-Уул	68.6	64.2	74.5	10.3
Дорноговь	73.1	68.6	79.1	10.5
Дундговь	75.9	72.5	81.1	8.5
Өмнөговь	74.2	69.9	79.2	9.3
Сэлэнгэ	71.8	67.0	78.3	11.2
Төв	73.3	71.0	76.1	5.1
Зүүн бүс				
Дорнод	71.4	67.3	76.2	8.8
Сүхбаатар	76.7	71.1	81.5	10.4
Хэнтий	74.8	72.0	77.8	5.8
Улаанбаатар	72.3	67.7	75.6	7.8

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо



БҮЛЭГ 2

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2025 ОН**

БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

2.1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

БҮЛЭГ 2 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

Sustainable Development Goals & Universal Health Coverage

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

1. "Алсын Хараа – 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
УИХ-ын 2020 оны 52-р тогтоол - Зорилт 2.2
2. "Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"
УИХ-ын 2020 оны 23-р тогтоол - Зорилт 2.2
3. "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"
ЗГ-ын 2017 оны 24-р тогтоол
Зорилго: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгах.

2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Газар нутаг: 1,567 мянган км²

Хүн амын нягтрал: 2.3 хүн/км²

Төрөлтийн нийлбэр коэффициент: 2.5

SDG

71.8

жил

Дундаж наслалт

3.1.1

31.4

/ 100k

Эхийн эндэгдлийн харьцаа

3.2.2

8.5

/ 1000

Нярайн эндэгдлийн түвшин

3.2.1

16.9

/ 1000

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

3.1.2

99.9

%

Мэргэжилтний эх барьсан төрөлт

3.7.2

14.9

/ 1000

Өсвөр насны охидын төрөлт



2.2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ИНДЕКС

Нэгдсэн үндэстний байгууллага болон Дэлхийн банкнаас гишүүн орнуудын Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг жил бүр үнэлж, үнэлгээний индексийг тооцон гаргадаг.


2025 онд ТХЗ-ын индекс нь нийт 125 үзүүлэлтийг багтаасан ба үүнээс 98 нь дэлхийн нийтлэг үзүүлэлт байсан. НҮБ-ын гишүүн 193 орноос Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн индексийг 167 улсын гүйцэтгэлийн оноог тооцоолж мэдээлсэн ба Финланд 87.02 оноотойгоор тэргүүлж байгаа бол Швед улс 85.74, Дани 85.26 оноотойгоор удаах байруудад орсон байна.

Дэлхийн дундаж оноо 66.1 байгаа нь хэрэгжилтэд дунд түвшний ахиц гарч байгааг илтгэж буй хэдий ч олон улс оронд ТХЗ-ын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна гэж дүгнэжээ.

Монгол улс ТХЗ-ын гүйцэтгэлийн индекс 66.75 оноотойгоор 100 дугаарт байна.

Уг гүйцэтгэлтийн индекс ТХЗ-ын үзүүлэлт тус бүрийн зорилтыг амжилттай биелүүлсэн, гүйцэтгэл дунд зэрэг ч сайжирч байгаа, хэрэгжилт зогсонги байдалд байгаа, зорилтын хэрэгжилт буурч байгаа, мэдээлэл байхгүй гэж ангилж үздэг бөгөөд Монгол Улсын эрүүл мэндийн зорилтын хэрэгжилтийн гүйцэтгэл дунд зэрэг ч сайжирч байгаа гэсэн үнэлгээтэй байна.

Зураг 2.1. Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн индекс, 2025 он



Эх үүсвэр: www.sdgindex.org

Хүснэгт 2.1. ТХЗ-ын эрүүл мэндийн үзүүлэлтийн үнэлгээ, чиг хандлага, 2025 он

SDG	Тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл	Дэлхийн дундаж	Бүсийн дундаж	ДЭМБ-ын тооцоолол	Хугацаа	Үнэлгээ	Чиг хандлага	Улсын дүн 2025 он
SDG	Хүн амын дундаж наслалт	71.4	77.4	70.1	2021			72.1
3.1.1	Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд)	197	35.4	41	2023			31.4
3.2.2	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	17.3	5.6	7.4	2023			8.5
3.2.1	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	36.7	11	13.6	2023			16.9
3.3.2	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100 000 хүнд ногдох)	134	97	491	2023			61.3
3.3.1	Халдваргүй 1000 хүнд ногдох тухайн жилд ХДХВ-ийн халдвар авсан хүний тоо	0.17	0.07	0.01	2023			0.005
3.4.1	30-70 насны Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал (%)	17.8	15.9	26.3	2021			(тухайн насны 10 000 хүнд) 42.5
3.4.2	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох)	9.2	9.5	18.5	2021			16.3
3.6.1	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүнд ногдох)	15	15.2	12.4	2021			15.6
3.7.2	Өсвөр насны охидын төрөлтийн түвшин (15-19 насны 1000 охидод)	38.3	11.1	21.1	2023			14.9
3.1.2	Эмнэлгийн мэргэжилтний эх барьсан төрөлтийн эзлэх хувь	87	98	99.3	2023			99.9
3.8.1	Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь	71	81	70	2023			-


Эх үүсвэр: www.sdgindex.org

Тайлбар: Чиг хандлагыг дараах байдлаар тодорхойлсон.

	Оноо буурч байгаа, сайжруулах шаардлагатай
	2030 он гэхэд ТХЗ-д хүрэхэд шаардагдах өсөлтийн хурд 50%-иас бага байна.
	Оноо 50%-иас дээш өсөлттэй байгаа хэдий ч 2030 он гэхэд ТХЗ-д хүрэхэд хангалтгүй байна
	2030 он гэхэд ТХЗ-д хүрэхэд хангалттай хүрэх боломжтой



Зураг 2.2. Төрөлтөөс тооцсон хүн амын дундаж наслалт, дэлхийн дундаж, бүс нутгийн дундажтай харьцуулахад, 2021 он



Эх үүсвэр: World Health Statistics 2025


Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2021 оны байдлаар дэлхийн дундаж 5.1 байхад манай улс дэлхийн дунджаас 1.4 дахин өндөр байгаа нь зөрүү хамгийн их орнуудын тоонд орж байна.

Үндэсний статистикийн хорооны тооцоолсноор Монгол хүний эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1965 онд 2.3 байсан бол 2025 онд 9.1 жил болж тухайн хугацаанд 6.8 жилээр нэмэгдсэн байна.

Зураг 2.3. Дундаж наслалт, хүйсээр, сонгосон онуудаар

Хүн амын дундаж наслалт, хүйсээр – сонгосон оноор

Эрэгтэй ← жил → Эмэгтэй · Дундах тоо = хүйсийн зөрүү




Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

2.3. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2.3.1. Эхийн эндэгдлийн харьцаа (ТХЗ 3.1.1)

Тогтвортой хөгжлийн зорилтын 3.1.1-д “2030 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 70 болгох” зорилт тавьсан. Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд тодорхойлсноор 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 2025 онд 20.0, 2030 онд 15.0, 2050 онд 5.0 болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн.


Зураг 2.4. ТХЗ 3.1.1 Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд)



Эх үүсвэр: World Health Statistics 2025: Annex 2-1

ДЭМБ-ын тооцооллоор Монгол улсын эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 41 байгаа нь Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж үзүүлэлтээс 6.0-оор өндөр байна.

Зураг 2.5. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, ДЭМБ-ын тооцооллоор, 2023 он



2025 онд эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдсэн нь 100 000 амьд төрөлтөд харьцуулахад 31.4 болж сүүлийн 10 жилийн дунджаас 5.2-оор бага хэдий ч, өмнөх онтой харьцуулахад 8.9-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтийг өмнөх 10 жилийн дундажтай харьцуулахад 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 14.1-оор буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 2025 онд 20.0 байгаа ба тухайн онд тодорхойлсон зорилтоос 11.4-оор өндөр байна.



Хүснэгт 2.2. Эхийн эндэгдлийн түвшин, 100 000 амьд төрөлтөд, сонгосон онуудаар


Он	Улсын дундаж	Улаанбаатар	Аймгийн дундаж
1975	158.3	175.1	153.0
1980	161.4	83.2	186.4
1985	157.5	97.9	178.3
1990	199	126	230.0
1995	186.7	96	217.0
2000	158.5	171.1	153.4
2005	93.0	73.3	105.7
2010	45.5	46.2	44.9
2015	26.0	28.8	23.0
2016	48.6	41.8	56.0
2017	26.9	31.2	22.3
2018	27.1	29.5	24.4
2019	23.0	24.3	21.6
2020	30.2	27.7	32.9
2021	94.9	118.1	70.9
2022	35.1	28.4	42.8
2023	26.4	37.9	13.3
2024	22.5	22.3	22.8
2025	31.4	33.7	28.6
10 жилийн дундаж	33.6	39.5	36.6

2.3.2. ЭМНЭЛГИЙН АЖИЛТАН ЭХ БАРЬСАН ТӨРӨЛТ (ТХЗ 3.1.2)

Эмнэлгийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн эзлэх хувь 2025 онд 99.9 байгаа ба энэ үзүүлэлт сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой байна. Дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад дээгүүр үзүүлэлттэй байна.

2025 онд төрсөн эхчүүдийн 99.8 хувь нь эмнэлэгт, 0.2 хувь нь гэртээ төрсөн байна. Гэртээ төрсөн 133 тохиолдлын 54 нь эмнэлгийн тусламжгүй буюу эмчлэх, сувилах, эх барих эмнэлгийн зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн төрөх үед байгаагүй бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор буюу 27 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 2.6. ТХЗ: 3.1.2 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь




Эх үүсвэр: World Health Statistics 2025

2.3.3. ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ТҮВШИН (ТХЗ 3.7.2)

Дэлхийн хэмжээнд өсвөр насны охидын төрөлтийн түвшин 2000 онд 64.5 байсан 2024 оны байдлаар 1000 охид тутамд 38.3 байгаа нь дэлхий даяар өсвөр насны жирэмслэлт буурч байгааг харуулж байгаа хэдий ч бүс нутаг тус бүрээр ялгаатай байна. Тухайлбал 2024 онд Африкийн бүсэд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 97.9, харин Европын бүсэд хамгийн бага буюу өсвөр насны 1000 охидод 13.1 төрөлт байна.


Зураг 2.7. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, 15-19 насны 1000 охидод



Эх үүсвэр: World Health Statistics 2024: Annex 2-2

Монгол улсын өсвөр насны охидын төрөлтийн түвшин 2024 оны ДЭМБ-ын статистикаар тухайн насны 1000 охидод харьцуулахад 17.0 байгаа нь дэлхийн дундаж (38.3)-аас 21.3-оор доогуур байгаа хэдий ч Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (11.1)-аас 5.6-оор өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.8. ТХЗ 3.7.2 Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад




Эх үүсвэр: World Health Statistics 2025

Эрүүл мэндийн статистикаар өсвөр насны охидын төрөлтийн түвшин 2025 онд тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 14.9 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 9.9, өмнөх онтой харьцуулахад 0.6-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна. 2016 оны байдлаар




нийт төрсөн эхчүүдийн 5.0 хувийг өсвөр насны охидын төрөлт эзэлж байсан бол 2025 онд 3.8 хувь болж сүүлийн 10 жилийн дунджаас 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2.9. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, 15-19 насны 1000 охидод, 2016-2025 он




Зураг 2.10. Өсвөр насны охидын төрөлтийн түвшин, аймгаар, 2025 он



2.3.4. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ (ТХЗ 3.2.1)


Тогтвортой хөгжлийн зорилтын 3.2-д “2030 он гэхэд нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг зогсоох, бүх улс орнууд нярайн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 12-оос доош, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 25-аас доош” болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Зураг 2.11. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад



ДЭМБ-ын 2023 оны статистикаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 13.6 байгаа нь дэлхийн дундаж (36.7)-аас 23.1-оор бага, номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (11.2)-аас 2.4-оор өндөр байна.

Зураг 2.12. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад, 1000 амьд төрөлтөд (ТХЗ: 3.2.1)



Эх үүсвэр: World Health Statistics 2025

Монгол улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд “1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшинг 2025 онд 9.0, 2030 онд 8.0, 2050 онд 2.3” болгон бууруулах зорилтыг дэвшүүлсэн.



Хүснэгт 2.3. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, сонгосон онуудаар


Үзүүлэлт	1990	2000	2010	2015	2020	2021	2022	2023	2024	2025	2030*
Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/											
Хүйс											
Эрэгтэй	-	-	21.3	17.4	12.6	12.6	14.2	13.1	13.6	14.6	
Эмэгтэй	-	-	17.3	13.0	10.4	10.4	10.5	11.5	10.6	12.6	
Байршил											
Улсын дундаж	63.4	31.23	19.4	15.3	13.7	11.6	12.4	12.3	12.2	13.6	9.0 ^a
УБ хот	70.3	32.8	16.1	14.7	13.2	11.1	12.5	13.7	12.4	14.3	-
Аймгийн дундаж	62.5	30.8	22.1	15.9	14.3	12.0	12.3	10.8	11.9	12.9	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/											
Хүйс											
Эрэгтэй	-	-	26.4	20.7	17.7	15.0	18.1	16.1	16.8	18.1	
Эмэгтэй	-	-	22.7	15.7	14.5	12.7	12.9	13.6	13.4	15.6	
Байршил											
Улсын дундаж	87.5	42.4	24.6	18.3	14.0	13.9	15.5	14.9	15.2	16.9	-
УБ хот	99.9	42.4	20.6	17.3	13.4	13.1	14.9	15.7	14.9	16.9	-
Аймгийн дундаж	94.4	42.5	28.0	19.2	14.6	14.7	16.2	14.1	15.5	16.9	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Эрүүл мэндийн статистикаар 2025 онд нялхсын эндэгдэл 738 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.6 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.5-оор, өмнөх онтой харьцуулахад 1.4-оор тус тус өссөн байна. Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт (13.1)-ийг өмнөх 10 жилийн дундаж (17.1) тай харьцуулахад 4.0-оор буурсан үзүүлэлттэй байна.


Нялхсын эндэгдлийн 62.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.5 байна.

Зураг 2.13. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2016-2025 он




Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 914 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.9 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.8-оор, өмнөх оноос 1.7-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт (16.1)-ийг өмнөх 10 жилийн дундаж (20.8) тай харьцуулахад 4.7-оор буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2.14. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд, хүйсээр, 2016-2025 он



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт (16.1)-ийг аймгаар харьцуулан харуулбал Төв аймагт 24.2 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт буюу улсын дунджаас 8.1, аймгийн дунджаас 7.3-оор тус тус өндөр байна. Мөн Хөвсгөл, Баян-Өлгий, Архангай, Завхан, Увс, Булган, Ховд, Өмнөговь, Говь-Алтай, Хэнтий аймгуудад улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.15. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилийн дундаж, аймгаар




2.3.5. НЯРАЙН ЭНДЭГДЭЛ (ТХЗ 3.2.2)

Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 он гэхэд бүх улс орнууд нярайн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 12-оос доош болгон бууруулах зорилт тавьсан. Нярайн эндэгдлийн түвшин Дэлхийн хэмжээнд 1990 онд 1000 амьд төрөлт тутамд 37 байсан бол 2023 оны байдлаар 17.3 болж 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч бүс нутгийн ялгаа их хэвээр байна.




Зураг 2.16. Нярайн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд



Нярайн эндэгдлийн түвшин 2023 оны ДЭМБ-ын статистикаар 1000 амьд төрөлтөд харьцуулахад 7.4 байгаа нь дэлхийн дундаж (17)-аас 9.0-оор бага, харин номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (6)-аас 2.0-оор өндөр байна.

Зураг 2.17. ТХЗ: 3.2.2 Нярайн эндэгдлийн түвшин, дэлхийн болон бүсийн дундажтай харьцуулахад



Эх үүсвэр: World Health Statistics 2025


Монгол улсын хувьд 2016 онд нярайн эндэгдлийн түвшин 9.2 байсан бол 2025 онд 8.5 болж 0.7-оор бүүрсан байна. Нярайн эндэгдэл дотор эрт нярайн эндэгдлийн эзлэх хувь хамгийн өндөр 68.9 хувийг эзэлж байгаа нь 2016 онтой харьцуулахад 4.3 хувиар бүүрсан байна.

Хүснэгт 2.4. Нярайн болон перинаталь эндэгдлийн түвшин, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нярайн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/										
Аймгийн дундаж	9.1	8.5	8.1	8.3	7.8	8.6	7.7	6.9	7.3	8.1
УБ хот	9.3	8.9	9.2	8.0	8.3	7.9	7.8	8.5	7.6	8.8
Улсын дундаж	9.2	8.7	8.7	8.6	7.3	8.2	7.8	7.7	7.5	8.5
Эрэгтэй	10.5	9.8	9.9	9.4	8.7	8.9	9.3	8.9	8.7	9.4
Эмэгтэй	7.8	7.6	7.3	7.1	6.9	7.5	6.2	6.5	6.1	7.5
Амьгүй төрөлт /1000 нийт төрөлтөд/										
Аймгийн дундаж	5.9	5.5	4.7	4.4	5.3	5.1	4.8	4.4	4.0	4.4
УБ хот	6.5	6.6	6.4	5.9	5.5	5.9	5.7	6.1	5.8	4.8
Улсын дундаж	6.2	6.0	5.6	5.2	5.4	5.5	5.3	5.3	5.0	4.6
Перинаталь эндэгдэл /1000 нийт төрөлтөд/										
Аймгийн дундаж	12.6	11.9	10.8	10.6	10.4	11.3	10.2	8.6	9.0	9.8
УБ хот	13.2	12.9	12.8	11.4	11.6	12.2	11.4	11.9	10.6	11.0
Улсын дундаж	12.9	12.4	11.9	11.0	11.1	11.8	10.8	10.4	9.8	10.5

Нярайн эндэгдлийн сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт (8.5)-ийг аймгаар харьцуулан харуулбал Завхан аймагт 11.1 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт буюу улсын дунджаас 2.7, аймгийн дунджаас 2.9-оор тус тус өндөр байна. Мөн Өмнөговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Увс, Булган, Өвөрхангай, Говь-Алтай аймгуудад улсын дундаас өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.18. Нярайн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилийн дундаж, аймгаар



2.4. ХАЛДВАРТ ӨВЧИН

Халдварт өвчин гэдэг нь өвөрмөц үүсгэгчээр үүсэж, цаашаа халдвар тараадаг, үечилсэн явцтай, өвөрмөц дархлал тогтдог өргөн хүрээний бүлэг өвчин юм. Халдварт өвчнүүдийн гаралтад хотжилт, хүн амын хурдацтай өсөлт, антибиотикийн буруу хэрэглээ, нийгмийн



эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй байх, хүний буруутай үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны тэнцэл алдагдах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлс нөлөөлнө. Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх, бүр мөсөн устгах зэрэгт нянгийн эсрэг эм, вакциныг боловсруулж эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжийг сайжруулах зэргээр томоохон дэвшил гарсан.


2.4.1. ХДХВ-ийн ХАЛДВАРЛААГҮЙ 1000 ХҮНД НОГДОХ ХДХВ-ийн ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТОО (ТХЗ 3.3.1)

Манай улсын хувьд ХДХВ/ДОХ бага тархалттай орны тоонд ордог хэдий ч БЗДХ-ын тархалт өндөр, эрсдэлт бүлэг болон нийт хүн амын дунд бэлгэвчний хэрэглээ бага, ХДХВ-ийн халдвар хамгийн хурдацтай тархаж буй хоёр том гүрний дунд оршдог, хилээр зорчих хөдөлгөөн ихтэй зэрэг шалтгаануудын улмаас ХДХВ-ийн халдвар тархах эрсдэл өндөртэй оронд тооцогддог байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2022 оны тооцооллоор дэлхий даяар 39.0 сая ХДХВ-ийн халдвартай хүн амьдарч байсан бөгөөд үүний дотор 1.5 сая нь 15-аас доош насны хүүхдүүд байна.

ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүнд ногдох өвчлөлийн түшингээр Номхон далайн баруун бүсийн орнуудын дундаж түвшин 0.07 байгаа нь дэлхийн дунджаас 0.1-оор доогуур байгаа бөгөөд Монгол улсын хүн амын халдварлаагүй 1000 хүнд ногдох өвчлөлийн түвшин 0.01 буюу дэлхийн дундажтай харьцуулахад 0.16, бүсийн дунджаас 0.06-оор тус тус бага байна.


Зураг 2.19. ТХЗ 3.3.1 ХДХВ-ийн халдварлаагүй 1000 хүнд ногдох ХДХВ-ийн шинэ тохиолдлын тоо



Эх үүсвэр: World Health Statistics 2025


1992 онд Монгол улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2025 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 427 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 39 тохиолдол нь шинээр бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 427-аас 51 тохиолдол нь нас барсан байна.

Зураг 2.20. ХДХВ-ийн шинэ тохиолдол, нас баралтын тоо, бүртгэгдсэн оноор



Нийт тохиолдлын 85.9% нь (367) эрэгтэйчүүд, 13.8% нь (59) эмэгтэйчүүд, 1 тохиолдол (0.3%) хүйс тодорхойгүй хүн байна. ХДХВ/ДОХ-ийн бүртгэгдсэн нийт тохиолдлууд бэлгийн замаар дамжсан ба цус цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эхээс хүүхдэд цусаар дамжсан халдварын тохиолдол бүртгэгдээгүй байна.

Зураг 2.21. Бүртгэгдсэн ХДХВ-ийн шинэ тохиолдол, хүйс, насны бүлгээр



2.4.2. СҮРЬЕЭГИЙН ӨВЧЛӨЛИЙН ТОХИОЛДОЛ (ТХЗ 3.3.2)


2024 онд дэлхийн хэмжээнд сүрьеэгийн өвчлөл 100 000 хүнд дунджаар 134 шинэ тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх онтой ижил түвшинд байна. Энэхүү үзүүлэлт нь 2015 оноос хойш 8.3%-иар буурсан ч, ДЭМБ-ын “Сүрьеэг устгах стратеги”-ийн 2025 он хүртэлх зорилт болох 50%-ийн бууралтад хүрэхэд хангалтгүй байна.

Монгол улсын хүн амын дундах сүрьеэгийн өвчлөлийн түвшин 2023 оны ДЭМБ-ын тооцооллоор номхон далайн баруун эргийн бүсийн орнуудтай харьцуулахад тархалтын түвшингээр гуравдугаарт орж байгаа ба 100 000 хүнд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин



491 байгаа нь дэлхийн дундаж (134)-аас 357, бүсийн дундаж (97)-аас 394-оор тус тус өндөр байна.

Зураг 2.22. ТХЗ 3.3.2 Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин /100 000 хүнд/



Эх үүсвэр: World Health Statistics 2025


Монгол улс нь сүрьеэгийн халдварын тархалт өндөрт тооцогддог ба сүүлийн 10 жилийн дунджаар 2966 тохиолдол бүртгэгдэж, 2025 оны байдлаар 70.4 хувь нь уушгины сүрьеэ эзэлж байна.

Хүснэгт 2.5. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 100 000 хүнд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2010	2015	2020	2023	2024	2025
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин*									
Улсын дундаж	79.0	125.0	178.0	154.0	144.1	103.5	69.7	65.3	61.3
УБ хот	84.0	155.0	244.0	189.0	183.7	138.8	89.9	78.1	72.8
Аймгийн дундаж	63.0	99.0	123.0	136.0	105.4	73.5	53.4	53.2	50.3
Хүйс									
Эрэгтэй				174.5	160.4	114.0	85.4	77.3	75.8
Эмэгтэй				145.5	128.3	93.4	54.4	53.6	47.1
Сүрьеэгийн нас баралтын түвшин*									
Улсын дундаж	4.8	3.2	4.0	3.3	3.6	3.0	2.7	1.9	2.2
УБ хот	5.4	2.5	3.3	4.4	5.4	4.0	4.0	2.3	3.0
Аймгийн дундаж	3.9	2.0	4.3	2.5	2.0	2.1	1.6	1.5	1.4
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь*									
Улсын дундаж	-	100/80	100/79	100/84.5	100/79.5	100/76.4	100/75.0	100/77.4	100/67.6
УБ хот	-	100/84	100/74	100/81.7	100/74.3	100/67.7	100/69.2	100/74.1	100/64.0
Аймгийн дундаж	-	100/81	100/84	100/87.5	100/87.8	100/87.1	100/83.4	100/86.8	100/72.4


Эрүүл мэндийн статистикаар 2025 онд 100 000 хүнд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшинг тооцоход 61.3 байна. Сүүлийн 10 жилийн дунджаас 100 000 хүн ам тутамд 29.7, өмнөх онтой харьцуулахад 4.0-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2.23. Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин, 100 000 хүнд, 2016-2025 он



Сүрьеэгийн өвчлөлийн түвшин сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт (90.9)-ийг аймгаар харьцуулан харуулбал төвийн болон зүүн бүсийн аймгуудад харьцангуй өндөр бүртгэгдсэн байна. Дархан-Уул аймагт 118.4 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт буюу улсын дунджаас 27.5, аймгийн дунджаас 49.8-оор тус тус өндөр байна. Мөн Улаанбаатар, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Төв, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад улсын дундаас 4.4-26.0-оор өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.24. Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин, 100 000 хүнд, сүүлийн 10 жилийн дунджаар






2.5 ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2.5.1. 30-70 НАСНЫ ХҮН АМЫН ДУНДАХ ЗҮРХ СУДАС, ХАВДАР, ЧИХРИЙН ШИЖИН, АМЬСГАЛЫН ЗАМЫН АРХАГ ӨВЧНӨӨР НАС БАРАХ МАГАДЛАЛ (ТХЗ 3.4.1)

Дэлхий дахинд халдварт бус өвчнүүд нь нийт нас баралтын 74 хувийг эзэлж, жил бүр 41 сая хүний амь насыг авч байна. Эдгээрийн дотор зүрх судасны өвчин (19 сая), хорт хавдар (10 сая), амьсгалын замын архаг өвчин (4 сая), чихрийн шижин (1.6 сая) зэрэг дөрвөн гол өвчин нийт халдварт бус өвчний нас баралтын 80 гаруй хувийг бүрдүүлж байна. Жил бүр 15 сая гаруй хүн 30-69 насандаа нас барж байгаа бөгөөд эдгээрийн 85 хувь нь бага болон дунд орлоготой орнуудад тохиолдож байна. Энэхүү нөхцөл байдал нь дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоонд томоохон сорилт болж, ТХЗ 3.4-ийн зорилтыг биелүүлэхэд онцгой анхаарал шаардлагатайг харуулж байна.

Зураг 2.25. ТХЗ 3.4.1 30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барах магадлал, 2021 он




Эх үүсвэр: World Health Statistics 2024

ДЭМБ-ын тооцооллоор Монгол улсын 30-70 насны хүн амын дундах халдварт бус өвчний дөрвөн гол өвчнөөр нас барах магадлал 26.3 байгаа нь дэлхийн дундаж (17.8)-аас 8.5, бүсийн дундаж (15.9)-аас 10.4-оор тус тус өндөр байна.

Эрүүл мэндийн статистикаар 2025 онд зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барсан 30-70 насны шалтгаант нас баралтын 6608 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 36.9 хувийг эзэлж байна. Эдгээр өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 2025 оны байдлаар тухайн насны 10 000 эрэгтэйд 61.1, эмэгтэйд 25.3 байна.

Зураг 2.26. 30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, тухайн насны 10 000 хүнд, 2016-2025 он



Хүснэгт 2.6. 30-70 насны хүн амын дундах зүрх судас, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин, тухайн насны 10 000 хүнд, 2016-2025 он

Үзүүлэлт	2015	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин (30-70 нас)									
Бүгд	48.3	45.0	45.2	41.2	43.1	42.9	41.8	41.3	42.5
эрэгтэй	64.4	60.9	62.1	57.3	59.6	61.9	59.2	59.7	61.1
эмэгтэй	33.3	30.2	29.5	26.4	27.8	25.4	25.7	24.2	25.3
Зүрх судасны өвчний нас баралт, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад (30-70 нас)									
Бүгд	24.8	22.8	21.1	19.5	21.3	21.4	20.6	20.3	21.1
эрэгтэй	34.9	33.0	31.4	29.3	31.6	32.9	31.1	31.8	32.6
эмэгтэй	15.3	13.4	11.5	10.5	11.8	10.8	10.9	9.5	10.3
Хорт хавдрын шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад (30-70 нас)									
Бүгд	21.3	19.9	21.5	19.4	18.7	18.4	18.4	17.9	18.3
эрэгтэй	26.7	24.9	27.1	25.0	24.2	24.7	24.2	23.5	23.9
эмэгтэй	16.4	15.3	16.3	14.2	13.6	12.5	13.1	12.7	13.1
Чихрийн шижин өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад (30-70 нас)									
Бүгд	1.1	0.9	1.4	1.3	1.8	1.5	1.2	1.6	1.6
эрэгтэй	1.3	1.1	1.7	1.6	2.0	1.8	1.6	2.0	2.0
эмэгтэй	1.0	0.8	1.0	1.1	1.6	1.2	1.0	1.3	1.2
Амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад (30-70 нас)									
Бүгд	1.1	1.3	1.3	1.0	1.3	1.6	1.5	1.5	1.6
эрэгтэй	1.5	1.9	2.0	1.4	1.9	2.4	2.3	2.4	2.4
эмэгтэй	0.6	0.7	0.6	0.6	0.8	0.8	0.7	0.8	0.7




2.5.2. АМИА ХОРЛОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН (ТХЗ 3.4.2)

Дэлхий даяар жил бүр 720 000 гаруй хүн амиа хорлож нас барж байгаа ба нэг амиа хорлож нас барсан тохиолдол бүрд дунджаар 20 удаагийн оролдлого тохиолдож байгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал дэлхийн хэмжээнд анхаарах асуудлын нэг байгааг харуулж байна. Амиа хорлолт нь амьдралын аль ч үе шатанд, бүх бүс нутгуудад тохиолддог бөгөөд 2021 оны байдлаар 15–29 насны залуучуудын дунд гурав дахь гол нас баралтын шалтгаан болсон байна. Мөн нийт амиа хорлолтын 73 хувь нь бага болон дунд орлоготой орнуудад бүртгэгджээ.

Амиа хорлолтын шалтгаан нь олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд эдгээрийн дотор сэтгэл гутрал, архины хэт хэрэглээ, өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан түүх голлох эрсдэлт хүчин зүйлүүдийн нэг болдог. Үүнээс гадна сэтгэл хямралын үеийн гэнэтийн шийдвэр, ойр дотны хүнээ алдах, ганцаардал, ялгаварлан гадуурхалт, харилцааны зөрчил, санхүүгийн хүнд байдал, архаг өвчин, хүчирхийлэл, зөрчил мөргөлдөөн зэрэг нөхцөл байдал нь амиа хорлох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал болон амиа хорлолттой холбоотой нийгмийн гутаан доромжлол, гадуурхалт нь тусламж хүсэх, авах боломжид саад учруулдаг бөгөөд амиа хорлолт, оролдлого нь зөвхөн тухайн хувь хүнд бус гэр бүл, хамт олон, нийгэмд өргөн хүрээтэй нөлөөлөл үзүүлдэг. Иймд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн ойлголт, хандлагыг сайжруулах нь чухал асуудлын нэг хэвээр байна.


Зураг 2.27. Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)



Эх үүсвэр: World Health Statistics 2024

Монгол улсын хүн амын дундах амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин 100 000 хүнд 2021 оны ДЭМБ-ын статистикаар 18.5 байгаа нь дэлхийн дундаж (9.2)-аас 9.3, Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (9.4)-аас 9.1-оор тус тус өндөр байна. 2021 оны байдлаар амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин номхон далайн баруун бүсийн орнуудын дунд 2 дахь өндөр тархалттай орон болж байна.

Зураг 2.28. ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо)




Эх үүсвэр: World Health Statistics 2025

2025 оны эрүүл мэндийн статистикаар Монгол улсын хүн амын дундах амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин 100 000 хүнд 16.3 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 1.3-оор, өмнөх оноос 1.0-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийт нас баралтад эзлэх амиа хорлогчдын хувь бага хэдий ч насны бүлэгт эзлэх хувь харьцангуй ялгаатай байна. Тухайлбал, 2025 онд нас барсан 20-24 насны залуучуудын 29.0 хувь, 25-29 насны залуучуудын 31.7 хувь, 15-19 насныхны 21.9 хувь буюу тухайн насны залуучуудын 4 хүн тутмын 1 нь амиа хорлож нас барсан байна.

Зураг 2.29. ТХЗ 3.4.2 Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин (100 000 хүнд ногдох амиа хорлосон хүний тоо), 2016-2025 он




2.5.3. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ (ТХЗ 3.6.1)

Монгол улсын хүн амын дундах зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин 100 000 хүнд 2019 оны ДЭМБ-ын статистикаар 21.0 байгаа нь дэлхийн дундаж (16.7)-аас 4.3, Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (16.4)-аас 4.6-оор тус тус өндөр байна.



Зураг 2.30. ТХЗ 3.6.1 Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (100 000 хүнд ногдох зам тээврийн ослоор нас барсан хүний тоо)




Эх үүсвэр: World Health Statistics 2024

Эрүүл мэндийн статистикаар 2025 онд 536 хүн зам тээврийн ослын нас баралтын тохиолдол бүртгэгдэж, 100 000 хүнд ногдох баралтын түвшин 15.6 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.2-оор буурч, өмнөх онтой харьцуулахад 0.2-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ослын шалтгаанаар харуулбал, бусад тээврийн осол 54.3%, мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орсон 16.6%, явган зорчигч зам тээврийн осолд орсон 28.2%-ийг тус тус эзэлж байна.

Хүйсийн хувьд бусад тээврийн ослын улмаас нас барсан эрчүүд эмэгтэйчүүдээс 2.9 дахин их, явган зорчигч нас барсан тохиолдол 3.4 дахин их байгаа бол мотоциклтой зорчигч нас барсан тохиолдолд эрэгтэйчүүд 16.8 дахин илүү байна. 2025 онд зам тээврийн ослоор нас барсан тохиолдлыг насны ангиллаар харуулбал: 15 хүртэлх насны хүүхэд 10.3 хувь, 15-29 насныхан 15.9 хувийг эзэлж байгаа ба 30-39 насныхан 20.5 хувь, 40-49 насныхан 25.6 хувь, 50-59 насныхан 18.7 хувийг эзэлж байгаа нь насны ангилал дотроо өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 2.31. Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он




2.6. БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

2.6.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАМРАЛТЫН ХУВЬ (ТХЗ-ЫН 3.8.1)

Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын үзүүлэлт нь нөхөн үржихүй, эх, нярай болон хүүхдийн эрүүл мэнд, халдварт өвчин, халдварт бус өвчин болон үйлчилгээний хүчин чадал, хүртээмж зэрэг дөрвөн бүлгийн 14 суурь үзүүлэлтийн жигнэсэн геометр дунджаар тооцоолсон 0–100 хүртэлх онооны нэгдсэн индекс юм. Дэлхийн хэмжээнд энэхүү индекс 2000 онд 54 байсан 2023 онд 71 болж өссөн бөгөөд 2015–2023 оны хугацаанд жилийн өсөлтийн хурд 2015 оноос өмнөхтэй харьцуулахад гуравны нэгээр буурсан байна.

2023 оны байдлаар дэлхийн нийт 4.6 тэрбум хүн эрүүл мэндийн зайлшгүй үйлчилгээнд бүрэн хамрагдаагүй байгаа нь 2000 оноос хойш 20 хувиар буурахад нөлөөлсөн байна. Дэлхийн хэмжээнд үйлчилгээний хамралтын өсөлтийг голчлон халдварт өвчний хяналт хангасан бөгөөд энэ нь нийт өсөлтийн 52%-ийг бүрдүүлж байна. Харин халдварт бус өвчний тусламж үйлчилгээний хамралт 2023 онд 61 оноотой бусад бүлгүүдээс доогуур байна.

Зураг 2.32. ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь



Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувийг ДЭМБ-аас тооцоолсноор 2023 онд 70 хувь байгаа нь дэлхийн дундаж (71)-аас 1, бүсийн дундаж (81)-аас 10 хувиар тус тус бага байна.

Нэгдсэн индексийг бүрдүүлж буй дөрвөн үндсэн бүлгийн үзүүлэлтийг харьцуулбал дараах зураг харагдаж байна. Үйлчилгээний хүчин чадал, хүртээмж 87 оноотой байгаа нь дөрвөн бүлгийн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд эмч, сувилагч, эмнэлгийн орны тоо, хүн амын эрүүл мэндийн боловсрол зэрэг дэд бүтцийн хүчин зүйлсэд Монгол Улс харьцангуй сайн хэвээр байгааг илтгэж байна.


Нөхөн үржихүй, эх, нярай болон хүүхдийн эрүүл мэнд 76 оноотой байгаа ба эх баригч, эмэгтэйчүүдийн эмчийн хамралт, вакцинжуулалт, төрөлт, жирэмсний хяналт зэрэг чиглэлд тогтвортой ахиц гарсаныг харуулж байна. Халдварт өвчин 72 оноотой байгаа ба сүрьеэ, ХДХВ, малариа зэрэг халдварт өвчний эсрэг хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжиж байгааг илэрхийлж байна.

Халдварт бус өвчин 52 оноотой байгаа нь дөрвөн бүлгийн хамгийн бага, бусад



бүлгүүдээс 20–35 оноогоор доогуур байна. Зүрх судасны өвчин, чихрийн шижин, хорт хавдар, амьсгалын замын архаг өвчин зэрэг халдварт бус өвчний оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна. Энэ үзүүлэлт дэлхийн хэмжээнд ч 61 оноотой байгаа бөгөөд манай улс дэлхийн дунджаас 9 оноогоор доогуур байна.

Зураг 2.33. ТХЗ 3.8.1 Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь



Эх үүсвэр: World Health Statistics 2025

Монгол улсын хувьд эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний үзүүлэлтээс эмнэлгийн тусламж үйлчилгээний хүчин чадал, хүртээмжийн үзүүлэлт, нөхөн үржихүйн, эх, нярайн болон хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд харьцангуй өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 2.7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүчин чадал, хүртээмжийн үзүүлэлт, сонгосон онуудаар

Үзүүлэлт		2000	2005	2010	2015	2020	2025
Хэвтүүлэн эмчлэх ор*	тоо	16283	16653	16317	19982	25249	27518
	10 000 хүнд	67.5	65.4	59.2	66.0	78.3	80.5
Их эмч	тоо	6498	6788	7497	9653	12431	16093
	1000 хүнд	2.8	2.8	2.8	3.2	3.9	4.7
Сэтгэцийн эмч	тоо	98	129	130	127	171	208
	100 000 хүнд	4.1	5.2	4.9	4.3	5.3	6.1
Мэс заслын эмч	тоо	279	312	372	414	591	755
	100 000 хүнд	11.6	12.2	13.5	13.7	18.3	22.1

*Хэвтүүлэн эмчлэх орны тоонд төрөх тасгийн орны тоог хасч тооцсон.

2.7. ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДТЭЙ ХОЛБООТОЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтын 3.9-д 2030 он гэхэд аюултай химийн бодис, агаар, ус, хөрсний бохирдол, халдвараас болж нас барсан, өвдсөн хүмүүсийн тоог үлэмж хэмжээгээр бууруулах зорилт тавьсан.


Дэлхийн хүн амын 99% нь нарийн ширхэглэгт тоосонцрын (PM 2.5) агууламж нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс давсан агаараар амьсгалж байна.

2021 оны байдлаар, агаарын бохирдол нь дэлхий даяар 8.1 сая хүний нас баралтад хүргэсэн бөгөөд энэ нь дэлхийн хоёр дахь том эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл болж байна. Нас баралтын шалтгааны дийлэнх хувь нь (85%) халдварт бус өвчин түүний дотроос тархинд цус харвалт, зүрхний ишеми өвчин, уушгины архаг бөглөрөлт өвчин гуурсан хоолойн багтраа, уушгины хорт хавдар шалтгаантай байгаа ба тав хүртэлх насны хүүхдийн дунд амьсгалын замын халдварт өвчний нас баралт мөн өндөр байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5-ийн жилийн дундаж агууламж сүүлийн 10 жилд 2.5 дахин буурсан боловч энэ нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 8 дахин их, үндэсний агаарын чанарын стандартаас 1.6 дахин их байна.

Монгол Улсад гадаад ба дотоод орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин 100 000 хүнд 215 байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна. Тархинд цус харвалт, зүрхний шигдээс өвчний шалтгаант нас баралтын 39% нь агаарын бохирдлоос шалтгаалж байна.

Зураг 2.34. ТХЗ 3.9.1 Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин



Эх үүсвэр: Дэлхийн эрүүл мэндийн статистик, ДЭМБ, 2025



2.7.1. ДОТООД БОЛОН ГАДААД ОРЧНЫ АГААРЫН БОХИРДЛООС ШАЛТГААЛСАН НАС БАРАЛТЫН ТҮВШИН (ТХЗ-ЫН 3.9.1)

Монгол улсын хүн амын дундах дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин 100 000 хүнд 2019 оны ДЭМБ-ын статистик тооцооллоор 215 байгаа нь дэлхийн дундаж (103.6)-аас 111.1, Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (94.0)-аас 120.7-оор тус тус өндөр байна. 2019 оны байдлаар дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин номхон далайн баруун бүсийн орнуудын дунд хамгийн өндөр тархалттай орон болж байна.

Хүснэгт 2.8. Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшин, ДЭМБ-ын тооцооллоор

Хүйс	Бүгд	Амьсгалын доод замын халдвар	Уушгины хавдар	Зүрхний ишеми	Тархинд цус харвалт	Уушгины архаг бөглөрөлт өвчин
100 000 нийт хүнд тооцоолсноор						
Эрэгтэй	161	6	6	96	48	5
Эмэгтэй	89	3	1	51	31	3
Бүгд	120	4	3	70	38	4
Тухайн насны 100 000 хүнд тооцоолсноор						
Эрэгтэй	285	10	15	159	90	10
Эмэгтэй	164	6	3	88	61	6
Бүгд	215	8	8	118	73	8

Эх үүсвэр: World Health Statistics 2024

Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшинг тооцож харуулахдаа эрүүл мэндийн албан ёсны статистикаар бүртгэгдсэн хүн амын нас баралтын мэдээллийн сангаас Тогтвортой хөгжлийн зорилгын 3.9.1 зорилтын тооцох аргачлалын дагуу өвчний олон улсын 10-р ангиллын дагуу 25 ба түүнээс дээш насны хүн амын дунд бүртгэгдсэн нас баралтын тоог тухайн насны 100 000 хүнд харьцуулан харуулсан болно.

2025 оны эрүүл мэндийн статистикаар Монгол улсын хүн амын дундах дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралт буюу тухайн кодоор бүртгэгдсэн нас баралтын түвшин тухайн насны 100 000 хүнд 274.4 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 31.2-оор, өмнөх оноос 19.5-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.9. Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалах нас баралтын түвшин, Эрүүл мэндийн статистикаар

Хүйс	Бүгд	Амьсгалын доод замын халдвар	Уушгины хавдар	Зүрхний ишеми	Тархинд цус харвалт	Уушгины архаг бөглөрөлт өвчин
100 000 нийт хүнд тооцоолсноор						
Эрэгтэй	197.55	13.99	22.78	88.18	61.98	10.62
Эмэгтэй	104.07	8.39	5.29	46.75	38.35	5.29
Бүгд	150.20	11.16	13.92	67.19	50.01	7.92
Тухайн насны 100 000 хүнд тооцоолсноор						
Эрэгтэй	372.1	26.4	42.9	166.1	116.7	20.0
Эмэгтэй	184.7	14.9	9.4	83.0	68.1	9.4
Бүгд	274.4	20.4	25.4	122.7	91.4	14.5

Хүснэгт 2.10. Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалах өвчлөлийн шалтгаант баралтын түвшин, тухайн насны 100 000 хүнд, 2016-2025 он


Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалах өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин, тухайн насны 100 000 хүнд										
Бүгд	327.3	305.8	328.0	313.1	277.5	344.0	311.4	293.9	285.4	274.4
эрэгтэй	411.3	398.1	413.4	402.1	359.5	433.7	406.1	385.1	387.3	372.1
эмэгтэй	251.0	221.9	249.5	231.1	202.4	262.0	224.7	210.4	192.2	184.7
Уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт, тухайн насны 100 000 хүнд харьцуулахад (25 ба дээш нас)										
Бүгд	21.3	23.1	23.4	26.2	24.2	25.2	26.7	22.4	26.9	25.4
эрэгтэй	36.2	39.2	38.3	42.3	40.2	42.6	45.2	36.6	43.6	42.9
эмэгтэй	7.7	8.5	9.8	11.3	9.5	9.2	9.8	9.5	11.5	9.4
Зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 100 000 хүнд (25 ба дээш нас)										
Бүгд	147.9	142.3	153.6	142.2	123.6	162.1	140.8	135.2	126.8	122.7
эрэгтэй	187.2	187.7	192.2	180.5	159.7	197.3	174.7	173.2	168.6	166.1
эмэгтэй	112.0	100.9	118.1	106.9	90.6	130.0	109.9	100.4	88.6	83.0
Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, тухайн насны 100 000 хүнд харьцуулахад (25 ба дээш нас)										
Бүгд	119.3	112.9	120.7	110.4	104.4	113.3	108.4	100.7	95.7	91.4
эрэгтэй	139.7	136.7	144.3	134.8	128.2	142.2	139.2	125.9	122.9	116.7
эмэгтэй	100.7	91.2	99.0	88.0	82.6	87.0	80.2	77.6	70.9	68.1
Уушгины архаг бөглөрөлт өвчний шалтгаант нас баралт, тухайн насны 100 000 хүнд харьцуулахад (25 ба дээш нас)										
Бүгд	10.7	8.9	7.1	8.1	7.5	9.0	9.4	11.6	12.4	14.5
эрэгтэй	13.7	13.2	9.8	10.3	9.0	11.6	13.2	17.5	18.4	20.0
эмэгтэй	8.0	5.0	4.7	6.1	6.1	6.6	5.9	6.1	6.9	9.4



2.8. БАТАЛГААГҮЙ УНДНЫ УС, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР НӨХЦӨЛДСӨН НАС БАРАЛТЫН ТҮВШИН (ТХЗ-ЫН 3.9.2)

Монгол улсын хүн амын дундах баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин 100 000 хүнд 2019 оны ДЭМБ-ын статистик тооцоолоор 3.2 байгаа нь дэлхийн дундаж (18.3)-аас 15.1, Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (4.3)-аас 1.1-оор тус тус доогуур байна.


Зураг 2.35. Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин, 100 000 хүнд, ДЭМБ-ын тооцоолоор



Эх үүсвэр: World Health Statistics 2025

Эрүүл мэндийн статистикаар баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаас шалтгаалсан нас баралтын түвшинг олон улсын аргачлалын дагуу Өвчний олон улсын ангилал-10 (ӨОУА-10)-д заасан суулгалттай холбоотой A00, A01, A03, A04, A06-A09 кодтой өвчлөл, гэдэсний халдварт B76-B77, B79, хоол, тэжээлийн дутагдалтай холбоотой E40-E46 кодтой өвчлөл, амьсгалын замын цочмог халдварууд J00-J22, нярайн халдвар P23 өвчлөлийг хамруулан тооцоолон гаргалаа.

Зураг 2.36. Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин, 100 000 хүнд



Эх үүсвэр: World Health Statistics 2025

2.8.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН

Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ (УАЦЭА) нь халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагааны чухал хэсэг бөгөөд үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж үйлчилгээний чанарыг тодорхойлдог. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 6 дугаар зорилгын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээнд гарч буй ахиц дэвшлийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хамтарсан хяналтын хөтөлбөр мэдээлдэг.

2023 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хамтран ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хамтарсан хяналтын хөтөлбөрөөс гаргасан 2018 оны аргачлалын дагуу Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 319 эрүүл мэндийн байгууллагын ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй, хог хаягдлын менежмент, орчны цэвэрлэгээний үйлчилгээний түвшинг үнэлсэн.

Хүснэгт 2.11. Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшингийн ангиллын тодорхойлолт

	СУУРЬ	ХЯЗГААРЛАГДМАЛ	ҮЙЛЧИЛГЭЭ ХАНГАГДААГҮЙ
УС ХАНГАМЖ	Сайжруулсан буюу үндны усны шаардлага хангасан эх үүсвэрээс ус дамжуулах шугам хоолойд холбогдсон, байнга устай байдаг.	Сайжруулсан усны эх үүсвэр нь байгууламжаас 500 метрийн зайд байрладаг боловч үндсэн үйлчилгээний бүх шаардлагыг хангаагүй.	Хамгаалаагүй гар худаг, булаг, гадаргын усны эх үүсвэртэй; эсвэл байгууламжаас 500 метрээс дээш зайд байрлах сайжруулсан эх үүсвэрээс усаа авдаг; эсвэл усны эх үүсвэргүй
АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай ба ажилчдад зориулсан дор хаяж нэг бие засах газар, сарын тэмдгийн үеийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, хүйсээр тусгаарлагдсан, тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан багадаа нэг ариун цэврийн өрөө/бие засах газартай	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай хэдий ч суурь үйлчилгээний шаардлагыг бүрэн хангаагүй (ажилтанд зориулсан, сарын тэмдгийн үеийн эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, хүйсээр тусгаарлагдсан, тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөгүй).	Сайжруулаагүй ариун цэврийн байгууламжтай (Гишгүүргүй, бүхээггүй, хөрсний доторлогоогүй энгийн нүхэн жорлон)
ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өрөө тасалгаа болон ариун цэврийн өрөөнөөс 5 метрийн зайд гарын эрүүл ахуй хангах цэг (угаалтуур, ус, саван, халдваргүйжүүлэгч)-тэй	Гарын эрүүл ахуй сахих цэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цэг болон ариун цэврийн өрөөний аль нэгэнд нь байдаг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цэг болон ариун цэврийн өрөөний аль аль нь гарын эрүүл ахуй сахих цэггүй



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	Хог хаягдлыг гурваас доошгүй төрлийн шошготой хогийн саванд ангилж цуглуулдаг бөгөөд халдвартай болон хурц үзүүртэй хог хаягдлыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсруулж, устгадаг.	Хурц болон халдвартай хог хаягдлыг зөв ялган ангилдаг хэдий ч халдваргүйжүүлэх, устгах үйл ажиллагаа хязгаарлагдмал ба суурь үйлчилгээний шаардлагыг бүрэн хангаагүй	Хурц болон халдвартай хог хаягдлыг зөв ангилан ялгадаггүй, хурц үзүүртэй болон халдвартай хог хаягдалд боловсруулалт хийдэггүй, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй аргаар устгадаг.
ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ	Цэвэрлэгээний заавар, журамтай бөгөөд цэвэрлэгээ үйлчилгээний ажилтнууд зохих сургалтад хамрагдсан.	Цэвэрлэгээний журам, заавартай хэдий ч цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан ажилтны зарим нь сургалтад хамрагдсан.	Цэвэрлэгээний журам, зааваргүй бөгөөд үйлчилгээ хариуцсан бүх ажилтан сургалтад хамрагдаагүй.

Хамтарсан хяналтын хөтөлбөрөөс жил бүр гаргадаг Эрүүл мэндийн байгууллагын УАЦЭА тайланд энэхүү үнэлгээний үр дүнг оруулсан болно.

https://cdn.who.int/media/docs/default-source/wash-documents/wash-coverage/jmp/jmp-2023_hcf_launch.pdf?sfvrsn=5281a01a_3&download=true

Үнэлгээг тухайн эрүүл мэндийн байгууллага ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн суурь үйлчилгээтэй, хязгаарлагдмал үйлчилгээтэй болон үйлчилгээ хангагдаагүй гэсэн 3 ангиллын дагуу хийсэн.

Үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын УАЦЭА-н суурь үйлчилгээний түвшинг тоймлоход:

- 88.1% нь сайжруулсан усны эх үүсвэртэй, ус дамжуулах шугам хоолойд холбогдсон, байнгын устай;
- 40% нь ашиглах боломжтой, сарын тэмдгийн эрүүл ахуйг сахих нөхцөлийг хангасан, хүйсээр тусгаарласан, өвчтөн болон ажилчдын хувьд тусдаа, хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүст хүртээмжтэй, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай;
- 72.4% нь түслэмж үйлчилгээний цэгт ус, савантай, эсвэл спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч бүхий гарын эрүүл ахуй сахих цэг болон ариун цэврийн өрөөнөөс 5 метрийн дотор зайд ус, савантай гар угаалтууртай;
- 83.7% нь хог хаягдлыг гурваас доошгүй төрлийн ангиллаар хогийн саванд ангилж цуглуулдаг, халдвартай болон хурц үзүүртэй хог хаягдлыг аюулгүй боловсруулж, устгадаг;
- 49.2% нь цэвэрлэгээний журам, хуваарьтай бөгөөд цэвэрлэгээ хийх үүрэгтэй бүх ажилтнууд сургалтад хамрагдсан буюу суурь үйлчилгээний түвшнийг хангаж байна.

Үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудын УАЦЭА-н үйлчилгээний ерөнхий түвшинг авч үзэхэд 66.6% нь суурь үйлчилгээтэй, 29.7% нь хязгаарлагдмал үйлчилгээтэй байна. Энэ үзүүлэлт нь газар зүйн байршлын хувьд ялгаатай байгаа бөгөөд хот, аймгийн төвийн эрүүл мэндийн байгууллагын 71% нь УАЦЭА-н суурь үйлчилгээтэй байхад, хөдөөгийн буюу сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 49% нь л суурь үйлчилгээтэй, 40.9% нь хязгаарлагдмал үйлчилгээтэй, 12.5% үйлчилгээгүй гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 2.12. ЭМБ-ын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшин, хувиар, 2023 он


Эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь		Үндэсний түвшинд	Хот	Хөдөө	Эмнэлгийн	Эмнэлгийн бус	Төрийн	Хувийн
БҮГД		319	255	64	319	-	194	125
УС ХАНГАМЖ	Сүүрь үйлчилгээ	88.1	93.3	67.2	99.7	-	83.0	96.0
	Хязгаарлагдмал үйлчилгээ	11.6	6.7	31.3	11.6	-	16.5	4.0
	Үйлчилгээгүй	0.3	0	1.6	0.3	-	0.5	0
АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай	85.4	92.4	57.8	85.4	-	78.6	96.0
	Ашиглах боломжтой сайжруулсан ариун цэврийн байгууламжтай	85.4	92.4	57.8	85.4	-	78.6	96.0
	Сүүрь үйлчилгээ	39.8	41.2	34.4	39.8	-	46.4	29.6
	Хязгаарлагдмал үйлчилгээ	45.6	52.1	23.4	45.6	-	32.2	66.4
	Үйлчилгээгүй	14.6	7.6	42.2	14.6	-	21.4	4.0
ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙ	Тусламж үйлчилгээний цэгт ус, савантай, эсвэл спирттэй гар халдваргүйжүүлэгч бүхий гарын эрүүл ахуй сахиx цэгтэй	93.4	95.3	85.9	93.4	-	91.8	96.0
	Ариун цэврийн өрөөнөөс 5 метрийн зайд ус, савантай гар угаалтууртай	75.5	83.5	43.8	75.5	-	69.6	84.8
	Сүүрь үйлчилгээ	72.4	79.6	43.8	72.4	-	66.0	82.4
	Хязгаарлагдмал үйлчилгээтэй	27.6	20.4	56.3	27.6	-	34.0	17.6
ХОГ ХАЯГДАЛ	Үзлэг эмчилгээний өрөөнд хог хаягдлыг зөв ангилдаг	87.1	90.2	75.0	87.1	-	85.6	89.6
	Халдвартай/хурц үзүүртэй хог хаягдлыг аюулгүй боловсруулж/ зайлуулдаг	94.4	98.8	76.6	94.4	-	92.8	96.8
	Сүүрь үйлчилгээ	83.7	89.4	60.9	83.7	-	80.9	88.0
	Хязгаарлагдмал үйлчилгээ	15.0	10.6	32.8	15.0	-	17.5	11.2
	Үйлчилгээгүй	1.3	-	6.3	1.3	-	1.5	0.8
ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ	Цэвэрлэгээний журам, заавартай	70.2	71.4	65.6	70.2	-	75.3	62.4
	Цэвэрлэгээ үйлчилгээний ажилтнууд сургалтад хамрагдсан	58.6	59.6	54.7	58.6	-	69.6	41.6
	Сүүрь үйлчилгээ	49.2	51.8	39.1	49.2	-	58.8	34.4
	Хязгаарлагдмал үйлчилгээ	48.9	45.9	60.9	48.9	-	40.7	61.6
	Үйлчилгээгүй	1.9	2.4	0	1.9	-	0.5	4.0
БҮГД	Сүүрь үйлчилгээ	66.6	71.1	49.1	69.0	-	67.0	66.1
	Хязгаарлагдмал үйлчилгээ	29.7	27.1	40.9	29.7	-	28.2	32.2
	Үйлчилгээгүй	4.5	3.3	12.5	4.5	-	6.0	2.2

Эх үүсвэр: ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ



Доорх зурагт эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хог хаягдлын менежмент, орчны цэвэрлэгээний үйлчилгээний түвшинг Зүүн өмнөд Азийн орнууд харьцуулан харуулав. Монгол Улсын хувьд эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн байгууламж болон орчны цэвэрлэгээний суурь үзүүлэлт маш доогуур түвшинд байна.

Зураг 2.37. Монгол болон Зүүн өмнөд Азийн зарим орнуудын эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшин




Цаашид эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний түвшинг тодорхойлох эдгээр үзүүлэлтүүдийг жил бүр тооцож, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт болгон тайлагнах нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах буюу бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд чухал ач холбогдолтой юм.

2.9- САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТСӨНӨӨС ШАЛТГААЛСАН НАС БАРАЛТЫН ТҮВШИН (ТХЗ-ЫН 3.9.3)


Монгол улсын хүн амын дундах санамсаргүй хордох, хордлогын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд харьцуулахад ДЭМБ-ын судалгаагаар 2.8 байгаа нь дэлхийн дундаж (1.1)-аас 1.7, Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж (1.4)-аас 1.4-оор тус тус өндөр байна. 2019 оны байдлаар санамсаргүй хордох, хордлогын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд харьцуулахад номхон далайн баруун бүсийн орнуудын дунд хамгийн өндөр тархалттай орон болж байна.

Зураг 2.38. Санамсаргүй хордох, хордлогын шалтгаант нас баралтын түвшин, 100 000 хүнд харьцуулахад



Эх үүсвэр: World Health Statistics 2025

Эрүүл мэндийн статистикаар санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтыг ӨОУА-10-р ангиллын дагуу Х40-Х49 кодтой өвчний шалтгаант нас баралтыг түүвэрлэн тооцоолсон бөгөөд 2025 онд санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан баралтын 1011 тохиолдол бүртгэгдэж, 100 000 хүнд ногдох баралтын түвшин 29.4 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 2.3-оор өндөр байгаа ба өмнөх оноос 4.0-оор буурсан үзүүлэлттэй байна. Ослын шалтгаанаар харуулбал, архи, спиртийн төрлийн бодист хордож нас барсан тохиолдол 87.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр тохиолдол байна. Хий, ууранд санамсаргүй хордох, өртөх 11.3%, эмийн бодист санамсаргүй хордох тохиолдол 1.4%-ийг тус тус эзэлж байна.



БҮЛЭГ 3

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД



Улсын хэмжээнд 2025 онд

53 716
эх амаржсан

өмнөх онтой харьцуулахад
↓ **3 603** тохиолдлоор
буюу 6.3 хувиар буурсан.



ТӨРСӨН ЭХЧҮҮДИЙН ТОО, ХУВЬ

25.1%  анхны төрөгч

72.3%  2–5 удаа төрсөн

2.6%  6 ба түүнээс дээш удаа төрсөн

ТӨРӨЛТ ХООРОНДЫН ЗАЙ

4.1%  1 жил

13.1%  2 жил

57.6%  3 ба түүнээс дээш жил

 Нийт төрөлтийн **99.9** хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан

НАСНЫ ХУВЬД

3.8%  20 хүртэлх насны

25.3%  35-аас дээш насны

ТӨРӨЛТИЙН ТУСГАЙ КОЭФФИЦИЕНТ

 **99.7**

нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутам хүүхэд төрүүлсэн тоо

2025 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд

54 137 хүүхэд амьд төрсөн

өнгөрсөн оны мөн үеэс
↓ **3 619** тохиолдлоор
буюу 6.3 хувиар буурсан.

ТӨРӨЛТИЙН ТҮВШИН

 **15.8**
/1000 хүн амд/

АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ХҮЙСИЙН БАЙДАЛ

 **28 036** (51.8%) хүү

 **26 101** (48.2%) охин



ТӨРӨХ ҮЕИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА

 **107** хүү



 **100** охин

100 охинд ойролцоогоор 107 хүү ногдож байна.

АМЬД ТӨРСӨН ХҮҮХДЭЭС

 **2 630** нярай (4.9%)
2500 граммаас доош жинтэй

 **445** төрөлхийн гажигтай төрсөн (0.8%)

 **95.9%** Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан

 **70.9** Дутуу төрөлтийн түвшин (1000 амьд төрөлтөнд)

 **4.6** Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөнд)

БҮЛЭГ 3. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

3.1. ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД


Монгол Улсын Эрүүл Мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2021-2024 онуудад Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах зорилго тавьсан.

3.1.1. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ БА ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 53 779 жирэмсэн эмэгтэйчүүд шинээр хяналтад хамрагдсан бөгөөд 93.2 % нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа, 6.1 % нь 4-6 сартайдаа, 0.7% нь хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад хамрагджээ. Жирэмсний эрт үеийн хяналт Улаанбаатарт 92.7%, орон нутагт 93.7% байна. Өмнөх онтой харьцуулахад Улаанбаатар болон орон нутагт 0.1 %-р тус тус өссөн байна.

Шинээр хяналтад хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.7% нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 3.6% нь цус багадалттай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.4%-р буурсан байна. Шинжилгээгээр Баянхонгор, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Сүхбаатар, Баян-Өлгий аймагт цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дүнгээс 0.2-5.1%-р их байна.

Зураг 3.1. Цус багадалттай жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь, 2025 он



Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд 98.1% хамрагдсанаас 1.3 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Дорнод 2.6, Хөвсгөл 2.1, Архангай 1.8, Баянхонгор 1.7, Говь-Алтай 1.5, Улаанбаатар 1.7 хувьтай байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 0.2-1.3 хувиар их байна.

Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 92.1 хувь нь хамрагдсан нь өмнөх оноос 0.4хувиар буурсан байна. Шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.1 хувьд нь заг хүйтэн өвчин илэрчээ. Хөвсгөл 1.0, Булган 0.6, Баянхонгор, Сэлэнгэ, Төв аймгууд 0.2 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дүнгээс 0.1-0.8 хувиар их байна.




Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 92.1 хувь нь хамрагдсанаас 1.1 хувьд нь эерэг байна. Баянхонгор 4.7, Орхон 2.1, Сүхбаатар 1.9, Сэлэнгэ 1.8, Говьсүмбэр 1.6, Төв 1.6, Дархан-Уул 1.8, Хэнтий 1.2, Булган 1.2 хувийг тус тус эзэлж байгаа нь улсын дунджаас 0.1-3.6 хувиар их байна. Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс идэвхтэй хэлбэрийн сүрьеэгийн 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2025 онд эхчүүдийн амрах байр 329 ажиллаж байгаагаас сум, тосгоны эрүүл мэндийн төвд 305, аймгийн нэгдсэн эмнэлэгт 18, БОЭТ-д 5 тус тус байна.

Эхчүүдийн амрах байрны 87 буюу 26.4 хувь нь зориулалтын байранд, 242 буюу 73.6 хувь нь эмнэлэг дотор байрлаж нийт 34 643 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 3.0 байна. 2025 онд 4 байр шинээр баригдаж, 29 байранд засвар үйлчилгээ, 56 байранд тохижилт хийгдсэн байна. Нийт амарвал зохих эхчүүдийн 60.6 хувь нь амрах байранд амарсан байна.

Зураг 3.2. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, аймгаар, 2025 он




Нийт амаржсан эхчүүдийн 86.0 хувь нь жирэмсний хугацаанд эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан нь өмнөх оноос 2.3 хувиар нэмэгдсэн байна.

3.1.2. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын хэмжээнд 2025 онд 53 716 эх амаржсан нь өмнөх онтой харьцуулахад 3603 тохиолдлоор буюу 6.3 хувиар буурсан байна. Төрөлт Улаанбаатар болон бусад аймгуудад 11-1739 тохиолдлоор жигд буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлтийн түвшин улсын дүнгээр 15.8 байгаа бол энэ үзүүлэлт Баян-Өлгий (22.3), Ховд (18.7), Орхон (18.2), Улаанбаатар (17.7), Дархан-Уул (17.2), Увс (16.1) аймгуудад улсын дунджаас өндөр байна.


Төрсөн эхчүүдийн 25.1 хувь нь анхны төрөгч, 72.3 хувь нь 2-5 удаа төрсөн, 2.6 хувь нь 6 ба түүнээс дээш удаа төрсөн байна. Төрөлт хоорондын зай 4.1 хувь нь 1 жил, 13.1 хувь нь 2 жил, 57.6 хувь нь 3 ба түүнээс дээш жил байна.

Зураг 3.3. 1000 хүнд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2025 он



Нийт төрөлтийн 99.9 хувийг эмнэлгийн мэргэжилтэн удирдан явуулсан байна. Насны хувьд 3.8 хувь нь 20 хүртэлх насны, 25.3 хувь нь 35-аас дээш насны төрөлт эзэлж байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход 2025 онд нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 99.7 нь хүүхэд төрүүлсэн байна.

Зураг 3.4. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2025 он






ДЭМБ-аас нийт төрөлтийн 15 хүртэлх хувийг мэс заслын аргаар төрүүлж болно гэж зөвлөдөг. Монгол улсад 2025 оны байдлаар 28.9 хувь байгаа нь тоог өмнөх онтой харьцуулахад 0.7 хувиар өссөн байна.

Мэс заслын аргаар төрүүлсэн хувийг аймгийн дундажтай харьцуулахад Төвийн ба Баруун бүсэд 0.9-2.3 хувиар бага, Хангай болон Зүүн бүсэд 0.9-4.3 хувиар их байна. Улаанбаатарт улсын дунджаас 3.1 хувиар их байна.


Зураг 3.5. Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр, 2025 он




Гэрийн төрөлтийн 133 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 21 тохиолдлоор буюу 13.6 хувиар буурсан байна. Гэрийн төрөлтийн 54.9 хувь нь Улаанбаатарт бүртгэгдсэн ба өмнөх оноос 2.9 хувиар буурсан байна.

Эмнэлгийн тусламжгүй төрөлт 54 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор буюу 38.5 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд орон нутгийн харьяат 5659 эх амаржсан нь өмнөх оноос 280 тохиолдлоор буурсан ба Улаанбаатарт бүртгэгдсэн төрөлтийн 19.3 хувийг эзэлж байна.

Зураг 3.6. Улаанбаатар хотод орон нутгаас ирж амаржсан эхчүүд, бодит тоо, 2025 он




Зураг 3.7. Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2025 он



Төрөлтийн нийлбэр коэффициент 2.5 байгаа ба 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 100.8 нь, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 134.9 нь, 30-34 насны 1000 эмэгтэй тутмын 113.2 нь хүүхэд төрүүлж байна.

Зураг 3.8. Төрөлт, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2025 он



Нийт төрөлтийн 41.7 хувь нь Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон амаржих газруудад, 27.5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 13.0 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 8.2 хувь нь бусад эмнэлэгт 4.7 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 3.4 хувь нь хувийн эмнэлэгт, 1.3 хувь нь дүүргийн эрүүл мэндийн төв, 0.2 хувь нь гэрийн төрөлт байна.

2025 онд нийт амаржсан эхчүүдийн 81.5 хувь нь төрсний дараах өрхийн эмчийн хяналтад товллын дагуу үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.9 хувиар буурсан байна.

3.1.3. ЖИРЭМСЭН, ТӨРӨЛТ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ХҮНДРЭЛ

Нийт хүндрэлд :


- Жирэмсэн үеийн хүндрэл 48.0 хувь
- Төрөх үеийн хүндрэл 41.2 хувь
- Төрсний дараах үеийн хүндрэл 2.5 хувь
- Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 8.3 хувийг тус тус эзэлж байна.




Төрөлхийн тэмбүүгийн нийт 25 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотод 17, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Завхан, Өвөрхангай аймгуудад тус бүр 1, Орхон, Төв аймгуудад 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 3.9. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, байршлаар, 2025 он




Зураг 3.10. Жирэмсний хүндрэлд манас таталт ба манас таталтын урьдлын эзлэх хувь, аймгаар 2025 он



Жирэмсний хүндрэлд манас таталтын урьдал болон манас таталтын эзлэх хувь Завхан 96.1, Сүхбаатар 71.7, Хэнтий 58.8, Хөвсгөл 52.2, Булган 51.0, Дорноговь 45.1, Өмнөговь 33.9, Баянхонгор 33.2 байгаа нь улсын дунджаас 11.9-74.9 хувиар их бол бусад аймгууд 0.6-17.5 хувиар бага байна.


Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал 21.1 хувь, манас таталт 0.1 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 33.4 хувь, төрсний дараах хүндрэлээс төрсний дараах үеийн цус алдалт 81.2 хувьтай тэргүүлж байна.

Зураг 3.11. Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь, аймгаар, 2025 он



Төрөх үеийн хүндрэлд төрөх хүчний сулралын эзлэх хувь хамгийн өндөр нь Ховд 100, хамгийн бага нь Хэнтий аймаг 2.8 хувь тус тус байна.

Зураг 3.12. Төрсний дараах хүндрэлд цус алдалтын эзлэх хувь, аймгаар, 2025 он



Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай, Дундговь, Булган, Увс, Хөвсгөл, Орхон, Өмнөговь, Говь-Алтай аймгуудад төрсний дараах хүндрэлд цус алдалтын тохиолдол өндөр бүртгэгдсэн байна.

3.1.4. ЭХИЙН ЭНДЭГДЭЛ


Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 70 болгох зорилт тавьсан. Монгол Улсын хувьд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлсноор 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 2025 онд 20.0, 2030 онд 15.0, 2050 онд 5.0 болгохоор тодорхойлсон.



Эхийн эндэгдэл 2025 онд 17 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 31.4 байна. Өмнөх оноос 4 тохиолдлоор, 100 000 амьд төрөлт тутамд 8.9 эндэгдлээр нэмэгдсэн байна. Баянхонгор, Сэлэнгэ, Увс, Ховд, Дорноговь, Дархан-Уул зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдсэн байна.

Эхийн эндэгдлийн 70.6 хувь нь эмнэлэгт, 29.4 хувь нь гэртээ эндсэн байна. 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг 2016 онтой /48.6/ харьцуулахад 2025 онд 17.2-оор буурсан байна.

Зураг 3.13. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, аймгаар, 2025 он



Эндсэн эхчүүдийг боловсролоор нв авч үзэхэд 58.8 хувь нь дунд, 29.4 хувь нь дээд, 5.9 хувь нь бага, 5.9 хувь нь боловсролгүй байсан ба 29.4 хувь нь ажилгүй, 58.8 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг, 11.8 хувь нь байсан байна.


Эхийн эндэгдэл бүртгэгдсэн эмнэлгийн төрлөөр нь авч үзвэл Амаржих газарт 17.6, дүүргийн эрүүл мэндийн төв 11.8, аймгийн нэгдсэн эмнэлэгт 23.5, сум тосгоны эрүүл мэндийн төвд 11.8, бусад эмнэлэгт 35.3 хувь тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 3.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, насны ангиллаар, 2025 он

Насны бүлэг	Эзлэх хувь	100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин /насны бүлгээр/
20 хүртэлх	0.0	0.0
20-24	23.1	30.3
25-29	30.8	27.7
30-34	7.7	7.1
35-39	53.8	64.4
40-өөс дээш	15.4	70.5

Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд насны бүлгээр авч үзэхэд 40 дээш насанд 70.5 байгаа нь улсын дүнгээс 39.4-оор их байна.

Зураг 3.14. Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2025 он



Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд бүс нутгаар авч үзвэл Төвийн бүсэд улсын дунджаас 32.8 тохиолдлоор өндөр, харин Хангайн бүсэд улсын дунджаас 19.0-оор бага байна.

3.2. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

3.2.1. ТӨРӨЛТ

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөж торних үндэс болдог.

Улсын хэмжээнд 2025 онд төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 95.9 байна. Энэ үзүүлэлт Улаанбаатарт улсын дунджаас 1.2 хувиар бага үзүүлэлттэй байна.


Хүснэгт 3.2. Төрсөн хүүхдийн тоо, бүсээр, 2025 он

Бүсээр	Амьд төрсөн хүүхэд					Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	
Баруун бүс	7152	3742	3410	109.7	3.9	4.6
Төвийн бүс	6233	3208	3025	106.0	3.4	4.0
Хангайн бүс	8036	4155	3881	107.1	3.5	4.1
Зүүн бүс	3045	1561	1484	105.2	3.7	5.9
Аймгийн дүн	24466	12666	11800	107.3	3.6	4.4
Улаанбаатар	29671	15370	14301	107.5	5.9	4.8
Улсын дүн	54137	28036	26101	107.4	4.9	4.6

Улсын хэмжээнд 54 137 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 3619 хүүхдээр буюу 6.3 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.9 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдийн 1310 нь хоёр ихэр, 18 нь гурван ихэр хүүхэд байна. Амьгүй төрөлтийн 252 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 нийт төрөлтөд 4.6 байгаа ба өмнөх онтой харьцуулахад 38 тохиолдлоор буюу 0.4 хувиар буурсан байна.



Зураг 3.15. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд, аймгаар, 2025 он




Амьгүй төрөлтийн түвшин Баян-Өлгий, Завхан, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймагт 1000 нийт төрөлтөд 5.0-11.9 байгаа нь улсын дунджаас 0.2-7.1 тохиолдлоор өндөр байна. Хангайн бүсэд амьгүй төрөлтийн түвшин улсын дунджаас бага боловч, Архангай аймагт 11.9 байгаа нь бүс болон улсын дунджаас 7.1-7.7 тохиолдлоор өндөр үзүүлэлттэй байна. Зүүн болон Баруун бүсийн амьгүй төрөлтийн түвшин улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 48.4 байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 93.8 байна. Нийт амьд төрөлтийн 0.8 хувьд нь төрөлхийн гажгийн тохиолдол бүртгэгдсэн байна.

3.2.2. ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛ

Нярай хүүхдийн өвчлөлийн 29 067 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь амьд төрсөн хүүхдийн 53.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оноос өвчлөл 6.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 3.16. Нярай хүүхдийн өвчлөл амьд төрсөн хүүхдэд эзлэх хувиар, аймгаар, 2025 он



Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор төрөхөд урагийн бүтэлт /488/ 3.0 хувь, нярайн шарлалт/6998/ 44.4 хувийг эзэлж байна.

Амбулаторид бүртгэгдсэн нэг хүртэлх насны хүүхдэд төрөлхийн гажгийн 9881 тохиолдлоос зүрхний таславчийн төрөлхийн гажиг 44.7 хувь, түнхний төрөлхийн гажиг 33.3, сэтэрхий уруул ба тагнай 2.0 хувь, шээс ялгаруулах тогтолцооны төрөлхийн гажиг 6.2 хувь, цусны эргэлтийн тогтолцооны төрөлхийн гажиг 3.4 хувьтай тэргүүлж байна.

Хүснэгт 3.3. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Амбулатор), 2025 он

Тэргүүлэх шалтгаан	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Амьсгалын тогтолцооны өвчин	20.5	59.9	31.0	61.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	5.3	7.1	15.9	17.4
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	21.0	5.8	0.1	0.0
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	3.2	0.6	14.3	2.1
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	6.5	6.1	8.2	6.1
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	10.7	3.8	3.1	0.3
Мэдрэлийн тогтолцооны өвчин	12.0	5.9	3.1	0.6

■ Тэргүүлэх шалтгаан ■ Хоёрдугаар шалтгаан ■ Гуравдугаар шалтгаан

Амбулаторид нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл Улаанбаатарт амьсгалын тогтолцооны өвчин, перинаталь үеийн эмгэг, мэдрэлийн тогтолцооны өвчин харин орон нутагт амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс амьсгалын дээд замын халдвар 29.7, цочмог бронхит 20.9, гүйлсэн бүлчирхайн үрэвсэл 13.0 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн дийлэнх буюу 15.1 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна.

Хүснэгт 3.4. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Стационар), 2025 он

Тэргүүлэх шалтгаан	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Амьсгалын тогтолцооны өвчин	43.7	64.8	66.0	78.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	10.9	7.2	10.7	6.4
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	30.2	18.5	0.0	0.0
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	1.1	0.8	3.4	2.9
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	0.8	1.2	2.2	3.6
Төрөлхийн гажиг	0.4	0.3	0.7	0.3
Мэдрэлийн тогтолцооны өвчин	2.1	3.0	2.4	1.4

■ Тэргүүлэх шалтгаан ■ Хоёрдугаар шалтгаан ■ Гуравдугаар шалтгаан

Стационарт нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл Улаанбаатар болон орон нутагт амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, перинаталь үеийн эмгэг тэргүүлэх шалтгаан болж байна.



Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 77.9, цочмог бронхит 11.3, гүйлсэн бүлчирхайн үрэвсэл 3.7 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 14.9 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна.

Хүснэгт 3.5. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, 2025 он (Амбулатор)

Тэргүүлэх шалтгаан	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	5914.9	2560.8	2124.4	1546.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1708.5	3027.4	1883.2	1763.3
Халдварт ба шимэгчид зарим өвчин	415.8	228.4	236.6	171.4
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	706.0	553.3	846.1	971.6
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	654.5	348.8	257.0	186.6
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	867.3	498.9	570.3	725.4
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	219.5	245.0	269.7	554.2
Нүд ба түүний дайврын өвчин	359.7	377.5	297.2	262.2

■ Тэргүүлэх шалтгаан ■ Хоёрдугаар шалтгаан ■ Гуравдугаар шалтгаан

Амбулаторид өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна. 1-4 насны 10 000 хүүхдэд ногдох өвчлөлд цочмог бронхит, амьсгалын дээд замын халдвар, 5-19 насны хүүхдийн өвчлөлд шүд цоорох, шүд ба дайврын эмгэг тэргүүлэх шалтгаан болж байна.

Хүснэгт 3.6. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, насны бүлгээр, тухайн насны 10 000 хүүхдэд, 2025 он (Стационар)

Тэргүүлэх шалтгаан	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	1383.6	454.0	419.7	310.7
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	172.4	83.9	95.0	113.3
Халдварт ба шимэгчид зарим өвчин	114.7	64.7	93.1	59.7
Гэмтэл, хордлого ба гаднынн шалтгаант бусад тодорхой эмгэг	62.2	56.8	74.7	91.6
Мэдрэлийн тогтолцооны өвчин	37.5	30.4	42.5	66.0
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	54.9	44.1	63.4	79.9

■ Тэргүүлэх шалтгаан ■ Хоёрдугаар шалтгаан ■ Гуравдугаар шалтгаан

Стационарт хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна. 1-4 насны 10 000 хүүхдэд ногдох өвчлөлд халдварт бус суулгалт, уушгины хатгалгаа, 5-19 насанд мухар олгойн өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна.

3.2.3. НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Улсын хэмжээнд 2025 онд нялхсын эндэгдэл 738 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.6 болж байгаа нь өмнөх оноос 36 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нялхсын эндэгдлийн 62.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.5 байна. Нярайн эндэгдлийн нийт 460 тохиолдол бүртгэгдсэний 317 буюу 68.9 хувь нь нярайн эрт үед (амьдралын эхний 0-6 хоногт), 143 буюу 31.1 хувь нь нярайн хожуу үед (амьдралын эхний 7-28 хоногт) эндсэн байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 914 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 тохиолдлоор нэмэгдсэн байна. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 508 тохиолдол буюу 55.6 хувь нь эрэгтэй, 406 тохиолдол буюу 44.4 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Аймгуудаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Увс (27.1), Төв (27.0), Хөвсгөл (24.9), Архангай (23.0), Өвөрхангай (21.8), Булган (21.7), Дорноговь (19.7), Завхан (19.3), Баян-Өлгий (19.2), Өмнөговь (18.9), Говь-Алтай (17.2), Сэлэнгэ (17.2) аймгуудад улсын дундаж үзүүлэлтээс 0.3-10.2 өндөр байна.

Хүснэгт 3.7. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувь, 2025 он

Үзүүлэлт	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Нярайн эрт үеийн эндэгдэл	176	141	317
Нярайн хожуу үеийн эндэгдэл	87	56	143
Нярайн эндэгдэл	263	197	460
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	508	406	914
Амьд төрсөн хүүхдийн тоо	28036	26101	54137

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үеийн эмгэг 57.6 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 16.1 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 8.9 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 3.8. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Стационар) 2025 он

Тэргүүлэх шалтгаанаар	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Мэдрэлийн тогтолцооны өвчин	1.2	3.2	2.2	4.8
Амьсгалын тогтолцооны өвчин	7.1	11.7	7.4	14.5
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	58.4	54.0	19.0	41.1
Төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг	21.0	11.1	19.0	9.4
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	3.5	9.8	9.2	19.8

■ Тэргүүлэх шалтгаан ■ Хоёрдугаар шалтгаан ■ Гуравдугаар шалтгаан

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн эндэгдлийн 85.6 хувь нь өвчнөөр, 14.4 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна. Перинаталь үед үүссэн эмгэг 46.5 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 14.0 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 10.4 хувийг тус тус эзэлж байна.

3.3. ҮР ХӨНДӨЛТ

Ихэнхи эмэгтэйчүүд хүсээгүй үедээ жирэмслэснээс үр хөндүүлдэг. Хөгжиж буй орнуудад хүсээгүй жирэмслэлтийн 84 хувийг орчин үеийн ЖСАХ-ийн хангагдаагүй хэрэгцээтэй эмэгтэйчүүд эзэлдэг. Иймд үр хөндөлтийн хувь хэмжээ нь гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдийн үр ашгийг харуулах чухал үзүүлэлт болдог.

Үр хөндөлт 2025 онд 11 797 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 217.9, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 14.1 үр хөндөлт ногдож байна. Үр хөндөлт өмнөх оноос 879 тохиолдлоор буюу 6.9 хувиар, 1000 амьд төрөлт тутамд 1.6 тохиолдлоор тус тус буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт Өмнөговь (349.5), Дорноговь (322.5), Архангай (239.2) зэрэг аймгууд болон Улаанбаатарт (295.5) байгаа нь улсын дунджаас 21.3-131.6 тохиолдлоор өндөр байна. Мөн хувийн эмнэлэгт хийгдсэн үр хөндөлт өмнөх оноос 371 тохиолдлоор буюу 10.4 хувиар буурсан байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 9.7 байна.



Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 20-иос доош насных 5.3 хувь, 20-34 насных 58.9 хувь, 35-аас дээш насны эмэгтэйчүүд 35.8 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 20-иос доош насны үр хөндөлт 55 тохиодол буюу 9.7 хувиар нэмэгдсэн байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 12.0 хувь нь төрөөгүй ба анх удаа үр хөндүүлсэн тоо өмнөх оноос 407 тохиолдлоор буюу 22.3 хувиар буурсан байна. Умайн агшилт суларч, цус алдалтаар хүндэрсэн 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүснэгт 3.9. Үр хөндөлт, эмнэлгийн төрлөөр, хувь 2025 он

№	Байршил	Бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	Эзлэх хувь
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	1294	11.0
2	Амаржих газрууд	4272	36.2
3	Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв	73	0.6
5	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	754	6.4
6	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1580	13.4
8	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	89	0.8
10	Хувийн эмнэлэг	3167	26.8
11	Бусад эмнэлэг	568	4.8
	Бүгд	11797	100

3.4. ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА ХЭРЭГСЭЛ (ЖСАХ)

Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийг зөв зохистой хэрэглэх нь хэт эрт, хожуу жирэмслэхээс сэргийлэх, хэт ойрхон төрөхгүй, төрөлт хоорондын зайг төлөвлөх, нийт хүүхдийн тоог хязгаарлах зэрэг боломжийг олгодог учир эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндэд нэн чухал юм.


ЖСАХ-ийг дотор нь орчин үеийн болон уламжлалт гэж ангилдаг ба орчин үеийн аргад умайн гуурсан хоолой, эрэгтэй үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, эрэгтэй/эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг болон яаралтай ууж хамгаалах эмийг ууж хамгаалах аргууд хамаардаг.

2025 онд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 49.5 хувь нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна.

Жирэмслэхээс сэргийлэх аргын хэрэглээг төрлөөр нь авч үзэхэд ерөндөг 27.9, бэлгэвч 24.2, бэлдмэл (эм) 17.4, бусад 11.6, тариа 9.3, суулгац (норплант) 6.5, умайн гуурсан хоолойг боох 3.1 хувийг тус тус эзэлж байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэж байсан эмэгтэйчүүдийн 17.8 хувь хэрэглэхээ больж 0.7 хувь нь жирэмсэлсэн байна.

Хүснэгт 3.10. ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүд, хувь, байршлаар, 2025 он

№	Байршил	ЖСАХ хэрэглэж байгаа эмэгтэйчүүдийн тоо	Эзлэх хувь
1	Өрхийн эрүүл мэндийн төв	298121	72.0
2	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	110017	26.6
3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1993	0.5
4	Хувийн эмнэлэг	801	0.2
5	Бусад	2998	0.7
6	Бүгд	413930	100



БҮЛЭГ 4

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ



Эрүүл мэндийн байгууллага



4 968

статистик тайлан
ирүүлсэн байгууллага

Тусламж үйлчилгээ
үзүүлж буй байгууллагууд



14

Төрөлжсөн
мэргэшлийн
эмнэлэг



3

Тусгай
мэргэжлийн
төв



5

Бүсийн
оношилгоо,
эмчилгээний төв



16

Аймгийн
нэгдсэн
эмнэлэг



4

Дүүргийн
нэгдсэн
эмнэлэг



10

Дүүргийн
НЭМ төв



337

Сум, тосгоны
ЭМ төв



228

Өрхийн
ЭМ төв



233

Хувийн ортой
эмнэлэг



1 644

Хувийн
клиник



Хэвтүүлэн эмчлэх ор

29 465

эмнэлгийн ор

2025 оны ашигласан ор




+1 620 ор

10 жилийн
дунджаас



-652 ор

өмнөх оноос



Эмнэлгийн орны ашиглалт

74.0%

Төрийн өмчит

26.0%

Хувийн хэвшил

Нийт ашигласан орноос



10 000 хүнд ногдох орны тоо

85.8

2025 онд



-5.6

5 жилийн
дунджаас



-2.3

өмнөх оноос

БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм хангамж, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн болон хувийн хэвшил, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шударга, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ.

Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын шатлал тус бүрээр харьцуулан дүгнэсэн болно.

Хүснэгт 4.1. Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2025 он

Эрүүл мэндийн байгууллагууд		Аймгийн дүн	Улаанбаатарын дүн	Улсын дүн
Өрхийн эрүүл мэндийн Төв		76	152	228
Тосгоны эрүүл мэндийн Төв		16	4	20
Сумын эрүүл мэндийн Төв	А зэрэглэл	53	-	53
	Б зэрэглэл	113	-	113
	В зэрэглэл	141	-	141
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг		6	-	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг		16	-	16
Дүүргийн нэгдсэн эмнэлэг		-	4	4
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ		-	10	10
Бүсийн оношилгоо эмчилгээний төв		5	-	5
Тусгай мэргэжлийн төв		-	3	3
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг		1	13	14
Амаржих газар		-	3	3
Түргэн тусламжийн төв		-	1	1
Клиник /хувийн/		540	1104	1644
Ортой хувийн эмнэлэг		95	138	233
Сувилал		51	40	91
Эм ханган нийлүүлэх байгууллага		82	61	143
Эмийн үйлдвэр		-	3	3
Эмийн сан		1008	1110	2118
Тусгай эмнэлэг		21	6	27
Бусад		71	21	92
Нийт		2295	2673	4968

2025 онд статистик тайлан ирүүлсэн 4 968 эрүүл мэндийн байгууллагаас хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 14, тусгай мэргэжлийн төв 3, бүсийн оношлогоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв 10, сум, тосгоны эрүүл мэндийн төв 337, өрхийн эрүүл мэндийн төв 228, хувийн ортой эмнэлэг 233, хувийн клиник 1644 байна.



4.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРНЫ ХҮРТЭЭМЖ

Улсын хэмжээнд 2025 онд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний 29 465 эмнэлгийн ор ашигласан бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаас 1620 ороор нэмэгдэж, өмнөх оноос 652 ороор буурсан байна. Үүнээс 74.0 хувь нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 26.0 хувь нь хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор байна.

Хүснэгт 4.2. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний эмнэлгийн орны тоо, 10 000 хүнд, 2016-2025 он

Он	Орны тоо	10 000 хүнд ногдох орны тоо
2016	22960.0	74.3
2017	23897.0	77.1
2018	24884.0	78.8
2019	25661.0	80.4
2020	27083.0	84.0
2021	35310.0	107.6
2022	29629.0	88.7
2023	29443.0	87.0
2024	30117.0	88.1
2025	29465.0	85.8
10 жилийн дундаж	27844.9	85.2

Тайлант онд 10 000 хүн амд дунджаар 85.8 хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ногдож байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.6-оор нэмэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 2.3-оор буурсан байна.

Хүснэгт 4.3. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ашиглалтын хувь, аймгаар, 2025 он

Аймаг/хот	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэг, БОЭТ	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	Дундаж
Архангай	65.5	49.9	51.3
Баян-Өлгий	68.2	37.4	51.9
Баянхонгор	59.3	51.5	55.1
Булган	75.5	51.8	63.7
Говь-Алтай	55.7	33.6	44.9
Говьсүмбэр	76.2	25.2	57.2
Дархан-Уул	66.4	55.9	52.1
Дорноговь	63.2	52.9	56.5
Дорнод	66.4	60.1	61.0
Дундговь	61.9	32.7	48.8
Завхан	54.5	49.1	55.7
Орхон	60.9	48.3	58.3
Өвөрхангай	70.9	52.9	54.1
Өмнөговь	40.4	38.8	40.1
Сүхбаатар	67.6	47.4	58.0
Сэлэнгэ	64.5	44.8	48.3
Төв	68.1	45.8	53.3
Увс	96.2	54.9	64.6
Ховд	77.5	53.6	62.3
Хөвсгөл	58.1	51.4	51.7
Хэнтий	60.9	59.3	60.5
Аймаг дундаж	64.8	48.0	54.3
Улаанбаатар	61.9	65.3	57.8
Улсын дундаж	63.8	48.2	56.2

Улсын хэмжээнд 2025 онд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ашиглалтын хувь улсын дундаж 56.2, эрүүл мэндийн байгууллагын төрлөөр авч үзвэл төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 79.5, аймгийн нэгдсэн эмнэлэгт 65.5, бүсийн оношилгоо эмчилгээний төвд 63.1, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэгт 61.9, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 48.2, хувийн эмнэлгүүдэд 38.6, бусад эмнэлгүүдэд 53.4 хувь тус тус байна.

Хүснэгт 4.4. Эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний орны эзлэх хувь, тасгаар, 2025 он


№	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор тасгаар	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Сум, тосгоны эмнэлэг	Хувийн эмнэлэг	Бусад эмнэлэг	Бүгд
1	Дотор	10.6	11.1	15.1	27.0	45.2	36.8	17.3	25.9
2	Мэс засал	9.8	7.8	7.7	8.1	3.5	9.7	5.6	7.7
3	Төрөх	4.0	9.9	9.8	1.3	10.9	1.1	15.6	6.6
4	Эмэгтэйчүүд	8.5	6.7	5.4	0.3	3.4	3.9	3.9	4.6
5	Хүүхэд	9.8	13.8	13.8	30.3	23.0	4.1	15.4	13.9
6	Халдварт	7.3	5.7	5.0	1.0	9.1	0.0	0.0	3.8
7	Арьс харшил	2.9	2.2	2.2	0.2	0.1	0.8	0.7	1.2
8	Сүрьеэ	4.1	3.4	4.3	0.2	0.1	0.0	1.7	1.7
9	Мэдрэл	3.9	6.5	7.9	11.4	0.9	13.0	5.1	7.4
10	Сэтгэц	11.3	6.1	5.2	0.3	0.1	0.5	2.5	3.4
11	Гэмтэл	11.8	6.6	4.8	2.7	0.1	1.7	3.4	4.1
12	Нефрологи	2.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.9	0.4
13	Урологи	1.8	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.3
14	Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах	3.3	2.1	1.9	4.2	0.4	0.6	1.6	1.8
15	Нүд	1.4	0.4	0.7	0.0	0.0	0.7	0.1	0.5
16	Чих, хамар хоолой	2.1	2.0	1.2	0.0	0.0	1.3	0.2	1.0
17	Эрүү нүүр	1.0	0.5	0.8	0.0	0.0	0.0	0.0	0.3
18	Хавдар	2.3	2.1	1.9	0.2	0.0	0.5	0.0	0.9
19	Уламжлалт эмчилгээ	0.7	5.0	5.7	3.5	1.4	21.2	13.9	9.0
20	Хөнгөвчлөх эмчилгээ	1.1	2.2	2.2	4.7	0.3	2.0	0.2	1.7
21	Бусад	0.6	5.8	4.3	4.4	1.6	2.2	11.7	3.7
22	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний орны эзлэх хувийг тасгаар авч үзэхэд дотрын ор 25.9 хувь хамгийн өндөр, эрүү нүүр, урологийн ор хамгийн бага 0.3 хувь байгаа бол төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт гэмтэл 11.8 хувь, сэтгэц 11.3 хувь, дотор 10.6 хувь хамгийн өндөр, уламжлалт эмчилгээ 0.7, бусад тасаг 0.6 хувь байгаа нь хамгийн бага байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум тосгоны эмнэлэг, хувийн эмнэлэг, бусад эмнэлэгт дотрын ор хамгийн өндөр 15.1-45.2 хувь байгаа нь нийт дотрын орны 80.4 хувийг эзэлж байна.



Зураг 4.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор ашиглалтын хувь, тасгаар, 2025 он



Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний ор ашиглалтын хувь улсын дунджаас эмэгтэйчүүд, хүүхэд, эрүү нүүр, чих, хамар хоолой, арьс харшил, гэмтэл, мэдрэл, нефрологи, урологи, сэтгэцийн тасгуудад 0.5-40.8 хувиар өндөр байна.

Хүснэгт 4.5. Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног, аймгаар, 2025 он

Аймаг/хот	Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт	Сум, тосгоны эрүүл мэндийн төвд	Нийт
Архангай	7.2	6.6	6.9
Баян-Өлгий	6.8	6.4	6.8
Баянхонгор	6.9	6.6	6.8
Булган	7.5	6.6	7.1
Говь-Алтай	6.8	6.9	6.8
Говьсүмбэр	7.1	6.6	7.1
Дархан-Уул	6.6	7.1	6.7
Дорноговь	6.9	7.0	7.0
Дорнод	6.7	6.9	6.8
Дундговь	7.0	6.6	7.0
Завхан	6.5	6.4	6.6
Орхон	6.4	7.0	6.4
Өвөрхангай	6.9	6.5	6.8
Өмнөговь	6.0	6.5	6.3
Сүхбаатар	7.6	7.1	7.5
Сэлэнгэ	7.3	7.2	7.1
Төв	7.7	7.1	7.4
Увс	6.8	6.6	6.7
Ховд	7.5	7.0	7.3
Хөвсгөл	6.2	6.5	6.5
Хэнтий	7.6	6.9	7.2
Аймаг дундаж	6.9	6.8	6.9
Улаанбаатар	6.2	6.8	6.4
Улсын дундаж	6.7	6.8	6.6

Хэвтэн эмчлүүлэгчдийн дундаж ор хоног улсын дундажаар 6.6, Улаанбаатарт 6.4, аймгийн дундаж 6.9 байна.

4.3. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь хүн амд чиг үүргийн дагуу нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах үйл ажиллагааг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

Монгол орны цаг уурын эрс тэс уур амьсгалын улмаас өвөл, хаврын улиралд амьсгалын замын өвчлөл нэмэгддэг нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Хүснэгт 4.6. Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо, 2016-2025 он

Он	Улаанбаатар	Аймгийн дүн	Улсын дүн
2016	133	87	220
2017	133	85	218
2018	135	84	219
2019	131	78	209
2020	131	78	209
2021	131	77	208
2022	131	76	207
2023	148	76	224
2024	151	76	227
2025	152	76	228
10 жилийн дундаж	138	79	217


Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 228 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 152 өрхийн эрүүл мэндийн төв, орон нутагт 76 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Улсын хэмжээнд 2025 онд нийт 67360 эрүүл мэндийн ажиллагчид байгаагаас 3862 нь өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт ажиллагчдын 1298 буюу 33.6 хувь нь их эмч, 1284 буюу 33.2 хувь нь сувилагч, 4.4 хувь нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, 28.8 хувь нь бусад ажилчид байна. Их эмч сувилагчийн харьцаа өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 1.0:1.0 байна.




Зураг 4.2. Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмчийн тоо, 2016-2025 он




Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа их эмчийн тоо сүүлийн 10 жилийн дунджаас 167 эмчээр, өмнөх оноос 3 эмчээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4.3. Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагчийн тоо, 2016-2025 он



Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа сувилагчийн тоо сүүлийн 10 жилийн дунджаас 207 сувилагчаар, өмнөх оноос 26 сувилагчаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4.4. Өрхийн хүн амын эрүүл мэндийн байдал, хувиар, 2025 он



Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 228 өрхийн эрүүл мэндийн төв, 751 938 өрхөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаагаас 353 714 буюу 47.0 хувь нь эрүүл өрх, 262 098 буюу 34.9 хувь нь өвчлөлд бага өртөмтгий өрх, 136 126 буюу 18.1 хувь нь өвчлөлд өртөмтгий өрх байна.

Хүснэгт 4.7. Нэг өрхийн эмчид ногдох үзлэг, нэг иргэний үзүүлсэн тоо, 2016-2025 он

Он	Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо
2016	2.9	6298.9
2017	2.8	6006.7
2018	3.0	5634.5
2019	2.7	5777.1
2020	2.6	5039.4
2021	2.4	4859.9
2022	2.7	4960.2
2023	2.8	5066.1
2024	3.0	5495.1
2025	3.0	5540.5
10 жилийн дундаж	2.8	5467.8

Өрхийн эрүүл мэндийн төвд 2025 онд 7.2 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 3 удаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байна. Нийт үзлэгийг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 1040.8 мянган үзлэгээр, өмнөх онтой харьцуулахад 75.4 мянгаар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4.8. Өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн эмчийн үзлэгийн тоо /мян.үзлэг/, 2016-2025 он

Он	Урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	Нийт үзлэг
2016	41.7	6097.4
2017	41.5	5916.6
2018	41.8	5634.5
2019	42.9	5863.7
2020	38.8	5659.2
2021	44.0	5477.1
2022	39.0	6051.4
2023	45.6	6499.8
2024	45.6	7116.1
2025	45.3	7191.5
10 жилийн дундаж	42.6	6150.7

Өрхийн эмчийн нийт үзлэгийн 45.3 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байгаа ба байршлаар нь авч үзвэл Улаанбаатарт 46.0 хувь, харин орон нутагт 43.8 хувь байна.

Өрхийн эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 2.7 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.

2025 оны байдлаар нэг хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хамралтын хувь 96.5 байгаа ба энэ үзүүлэлт Улаанбаатарт 98.3, орон нутагт 93.1 байна.


2025 онд өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад хамрагдсан тав хүртэлх насны хүүхдийн 0.6 хувь нь туранхай, 0.4 хувь нь тураалтай, 0.6 хувь нь өсөлтийн хоцрогдолтой



байсан ба өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь амьсгалын дээд замын цочмог халдвар 69.2 хувийг эзэлж байна.

2025 оны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвд жирэмсний хяналтад 40 416 эмэгтэйчүүдийг шинээр хяналтад авсан ба үүнээс 93.4 хувь нь эрт үеийн хяналтад хамрагдсан байна. Жирэмсний хяналтад шинээр хамрагдсан эхчүүдийн тоо өмнөх оноос 1871 тохиолдлоор буурсан байна.

Зураг 4.5. Өрхийн эрүүл мэндийн төвийн жирэмсний эрт хяналтын хувь, 2016-2025 он



4.4. СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.


Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дүгээр тушаалаар сумын эрүүл мэндийн төвүүдийг аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран А, Б, В гэсэн 3 зэрэглэлд ангилна.

Сумын эрүүл мэндийн төвийн А зэрэглэлд өөрийн сумын иргэдэд өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үзүүлэхээс гадна зэргэлдээх сумын хүн амд 4-өөс доошгүй үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхи бүхий сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна.

Сумын эрүүл мэндийн төвийн Б зэрэглэлд улсын хилийн дагуу болон улсын чанартай автозам, төмөр зам дагуу байрласан, осол гэмтлийн онцгой бүс, уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийн сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна. Сумын эрүүл мэндийн төвийн А болон Б зэрэглэлд ороогүй бусад бүх сумын эрүүл мэндийн төвүүд В зэрэглэлд хамаарагдана.

2025 оны байдлаар А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төв 53, Б зэрэглэлийн 113, В зэрэглэлд хамрагдах сумын эрүүл мэндийн төв 141, тосгоны эрүүл мэндийн төв 20, багийн эмчийн салбар 4, сумын нэгдсэн эмнэлэг 6 байгаа бөгөөд тухайн оны үзүүлэлтэд сумын нэгдсэн эмнэлгийн үзүүлэлтийг оруулж тооцсон болно.

Зураг 4.6. Хүн амын эрүүл мэндийн байдал, 2025 он




Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 337 сум, тосгоны эрүүл мэндийн төв, 309 085 өрхөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаагаас 158 117 буюу 51.2 хувь нь эрүүл өрх, 109 930 буюу 35.6 хувь нь өвчлөлд бага өртөмтгий өрх, 41 038 буюу 13.3 хувь нь өвчлөлд өртөмтгий өрх байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, сумын нэгдсэн эмнэлэгт нийт 8544 ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төвд 20.3 хувь, Б зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд 31.8 хувь, В зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд 34.4 хувь, тосгоны эрүүл мэндийн төвд 5.1 хувь, сумын нэгдсэн эмнэлэгт 8.0 хувь, багийн эмчийн салбарт 0.4 хувь нь тус тус ажиллаж байна.

2025 оны байдлаар сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд их эмч 1377 буюу нийт ажиллагчдын 16.1 хувийг эзэлж байгаа ба сувилагч 2243 /26.3 хувь/, бага эмч 785 /9.2 хувь/, эх баригч 358 /4.2 хувь/, эм найруулагч 120 /1.4 хувь/ тус тус ажиллаж байна.

Зураг 4.7. Сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он



2025 оны байдлаар эмнэлгийн нийт орны 15.7 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төв, сумын нэгдсэн эмнэлэгт ногдож байгаа өмнөх оноос 102 ороор буурсан байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвд жилд 120.2 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2025 онд хэвтэн эмчлүүлэгчдийн тоог сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 11.4 мянгаар, өмнөх онтой харьцуулахад 33.4 мянгаар тус тус буурсан байна.




Хүснэгт 4.9. Стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он

Он	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, мян.хүн	Дундаж ор хоног
2016	122.9	6.7
2017	114.2	6.8
2018	115.0	6.6
2019	114.6	6.6
2020	115.5	6.7
2021	171.5	7.7
2022	142.2	6.8
2023	146.8	6.8
2024	153.7	6.8
2025	120.2	6.8
10 жилийн дундаж	131.7	6.8

Ор ашиглалтын хувь дотор, гэмтлийн тасагт 73.0-94.0 байна. Тус тасгуудад дундаж ор хоног 6.9-7.2 байна.

Зураг 4.8. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он



Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь хүн амын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, Тогтвортой хөгжлийн зорилтын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багц нь эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт, хөнгөвчлөх тусламж, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ зэргээс бүрдэнэ.

Сум, өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 1993 оны А/180 тоот тушаалын дагуу тав хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтээр үзүүлдэг. Мөн Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/147 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгчид лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмч, ажилтнуудтай хамтран эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг хүүхэд, насанд хүрэгчдийн дунд жилдээ нэг эсвэл хоёр жилдээ нэг удаа зохион байгуулан ажилладаг.

2025 онд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 92.8 хувь болж сүүлийн 10 жилийн дунджаас 2.1 хувиар нэмэгдэж, өмнөх онтой харьцуулахад 0.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4.10. Сумын эрүүл мэндийн төвийн жирэмсний эрт хяналтын хувь, 2016-2025 он

Он	Жирэмсний хяналтад шинээр хамрагдсан	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь
2016	21565.0	86.8
2017	22767.0	88.9
2018	22150.0	89.3
2019	21527.0	90.0
2020	20916.0	91.6
2021	18523.0	91.4
2022	17502.0	91.3
2023	14904.0	92.1
2024	13540.0	92.9
2025	11894.0	92.8
10 жилийн дундаж	18528.8	90.7

2025 оны байдлаар сум, тосгоны эрүүл мэндийн төвд 2.9 сая үзлэг хийгдэж, нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2.7 байна. Эмчийн үзлэгийн тоо сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 459.1 мянгаар, өмнөх онтой харьцуулахад 173.6 мянгаар нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн 40.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 8.2 хувийг идэвхитэй хяналт, 39.0 хувийг өвчний учир амбулаторийн үзлэг, 12.7 хувийг гэрийн үзлэг эзэлж байна.

Хүснэгт 4.11. Сумын эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэг, 2016-2025 он


Он	Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь
2016	2047611	37.3
2017	2101458	38.7
2018	2171085	38.6
2019	2218311	39.5
2020	2477594	35.9
2021	2790630	48.6
2022	2247215	43.9
2023	2443273	35.5
2024	2690810	37.5
2025	2864367	40.1
10 жилийн дундаж	2405235	39.6

2025 онд сум, тосгоны эрүүл мэндийн төвд эхийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 79.0 байгаа нь сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 8.1-оор их байна.

Нялхсын эндэгдлийн 89 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлт тутамд 35.2 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 21.6-оор өндөр байгаа хэдий ч сүүлийн 10 жилийн дунджаас 2.2-оор бага, өмнөх оноос 1.1-оор буурсан байна.



Зураг 4.9. Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он



2025 оны байдлаар сумын эрүүл мэндийн төв, сумын нэгдсэн эмнэлгийн хөгжлийн бэрхшээлийн хяналтад 41913 хүн /нийт хяналтад байгаа хүний 38.6%/ байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр харуулбал 32.9 хувь нь төрөлхийн, 53.4 хувь нь ердийн өвчин, 1.1 хувь мэргэжлээс шалтгаалах өвчин, 3.4 хувь нь зам тээврийн осол, 0.5 хувь нь үйлдвэрийн осол, 6.0 хувь нь ахуйн осол, 2.7 хувь нь бусад ослоос шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Насны бүлгээр харахад 0-17 насны хүүхэд 9.4 хувь, хөдөлмөрийн насны иргэд 71.5 хувь, 19.1 хувь нь тэтгэврийн насныхан эзэлж байна. 15 ба түүнээс дээш насны хяналтад байгаа хүний 25.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 74.4 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй


4.5. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-оос доошгүй чиглэл /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.


2025 оны байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэгт 1292 их эмч, 1900 сувилагч, нийтдээ 5377 эмч, эмнэлгийн ажиллагчид, Улаанбаатар хотын 14 дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 1189 их эмч, 1239 сувилагч, нийтдээ 4247 эмч, эмнэлгийн ажиллагчид байна.

Зураг 4.10. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн их эмчийн тоо, 2016-2025 он



2025 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд 1900 сувилагч ажиллаж байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 51 сувилагчаар нэмэгдсэн хэдий ч өмнөх оноос 79 сувилагчаар буурсан байна. Эмч сувилагчийн харьцаа аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд 1:1.5 байгаа бол дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд 1:1.0 байна.

Зураг 4.11. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сувилагчийн тоо, 2016-2025 он




Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 2025 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2.5 сая байгаа ба нийт эмчийн үзлэгийн 10.2 хувийг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 3.4 сая буюу нийт үзлэгийн 14.0 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт амбулаториор үйлчлүүлэгчдийн дийлэнх нь буюу 76.6 хувь нь өвчний учир ирж үзүүлсэн, 10.2 хувь нь идэвхтэй хяналтын үзлэг эзэлж байна.




Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн амбулаториор үйлчлүүлэгчдийн дийлэнх нь буюу 63.8 хувь нь өвчний учир ирж үзүүлсэн, 12.6 хувь нь идэвхтэй хяналтын үзлэг, 0.1 хувийг гэрийн үзлэг эзэлж байна.

Зураг 4.12. Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо, 2016-2025 он



2025 оны байдлаар нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 12.7 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 9.9 хувиар, өмнөх оноос 1.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Мөн дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 23.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 6.3 хувиар буурч, өмнөх оноос 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 4.13. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь, 2016-2025 он



2025 оны байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэгт эхийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 26.9 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 1.6 доогуур, өмнөх онтой харьцуулахад 8.3-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн түвшин 2025 онд 8.9 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.8-оор нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дундажтай ижил үзүүлэлттэй байна.

Зураг 4.14. Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он



Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 14.1 хувь нь ногдож байгаа бөгөөд 2025 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 4143 байна.


2025 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт 142.0 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 15.5 хувийг эзэлж байна. 2025 онд ор ашиглалтын хувь 65.5 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 9.3 хувиар дээгүүр байна. Дундаж ор хоног 7.0 байгаа ба өмнөх оны мөн үеэс 0.1-ээр буурсан байна.

Хүснэгт 4.12. Аймгийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он

Он	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, мян.хүн	Дундаж ор хоног
2016	142.7	7.3
2017	138.1	7.2
2018	143.1	7.1
2019	142.8	7.1
2020	136	7.1
2021	159.6	7.7
2022	151.1	7.2
2023	153.3	7.1
2024	155.4	7.1
2025	142.0	7.0
10 жилийн дундаж	146.4	7.2




Зураг 4.15. Аймгийн нэгдсэн эмнэлгийн ор ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он



2025 онд дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны тоо 2911 болж, нийт эмнэлгийн орны 9.9 хувийг эзэлж байна.

2025 онд ор ашиглалтын хувь 61.9 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 5.7 хувиар дээгүүр байна. Дундаж ор хоног 6.2 байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаас 0.3, өмнөх оны мөн үеэс 0.2 тус тус буурсан байна.

Зураг 4.16. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн орны ашиглалтын үзүүлэлт, тасгаар, 2025 он




Хүснэгт 4.13. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он

Он	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, мян.хүн	Дундаж ор хоног
2016	109.6	6.8
2017	112.3	6.7
2018	125.1	6.6
2019	129.9	6.5
2020	147.9	5.8
2021	101.4	7.3
2022	125.0	6.4
2023	125.6	6.4
2024	118.1	6.4
2025	105.8	6.2
10 жилийн дундаж	120.1	6.5


2025 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд нас баралтын 1057 тохиолдол бүртгэгдсэнээс хоног болоогүй нас баралтын эзлэх хувь 27.5 байгаа нь сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 2.7 хувиар доогуур, өмнөх онтой харьцуулахад 0.7 хувиар буурсан байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд 942 нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 17.4 хувь нь эмнэлэгт хоног болоогүй нас барсан ба энэ үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар буурч, сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтээс 5.0 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 4.17. Хоног болоогүй нас баралтын хувь, 2016-2025 он



Зураг 4.18. Аймгийн нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралт, шалтгаан, хувиар, 2025 он






Зураг 4.19. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн хоног болоогүй нас баралт, шалтгаан, хувиар, 2025 он



4.6. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

Зураг 4.20. БОЭТ-ийн хүний нөөцийн үзүүлэлт, 2016-2025 он




БОЭТ-д 2025 онд нийт 2 247 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байгаагаас их эмч 546 (24.3%), сувилагч 824 (36.7%), эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан 318 (14.2%) тус тус ажиллаж байна. БОЭТ-ийн хүний нөөцийг 2016 онтой харьцуулбал нийт ажилчид 15.5, их эмч 21.6, сувилагч 16.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4.21. БОЭТ-ийн их эмч мэргэшлийн төрөл, хувиар, 2025 он



БОЭТ-ийн нийт эмч нарын 11.2 хувийг дотрын, 9.9 хувийг хүүхдийн, 8.6 хувийг эх барих эмэгтэйчүүдийн эмч эзэлж байна.

Зураг 4.22. БОЭТ-ийн сувилагч мэргэшлийн төрөл, хувиар, 2025 он






Хүснэгт 4.14. БОЭТ-ийн стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлт, 2016-2025 он

Он	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, мян.хүн	Эмнэлгийн орны тоо
2016	57.1	1539.0
2017	54.8	1681.0
2018	56.3	1682.0
2019	59.0	1692.0
2020	54.1	1870.0
2021	65.2	2246.0
2022	65.0	1914.0
2023	64.2	1859.0
2024	63.3	1801.0
2025	59.3	1741.0
10 жилийн дундаж	59.8	1802.5

Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд 2025 онд 1 741 (5.9%) ор ашиглаж, өмнөх онтой харьцуулахад 60 (3.3%) ороор буурсан байна. Тухайн онд 59.3 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн ба нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 6.5 хувийг эзэлж байна. БОЭТ-ийн ор ашиглалтын хувь 63.1 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 6.9 хувиар өндөр байна.

Зураг 4.23. БОЭТ-д хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, дундаж ор хоног, тасгаар, 2025 он



БОЭТ-д 2025 онд хэвтэн эмчлүүлэгчдийн дийлэнх хувийг хүүхдийн тасаг 17.6, төрөх 13.4, дотор 11.3, мэс засал 10.1, гэмтлийн тасаг 7.0 хувийг эзэлж байна. 2025 оны БОЭТ-ийн дундаж ор хоног 6.8 байгаа ба сүрьеэ, эрчимт эмчилгээ сэхээн амьдруулах, сэтгэц, нефролог, мэдрэл, уламжлалт эмчилгээ, арьс харшил, дотор, гэмтэл, хүүхдийн тасгийн дундаж ор хоног 0.2-17.3-аар их байна.


БОЭТ-үүдэд 13 115 (6.5%) мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлснээс 2 026 (15.4%) кесар хагалгаагаар төрүүлэх, 1386 (10.6%) мухар олгойн мэс засал, 1 284 (9.8%) арьс арьсан доорх эдийг зүсэх, 1 227 (9.4%) цөсний хүүдийн цөсний замд хийгдэх мэс заслууд, 1269 (9.7%) хугарал мултралыг засах мэс заслууд тэргүүлж байна.

Зураг 4.15. БОЭТ-ийн хоног болоогүй нас баралтын хувь, дундаж ор хоног, 2016-2025 он

Он	Хоног болоогүй нас баралтын хувь	Дундаж ор хоног
2016	30	7.5
2017	30.3	7.2
2018	30.9	7.2
2019	27.7	7.1
2020	35.7	6.9
2021	22.6	7.5
2022	29.9	6.9
2023	27.8	6.9
2024	29.1	6.9
2025	26.6	6.8
10 жилийн дундаж	29.1	7.1

Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд 2025 онд нийт нас баралтын 462 (2.6%) тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүнээс 123 (26.6%) тохиолдол нь эмнэлэгт ирээд 24 цагийн дотор нас барсан байна. Үүнээс эмнэлгийн тусламж авснаас хойш 8-24 цагийн дотор 62 (50.4%) хувь нь нас барсан байна. Хоног болоогүй нас баралтын хувь 26.6 байгаа нь өмнөх оноос 2.5 хувиар буурч, сүүлийн 10 жилийн дунджаас 2.5 хувиар бага байна.

Зураг 4.24. Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2016-2025 он




Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд 2025 онд амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 1019.7 (4.2%) мянга байгаа нь сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 246.4 мянгаар өссөн, өмнөх онтой харьцуулахад 14.4 мянгаар буурсан байна. Нийт үзлэгийн 74.5 хувийг амбулаторийн үзлэг, 15.4 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 9.6 хувийг идэвхтэй хяналтын үзлэг эзэлж байна. Амбулаториор үйлчлүүлэгчдийн 3.3 хувь нь бүсийн аймгуудаас буюу өвчтөн илгээх хуудсаар ирж үйлчлүүлсэн байна.

БОЭТ-ийн яаралтай тусламжийн тасгаар 95 661 хүн үйлчлүүлсний 65.2 хувь нь 16 ба түүнээс дээш насныхан, 17.7 хувь нь 0-5 насныхан, 17.1 хувь нь 5-16 насны хүүхдүүд эзэлж байна. Яаралтай түргэн тусламжийн тасгаар үйлчлүүлсэн иргэдийн 92.1 хувь нь өөрөө ирж үйлчлүүлсэн бол, 5.4 хувь нь түргэн тусламжаар, 2.2 хувь нь бусад эмнэлгээс, 0.3 хувь нь амбулаториос ирсэн байна. БОЭТ-үүдийн яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэгчдийн 77.3 хувийг 1-3 цаг, 21.1 хувийг 3-12 цаг, 1.6 хувийг 24 цагийн дотор эмчилгээ, оношилгоог шийдвэрлэсэн байна.



Зураг 4.25. Эх, хүүхдийн эндэгдлийн түвшин, 2016-2025 он



Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд 2025 онд 7 059 нярай амьд төрсөн ба үүнээс 180 нь ихэр төрөлт, амьгүй төрөлтийн 32 тохиолдол бүртгэгдсэн байна. Амаржсан эхчүүдээс 2026 (28.9%) мэс заслын аргаар төрж, 23 тохиолдол нь эх барихын хавчуураар, 9 тохиолдолд эхсийг гардаж авсан байна.


БОЭТ-д 2025 онд эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Нялхсын эндэгдлийн 62 тохиолдол бүртгэгдэж 1 000 амьд төрөлтөд 8.8 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.1-оор их, өмнөх оноос 1.3-оор өссөн үзүүлэлттэй байна.

4.7. ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг лавлагаа мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Зураг 4.26. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийн их эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он



Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд 2025 онд нийт 7 440 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байгаагаас их эмч 1 754 (23.6%), сувилагч 2 366 (31.8%), эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан 743 (10.0%) тус тус ажиллаж байна.


Хүснэгт 4.16. Хэвтэн эмчлүүлэгчийн тоо, (мянга), хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2016-2025 он

Он	Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь
2016	146.0	30.2
2017	149.6	20.2
2018	159.5	22.8
2019	157.9	23.0
2020	163.6	18.3
2021	192.8	10.2
2022	192.1	16.6
2023	196.7	15.2
2024	215.7	9.3
2025	192.5	8.2
10 жилийн дундаж	176.6	17.4

Нийт эмнэлгийн орны 4 875 (16.5%) нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ногдож тайланд онд 192.5 (21.0%) мянган хүн хэвтэн эмчлүүлсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 15.9 мянган хүнээр их, өмнөх онтой харьцуулахад 23.2 мянган хүнээр буурсан байна.

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд сүүлийн 10 жилийн дунджаар 176.6 мянган хүн хэвтэн эмчлүүлсний 17.4 хувийг хөдөө орон нутгаас ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2025 онд хөдөө орон нутгаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийг 2016 онтой харьцуулбал 3.7 дахин буурсан байна.

Зураг 4.27. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн дундаж ор хоног, 2016-2025 он




Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн ор ашиглалтын хувь 2025 онд 79.5 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 23.3 хувиар өндөр байна. Дундаж ор




хоног 7.3 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.5-аар бага, өмнөх оноос 0.3-аар өндөр байна. Дундаж ор хоног тасаг бүрээр ялгаатай байгаа ба эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасаг 22.9, сэтгэцийн тасагт 20.9, сүрьеэгийн тасагт 16.8, уламжлалт эмчилгээний тасагт 10.4, нефрологийн тасагт 8.2 байгаа нь улсын дунджаас 0.9-15.6-аар өндөр байна.

Зураг 4.28. Хоног болоогүй нас баралтын хувь, 2016-2025 он



Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 2025 онд нийт нас баралтын 1 909 (10.7%) тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 344 тохиолдол нь эмнэлэгт ирээд 24 цагийн дотор нас барж, 170 (49.4%) тохиолдол нь эмнэлгийн тусламж авснаас хойш 8-24 цагийн дотор нас барсан байна. Хоног болоогүй нас баралт 18.0 хувь байгаа нь өмнөх оноос 1.0 хувиар өсч, сүүлийн 10 жилийн дунджаас 0.9 хувиар бага байна.

Зураг 4.29. Амбулаторид үйлчлүүлэгчдийн тоо, мянган хүнээр 2016-2025 он



Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 2 236.4 мянган (9.2%) эмчийн үзлэг хийгдсэн нь 2016 онтой харьцуулахад 951.1 мянган хүнээр өмнөх онтой харьцуулахад 30.9 мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн 92.0 хувийг өвчний учир үзлэг, 3.3 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 4.7 хувийг идэвхтэй хяналт эзэлж байна. Нийт үйлчлүүлэгчдийн 1.2 хувь нь орон нутгаас илгээх хуудсаар ирж үйлчлүүлсэн байна.

Хүснэгт 4.17. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2025 он

Эмнэлгүүдийн нэр	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралтын хувь
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	316630	21021.5	5.9	16.1
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	204609	15336.0	5.9	21.4
Улсын гуравдугаар төв эмнэлэг	254791	20040.0	6.6	22.1
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	310464	34504.0	6.4	5.4
Хавдар судлалын үндэсний төв	167914	10867.5	5.6	18.6
Халдварт өвчин судлалын үндэсний төв	111193	15274.5	8.8	7.1
Гэмтэл согог судлалын үндэсний төв	287805	21421.0	7.9	21.4
Арьсны өвчин судлалын үндэсний төв	94940	5029.5	7.2	0.0
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	78274	10054.0	20.9	0.0
Хүүхдийн төв сувилал	651	2606.5	7.0	0.0
Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн	11733	5749.0	6.9	0.0
Монгол Японы эмнэлэг	171486	5603.0	4.5	12.3
Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	26876	0.0	0.0	0.0
Геронтологийн үндэсний төв	21157	0.0	0.0	0.0
Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2	171743	29380.0	6.4	12.5
АШУУИС-ийн төв эмнэлэг	27219	1199.0	5.5	0.0

4.8. ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 50.0 хувийг хувийн эмийн сан, 38.8 хувийг хувийн клиник, 3.4 хувийг эм ханган нийлүүлэх байгууллага, 5.5 хувийг ортой хувийн эмнэлэг, 2.2 хувийг сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв эзэлж байна. Эдгээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 29.3 мянган ажиллагчид байгаагаас 34.0 хувь нь хувийн клиникт, 31.4 хувь нь эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад, 26.3 хувь нь ортой хувийн эмнэлэгт, 7.9 хувь нь сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төвд тус тус ажиллаж байна.

Хүснэгт 4.18. Хувийн хэвшлийн эмнэлгийн тоо, 2016-2025 он

Он	Ортой эмнэлгийн тоо	Хувийн клиник
2016	234	1076
2017	240	1226
2018	243	1340
2019	237	1444
2020	241	1491
2021	239	1548
2022	215	1458
2023	216	1466
2024	229	1588
2025	233	1644
10 жилийн дундаж	233	1428

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 233 ортой хувийн эмнэлэг, 1 644 хувийн клиник үйл ажиллагаа явуулж хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Ортой хувийн эмнэлгийн тоо сүүлийн 10 жилийн дундажтай ижил байна. Хувийн клиникийн тоо



сүүлийн 10 жилийн дунджаас 216-аар нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 33.8 хувь нь хөдөө орон нутагт, 66.2 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 4.19. Хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх орны тоо, 2016-2025 он

Он	Эмнэлгийн орны тоо	Нийт оронд эзлэх хувь
2016	5611	24.4
2017	5756	24.1
2018	5985	24.1
2019	6205	24.2
2020	7291	26.9
2021	6709	19.0
2022	7352	24.8
2023	7508	25.5
2024	8192	27.2
2025	7664	26.0
10 жилийн дундаж	6827.3	24.6

Хувийн хэвшлийн эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх орны тоо 2016 онд 5 611 байсан бол 2025 онд 7 664 болж 2.1 мянгаар нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 26.0 хувийг эзэлж байна.


Хүснэгт 4.20. Хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, мянган хүн, 2016-2025 он

Он	Эмнэлэгт хэвтсэн хүний тоо	Дундаж ор хоног
2016	159.2	7.2
2017	167.9	7.0
2018	177.5	7.0
2019	181.9	6.9
2020	184.1	6.7
2021	197.8	6.6
2022	218.9	6.3
2023	238.3	6.3
2024	238.7	6.0
2025	188.8	5.7
10 жилийн дундаж	195.3	6.6

Хувийн эмнэлгүүдэд 238.7 (22.9%) мянган хүн хэвтэн эмчлүүлсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 48.1 мянга, 2015 онтой харьцуулахад 96.6 мянган хүнээр тус тус нэмэгдсэн байна. Тухайн онд ор ашиглалтын хувь 48.0 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 16.1 хувиар бага буюу орны ачаалал харьцангуй бага байгаа ч эмнэлэг тус бүрээр ялгаатай байна.

Дундаж ор хоног 2015 онд 7.0 байсан бол 2024 онд 6.0 болж буурсан байна. Орны эргэлт 29.1 байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 5.6-аар бага байна.

Зураг 4.30. Амбулаториор үйлчлүүлэгдийн тоо, мянган хүн, 2016-2025 он



Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2025 онд амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо 4 102.4 (16.8 %) мянга байгаа нь өмнөх онтой харьцуулахад 75.1 мянган хүнээр бүүрч, сүүлийн 10 жилийн дунджаас 1087.6 мянган хүнээр нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн дийлэнх нь буюу 91.0 хувь нь өвчний учир ирж үйлчлүүлсэн байна.

Хүснэгт 4.21. Хувийн эмнэлгийн орны хүчин чадлын үзүүлэлт, 2025 он

Үзүүлэлт	Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
5-8 ортой	5	2.1	315	0.2
9-12 ортой	25	10.7	6735	3.6
13-19 ортой	44	18.9	17583.5	9.3
20-25 ортой	43	18.5	28094	14.9
26-39 ортой	46	19.7	30230	16.0
40-49 ортой	26	11.2	26217.5	13.9
50 ба түүнээс дээш ортой	44	18.9	79673	42.2
Нийт дүн	233	100.0	188848	100.0

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны хүчин чадлаар ангилж авч үзвэл тайлант онд 31.8 хувь нь 20-оос доош ортой, 38.2 хувь нь 20-40 ортой, 30.0 хувь нь 40-өөс дээш ортой эмнэлэг эзэлж байна. 2016 онтой харьцуулахад 20-оос доош ортой эмнэлгийн тоо 16.9 хувиар бүүрсан байна.



БҮЛЭГ 5

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

Нийт ажиллагчид



67.4
мянга



95.0%
— эрүүл мэндийн салбарын ажиллагчид

5.0%
— бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид



+8.6 мянга

сүүлийн 10 жилийн дунджатай харьцуулахад



+15.7

10 000 хүн амд




+0.3

өмнөх онтой харьцуулахад

Байгууллагын өмчийн хэлбэр



эрүүл мэндийн салбарт ажиллаж буй нийт ажилтануудын



56.5%
— төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагад

43.5%
— хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад

Эмнэлгийн төрлөөр



Хувийн клиник

14.8%



Хувийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага

13.8%



Сум, тосгоны эрүүл мэндийн төв

12.7%



Ортой хувийн эмнэлэг

11.4%



Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг

10.7%

Хүйс ба насны бүтэц




82.4%
Эмэгтэй



17.6%
Эрэгтэй

Насны бүлгээр



Газарзүйн байршил



1	Улаанбаатар	59.2%
2	Хангайн бүс	13.7%
3	Төвийн бүс	12.0%
4	Баруун бүс	10.5%
5	Зүүн бүс	4.6%




Нийт ажиллагчдын **59.2** хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байна.

БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

5.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛЛАГЧИД

2025 оны байдлаар эрүүл мэндийн салбарт нийт 67.4 мянган ажиллагчид Монгол улсад оршин суугаа 3.425.2 мянган хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад нийт ажиллагчдын тоо 8.6 мянгаар буюу 10 000 хүн амд 15.7-оор, өмнөх онтой харьцуулахад 0.3-оор тус тус нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдаас 95.0 хувь нь эрүүл мэндийн салбарын, 5.0 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна.


Зураг 5.1. Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд ногдох, 2016-2025 он



Эрүүл мэндийн ажиллагчдын дийлэнх нь буюу 82.4% нь эмэгтэйчүүд 17.6% нь эрэгтэйчүүд байгаа ба 2025 онд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2016 онтой харьцуулахад 0.6 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн ажиллагчдыг хүйсээр харьцуулбал баруун бүсийн аймгуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дунджаас харьцангуй бага буюу 76-83 хувь байна. Төв, Хангайн бүсийн аймгуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт ажиллагчдын 20.6 хувийг 30 хүртэлх насны, 34.3 хувийг 30-39 насны, 21.2 хувийг 40-49 насны, 10.5 хувийг 50-54 насны, 7.2 хувийг 55-59 насны, 6.3 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна. Насны бүлгийг хүйсээр зураг 5.2-т харуулав.


Зураг 5.2. Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлгээр, хүйсээр, 2025 он



Мэргэжлийн төрөл бүрээр насны ангилал харилцан адилгүй байгаа бөгөөд эх баригч нарын 22.8 хувь, эм зүйчид 31.8, сувилагч 23.3, их эмч нарын 23.0 хувь нь 30 хүртэлх насныхан эзэлж байна.



Зураг 5.3. Эрүүл мэндийн ажиллагчид, насны бүлэгт эзлэх хувь, мэргэжлийн төрлөөр, 2025 он



Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан 1597 буюу нийт ажиллагчдын 2.4 хувийг эзэлж байгаа ба насны ангиллаар харуулбал, 2.5 хувийг 30 хүртэлх насны, 27.8 хувийг 30-39 насны, 32.4 хувийг 40-49 насны, 13.3 хувийг 50-54 насны, 11.3 хувийг 55-59 насны, 12.6 хувийг 60-аас дээш насныхан эзэлж байна. Удирдах ажилтнуудын 11.6 хувь магистрын зэрэгтэй ба үүнээс 1.8 хувь нь тухайн жилд зэрэг хамгаалсан ба 2.5 хувь нь докторын зэрэгтэй байна. Мөн мэргэжлийн зэргээр харуулбал 5.8 хувь нь ахлах, 5.0 хувь нь тэргүүлэх зэрэгтэй байна.

Эрүүл мэндийн ажиллагчдын 23.9% их эмч, 22.4% сувилагч, 7.1% эм зүйч, 3.4% эм найруулагч, 2.3% бага эмч, 2.1% лабораторийн техникч тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн бус дээд мэргэжилтэн нийт ажиллагчдын 7.8 хувийг эзэлж байгаа ба мэдээллийн технологийн мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер тус тус 0.5 хувийг эзэлж байгаа ба нийт ажиллагчдын 17.9 хувь нь тогооч, жолооч, үйлчлэгч зэрэг бусад ажилтнууд байна.


5.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАГЧИД БАЙРШЛААР

Эрүүл мэндийн ажиллагчдыг газарзүйн байршлаар харуулбал, нийт ажиллагчдын 59.2 хувь нь Улаанбаатар хотод байгаа ба Хангайн бүсийн аймгуудад 13.7 хувь, Төвийн бүсэд 12.0 хувь, Баруун бүсэд 10.5 хувь, Зүүн бүсийн аймгуудад 4.6 хувь нь тус тус ажиллаж байна.

2025 оны байдлаар 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажиллагчид 196.2 байгаа нь сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 15.7-оор, өмнөх онтой харьцуулахад 0.3-оор тус тус нэмэгдсэн байна.


10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажиллагчдын тоо Улаанбаатар хотод улсын дунджаас 41.8-оор өндөр, бусад бүсүүдэд улсын дунджаас 24.7-60.4-оор бага байна. Нийт ажиллагчдын тоог бүсээр харьцуулбал, 10000 хүнд ногдох ажиллагчид Баруун бүсэд хамгийн өндөр буюу 175.5, Төвийн бүсэд 155.5, Хангайн бүсэд 154.5 байгаа ба Зүүн бүсэд хамгийн бага буюу 135.8 байна.

Зураг 5.4. Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд, бүсээр, 2025 он



10 000 хүнд ногдох эрүүл мэндийн ажиллагчдын тоог аймгуудаар харьцуулан харуулбал Говь-Алтай аймагт улсын дундаж үзүүлэлтээс өндөр, бусад аймгуудад 10 000 хүн ам тутамд 130-204 эрүүл мэндийн ажиллагчид ногдож байна. Булган, Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Архангай, Хэнтий, Төв аймгуудад хамгийн бага буюу эрүүл мэндийн ажиллагчдын ачаалал өндөр байгаа нь харагдаж байна.

Зураг 5.5. Эрүүл мэндийн ажиллагчид, 10 000 хүнд, аймгаар, 2025 он




Нийт ажиллагчдын 56.5 хувь нь төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад, 43.5 хувь нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна.

Эмнэлгийн төрлөөр харуулбал нийт ажиллагчдын 14.8 хувь нь хувийн клиникт, 13.8 хувь нь хувийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, 12.7 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 11.4 хувь нь ортой хувийн эмнэлэгт, 10.7 хувь нь Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.



Зураг 5.6. Эрүүл мэндийн ажиллагчид, эмнэлгийн төрлөөр, 2025 он



5.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАГЧДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2025 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын шилжилт хөдөлгөөний тайлангаас харахад 15405 хүн шинээр нэмэгдэж орж ирсэн нь өмнөх онтой харьцуулахад 1569 хүнээр бага байгаа ба үүнээс 1526 буюу 9.9 хувь нь тухайн онд сургууль төгсөөд ажилд орсон хүн байна. Мөн 70.2 хувь нь шинээр ажилд орсон, 11.0 хувь нь эрүүл мэндийн байгууллага хооронд шилжиж ирсэн, 8.9 хувь нь жирэмсний болон хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон байна.

2025 онд эрүүл мэндийн ажиллагчдаас 1148 хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон нь ажлаас чөлөөлөгдсөн хүний 6.5 хувийг эзэлж байна. Мөн 0.3 хувь нь нас барсан, 0.1 хувь нь хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг тогтоолгосон ба 5.7 хувь нь бусад шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн байна.


5.4. ИХ ЭМЧ

ДЭМБ-ын Global Health Workforce Statistics мэдээллийн санд тулгуурлан авч үзвэл дэлхийн хэмжээнд 10 000 хүн ногдох их эмчийн тоо 17.2 байгаа бөгөөд бүс нутгуудаар харилцан адилгүй байна. Африкийн бүс нутагт энэ үзүүлэлт ердөө 2.9 байхад Төв, Зүүн Европ болон Төв Азид 38.3 байгаа нь бүс нутгуудын хоорондын тэгш бус байдлыг харуулж байна. Европын орнуудаас Герман, Итали 10 000 хүнд 42-45 эмчтэй байгаа бол АНУ, Их Британи, Франц 31-32 орчим байгаа ба Монгол Улсад 10 000 хүн ногдох их эмчийн тоо 46.0 байна.

Их эмч нарын 1659 буюу 10.3 хувь магистрын зэрэгтэй ба үүнээс 174 нь тухайн жилд зэрэг хамгаалсан ба 0.5 хувь нь докторын зэрэгтэй байна. Мөн мэргэжлийн зэргээр харуулбал 9.6 хувь нь ахлах, 5.7 хувь нь тэргүүлэх, 1.3 хувь зөвлөх зэрэгтэй эмч байна.

Зураг 5.7. 10 000 хүнд ногдох их эмчийн тоо, ДЭМБ тооцооллоор

World
2024



46 in 2024.


Mongolia

2000 – 2024



Монгол Улсад 10 000 хүн ногдох их эмчийн тоо 46.0 байгаа нь бусад улс орнуудаас өндөр үзүүлэлт бөгөөд дэлхийн дундаж (17.2)-аас 2.7 дахин, бүсийн дундаж (23.2)-аас 2 дахин их байна.

Зураг 5.8. 10 000 хүнд ногдох их эмчийн тоо, дэлхийн дундаж болон бүсийн улс орнуудтай харьцуулахад, ДЭМБ тооцооллоор




2025 оны байдлаар нийт 16 093 их эмч Монгол улсад оршин суугаа хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ба 10 000 хүн тутамд 46.9 их эмч ногдож байна. Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 3096 буюу 10 000 хүнд 6.6, өмнөх онтой харьцуулахад 120 эмчээр буюу 10 000 хүн амд ногдох эмчийн тоо 2.6-оор тус тус нэмэгдсэн байна.


Үүнээс хүний их эмч 12 296 байгаагаас 81.3 хувь нь үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байна. Уламжлалт анагаахын эмч 1406, Нүүр амны эмч 2391 байна. Насны бүлгээр авч үзвэл нийт их эмчийн 23.0 хувийг 30 хүртэлх насны, 40.8 хувийг 30-39 насны, 17.0 хувийг 40-49 насны, 6.0 хувийг 50-54 насны, 5.4 хувийг 55-59 насны, 7.8 хувийг 60-аас дээш насны эмч нар эзэлж байна.



Зураг 5.9. Их эмч, насны бүлэгт эзлэх хувь, хүйсээр, 2025 он




Зураг 5.10. 10 000 хүнд ногдох их эмч, сувилагчийн тоо, 2016-2025 он




Их эмчийг мэргэшлийн төрлөөр нь харуулбал: 2000 онд 10 000 хүн амд ногдох дотрын эмч 4.1 байсан бол 2010 онд 2.8 болж буурсан хэдий ч сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ба 2025 онд 4.4 болсон байна.

2025 онд 10 000 хүн амд ногдох мэс засал ба гэмтэл согог заслын эмч 3.3, эх барих эмэгтэйчүүдийн эмч 3.1 байгаа нь 2000 онтой харьцуулахад 1.7 ба 1.0-оор тус тус нэмэгдсэн байна. Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч 1.8 байгаа нь 2000 оноос 1.2, 2010 оноос 0.8-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 5.11. 10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, сонгосон онуудаар




Зураг 5.12. 10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, сонгосон онуудаар



2025 оны байдлаар хүүхдийн эмч 879 ажиллаж байгаа нь 10 000 хүүхдэд 8.1 хүүхдийн эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч 1050 байгаа нь нөхөн үржихүйн насны 10 000 эмэгтэйд тооцоолж үзэхэд 12.6 эмч ногдож байна.


Зураг 5.13. 10 000 хүнд ногдох их эмч, мэргэшлийн төрлөөр, 2025 он



Орон нутагт 10 000 хүнд ногдох их эмч 31.0 байхад Улаанбаатар хотод эмч 63.5 байгаа нь хот суурин газар эмчийн нягтрал ихтэй байгаа нь харагдаж байна. Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад мэс заслын эмч 3.4 дахин, гэмтэл, согог заслын эмч 2.9 дахин, дүрс оношилгоо, нүүр амны эмч 2.3-3.6 дахин тус тус бага байна.



Зураг 5.14. 10 000 хүнд ногдох их эмч, бүс нутгаар, сүүлийн 5 жилээр





Нийт эмч нарын 66.1 хувь нь Улаанбаатар хотод, 33.9 хувь нь аймаг, орон нутагт ажиллаж байна. 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо Улаанбаатар хотод 63.5 буюу улсын дунджаас 16.6-оор их байгаа ба харин баруун бүсэд 14.2, хангайн бүсэд 17.1, төвийн бүсэд 13.6, зүүн бүсэд 20.7-оор тус тус доогуур байна.

5.5. СУВИЛАГЧ, ЭХ БАРИГЧ


ДЭМБ-ын Global Health Workforce Statistics мэдээллийн санд тулгуурлан авч үзвэл дэлхийн хэмжээнд 10 000 хүнд ногдох сувилагч, эх баригчийн дундаж тоо 43.4 байгаа бөгөөд бүс нутгуудаар харилцан адилгүй байна. Африкийн бүс нутагт 10 000 хүнд ногдох сувилагчийн тоо 14.1 байхад Европын бүсэд 76.9 байгаа нь бүс нутгуудын хоорондын тэгш бүс байдлыг харуулж байна. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын 80 ононд хүрэхийн тулд 10 000 хүнд 70.6 сувилагч, эх баригч шаардлагатай гэж тооцоолсон байна.

Зураг 5.15. 10 000 хүнд ногдох сувилагч/эх баригчийн тоо, ДЭМБ-ын тооцооллоор



Монгол Улсын 46.96 үзүүлэлт нь дэлхийн дундажаас давж байгаа хэдий ч бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын зорилтот хэмжээнд хүрэхийн тулд улам нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 5.16. 10 000 хүнд ногдох сувилагч/эх баригчийн тоо, дэлхийн дундаж болон бүсийн улс орнуудтай харьцуулахад, ДЭМБ тооцооллоор



2025 оны байдлаар нийт 15099 сувилагч Монгол улсад оршин суугаа хүн амд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ба 10 000 хүн ам тутамд 44.0 сувилагч ногдож байна.

Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1717 буюу 10 000 хүн амд 3.0-оор нэмэгдсэн, харин өмнөх онтой харьцуулахад 53 буюу 10 000 хүн амд ногдох сувилагчийн тоо 0.3-оор буурсан байна.

Нийт сувилагчийн 54.3 хувь нь бакалаврын, 35.6 хувь нь дипломын боловсролтой ба 10.1 хувь нь туслах сувилагч эзэлж байгаа ба 13.8 хувь нь ахлах зэрэгтэй, 7.8 хувь нь тэргүүлэх зэрэгтэй байна. Насны бүлгээр авч үзвэл 23.3 хувийг 30 хүртэлх насны, 32.9 хувийг 30-39 насны, 19.9 хувийг 40-49 насны, 12.1 хувийг 50-54 насны, 6.8 хувийг 55-59 насны, 5.1 хувийг 60-аас дээш насны сувилагч эзэлж байна.

Сувилагчийг байршлаар авч үзэхэд хөдөө орон нутагт 10 000 хүнд ногдох сувилагч 40.8 байхад Улаанбаатар хотод 49.5 байна.


Зураг 5.17. 10 000 хүнд ногдох сувилагч, бүс нутгаар, сүүлийн 5 жилээр





ДЭМБ-ын зөвлөмжөөр бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын зорилгод хүрэхийн тулд 10 000 хүнд 10-аас доошгүй эх баригч шаардлагатай байдаг бөгөөд Монгол Улсын одоогийн үзүүлэлт энэ хэмжээнээс 3 дахин бага байна. 2025 оны байдлаар 10 000 хүнд ногдох эх баригчийн тоо 3.4 байгаа нь 2016 онтой харьцуулахад 0.2-оор өндөр байна.

Зураг 5.18. Эх баригчийн тоо, 10 000 хүнд, 2016-2025 он




5.6. ИХ ЭМЧ, СУВИЛАГЧИЙН ХАРЬЦАА

Ази-Номхон далайн бүсийн улс орнуудын хувьд 1000 хүн амд ногдох сувилагчийн тоо ихээхэн ялгаатай байгаа ба өндөр орлоготой орнуудад сувилагчийн тоо дунджаар 1000 хүн амд 10 сувилагч ногдож байгаа ба тухайлбал: Японд 12.2, Шинэ Зеландад 11.9, Австрали 11.7 байгаа ба Монгол улсын хувьд 2023 оны байдлаар 1000 хүн амд ногдох сувилагчийн тоо 4.3 байна.

Эмч сувилагчийн харьцаа Ази номхон далайн бүс нутгуудын улс орнуудад 2020 оны байдлаар зураг 5.19-д харуулав.


Зураг 5.19. Эмч, сувилагчийн харьцаа, Ази-Номхон далайн бүсийн орнуудаар харьцуулснаар



Эх сурвалж: OECD Health Statistics 2020; WHO GHO, 2020; National Data Sources (see Annex A).

2025 оны байдлаар манай улсад эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:0.9, Улаанбаатар хотод 1:0.8, аймгийн түвшинд 1:1.3 байгаа нь өмнөх оны түвшинд байна. Эмч, сувилагчийн харьцаа аймаг бүсүүдээр ялгаатай байгаа ба хангай, баруун, зүүн бүсийн аймгуудад 1:1.3-1.4 байгаа бол төвийн бүсийн аймгуудад 1:1.1 байна.

Зураг 5.20. Эмч, сувилагчийн харьцаа, бүс нутгаар, 2025 он



Хүснэгт 5.1. Их эмч, сувилагчийн хүртээмжийн үзүүлэлт, бүс, аймаг, нийслэлээр 2019-2025 он


Аймаг, нийслэл	Нэг их эмчид ногдох хүний тоо										Нэг сувилагчид ногдох хүний тоо				
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2019	2020	2021	2022	2023	2024	2025	
Улсын дундаж	271	259	253	239	226	214	213	250	246	244	248	233	226	227	
Баруун бүс	381	362	362	347	324	315	306	267	264	261	263	240	235	236	
Баян-Өлгий	436	411	401	380	350	332	342	288	278	274	279	248	240	254	
Говь-Алтай	313	282	284	277	269	265	270	217	227	219	219	224	216	213	
Завхан	399	395	395	409	368	373	342	254	259	260	260	238	235	241	
Увс	423	424	404	386	360	358	339	284	270	270	272	244	245	246	
Ховд	334	311	327	298	281	268	252	280	276	272	274	238	234	220	
Хангайн бүс	403	409	403	387	368	346	336	304	298	290	291	275	259	260	
Архангай	464	455	470	462	439	403	381	318	337	336	336	336	310	305	
Баянхонгор	414	437	462	426	392	380	350	288	304	297	297	277	260	260	
Булган	459	418	451	542	477	486	459	299	271	290	290	295	287	276	
Орхон	278	296	271	241	234	223	222	250	249	244	245	209	207	210	
Өвөрхангай	406	393	399	384	347	320	335	332	307	283	283	287	264	260	
Хөвсгөл	490	516	474	467	481	438	409	340	323	307	309	288	264	276	
Төвийн бүс	353	339	341	340	322	304	300	297	290	294	295	281	268	269	
Говь-Сүмбэр	264	311	251	266	255	260	243	300	341	306	307	296	285	285	
Дархан - Уул	366	336	338	321	295	278	272	233	232	227	228	221	211	214	
Дорноговь	280	259	268	278	265	248	270	295	260	286	287	283	254	255	
Дундговь	305	292	316	336	315	288	279	299	297	286	285	313	300	299	
Өмнөговь	306	300	293	301	293	284	269	366	344	376	383	332	312	311	
Сэлэнгэ	437	468	468	428	403	393	374	328	331	343	342	289	278	278	
Төв	437	382	395	405	389	355	360	315	307	301	301	306	307	305	
Зүүн бүс	412	395	400	400	386	382	381	294	292	286	288	278	279	276	
Дорнод	410	420	416	413	373	367	376	285	278	280	282	275	270	270	
Сүхбаатар	430	388	407	415	431	408	400	284	278	268	271	279	284	272	
Хэнтий	400	376	378	377	369	378	373	313	323	310	312	279	284	286	
Улаанбаатар	201	191	184	172	164	156	157	214	211	210	216	205	199	202	

Хүснэгт 5.2. Их эмч, сувилагчийн харьцаа

Аймаг, нийслэл	2019		2020		2021		2022		2023		2024		2025	
	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч
Улсын дундаж	1.0	1.08	1.0	1.1	1.0	1.1	1.0	1.08	1.0	1.1	1.0	0.9	1.0	0.9
Баруун бүс	1.0	1.43	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.43	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.3
Баян-Өлгий	1.0	1.52	1.0	1.5	1.0	1.5	1.0	1.52	1.0	1.5	1.0	1.4	1.0	1.3
Говь-Алтай	1.0	1.44	1.0	1.2	1.0	1.4	1.0	1.44	1.0	1.2	1.0	1.2	1.0	1.3
Завхан	1.0	1.57	1.0	1.5	1.0	1.6	1.0	1.57	1.0	1.5	1.0	1.6	1.0	1.4
Увс	1.0	1.49	1.0	1.6	1.0	1.5	1.0	1.49	1.0	1.6	1.0	1.5	1.0	1.4
Ховд	1.0	1.19	1.0	1.1	1.0	1.2	1.0	1.19	1.0	1.1	1.0	1.1	1.0	1.1
Хангайн бүс	1.0	1.33	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.33	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.3
Архангай	1.0	1.46	1.0	1.4	1.0	1.5	1.0	1.46	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.2
Баянхонгор	1.0	1.44	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.44	1.0	1.4	1.0	1.5	1.0	1.3
Булган	1.0	1.53	1.0	1.5	1.0	1.5	1.0	1.53	1.0	1.5	1.0	1.7	1.0	1.7
Орхон	1.0	1.11	1.0	1.2	1.0	1.1	1.0	1.11	1.0	1.2	1.0	1.1	1.0	1.1
Өвөрхангай	1.0	1.22	1.0	1.3	1.0	1.2	1.0	1.22	1.0	1.3	1.0	1.2	1.0	1.3
Хөвсгөл	1.0	1.44	1.0	1.6	1.0	1.4	1.0	1.44	1.0	1.6	1.0	1.7	1.0	1.5
Төвийн бүс	1.0	1.19	1.0	1.2	1.0	1.2	1.0	1.19	1.0	1.2	1.0	1.1	1.0	1.1
Говь-Сүмбэр	1.0	0.88	1.0	0.9	1.0	0.9	1.0	0.88	1.0	0.9	1.0	0.9	1.0	0.9
Дархан - Уул	1.0	1.57	1.0	1.4	1.0	1.6	1.0	1.57	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.3
Дорноговь	1.0	0.95	1.0	1.0	1.0	0.9	1.0	0.95	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.1
Дундговь	1.0	1.02	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.02	1.0	1.0	1.0	1.0	1.0	0.9
Өмнөговь	1.0	0.84	1.0	0.9	1.0	0.8	1.0	0.84	1.0	0.9	1.0	0.9	1.0	0.9
Сэлэнгэ	1.0	1.33	1.0	1.4	1.0	1.3	1.0	1.33	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.3
Төв	1.0	1.39	1.0	1.2	1.0	1.4	1.0	1.39	1.0	1.2	1.0	1.2	1.0	1.2
Зүүн бүс	1.0	1.40	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.40	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.4
Дорнод	1.0	1.44	1.0	1.5	1.0	1.4	1.0	1.44	1.0	1.5	1.0	1.4	1.0	1.4
Сүхбаатар	1.0	1.51	1.0	1.4	1.0	1.5	1.0	1.51	1.0	1.4	1.0	1.4	1.0	1.5
Хэнтий	1.0	1.28	1.0	1.2	1.0	1.3	1.0	1.28	1.0	1.2	1.0	1.3	1.0	1.3
Улаанбаатар	1.0	0.94	1.0	0.9	1.0	0.9	1.0	0.94	1.0	0.9	1.0	0.8	1.0	0.8

Хүснэгт 5.3. 10 000 хүнд ногдох их эмч, сувилагчийн тоо, аймаг, бүсээр, 2019-2025 он

Аймаг, нийслэл	10 000 хүнд ногдох их эмч										10 000 хүнд ногдох сувилагч				
	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2019	2020	2021	2022	2023	2024	2025	
Улсын дундаж	36.9	38.5	39.5	41.9	44.3	46.7	46.9	40.0	40.7	42.5	41.8	42.8	44.3	44.0	
Баруун бүс	26.3	27.6	27.6	28.8	30.9	31.8	32.7	37.5	37.9	39.9	39.5	41.7	42.5	42.4	
Баян-Өлгий	22.9	24.3	24.9	26.3	28.5	30.1	29.2	34.8	35.9	37.7	37.0	40.3	41.7	39.4	
Говь-Алтай	32.0	35.4	35.2	36.1	37.2	37.8	37.0	46.1	44.0	46.3	46.3	44.6	46.4	46.9	
Завхан	25.1	25.3	25.3	24.5	27.1	26.8	29.3	39.4	38.6	38.5	38.5	42.0	42.6	41.4	
Увс	23.7	23.6	24.8	25.9	27.8	28.0	29.5	35.2	37.1	38.7	38.4	40.9	40.8	40.6	
Ховд	29.9	32.2	30.6	33.6	35.6	37.4	39.7	35.7	36.3	40.5	40.1	42.0	42.8	45.5	
Хангайн бүс	24.8	24.5	24.8	25.8	27.2	28.9	29.8	32.9	33.6	35.7	35.6	36.4	38.6	38.5	
Архангай	21.6	22.0	21.3	21.7	22.8	24.8	26.3	31.5	29.7	30.8	30.8	29.8	32.2	32.8	
Баянхонгор	24.2	22.9	21.6	23.5	25.5	26.3	28.6	34.7	32.9	33.7	33.6	36.0	38.4	38.4	
Булган	21.8	23.9	22.2	18.4	21.0	20.6	21.8	33.4	37.0	33.2	33.2	33.9	34.8	36.2	
Орхон	35.9	33.8	36.9	41.4	42.7	44.8	45.0	40.0	40.1	46.1	45.9	47.9	48.4	47.7	
Өвөрхангай	24.6	25.5	25.0	26.0	28.8	31.3	29.8	30.2	32.6	33.8	33.8	34.9	37.9	38.5	
Хөвсгөл	20.4	19.4	21.1	21.4	20.8	22.9	24.4	29.4	30.9	35.3	35.1	34.8	37.8	36.2	
Төвийн бүс	28.3	29.5	29.3	29.4	31.1	32.9	33.3	33.6	34.5	34.9	34.8	35.6	37.3	37.2	
Говь-Сүмбэр	37.9	32.2	39.8	37.6	39.3	38.4	41.1	33.3	29.3	32.1	32.0	33.7	35.1	35.1	
Дархан - Уул	27.3	29.7	29.6	31.2	33.9	36.0	36.8	43.0	43.1	45.1	44.9	45.2	47.3	46.6	
Дорноговь	35.7	38.6	37.3	36.0	37.7	40.3	37.0	33.9	38.4	36.4	36.3	35.3	39.3	39.2	
Дундговь	32.8	34.3	31.6	29.8	31.7	34.7	35.8	33.5	33.6	29.3	29.3	31.9	33.4	33.5	
Өмнөговь	32.7	33.3	34.1	33.2	34.1	35.2	37.2	27.3	29.1	27.6	27.1	30.1	32.0	32.1	
Сэлэнгэ	22.9	21.4	21.4	23.3	24.8	25.4	26.7	30.4	30.2	32.9	32.9	34.6	35.9	36.0	
Төв	22.9	26.2	25.3	24.7	25.7	28.2	27.8	31.8	32.6	33.7	33.8	32.7	32.5	32.8	
Зүүн бүс	24.3	25.3	25.0	25.0	25.9	26.2	26.2	34.0	34.2	35.6	35.3	36.0	35.9	36.2	
Дорнод	24.4	23.8	24.0	24.2	26.8	27.2	26.6	35.1	36.0	37.1	36.9	36.3	37.0	37.1	
Сүхбаатар	23.3	25.8	24.5	24.1	23.2	24.5	25.0	35.2	36.0	36.9	36.5	35.8	35.2	36.8	
Хэнтий	25.0	26.6	26.5	26.5	27.1	26.4	26.8	32.0	30.9	32.9	32.7	35.8	35.2	34.9	
Улаанбаатар	49.9	52.4	54.2	58.1	60.9	64.0	63.5	46.8	47.4	49.5	48.0	48.8	50.2	49.5	



БҮЛЭГ 6

ХАЛДВАРТ ӨВЧИН



Улаан бурхан



13,846
ТОХИОЛДОЛ

11
НАС БАРАЛТ

45.5%
амьсгалын
замын халдварт
өвчний дундах
эзлэх хувь

Менингококкт халдвар



12
ТОХИОЛДОЛ

Нийт тохиолдлын:

УБ: 8
66.7%

Орон нутаг: 4
33.3%

Сүрьеэ



2,104
ТОХИОЛДОЛ

10,000 хүнд
6.1

10 жилийн
дунджаас

Өмнөх оноос

↓ -862
10,000 хүнд 3.1

↓ -128
тохиолдол

ХДХВ/ДОХ



427
Нийт тохиолдол

39
Шинэ тохиолдол

39
ХАМГИЙН ӨНДӨР
бүртгэгдсэн жил

БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

6.1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор халдварт өвчнийг тандах, сэргийлэх, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг уян хатан, чанартай, хүртээмжтэй, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлэхэд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах замаар халдварт өвчний тархалтыг бууруулах зорилгоор “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийг баталсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлтэд 2025 онд цусан суулга өвчнийг 10 000 хүнд 4.0, сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдлыг 100 000 хүнд 150, төрөлхийн тэмбүүтэй төрсөн нярайн тоо (100 000 амьд төрөлтөнд) 50-с бага, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчний халдварын тархалтыг 1.5 хувиас бага болгох зорилт тавьсан байна.

Энэхүү зорилтыг 2025 оны байдлаар 100 000 хүнд сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол 61.3, төрөлхийн тэмбүүтэй төрсөн нярайн тоо (100 000 амьд төрөлтөнд) 46.2, жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчний халдварын тархалт 1.3 хувь буюу зорилтод түвшинг хангасан боловч 10 000 хүнд цусан суулга халдварт өвчин 4.1 байгаа нь зорилтод үзүүлэлтээс өндөр байна.

6.2. ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар 30 гаруй төрлийн 52.8 мянган халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүн тутамд 154.0 байна. Нийт халдварт өвчний 57.9 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 19.7 хувь нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 11.0 хувь нь гэдэсний халдварт өвчин, 0.3 хувь нь зоонозын халдварт өвчин, 11.1 хувь нь бусад халдварт өвчин тус тус эзэлж байна.

Зураг 6.1. Халдварт өвчний бүтэц (хувиар), төрлөөр, 2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Өмнөх онтой харьцуулахад гэдэсний халдварт өвчин 27.8 хувь нь, бэлгийн замаар дамжих халдварт өвчин 16.9 хувь нь, Зоонозын халдвар 12.3 хувиар тус тус буурсан бол амьсгалын замын халдвар 48.8 хувиар нэмэгдсэн байна.



Тайлант онд амьсгалын замын халдварт өвчин тэр дундаа улаанбурхан, салхинцэцэг өвчний тохиолдол өндөр бүртгэгдсэн байна. Гэдэсний халдварт өвчнөөс гар, хөл, амны өвчин (B08.4), бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс тэмбүү (A50-A53), бусад халдварт өвчнөөс энтеровируст халдвар тодорхойгүй (B34.1), зургаа дахь өвчин (B08.2), вируст үү (B07) зонхилон тохиолдсон байна.

Зураг 6.2. Тэргүүлэх халдварт өвчнүүдийн бүтэц, 2025 он




Тайлбар: Х.Эритема – Халдварт эритема(B08.3), Г.Х.А-ны өвчин – Гар, хөл, амны өвчин(B08.4), Б.Г.Б.Х-ны хордлого – Бактерын гаралтай бусад хоолны хордлого(A05)

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Тайлант онд бүртгэгдсэн халдварт өвчний тэргүүлэх хоёр өвчлөл нь хүйсийн хувьд ялгаагүй боловч эрэгтэйчүүдийн тэргүүлэх 3-р байрт гонококкт халдвар орсон бол эмэгтэйчүүдийн хувьд бусад халдварт өвчин буюу энтеровируст халдвар тодорхойгүй (B34.1), зургаа дахь өвчин (B08.2), вируст үү (B07) зэрэг халдварт өвчин орсон байна. Насны ангилалаар авч үзвэл 0-9 насны хүүхдүүдийн хувьд амьсгалын болон халдварт тууралтат өвчин зонхилж байна. 10-19 насны хүүхдүүдийн хувьд улаан бурхан өвчний тохиолдол 49.2%-г эзэлж байна. 20-34 насны залуучуудын хувьд бэлгийн замын халдварт өвчин зонхилж байна. 35-54 насныхны хувьд тэмбүү, сүрьеэ өвчний халдвар дийлэнх хувийг эзэлж байна. 55-с дээш насны ахмад настны хувьд сүрьеэгийн халдвар тэргүүлж байна.

Зураг 6.3. Халдварт өвчний тохиолдол насны ангилал, хүйсээр (хувиар), 2025 он



Тайлбар: Х.Эритема – Халдварт эритема(В08.3), Г.Х.А-ны өвчин – Гар, хөл, амны өвчин(В08.4), Б.Г.Б.Х-ны хордлого – Бактерын гаралтай бусад хоолны хордлого (А05)


Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Салхинцэцэг, улаан бурхан өвчний тархалт улсын хэмжээнд жигд тархалттай байна.




БЗДХ буюу тэмбүү, гонококкт халдвар дунджаар 3-5-р байрыг эзэлж байна. Улаанбаатар хотод амьсгалын замын халдварт өвчин тэр дундаа улаан бурхан, салхинцэцэг өвчин өндөр бүртгэгдсэн байна. Гар, хөл, амны өвчин, трихомониаз, сүрьеэ зэрэг нь ихэнх аймагт 5–10-р байрыг эзэлж байна. Цусан суулга, хоолны хордлого зарим аймгуудад дээгүүр байр эзэлж байна.

Зураг 6.4. Халдварт өвчний тэргүүлэх тохиолдол, нас баралтын эрэмбэ, өвчний ангилал, аймгаар, 2025 он



Халдарт өвчний шалтгаант нас баралт



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


Хүснэгт 6.1. Халдварт өвчин (бодит тоо, хувь, 10 000 хүнд), төрлөөр, 2025 он

№	Халдварт өвчний бүртгэгдсэн тохиолдлын тоо	ICD-10	Нийт	Эзлэх хувь	10 000 хүнд
Нийт дүн			52 882	100%	154.0
Гэдэсний халдварт өвчин					
№	Бүгд дүн		5 840	100%	17.0
1	Гар, хөл, амны өвчин	B08.4	2 468	42.3%	7.2
2	Цусан суулга	A03	1 421	24.3%	4.1
3	Бактерийн гаралтай бусад хоолны хордлого	A05	921	15.8%	2.7
4	Сальмонеллэз	A02	700	12.0%	2.0
5	Суулгалт халдвар	A09	326	5.6%	0.9
6	Вируст гепатит А	B15	4	0.1%	0.01
Амьсгалын замын халдварт өвчин					
№	Бүгд дүн		30 440	100%	88.7
1	Улаан бурхан	B05	13 846	45.5%	40.3
2	Салхин цэцэг	B01	11 360	37.3%	33.1
3	Сүрьеэ	A15-19	2 104	6.9%	6.1
4	Халдварт эритема	B08.3	1 914	6.3%	5.6
5	Улаан эсэргэнэ	A38	731	2.4%	2.1
6	Ёлом	A46	301	1.0%	0.9
7	Гахайн хавдар	B26	172	0.6%	0.5
8	Менингококкт халдвар	A39	12	0.04%	0.03
Бэлгийн замаар дамжих халдварт өвчин					
№	Бүгд дүн		10 392	100%	30.3
1	Тэмбүү	A50-53	4 366	42.0%	12.7
2	Гонококкт халдвар	A54	3 564	34.3%	10.4
3	Трихомониаз	A59	2 423	23.3%	7.1
4	ХДХВ/ДОХ	B20-B24	39	0.4%	0.1
Зоонозын халдварт өвчин					
№	Бүгд дүн		138	100%	0.4
1	Хачигт рикеттсиоз	A77	68	49.3%	0.2
2	Бруцеллэз	A23	55	39.9%	0.2
3	Хачигт энцефалит	A84	6	4.3%	0.02
4	Хумхаа	B50	6	4.3%	0.02
5	Тарваган тахал	A20	1	0.7%	0.003
6	Боом	A22	1	0.7%	0.003
7	Хачигт боррелиоз	A69	1	0.7%	0.003
Бусад халдварт өвчин					
№	Бүгд дүн		6 276	100%	18.3
1	Мөөгөнцөр	B35-45	1 446	23.0%	4.2
2	Вируст гепатит	B16-19	204	3.3%	0.6
3	Нярайн бактерт үжил	P36	4	0.1%	0.01
4	Бусад		4 622	73.6%	13.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Гэдэсний халдварт өвчний 42.3 хувийг гар, хөл, амны өвчин, амьсгалын замын халдварт өвчний 45.5 хувийг улаан бурхан, бэлгийн замаар дамжих халдварт өвчний 42.0 хувийг тэмбүү, зоонозын халдварт өвчний 49.3 хувийг хачигт рикеттсиозын халдвар эзэлж байна.

Зураг 6.5. Халдварт өвчин, 10 000 хүнд, төрлөөр, 2016-2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Өмнөх онтой харьцуулахад 10 000 хүнд бэлгийн замаар дамжих халдварт өвчин 11.0-оор, гэдэсний халдварт өвчин 4.9-оор, зоонозын халдварт өвчин 0.5-оор тус тус буурсан, амьсгалын замын халдварт өвчин 37.3-оор өссөн байна. 2016 онуудад улаан бурхан* өвчний дэгдэлтээр 53 737 тохиолдол, 2025 онд 13 846 тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүнд амьсгалын замын халдварт өвчний тохиолдлыг эрс нэмэгдүүлсэн байна.

6.3. АМЬСГАЛЫН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Амьсгалын замын халдварт өвчин 2025 онд сүрьеэ, салхин цэцэг, ёлом, улаан эсэргэнэ, гахайн хавдар, менингококкт халдвар, эритема, улаан бурхан зэрэг 8 төрлийн 30440 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 57.9 хувийг эзэлж байна.


Зураг 6.6. Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Тайлант онд амьсгалын замын халдварт өвчин 10 000 хүнд 88.7 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 37.3-оор өндөр байна. Өмнөх онтой харьцуулахад 10 000 хүнд 43.1-оор өндөр байна.

Зураг 6.7. Амьсгалын замын халдварт өвчний бүтэц (хувиар), 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Сүүлийн 10 жилийн байдлаар амьсгалын замаар дамжих халдварын дийлэнх хувийг улаан бурхан, салхин цэцэг, сүрьеэгийн тохиолдол эзэлж байна.

Тайлант онд амьсгалын замын халдварт өвчний 45.5 улаан бурхан, 37.3 салхин цэцэг, 6.9 сүрьеэ, 6.3 халдварт эритема 2.4 улаан эсэргэнэ, 1.0 ёлом, 0.6 гахайн 0.04 менингококкт халдвар тус тус эзэлж байна.

Хүснэгт 6.2. Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), төрлөөр, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Сүрьеэ	13.4	12.2	11.1	11.4	10.4	7.1	7	7	6.5	6.1
Менингококкт халдвар	0.03	0.04	0.04	0.06	0.02	0.01	0.01	0.02	0.01	0.03
Салхин цэцэг	22.6	31.1	25.7	33.4	8.9	0.9	10.4	35.1	35.8	33.1
Улаан бурхан	100.01	0.05	0	0.01	0	0	0	0	0.04	40.3
Улаан эсэргэнэ	4.6	5.8	2.9	2.9	0.8	0.1	0.5	4.1	1.5	2.1
Гахайн хавдар	1.1	0.7	1	0.4	0.3	0.1	0.2	0.6	0.9	0.5
Ёлом	0.5	0.8	0.6	0.8	0.5	0.1	0.3	0.6	0.7	0.9
Халдварт эритема	0.34	0.29	0.15	0.11	0.02	0	0.01	0.03	0.05	5.6
Улаанууд	0.16	0.04	0.01	0.02	0	0.01	0.02	0.01	0.00	0
Нийт	142.7	51	41.5	49	20.9	8.3	18.4	47.4	45.6	88.7

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

2025 онд сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 10 000 хүнд улаан бурхан 26.3-оор, салхинцэцэг 9.4-оор, халдварт эритема 4.9-оор, ёлом 0.3-оор тус тус өссөн байна.

Сүрьеэ 3.1-оор, улаан эсэргэнэ 0.4-оор, гахайн хадвар 0.1-оор тус тус буурсан байна. Менингококкт халдвар сүүлийн 10 жилийн дундажтай ижил түвшинд байна.



Хүснэгт 6.3. Амьсгалын замын халдварт өвчин (10 000 хүнд), бүсээр, 2020-2025 он

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025
Баруун бүс	9.3	4.1	18.5	28.6	31.2	39.1
Хангайн бүс	12.6	5.2	12.2	28.3	48.4	40.5
Төвийн бүс	23.0	8.2	19.7	59.5	53.7	68.4
Зүүн бүс	23.4	10.0	27.2	63.3	55.5	86.2
Улаанбаатар	26.4	10.5	19.1	53.2	44.2	124.6
Улсын дүн	20.9	8.3	18.4	47.4	45.6	88.7


Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Сүүлийн 5 жилийн дунджаас (КОВИД-19-ын халдвар ороогүй) 2025 онд бүртгэгдсэн халдварт өвчин 10 000 хүнд улсын хэмжээнд 50.5-оор, өмнөх оноос 43.1-оор тус тус өссөн байна.

6.3.1. САЛХИНЦЭЦЭГ

Тайлант онд салхин цэцэг халдварт өвчний 11 360 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд 33.1 байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаас 3 623.7 тохиолдол, 10 000 хүнд 9.4-оор өссөн, өмнөх оноос 866 тохиолдол, 10 000 хүнд 2.7-оор тус тус буурсан байна.

Зураг 6.8. Салхин цэцэг (бодит тоо, 10 000 хүнд), 2016-2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Салхин цэцэг халдварт өвчний 52.1 хувь нь эрэгтэй, 47.9 хувь эмэгтэй буюу хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүдэд бага зэрэг өндөр бүртгэгдсэн байна. Насны ангиллаар авч үзвэл 33.9 хувь нь 5 хүртэлх насны, 33.7 хувь нь 5-9 насны, 17.5 хувь нь 10-14 насны хүүхдүүд эзэлж байгаа нь нийт салхин цэцэг халдварт өвчний 85.1 хувийг эзэлж байна.

Халдварт өвчний онош тогтоогдсон байдлаас харахад 11 316 тохиолдлыг эмнэлзүйн шинж тэмдгээр оношилж, 44 тохиолдол нь тархвар судлал, лабораторийн шинжилгээгээр давхар баталсан байна.

Нийгмийн байдлаар нь авч үзвэл нийт өвчлөгчдийн 23.1 хувийг сургуулийн өмнөх насны хүүхдүүд, 41.6 хувийг сургуулийн сурагчид, 3.0 хувийг оюутнууд тус тус байгаа нь нийт халдварын 67.7 хувийг эзэлж байна.

Зураг 6.9. Салхинцэцэг өвчин бүртгэгдсэн сараар (бодит тоо), 2025 он




Эх үүсвэр: Сар тутмын “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл”

Улсын хэмжээнд сард дунджаар 946.7 тохиолдол бүртгэгдсэн ба 1-7, 12 саруудад дунджаас өндөр бүртгэгдсэн байна. 1-7 сард халдварын тохиолдол өндөр бүртгэгдсэн. Салхин цэцгийн хүндрэлээр эндэгдэл бүртгэгдээгүй байна.

6.3.2. УЛААН БУРХАН

Улсын хэмжээнд 2015, 2016 онуудад улаан бурхан өвчний дэгдэлт гарч 53 737 тохиолдол, 139 нас баралт бүртгэгдэж байсан. 2025 онд 13 846 тохиолдол, 11 нас баралт бүртгэгдсэн.

Зураг 6.10. Улаан бурхан (10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


Улаан бурхан халдварт өвчний 54.6 хувь нь эрэгтэй, 45.4 хувь эмэгтэй буюу хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүдэд бага зэрэг өндөр бүртгэгдсэн байна. Насны ангиллаар авч үзвэл 27.4 хувь нь 5 хүртэлх насны, 15.7 хувь нь 5-9 насны, 43.8 хувь нь 10-14 насны хүүхдүүд эзэлж байгаа нь нийт салхин цэцэг тохиолдлын 86.9 хувийг эзэлж байна. 10-с дээш насныханд халдварын тохиолдол өндөр бүртгэгдсэн байна.

Халдварт өвчний онош тогтоогдсон байдлаас харахад 9 818 тохиолдлыг эмнэлзүйн шинж тэмдгээр оношилж, 4 028 тохиолдол нь тархвар судлал, лабораторийн шинжилгээгээр давхар баталсан байна.



Нийгмийн байдлаар нь авч үзвэл нийт өвчлөгчдийн 7.9 хувийг сургуулийн өмнөх насны хүүхдүүд, 63.4 хувийг сургуулийн сурагчид, 4.6 хувийг оюутнууд тус тус байгаа нь нийт халдварын 75.9 хувийг эзэлж байна.

Зураг 6.11. Улаан бурхан өвчин бүртгэгдсэн сараар (бодит тоо), 2025 он




Эх үүсвэр: Сар тутмын “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл”

Улаан бурхан халдварт өвчин 3 сараас эхэлж 5-7 сард оргилдоо хүрээд буурсан байна. Эпидемийн муруйг ажиглавал улс орныг хамарсан дэгдэлт болсонг харуулж байна.

6.3.3. МЕНИНГОКОККТ ХАЛДВАР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн менингококкт халдварын хөдлөлзүйгээс харахад 1974, 1994 онд хүн амыг олноор хамарсан тахалт тархалт гарч 10 000 хүнд 14-19 тохиолдол бүртгэгдэж, 1995 оноос тууштай буурсан хэдий ч 2007 онд бага зэрэг нэмэгдэн 10 000 хүнд 0.6 тохиолдол бүртгэгдэж байсан. Сүүлийн 10 жилийн дунджаар 9 тохиолдол бүртгэгдсэн нь энэ оноос 3 тохиолдоор бага байна. Энэ онд 12 тохиолдол бүртгэгдсэн нь Улаанбаатар хотод 8, хөдөө орон нутагт 4 тохиолдол байна.

Зураг 6.12. Менингококкт халдварын түвшин (10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


6.3.4. СҮРЬЕЭ

Монгол улс нь ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн 37 орноос сүрьеэгийн халдвар өндөртэй орны тоонд ордог. Дэлхийн бусад улс орнуудын адил Монгол Улс 1996

оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлснээр сүрьеэгийн шинээр илэрсэн тохиолдол 1996 оноос хойш тасралтгүй нэмэгдээд 2007 оноос буурах хандлага ажиглагдаж байна. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөг 2025 онд баталж 100 000 хүнд шинэ болон дахилтат сүрьеэг 150 ба түүнээс доош болгох зорилт тавьсан ба энэ онд улсын хэмжээнд 61.3 болж 88.7-оор бага байна.

Энэ онд 2 104 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүнд 6.1 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 862 (10 000 хүнд 3.1) тохиолдлоор, өмнөх оноос 128 тохиолдлоор тус тус буурсан байна. Шинээр бүртгэгдсэн тохиолдлын 61.1 хувь нь эрэгтэй, 38.9 хувь эмэгтэй байгаа ба насны ангиллаар авч үзвэл 1.9 хувь нь 5 хүртэлх насны, 2.4 хувь нь 5-9 насны, 3.0 хувь нь 10-14 насны, 6.9 хувь нь 15-19 насны хүүхдүүд эзэлж байна. Ахмад настан 17.2 хувийг эзэлж байна.

Зураг 6.13. Сүрьеэ өвчний түвшин (10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Эмчилгээ хяналтын өвчтөнөөс сүрьеэгээр нас барсан нийт 119 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 4 тохиолдлоор өссөн байна. Өвчний бүтцээр нь үзвэл: эмэнд мэдрэг 105 (88.2%), эмэнд тэсвэртэй 14 (11.8%) тус тус нас барсан байна.

Хүснэгт 6.4. Сүрьеэгийн өвчний түвшин (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Баруун бүс	5.0	4.7	4.5	4.7	4.6	2.9	4.4	3.0	3.2	3.1
Хангайн бүс	7.6	6.5	6.4	6.5	6.3	4.1	4.0	4.4	5.1	4.6
Төвийн бүс	13.2	13.7	11.3	12.3	9.0	6.3	6.8	7.1	6.4	6.4
Зүүн бүс	14.2	12.5	13.3	14.2	11.3	7.6	8.1	8.3	7.2	6.7
Улаанбаатар	16.2	16.2	14.5	14.5	13.9	9.6	8.8	8.7	7.8	7.3
Улсын дүн	13.4	12.2	11.1	11.4	10.4	7.1	7.0	7.0	6.5	6.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Сүрьеэгийн өвчний тохиолдлыг байршлаар харуулбал Баруун бүс 3.0-оор, Хангай бүс 1.5-оор тус тус улсын дунджаас бага байна. Төвийн бүс 0.3, Зүүн бүс 0.6, Улаанбаатар хотод 1.2-оор тус тус улсын дунджаас өндөр байна. 2016 оноос Улаанбаатар 8.9, Зүүн бүс 7.5, Төвийн бүс 6.8, Хангайн бүс 3.0, Баруун бүс 1.9-оор тус тус буурсан байна.

Сүрьеэгийн шинэ тохиолдлын 1 219 (57.9%) нь Улаанбаатар хотод, 885 (42.1%) нь орон нутагт бүртгэгдсэн ба 81.2% нь уушгины сүрьеэ, 18.8% нь уушгины бус эрхтний сүрьеэ байна.



6.3.5. ХҮҮХДИЙН СҮРЬЕЭ

Сүүлийн 10 жилийн дунджаар 299.5 хүүхэд шинээр сүрьеэгээр өвчилсөн нь нийт сүрьеэгийн халдварын 10.1%-г эзэлж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд 2016 онд хамгийн их буюу 516 хүүхэд бүртгэгдэж байсан бол 2025 онд 154 тохиолдол болж буурсаар байна.

Хүснэгт 6.5 Нийт сүрьеэ (бодит тоо), Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол (бодит тоо, хувиар), 2016-2025 он


Үзүүлэлт	Шинэ сүрьеэ	0-14 насны хүүхэд	Хүүхдийн сүрьеэгийн эзлэх хувь
2016	4045	516	12.8
2017	3779	424	11.2
2018	3498	293	8.4
2019	3624	382	10.5
2020	3329	397	11.9
2021	2331	317	13.6
2022	2355	193	8.2
2023	2357	161	6.8
2024	2232	158	7.1
2025	2104	154	7.3
10 жил дундаж	2965.4	299.5	10.1

Энэ онд 15 хүртэлх насны 154 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн нь нийт тохиолдлын дотор 7.3%-г эзэлж байгаа ба өнгөрсөн оноос 4 тохиолдол (2.6 хувиар), сүүлийн 10 жилийн дунджаас 145.5 тохиолдлоор (0.9 дахин) тус тус буурсан байна. 86.4 хувь нь уушгины сүрьеэ өвчнөөр оношлогдсон байна.

6.4. ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар гэдэсний халдварт өвчний 7037.2 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд 21.8 байна. Сүүлийн 10 жилийн дунджаар гэдэсний халдварын дийлэнх хувийг цусан суулга, гар хөл амны өвчин, бактерийн гаралтай бусад хоолны хордлогын тохиолдол эзэлж байна. 2025 онд бүртгэгдсэн 5 840 тохиолдлыг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 1197.2 тохиолдлоор өссөн байна.

Зураг 6.14. Гэдэсний халдварт өвчний тохиолдол, 10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Улсын хэмжээнд 2025 онд гэдэсний халдварын 6 төрлийн (цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллёзын халдвар, суулгалт халдвар, гар, хөл, амны өвчин, цочмог гепатит А) халдварт өвчин бүртгэгдэж, 10 000 хүн ам тутамд 17.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8-оор буурсан үзүүлэлттэй байна. Гэдэсний халдварт өвчин нийт халдварт өвчний 11.0 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэдэсний халдварын 24.3 хувь нь цусан суулга, 42.3 хувь нь гар, хөл, амны өвчин, 12.0 хувь нь сальмонеллёз, 15.8 хувь нь бактерийн гаралтай хоолны хордлого, 5.6 суулгалт халдвар, 0.07 вируст гепатит А тус тус эзэлж байна. Гэдэсний халдварт өвчнийг бүс нутгаар харьцуулан харахад 10 000 хүнд Улаанбаатар хот 4.4, Баруун бүс 1.1 тохиолдлоор улсын дүнгээс өндөр байна. Төвийн бүс 0.9, Зүүн бүс 1.7, Хангайн бүс 11.7 тохиолдлоор тус тус бага үзүүлэлттэй байна.


Хүснэгт 6.6. Гэдэсний халдварт өвчин (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	10 жил дундаж
Баруун бүс	5.0	4.7	4.5	4.7	4.6	2.9	4.4	3.0	3.2	3.1	6.5
Хангайн бүс	7.6	6.5	6.4	6.5	6.3	4.1	4.0	4.4	5.1	4.6	9.5
Төвийн бүс	13.2	13.7	11.3	12.3	9.0	6.3	6.8	7.1	6.4	6.4	14.2
Зүүн бүс	14.2	12.5	13.3	14.2	11.3	7.6	8.1	8.3	7.2	6.7	19.1
Улаанбаатар	16.2	16.2	14.5	14.5	13.9	9.6	8.8	8.7	7.8	7.3	33.9
Улсын дүн	13.4	12.2	11.1	11.4	10.4	7.1	7.0	7.0	6.5	6.1	21.7

6.4.1. ЦУСАН СУУЛГА ӨВЧИН

Улсын хэмжээнд 2025 онд цусан суулга өвчний 1 421 тохиолдол бүртгэгдсэн 10 000 хүнд 4.1 байгаа ба гэдэсний халдварт өвчний 24.3 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 1625.2 тохиолдол буюу 10 000 хүнд 5.4-оор, өмнөх онтой харьцуулахад 1543 тохиолдол, 10 000 хүнд 4.6-оор тус тус буурсан байна.

Зураг 6.15. Цусан суулга халдварын тохиолдол, 10 000 хүнд, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


Цусан суулга өвчний 50.7 хувь нь эрэгтэй, 49.3 хувь эмэгтэй байгаа ба насны ангиллаар авч үзвэл 45.4 хувь нь 5 хүртэлх насны, 19.4 хувь нь 5-9 насны, 7.0 хувь нь 10-14 насны хүүхдүүд эзэлж байна.3

Цусан суулга өвчний онош тогтоогдсон байдлаас харахад 1 262 (88.8%) тохиолдлыг



эмнэлзүйн шинж тэмдгээр оношилж, 159 (11.2%) тохиолдол нь эмнэлзүй лабораторийн шинжилгээгээр давхар баталсан байна. Нийгмийн байдлаар нь авч үзвэл нийт өвчлөгчдийн 28.5 хувь нь 1 хүртэлх насны буюу гэртээ байдаг хүүхдүүд, 10.8 хувийг цэцэрлэгийн хүүхдүүд, 27.9 хувийг сургуулийн сурагчид эзэлж байгаа дийлэнх буюу 67.3 хувийг эзэлж байна.

Зураг 6.16. Цусан суулга халдварын тохиолдол (бодит тоо), сараар, 2025 он




Эх үүсвэр: Сар тутмын “Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл”

6.4.2. ГЕПАТИТ ВИРУС

Улсын хэмжээнд 2025 оны байдлаар гепатит вирусийн цочмог халдварын 208 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд 0.6 байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 5 тохиолдлоор буурсан байна.

Зураг 6.17. Гепатит вирусийн бүртгэгдсэн тохиолдол, төрлөөр, 2016-2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гепатит вирусийн цочмог халдвар нь 2016 онд хамгийн их буюу 10 000 хүн ам тутамд 1.8 ногдож байсан бол 2017 оноос

тууштай бүүрч байна. Энэ онд бүртгэгдсэн гепатит вирусийн халдварын 1.9 хувийг гепатит А вирусийн халдвар, 34.6 хувийг гепатит В вирусийн халдвар, 44.5 хувийг гепатит С вирусийн халдвар, 12.0 хувийг гепатит вирусийн бусад халдвар тус тус эзэлж байна.

Зураг 6.18. Гепатит вирусийн бүтэц (хувиар), 2025 он



Тайлант онд бүртгэгдсэн тохиолдлын 54.8 хувь нь эрэгтэй, 45.2 хувь нь эмэгтэй, насны ангиллаар авч үзвэл 29.3 хувь нь 20-29 нас, 32.7 хувь нь 30-39 насныхан эзэлж байна. Нийт халдварын 75.5 хувь нь лабораториор оношлогдсон байна. Гепатит вирусийн халдвараар 5 нас баралт бүртгэгдсэн байна.


Нийгмийн байдлаар авч үзвэл нийт тохиолдлын 36.5 хувийг ажил эрхэлдэг, 17.8 хувийг ажилгүй, 8.2 хувийг тэтгэврийн насныхан, 12.5 хувийг малчин, 8.2 хувийг оюутан залуус эзэлж байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

6.5. БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРТ ӨВЧИН

Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол сүүлийн 10 жилийн дунджаар 13333 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд харьцуулахад 41.2 байна. 2025 онд нийт 10 392 тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 2 941 тохиолдол (10 000 хүнд 10.9-оор) бага, өмнөх онтой харьцуулахад 1760 тохиолдол (10 000 хүнд 5.2-оор) бүүрсан үзүүлэлттэй байна.

Зураг 6.19. Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол (10 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


6.5.1. ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР

Тэмбүүгийн халдвар сүүлийн 10 жилийн дунджаар 5748 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд 18.1 байна. Энэ онд тэмбүүгийн халдварын 4366 тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 1041-р, өмнөх оноос 881 тохиолдлоор тус тус бүүрсан үзүүлэлттэй байна.



Энэ онд жирэмсний хяналтад шинээр 53 779 эмэгтэйчүүд хамрагдсанаас тэмбүү өвчний халдвар илрүүлэх шинжилгээг 98.1 хувьд нь хийсэн, үүнээс 1.3 хувьд нь тэмбүү өвчний халдвар илэрсэн байна. Энэ нь “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний хүрэх түвшнээс 0.2 пунктээр доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 6.20. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин (10 000 хүнд), төрлөөр, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

10 000 хүнд тутамд сүүлийн 10 жилийн дунджаас тэмбүү 4.1-оор, заг хүйтэн 3.0-оор, трихомониаз 4.0-оор тус тус бага үзүүлэлттэй байна. Өмнөх онтой харьцуулахад тэмбүү 2.6-оор, заг хүйтэн 1.3-оор, трихомониаз 1.3-оор тус тус буурсан байна.

Хүснэгт 6.7. Бэлгийн замаар дамжих халдвар (10 000 хүнд), бүсээр, 2016-2025 он


Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	10 жил дундаж
Баруун бүс	26.3	32.5	27.4	36.6	36.4	14.9	12.8	13.0	18.1	14.8	23.3
Хангайн бүс	48.8	49.7	63.7	68.8	51.7	36.2	42.7	31.8	28.3	26.7	44.9
Төвийн бүс	37.4	36.3	38.2	42.9	41.6	20.7	21.9	26.2	27.7	28.2	32.1
Зүүн бүс	90.5	112.1	107.5	88.1	72.6	56.6	58.0	52.3	48.1	35.4	72.1
Улаанбаатар	52.0	49.6	48.3	55.8	52.7	27.4	32.6	32.3	43.2	35.3	42.9
Улсын дүн	48.4	49.6	51.1	56.0	50.1	28.5	32.1	30.3	35.5	30.3	41.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Бүс нутгаар сүүлийн 10 жилийн байдлаар 10 000 хүнд Зүүн бүс 12.7-оор, Хангайн бүс 1.6-оор, Улаанбаатар 7.9, Баруун бүс 3.3-оор тус тус бага үзүүлэлттэй байна. Төвийн бүс 0.5-оор өндөр байна.


Сүүлийн 10 жилийн дунджаар нийт халдварт өвчинд бэлгийн замаар дамжих халдвар 36.9 хувь эзэлж байгаа ба 2025 онд бэлгийн замаар дамжих халдвар нь нийт халдварт өвчний 19.7 хувийг эзэлж байна.

Зураг 6.21. Нийт халдварт өвчинд бэлгийн замаар дамжих халдварын эзлэх хувь, 2016-2025 он



Бэлгийн замын халдварт өвчний төрлөөр, сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2011-2012 онд гоноккокт халдвар нийт бэлгийн замаар дамжих халдварын 36.9-38.4 хувийг эзэлж тэргүүлдэг байсан бол 2016-2025 онд тэмбүүгийн халдварын тохиолдол 37.8-43.4 хувийг эзэлж байна.

Зураг 6.22. Бэлгийн замын халдварт өвчин (хувиар), төрлөөр, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Сүүлийн 10 жилийн дунджаас ХДХВ/ДОХ 0.2, тэмбүү 1.4, заг хүйтэн 1.6 пунктээр тус тус өссөн бол, трихомониаз 3.2 пунктээр буурсан.

Улсын хэмжээнд 2025 онд төрөлхийн тэмбүүгийн 25 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн байна. Орон нутгаас Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай аймгуудад тус бүр 1 тохиолдол, Орхон, Төв аймгуудад тус бүр 2 тохиолдол, Улаанбаатар хотод 17 тохиолдол бүртгэгдсэн байна.

6.5.2. ХДХВ/ДОХ-ЫН ХАЛДВАР


Монгол Улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдолын вирусийн халдварын тархалтын түвшин 0.1 хувиас бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд 5.0 хувиас бага байгаа нь нийт хүн амын дунд бага, эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрсөн тархалттай орны тоонд орж байна.

1992 онд Монгол Улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол батлагдсанаас хойш 2025 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 427 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ онд 39 тохиолдол (100 000 хүнд 1.1) шинээр бүртгэгдсэн нь хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн



жил болсон. Сүүлийн 10 жилийн дунджаас 16.2 тохиолдлоор (100 000 хүнд 0.4) өндөр үзүүлэлттэй байна. Нийтдээ 51 нас баралтын тохиолдол бүртгэгдсэн байна (энэ онд нас бүргэгдээгүй).

Зураг 6.23. ХДХВ/ДОХ-ын халдварын тохиолдол (бодит тоо, 100 000 хүнд), 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть


6.6. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Сүүлийн 10 жилийн дунджаар зоонозын халдварт өвчний 298.3 (10 000 хүнд 0.9) тохиолдол бүртгэгдсэнээс 54.3%-г хачгаар дамжих халдварт өвчин эзэлж байна. Сүүлийн жилүүдэд тарваган тахал, боом, галзуугийн халдварын намжмал, хачгаар дамжих халдвар нэмэгдэж, хүмхиа, эбола, зика, денге чичрэг зэрэг өвчин бусад улсаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэл өндөр байна.

Боомын хүний өвчний тохиолдол сүүлийн жилүүдэд буурч, жилд 1-3 тохиолдол бүртгэгдэж байгаа бол хүмхиа өвчин 2009 онд анх бүртгэгдэж, 2025 онд нийтдээ 53 тохиолдол зөөвөрлөгдөн ирсэн.

Улсын хэмжээнд 2025 онд зоонозын халдварт өвчний 138 тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүнд 0.4 байгаа ба сүүлийн 10 жилийн дунджаас 160.3 (10 000 хүнд 0.5) тохиолдлоор үзүүлэлттэй байна.


Зураг 6.24 Зоонозын халдварт өвчин, 10 000 хүнд, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл II боть

Улсын хэмжээнд 2025 онд бүртгэгдсэн зоонозын халдварт өвчний 49.3 хувь хачигт рикеттсиоз, 39.9 хувь бруцеллез, 4.3 хувь хачигт энцефалит, 4.3 хувь хумхаа, 0.7 хувь боом, 0.7 хувь хачигт боррелиоз, 0.7 хувь тарваган тахал тус тус эзэлж байна.

Зураг 6.25. Зоонозын халдварт өвчний бүтэц (хувиар), 2025 он





БҮЛЭГ 7

ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ



ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

10 000 хүн амд, 2025 он



Амьсгалын тогтолцооны өвчин 1855.4



Хоол боловсруулах тогтолцооны өвчин 1805.5



Зүрх-судасны тогтолцооны өвчин 1215.9



Шээс бэлгийн тогтолцооны өвчин 1050.2



Яс булчингийн тогтолцоо болон холбох эдийн өвчин 799.7



ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН

10 000 хүн амд, 2025 он



Амьсгалын тогтолцооны өвчин 480.3



Зүрх-судасны тогтолцооны өвчин 297.2



Хоол боловсруулах тогтолцооны өвчин 265.8



Шээс бэлгийн тогтолцооны өвчин 190.3



Яс булчингийн тогтолцоо болон холбох эдийн өвчин 149.8



ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГСЭД, ХҮЙСЭЭР

10 000 хүн амд, 2025 он

ЭРЭГТЭЙ



10 000 хүн амд

2102.7

ЭМЭГТЭЙ



10 000 хүн амд

3199.3



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХЭВТЭЛТ ЭРЭГТЭЙЧҮҮДЭЭС

1.5
ДАХИН ИХ



АМБУЛАТОРИЙН ӨВЧЛӨЛИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

10 000 хүн амд, 2025 он

■ Эрэгтэй ■ Эмэгтэй



Нийт өвчлөл 8464.8



Амьсгалын тогтолцооны өвчин 1767.2



Хоол боловсруулах тогтолцооны өвчин 1500.9



Зүрх-судасны тогтолцооны өвчин 919.7



Шээс бэлгийн тогтолцооны өвчин 509.8



Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант төрөдийн эмгэг 955.2


БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ

Халдварт бус өвчлөл нь хүн амын зан үйл, нийгмийн хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг бөгөөд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж эмчлэх боломжтой байдаг.

Манай улсын хүн амын өвчлөлийн хэв маягт 1990 оноос өмнө халдварт өвчин давамгайлж байсан бол 1990-ээд оноос эхлэн тархвар зүйн өөрчлөлт орж, хүн амын дунд халдварт бус өвчлөл, үүнээс шалтгаалсан нас баралт нэмэгдсэ эр байна.

2025 онд улсын хэмжээнд хүн амын өвчлөлийн тохиолдол 4.5 саяд (давхардсан тоогоор) хүрч, 2016 оноос 1949.4 мянга, өмнөх оноос 758.8 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 7.1. Хүн амын өвчлөлийн тохиолдол, 1000 хүнд, 10 жилийн дундаж, 2016-2025 он




Тайлбар: Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн өвчлөлийн мэдээллийг оруулав.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

7.1. ХҮН АМЫН АМБУЛАТОРИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Улсын хэмжээнд 2025 онд 10 000 хүнд ногдох амбулаторийн өвчлөлийн түвшин (давхардсан тоогоор) 10437.6 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 622.0-оор нэмэгдэж өмнөх оноос 493.3 -оор буурсан байна. Тухайн онд 10 000 эрэгтэйд 8464.8, эмэгтэйд 12359.3 бүртгэгдсэн байна.


Зураг 7.2. Амбулаторид бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүнд, хүйсээр, 10 жилийн дундаж, 2016-2025 он





Тайлант онд амны хөндийн өвчин нь нийт өвчлөлийн 7.8% хамгийн өндөр шалтгаан болж байгаа бөгөөд шүд цоорох, буйл болон амны хөндийн бусад өвчлөл давамгай байна. Улирлын чанартай томуу, ханиадтай холбоотой амьсгалын дээд замын цочмог өвчин 6.1%-г эзэлж өндөр түвшинд байна. Артерийн даралт ихсэх өвчин 5.3%-г эзэлж байгаа нь насжилт, амьдралын хэв маягтай холбоотойгоор нэмэгдэх хандлагатай байна. Ажил хөдөлмөр, ахуйн болон зам тээврийн осолтой холбоотой биеийн бусад бэртэл нь нийт өвчлөлийн 3.3%-г эзэлж байна. Шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөлөөс бөөрний нефрит өвчин (3.3%) тэргүүлэх хувийг эзэлж байгаа бөгөөд бөөрний үрэвсэлт болон архаг эмгэгүүд түгээмэл байгааг харуулж байна.

Зураг 7.3. Халдварт бус өвчний бүтэц (хувиар), 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II


Тайлант онд бүртгэгдсэн өвчлөлийг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн дунд биеийн бусад бэртэл (5.7%) тэргүүлж, шүд цоорох (4.3%), амьсгалын цочмог өвчин (3.9%) удаалсан байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд даралт ихсэх өвчин (4.4%) хамгийн өндөр хувийг эзэлж, шүд цоорох (4.0%), архаг нефрит (3.6%) зонхилон бүртгэгдсэн байна.

Насны бүлгээр авч үзвэл 0–9 насны хүүхдүүдийн дунд амьсгалын цочмог өвчин (10.8%), шүд цоорох (10.0%), цочмог бронхит (8.4%) зонхилж байгаа нь амьсгалын замын болон амны хөндийн өвчлөл өндөр байгааг харуулж байна. 10–19 насны өсвөр үеийнхний дунд шүд цоорох (10.7%) болон шүдний бусад эмгэг (8.4%) хамгийн өндөр хувь эзэлж, биеийн бусад бэртэл (6.6%) удаалсан байна.

20–34 насны залуучуудын хувьд биеийн бусад бэртэл (6.5%), архаг нефрит (5.1%),

үтрээний үрэвсэл (3.7%) зонхилон бүртгэгдсэн байна. 35–64 насны хүн амын дунд даралт ихсэх өвчин (6.1%) тэргүүлж, архаг нефрит (4.1%), биеийн бусад бэртэл (3.2%) өндөр хувь эзэлж байна. Харин 65 ба түүнээс дээш насны ахмад настны хувьд даралт ихсэх өвчин (11.2%) хамгийн өндөр бүртгэгдэж, тархины судасны үлдэц (5.2%), ишемийн өвчин (4.4%) удаалсан нь зүрх судасны тогтолцооны архаг өвчин давамгайл байгааг харуулж байна.

Зураг 7.4. Амбулаторид бүртгэгдсэн тэргүүлэх 10 өвчлөл, насны ангилал, хүйсээр (хувиар), 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



Тайлант онд дээд замын цочмог халдвар, даралт ихсэх, шүд цооролт, амны хөндийн өвчин болон биеийн бусад бэртэл ихэнх аймагт тэргүүлэх өвчлөлийн шалтгаан болж бүртгэгдсэн байна. Баянхонгор, Орхон, Өмнөговь, Ховд зэрэг аймагт биеийн бусад бэртэл өндөр эрэмбэлэгдсэн бол Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймагт шүд цооролт болон амны хөндийн өвчлөл зонхилон бүртгэгдсэн байна. Мөн Дорнод, Сүхбаатар, Улаанбаатар хотод бөөрний архаг нефрит, харин төвийн бүс болон Улаанбаатар хотод артерийн даралт ихсэх, зүрхний ишеми, чихрийн шижин зэрэг халдварт бус архаг өвчлөл өндөр хувь эзэлж байна.

Зураг 7.5. Амбулаторид бүртгэгдсэн тэргүүлэх 10 өвчлөл, насны ангилал, хүйсээр (хувиар), 2025 он

	Эрэмбэ																			Бүртгэгдээгүй			
	1	2	3-4	5-8	9-14	15+																	
	Улсын дүн	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Улаанбаатар
Дээд замын цочмог халдвар	1	2	2	1	4	3	1	1	1	1	4	2	1	1	1	1	2	2	1	3	4	2	2
Даралт ихсэх	2	1	1	2	1	1	3	6	6	6	1	1	3	2	3	5	1	1	2	2	3	1	4
Шүд цооролт	3	10	6	5	2	6	7	11	2	3	5	4	9	5	7	16	5	6	6	1	2	8	3
Биеийн бусад бэртэл	4	6	19	24	16	5	6	8	13	19	7	11	25	7	23	12	11	14	24	23	23	19	1
Амны хөндий	5	3	4	6	3	2	9	13	3	2	13	3	5	15	6	13	7	8	13	5	1	11	7
Архаг нефрит	6	5	5	3	5	4	4	9	8	14	2	5	7	6	8	11	6	5	5	6	5	7	9
Бронхит	7	4	21	7	17	16	22	2	4	4	8	6	2	3	9	4	16	10	15	4	13	3	16
Гастрит	8	7	8	8	10	7	14	10	14	23	14	8	14	10	12	6	15	11	14	11	8	9	11
Дээд замын цочмог	9	11	15	10	14	11	5	3	10	5	18	9	4	8	5	3	12	4	9	9	6	5	24
Хатгаа	10	8	20	4	12	17	12	7	7	8	6	15	11	12	4	2	4	7	3	12	7	13	23
Ишеми	11	12	23	11	7	8	11	23	16	11	12	10	15	13	13	18	10	9	4	15	9	17	14
Бусад тархины судасны	12	16	14	9	19	23	21	21	15	21	21	20	14	24	22	18	19	12	14	12	22	5	
Арьсны бусад идээт	13	13	16	19	18	14	8	5	9	10	18	8	11	11	9	8	17	19	17	19	6	13	
Томуу	14	9	7	12	8	10	2	4	5	13	3	14	16	4	2	7	13	3	20	22	11	4	25
Бусад хамрын хөндийн	15	25	12	23	9	24	20	19	17	18	23	20	10	17	16	21	25	15	10	20	18	21	6
Нуруу өвдөх	16	18	9	13	22	25	10	24	12	7	15	22	12	22	15	24	21	18	23	13	20	12	12
Мэдрэлийн ёзоор, сүлжээний	17	17	24	15	15	13	24	12	15	21	9	7	24	9	10	10	9	21	8	24	10	10	18
Бамбай	18	15	11	14	23	12	23	18	24	16	20	16	19	25	18	17	17	25	7	16	16	24	10
Чихрийн шижин	19	14	18	20	13	18	17	14	23	20	17	13	21	21	19	15	3	16	21	19	21	18	15
Дунд чих, хөхлөг сэртэн	20	19	13	22	24	21	19	16	20	10	22	24	23	24	14	23	20	20	18	8	15	14	19
Уушги тэлэгдэх, архаг бөглөрөлт	21	20	10	16	6	15	13	22	11	17	11	17	13	16	21	8	14	12	22	10	17	15	22
Бусад үтрээний ба оодойн	22	23	22	18	11	9	16	15	18	12	16	12	6	23	22	19	19	13	16	7	24	23	20
Үений эмгэг	23	24	17	17	20	22	25	20	19	22	25	23	18	19	17	14	23	22	17	18	22	16	17
Бусад мөчний ясны гэмтэл	24	22	25	25	25	20	18	25	25	25	24	25	22	18	25	25	24	23	25	25	25	25	8
Цэсний чулуу	25	21	3	21	21	19	15	17	22	24	19	19	17	20	20	20	22	24	11	21	14	20	21

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

2025 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүнд:

- Амьсгалын тогтолцооны өвчин 1855.4
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 1805.5
- Зүрх-судасны тогтолцооны өвчин 1215.9
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин 1050.2
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг 799.7

Хүснэгт 7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны түвшин ба дундаж, 2016-2025 он

Хугацаа	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
2016	469.9	807.6	1,007.6	1,231.4	1,647.4
2017	511.2	952.4	1,145.6	1,558.8	1,671.4
2018	585.2	932.4	1,149.5	1,548.4	1,712.4
2019	665.9	1,119.6	1,321.3	1,844.8	2,099.4
2020	501.3	761.2	903.1	1,491.9	1,115.7
2021	475.8	682.3	936.5	1,354.2	788.4
2022	658.0	959.5	1,308.9	1,766.7	1,822.6
2023	764.7	1,150.3	1,376.9	2,083.1	1,930.8
2024	820.1	1,088.9	1,340.9	2,010.0	1,848.9
2025	799.7	1,050.2	1,215.9	1,805.5	1,855.4
10 жилийн дундаж	625.2	950.5	1,170.6	1,669.5	1,649.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хүснэгт 7.2. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, байршлаар, дүнд эзлэх хувиар, сонгосон онуудаар

Улсын дүн	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Амьсгалын тогтолцооны өвчин	20.0	17.9	17.8	18.6	13.8	9.3	17	17.1	16.9	17.8
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	14.9	16.7	16.1	16.3	17.8	16.0	16.5	18.5	18.4	17.3
Зүрх, судасны тогтолцооны өвчин	12.2	12.2	12.0	11.7	12.3	11.1	12.2	12.2	12.3	11.6
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	9.8	10.2	9.7	9.9	10.6	8.1	8.9	10.2	10.0	10.1
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	5.7	5.5	6.1	5.9	6.5	5.6	6.2	6.8	7.5	7.7
Бусад	36.9	36.8	37.9	36.9	38.1	50.3	40.1	35.2	35.0	35.6
Улаанбаатар	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Амьсгалын тогтолцооны өвчин	17.7	14.2	14.3	15.2	10.7	7.9	11.6	13.2	12.6	12.3
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	13.2	15.4	14.4	14.9	16.7	15.0	15.3	16.6	16.3	15.6
Зүрх, судасны тогтолцооны өвчин	10.8	10.8	10.0	10.4	10.6	9.8	10.5	11.2	10.7	10.2
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	8.6	9.3	8.7	9.3	9.8	7.4	8.8	10.1	10.4	10.7
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	8.3	8.0	9.4	9.1	8.7	9.1	10	10.8	11.7	11.9
Бусад	41.4	42.3	43.2	41.2	43.5	50.8	43.7	38.1	38.3	39.4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



Тайлант онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл 10000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчин Улаанбаатарт 1696.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 173.6 , орон нутагт 1909.2 байгаа нь 232.5 -оор тус тус буурсан.

Амьсгалын тогтолцооны өвчин Улаанбаатар 133.7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 112.3-оор буурч, харин орон нутагт 2353.6 байгаа нь 124.0-оор нэмэгдсэн байна.

Зүрх судасны тогтолцооны өвчин Улаанбаатарт 1582.9 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 117.7-оор нэмэгдэж, харин орон нутагт 1386.5 байгаа нь өмнөх оноос 62.1-оор буурсан байна.

Шээс бэлгийн тогтолцооны өвчин Улаанбаатарт 1201.5 , орон нутагт 825.1 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 36.0 ба 42.8-оор тус тус буурсан байна.

Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг Улаанбаатарт 1293.5 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 48.7-оор буурч харин орон нутагт 328.9 ногдож байгаа ба нь өмнөх онтой харьцуулахад 1.0-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

10 000 эмэгтэй хүн амд ногдох амбулаторт бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1.5 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл осол гэмтэл эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их, бусад өвчлөлийн тэргүүлэх шалтгаанууд 1.1-3.1 дахин бага байна.

Хүснэгт 7.3. Хүн амын амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйс, байршлаар, 10 000 хүнд, 2025 он

Үзүүлэлт	Нийт өвчлөл	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба бусад гаднынн шалтгаант тодорхой эмгэг
Хүйс						
Эрэгтэй	8464.8	1767.2	1500.9	919.7	509.8	955.2
Эмэгтэй	12359.3	1941.4	2102.2	1504.4	1576.7	648.2
Насны бүлэг						
Эрэгтэй						
20 хүртэлх	9018.7	3102.8	2007.2	85.9	279.2	937.6
20-44	5488.0	579.4	826.5	523.2	405.5	1055.0
45-64	10302.6	1162.6	1497.8	2351.7	798.7	858.4
65 ба түүнээс дээш	19343.8	1547.5	2247.5	5663.2	2235.7	731.0
Эмэгтэй						
20 хүртэлх	8891.9	2978.5	2279.8	81.8	339.2	563.7
20-44	11089.6	1213.1	1560.7	913.6	2475.3	646.4
45-64	17059.9	1372.2	2393.4	3382.4	2164.6	735.0
65 ба түүнээс дээш	23437.4	1552.5	2911.5	2164.6	2064.8	858.4
Байршил						
Хот	10868.2	1332.7	1696.7	1108.9	1158.6	1293.5
Хөдөө	10027.0	2353.6	1909.2	1317.9	946.9	328.9
Бүсээр						
Баруун	11637.7	2088.1	2574.4	1582.9	1201.5	323.1
Хангайн	8424.6	1842.1	1691.2	1386.5	825.1	312.0
Төв	10270.2	2767.5	1630.1	1127.8	941.3	395.2
Зүүн	10751.9	3226.0	1912.1	1092.4	819.2	233.5
Улсын дундаж	10437.6	1855.4	1805.5	1215.9	1050.2	799.7

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар тэргүүлэх 3 шалтгааныг авч үзвэл:

Баруун бүсэд

- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 2574.4
- Амьсгалын тогтолцооны өвчин 2088.1
- Зүрх судасны тогтолцооны өвчин 1582.9

Хангайн бүсэд

- Амьсгалын тогтолцооны өвчин 1842.1
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 1691.2
- Зүрх судасны тогтолцооны өвчин 1386.5

Төвийн болон зүүн бүсэд

- Амьсгалын тогтолцооны өвчин 2767.5 ба 3226.0
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 1630.1 ба 1912.1
- Зүрх судасны тогтолцооны өвчин 1127.8 ба 1092.4 байна.

Мөн амьсгалын тогтолцооны өвчлөл Баруун, Төв болон Зүүн, шээс бэлгийн тогтолцооны өвчин Баруун, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл Баруун болон Зүүн, зүрх судасны тогтолцооны өвчин Баруун болон Хангайн бүсүүдэд улсын дундажтай харьцуулахад өндөр байна.

7.1.1. АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Улсын хэмжээнд 10 000 хүнд ногдох амьсгалын тогтолцооны өвчлөл 1855.4 болж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 206.2-оор, өмнөх онтой харьцуулахад 6.6-оор нэмэгдсэн байна. байна.

Хүснэгт 7.4. Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүнд, байршлаар, 2016 -2025 он

Хугацаа	Улаанбаатар	Аймгийн дүн	Улсын дүн
2016	1632.3	1660.2	1647.4
2017	1520.0	1796.1	1671.4
2018	1571.0	1829.4	1712.4
2019	1960.6	2216.0	2099.4
2020	917.4	1284.5	1115.7
2021	714.2	852.3	788.4
2022	1331.6	2256.9	1822.6
2023	1560.9	2270.2	1930.8
2024	1445.0	2229.6	1848.9
2025	1332.7	2353.6	1855.4
10 жилийн дундаж	1398.6	1874.9	1649.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Байршлаар харуулбал орон нутагт 10 000 хүн амд ногдох өвчлөл 2353.6 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 478.8-оор нэмэгдэж, харин Улаанбаатарт 1332.7 байгаа нь 65.8 -оор буурсан байна.




Хүснэгт 7.5. Амьсгалын тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он

Хугацаа	Эрэгтэй	Эмэгтэй	Улсын дүн
2016	1628.0	1693.0	1647.4
2017	1610.0	1695.0	1671.4
2018	1675.0	1720.0	1712.4
2019	2022.0	2174.0	2099.4
2020	1038.9	1190.4	1115.7
2021	721.1	853.7	788.4
2022	1736.4	1906.3	1822.6
2023	1848.8	2010.4	1930.8
2024	1753.0	1942.1	1848.9
2025	1767.2	1941.4	1855.4
10 жилийн дундаж	1580.1	1712.6	1649.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II


Амьсгалын тогтолцооны өвчлөлийн түвшинг хүйсээр харуулбал, 10 000 эрэгтэйд 1767.2 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 187.7-оор, эмэгтэйд 1941.4 болж, 10 жилийн дунджаас 228.8-оор түс түс өссөн байна.

Зураг 7.6. Амьсгалын тогтолцооны өвчин, бүсээр, 10000 хүнд ногдох, улсын дундаж, 2016, 2025 он



Амьсгалын тогтолцооны өвчлөлийн түвшинг газарзүйн байршлаар нь харуулбал, 2025 оны байдлаар 10 000 хүн амд ногдох өвчлөл Зүүн бүсэд хамгийн өндөр байна.

Зураг 7.7. Амьсгалын тогтолцооны өвчин, насны бүлгээр, тухайн насны 10000 хүнд ногдох, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Амьсгалын тогтолцооны өвчлөлийн түвшинг 2016 онтой харьцуулахад бүх насанд 0.8-1.9 нэмэгдсэн байна. 2025 онд 0-4 хүртэлх насны хүүхдэд хамгийн өндөр буюу нийт өвчлөлийн 30.3 хувийг эзэлж байна. Насны бүлгээр өмнөх онтой /2024/ харьцуулахад өвчлөл 1.0-1.1 дахин жигд нэмэгдсэн байна

Хүснэгт 7.6. Амьсгалын тогтолцооны өвчлөлд эзлэх хувь, хүйсээр, 2016, 2025 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2016			2025		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Амьсгалын дээд замын цочмог халдвар	36.0	36.0	36.0	35.3	33.0	34.1
Томуу	10.4	10.6	10.5	9.5	9.8	9.7
Хатгалгаа	22.0	19.3	20.6	10.5	10.0	10.2
Цочмог бронхит	14.2	12.0	13.1	14.9	12.7	13.7
Уушгины архаг бөглөрөлт өвчин	5.5	7.1	6.3	6.8	8.2	7.6
Бусад өвчин	11.9	15.1	13.5	23.0	26.3	24.7

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Амьсгалын тогтолцооны өвчлөлд амьсгалын дээд замын цочмог халдварууд 34.1 хувьтай тэргүүлж байгаа бөгөөд 2016 онтой харьцуулахад 1.9 хувиар буурсан байна. 2025 оны байдлаар цочмог бронхит 13.7 хувь, уушгины хатгалгаа 10.2, томуу, томуу төст өвчин 9.7, уушгины архаг бөглөрөлт өвчин 7.6 хувьтай тэргүүлж, бусад өвчлөл 24.7 хувийг эзэлж байна.

2016 онтой харьцуулвал, томуу ,томуу төст өвчин 0.8 хувиар, уушгины хатгалгаа 10.4 хувиар буурч, цочмог бронхит 0.7, уушгины архаг бөглөрөлт өвчин 1.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. 2025 онд амьсгалын дээд замын цочмог халдвар, уушгины хатгалгаа эрэгтэйчүүдэд илүү бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7.7. Амьсгалын тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, 2016-2025 он

Хугацаа	Цочмог бронхит	Хатгалгаа	АдЗЦХ
2016	219.0	346.0	605.0
2017	237.0	306.0	529.0
2018	232.0	348.0	558.0
2019	296.0	374.0	647.0
2020	117.8	63.9	387.7
2021	73.1	53.4	222.5
2022	185.3	268.7	645.8
2023	197.8	283.7	680.1
2024	263.1	178.5	637.7
2025	189.7	254.4	632.4
10 жилийн дундаж	201.1	247.7	554.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Амьсгалын дээд замын цочмог халдваруудыг сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 10 000 хүн ам тутамд 77.8-оор, цочмог бронхит 11.4-оор, уушгины хатгалгаа өвчин 6.7-оор тус тус нэмэгдэж, ба өмнөх оноос амьсгалын дээд замын цочмог халдварууд 5.3 -оор, цочмог бронхит 65.3-оор буурч, харин уушгины хатгалгаа 75.9 -оор нэмэгдсэн байна.



7.1.2. ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН

Улсын хэмжээнд 10 000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 1805.5 болж, нийт өвчлөлийн 17.3 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 136.0 -оор нэмэгдэж, өмнөх онтой харьцуулахад 204.5-оор буурсан байна.

Хүснэгт 7.8. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, байршлаар, 2016-2025 он

Хугацаа	Улаанбаатар	Аймгийн дүн	Улсын дүн
2016	1219.6	1241.4	1231.4
2017	1655.8	1478.8	1558.8
2018	1576.5	1525.2	1548.4
2019	1913.6	1786.9	1844.8
2020	1489.0	1494.4	1491.9
2021	1362.5	1347.0	1354.2
2022	1759.6	1772.9	1766.7
2023	1958.4	2197.5	2083.1
2024	1870.3	2141.7	2010.0
2025	1696.7	1909.2	1805.5
10 жилийн дундаж	1650.2	1689.5	1669.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Байршлаар авч үзэхэд сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад Улаанбаатарт 46.5 -оор , орон нутагт 219.7-оор тус тус нэмэгдсэн байна.


Хүснэгт 7.9. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он

Хугацаа	Эр	Эм	Улсын дүн
2016	997.0	1477.0	1231.4
2017	1225.0	1847.0	1558.8
2018	1243.0	1819.0	1548.4
2019	1481.0	2199.0	1844.8
2020	1130.0	1843.8	1491.9
2021	1030.6	1668.6	1354.2
2022	1366.5	2155.2	1766.7
2023	1600.6	2551.8	2083.1
2024	1577.6	2430.5	2010.0
2025	1500.9	2102.2	1805.5
10 жилийн дундаж	1315.2	2009.4	1669.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн түвшин 10 000 эрэгтэй хүн амд 1500.9 болж 10 жилийн дундажаас 185.7-оор нэмэгдэж, өмнөх онтой харьцуулахад 76.7-оор буурсан үзүүлэлттэй байна. Харин 10 000 эмэгтэй хүн амд 2102.2 болж 10 жилийн дундажаас 92.8-оор нэмэгдэж , өмнөх онтой харьцуулахад 328.3-оор буурсан байна.


Зураг 7.8. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, улс, хот, бүсээр, 10 000 хүнд, улсын дундаж, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Баруун бүсийн аймгуудад 2025 оны байдлаар 10 000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчлөл хамгийн өндөр 2574.4 ба 2016 онтой харьцуулахад 2.4 дахин өссөн бол Төвийн бүсийн аймгуудын өвчлөлийн түвшин 1.2 дахин өссөн нь хамгийн бага өсөлттэй байна.

Зураг 7.9. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, насны бүлгээр, 10 000 хүнд ногдох, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн түвшинг насны бүлгээр 2016 болон 2025 оныг харьцуулан харвал 55-59 ба 60-64-с бусад насанд өвчлөл жигд нэмэгдсэн ба 2025 онд 5-9 насанд хамгийн их буюу 3027.4 болж, 2016 оноос 1969.4 -оор, өмнөх онтой харьцуулахад 746.0-оор тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 7.10. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл эзлэх хувь, хүйсээр, 2016, 2025 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2016 он			2025 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин	34.4	38.6	36.9	46.1	43.3	44.5
Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин	15.9	27.6	43.5	15.4	18.5	17.3
Элэгний өвчин	14.4	20.5	34.9	8.1	7.5	7.8
Цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин	11.5	24.6	36.1	12.3	1.6	6.0
Халдварт бус энтерит ба колит	12.1	11.1	23.2	5.0	3.5	4.1
Мухар олгойн өвчин	5.3	6.4	11.6	1.2	1.1	1.1
Хоол боловсруулах тогтолцооны бусад өвчин	6.4	4.2	10.6	12.0	24.3	19.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



Хоол боловсруулах тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2025 онд амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин 44.5 хувьтай тэргүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 7.6 хувиар нэмэгдсэн байна. Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин 17.3 хувь, цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин 7.8 хувь, элэгний өвчин 6.0 хувь, халдварт бус энтерит ба колит 4.1 хувь, мухар олгойн өвчин 1.1 хувийг тус тус эзэлж байна.

2025 оны байдлаар амны хөндий, шүлсний булчирхай ба эрүүний өвчин 2016 оноос 8.3 хувиар, улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин 7.6 хувиар, цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин 30.1 хувиар, элэгний эмгэг 27.1, халдварт бус энтерит ба колит 19.1 хувиар тус тус буурсан байна. Хүйсээр харуулбал, 2025 онд мухар олгойн өвчин, халдварт бус энтерит ба колит, элэгний эмгэг эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.

7.1.3. ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Зүрх судасны тогтолцооны өвчин Монгол улсын хүн амын дунд сүүлийн 30 жилийн хугацаанд нас баралтын тэргүүлэх шалтгаан, өвчлөлийн 3 дахь шалтгаан болсоор байна.

Амбулаторт бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчин нийт хүн амын дунд бүртгэгдсэн өвчлөлийн 11.6 хувийг эзэлж байгаа нь 2016 онтой харьцуулахад 1.3 дахин ихэссэн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 10 жилийн дунджаар 10 000 хүнд харьцуулахад 1170.6 тохиолдол бүртгэгдсэн байна. Зүрх судасны өвчлөл 2025 оны байдлаар 10 000 хүн амд 1215.9 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 45.3-оор нэмэгдэж, өмнөх оноос 125.0-оор буурсан үзүүлэлттэй байна.

Байршлаар харуулбал орон нутагт 10 000 хүн амд ногдох өвчлөл 1317.9 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 99.5-оор нэмэгдэж, Улаанбаатарт 1108.9 болж 8.9 -оор буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7.11. Зүрх, судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, 10 000 хүнд, 2016-2025 он

Хугацаа	Аймгийн дүн	Улаанбаатар	Улсын дүн
2016	1012.5	1001.7	1007.6
2017	1134.3	1159.3	1145.6
2018	1194.5	1095.1	1149.5
2019	1308.5	1336.5	1321.3
2020	967.1	827.9	903.1
2021	976.3	890.3	936.5
2022	1399.8	1206.1	1308.9
2023	1423.6	1326.0	1376.9
2024	1448.6	1226.6	1340.9
2025	1317.9	1108.9	1215.9
10 жилийн дундаж	1218.3	1117.8	1170.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Зүрх судасны тогтолцооны өвчлөлийг бүтцээр нь харуулбал: Артерийн даралт ихсэх өвчин хамгийн түгээмэл бүртгэгдсэн бөгөөд бөгөөд анхдагч даралт ихсэх өвчин 11.2 хувь, даралт ихсэх бусад өвчин 34.0 хувийг эзэлж байгаа бөгөөд нийтдээ өвчлөлийн 45.2 хувийг эзэлж байна. Зүрхний ишеми өвчний тохиолдол нийт өвчлөлийн 15.5 хувийг эзэлж байна.

Зураг 7.10. Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтэц, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хүснэгт 7.12. Зүрх судасны тогтолцооны өвчин, тэргүүлэх шалтгаанаар, 10 000 хүнд, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Артерийн даралт ихсэх өвчлөлийн түвшин, (I11-I15) 10 000 хүнд										
Бүгд	153.8	213.3	267.3	299.4	251.6	285.2	415.7	403.6	469.6	413.6
эрэгтэй	257	249.2	219.9	254.1	155.1	133.9	162.7	147.5	322.7	288.4
эмэгтэй	460.5	448.9	399.3	458.8	293.3	259.8	313.8	283.8	612.4	535.5
Анхдагч даралт ихсэх өвчлөлийн түвшин, (I10) 10 000 хүнд										
Бүгд	360.4	350.9	311.1	357.8	225.2	197.8	239.3	216.6	145.6	135.9
эрэгтэй	257	249.2	219.9	254.1	155.1	133.9	162.7	147.5	104.6	96.9
эмэгтэй	460.5	448.9	399.3	458.8	293.3	259.8	313.8	283.8	185.4	173.9
Зүрхний бусад ишеми өвчлөлийн түвшин (I20, I23-I25), 10 000 хүнд										
Бүгд	360.4	350.9	311.1	357.8	225.2	197.8	239.3	216.6	145.6	135.9
эрэгтэй	257	249.2	219.9	254.1	155.1	133.9	162.7	147.5	104.6	96.9
эмэгтэй	460.5	448.9	399.3	458.8	293.3	259.8	313.8	283.8	185.4	173.9
Тархи судасны бусад өвчлөлийн түвшин (I64-I69), 10 000 хүнд										
Бүгд	110.1	103.6	124.7	151.5	87.2	89.6	142.1	197.3	213.2	186.5
эрэгтэй	90.5	88.7	102	122	65.7	68.5	107.1	136.5	150.5	131.3
эмэгтэй	129	117.9	146.7	180.2	108.2	110.1	176.1	256.4	274.2	240.3
Зүрхний хэм алдагдал ба дамжуулагчийн эмгэгүүд (I44-I49), 10 000 хүнд										
Бүгд	6.6	11.9	12.8	22.8	19.8	29.8	50.3	71	83.3	86.2
эрэгтэй	5.7	9.8	10.9	18.2	14.5	21.1	37.7	50.8	57.0	56.5
эмэгтэй	7.5	13.9	14.6	27.2	24.8	38.2	62.6	90.6	108.9	115.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшинг хүйсээр харуулбал, эмэгтэйчүүдэд өвчлөлийн түвшин харьцангуй их байгаа ба 2025 оны байдлаар 10 000 эрэгтэйд 919.7 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 35.0-оор, эмэгтэйд 1504.4 болж, 10 жилийн дунджаас 58.9-оор тус тус өссөн байна.




Зураг 7.13. Зүрх судасны тогтолцооны өвчлөл, хүйсээр, 2025 он

Хугацаа	Улсын дүн	Эр	Эм
2016	1007.6	786.0	1238.0
2017	1145.6	879.0	1378.0
2018	1149.5	880.0	1392.0
2019	1321.3	1026.0	1609.0
2020	903.1	664.5	1135.1
2021	936.5	695.7	1170.4
2022	1308.9	974.0	1634.1
2023	1376.9	1018.2	1725.4
2024	1340.9	1003.6	1668.9
2025	1215.9	919.7	1504.4
10 жилийн дундаж	1170.6	884.7	1445.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Зүрх судасны өвчлөлийг газарзүйн байршлаар нь харахад 2025 оны байдлаар 10 000 хүн амд улсын дундаж (1215.9)-аас Баруун бүсэд 367.0-оор, Хангайн бүсэд 170.6-оор өндөр бөгөөд Төвийн бүсэд 88.1-оор ба Зүүн бүс нь 123.5-оор тус тус бага байна. Харин Улаанбаатарт 1108.9 байгаа нь өмнөх онтой (1226.6) харьцуулахад 117.7-оор буурсан байна.

Зураг 7.11. Зүрх судасны өвчлөл, 10000 хүнд ногдохоор, бүсээр, улсын дундаж, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II


Хүснэгт 7.14. Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он

Хугацаа	Улсын дүн	Эр	Эм
2016	1007.6	786.0	1238.0
2017	1145.6	879.0	1378.0
2018	1149.5	880.0	1392.0
2019	1321.3	1026.0	1609.0
2020	903.1	664.5	1135.1
2021	936.5	695.7	1170.4
2022	1308.9	974.0	1634.1
2023	1376.9	1018.2	1725.4
2024	1340.9	1003.6	1668.9
2025	1215.9	919.7	1504.4
10 жилийн дундаж	1170.6	884.7	1445.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшинг насны бүлгээр 2016 болон 2025 оныг харьцуулан 50-с дээш насанд өвчлөл буурч, бусад бүх бүлэг дэх өвчлөл нэмэгдсэн ба 2025 онд 65-аас дээш насанд хамгийн их буюу 6206.9 болж, 2016 оноос 1093.9-оор. өмнөх онтой харьцуулахад 850.6-оор тус тус буурсан байна.

Зураг 7.12. Зүрх судасны тогтолцооны өвчлөл, насны бүлгээр, 10000 хүнд ногдох, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтцийг харахад 2025 онд цусны даралт ихсэх 45.2 хувь, зүрхний ишеми 13.6, тархины судасны өвчин 15.8, вен тунгалгийн судас ба зангилааны өвчин 6.6, хэрлэгийн гаралтай зүрхний өвчин 1.5, артери, артериол, хялгасан судасны өвчин 1.6, бусад өвчин 15.6 хувийг эзэлж байна.

Өвчлөлийн бүтцийг хүйсээр харвал хэрлэгийн гаралтай зүрхний өвчин, тархины судасны болон цусны даралт ихсэх, зүрхний ишемит өвчин өвчнүүд эмэгтэйд илүү, артери, артериол, хялгасан судасны өвчин, вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд, зүрх судасны бусад өвчин эрэгтэйд илүү хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.15. Зүрх судасны тогтолцооны өвчнүүд, дүнд эзлэх хувиар, 2016, 2025 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2016 он			2025 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Цусны даралт ихсэх	45.5	52.8	50.0	41.9	47.2	45.2
Зүрхний ишемит өвчин	22.8	19.2	20.5	13.0	14.0	13.6
Тархины судасны өвчин	14.8	12.1	13.1	15.1	16.3	15.8
Вен, тунгалгийн судас ба зангилааны өвчнүүд	5.4	4.2	4.7	6.8	6.5	6.6
Хэрлэгийн гаралтай зүрхний өвчнүүд	2.2	3.0	2.7	1.2	1.7	1.5
Артери, артериол, хялгасан судасны өвчин	1.6	1.6	1.6	1.8	1.4	1.6
Зүрх судасны бусад	7.7	7.2	7.4	20.2	12.9	15.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



Артерийн даралт ихсэх өвчнийг насны ангиллаар харуулбал: 40 хүртэлх насныхан 9.3 хувь, 40-49 насныхан 15.6 хувийг, 50-59 насныхан 27.1 хувийг, 60-69 насныхан 29.8 хувийг, 70-аас дээш насныхан 18.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.16. Цусны даралт ихсэх өвчин, 10 000 хүнд, 2016 -2025 он

Хугацаа	10 000 хүнд	Эзлэх хувь
2016	514.0	50.0
2017	564.0	49.3
2018	577.0	50.2
2019	657.0	49.7
2020	476.7	52.8
2021	483.0	51.6
2022	655.0	50.0
2023	620.2	45.0
2024	615.1	45.9
2025	549.4	45.2
10 жилийн дундаж	571.2	49.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

7.1.4. ШЭЭС БЭЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Улсын хэмжээнд 10 000 хүн амд ногдох шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 1050.2 болж, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 99.8-оо нэмэгдэж, өмнөх онтой харьцуулахад 38.7-оор буурсан байгаа бөгөөд хүн амын нийт өвчлөлийн 10.0 хувийг эзлэж байна.


Хүснэгт 7.17 Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, 10000 хүнд, хүйсээр, 2016-2025 он

Хугацаа	Эр	Эм	Улсын дүн
2016	365.0	1248.0	807.6
2017	438.0	1428.0	952.4
2018	456.0	1379.0	932.4
2019	584.0	1640.0	1119.6
2020	396.4	1116.0	761.2
2021	375.3	980.6	682.3
2022	511.4	1394.7	959.5
2023	574.9	1709.4	1150.3
2024	548.9	1614.2	1088.9
2025	509.8	1576.7	1050.2
10 жилийн дундаж	476.0	1408.7	950.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Эрэгтэйчүүдийн хувьд 10 000 хүн амд 509.8 болж, 10 жилийн дунджаас 33.8-оор нэмэгдэж, өмнөх оноос 39.2 -оор буурсан. Эмэгтэйчүүдийн хувьд 10 000 хүн амд 1576.7 болж, 10 жилийн дунджаас 168.1-оор нэмэгдэж , өмнөх оноос 37.4-оор буурсан байна.

Зураг 7.13. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, бүсээр, улсын дунджаар, 10000 хүнд ногдох, 2016, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшинг насны бүлгээр 2016 онтой харьцуулахад 2025 онд бүх насанд нэмэгдсэн ба 65-аас дээш насанд хамгийн их буюу 2130.6 болж, 2016 оноос 448.6 -оор нэмэгдсэн байна.

Хүснэгт 7.18. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, дүнд эзлэх хувиар, 2016, 2025 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2016 он			2025 он		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бөөрний суганцарын өвчнүүд	67.7	54.3	57.2	36.2	30.9	32.2
Эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэл	0.0	22.5	17.5	0.0	28.7	21.8
Эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус	0.0	11.2	8.7	0.0	16.9	12.8
Түүдгэнцэрийн өвчнүүд	7.2	3.1	4.0	3.6	1.4	1.9
Хөхний өвчин	0.4	3.5	2.8	0.6	4.8	3.7
Цистит	1.4	2.4	2.2	1.8	4.0	3.5
Эр бэлэг эрхтэний бусад	16.1	0.0	3.5	36.9	0.0	8.8
Шээс ялгаруулах бусад	2.7	1.7	1.9	10.5	10.0	10.1
Шээс чулуужих өвчин	1.7	0.6	0.8	3.9	1.5	2.1
Бөөрний дутмагшил	2.8	0.8	1.2	6.6	2.0	3.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2025 онд бөөрний суганцарын өвчнүүд 32.2 хувьтай тэргүүлж байгаа ба эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин 21.8, эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус өвчин 12.8, шээс ялгаруулах тогтолцооны бусад өвчин 10.1, эр бэлэг эрхтэний өвчнүүд 8.8, хөхний өвчин 3.7, бөөрний түүдгэнцэрийн өвчнүүд 1.9, бөөрний дутмагшил 3.1, шээс чулуужих өвчин 2.1, цистит 3.5 хувийг тус тус эзэлж байна.

2025 оны байдлаар бөөрний түүдгэнцэрийн өвчнүүд 2016 онтой харьцуулахад 25.0 хувиар түүдгэнцэрийн өвчнүүд 2.1 хувиар тус тус буурсан байна. Харин шээс чулуужих өвчин 1.2, бөөрний дутмагшил 1.9 хувиар, шээс ялгаруулах тогтолцооны бусад эмгэг 8.2 хувиар тус тус нэмэгдсэн ба хүйсийн хувьд түүдгэнцэрийн өвчин эрэгтэйчүүдэд 2016 оноос 3.6, бөөрний суганцарын өвчин 31.6 хувиар тус тус буурсан байна. 2025 оны байдлаар түүдгэнцэрийн өвчин болон шээс чулуужих, бөөрний дутмагшил эрэгтэйчүүдэд илүү бүртгэгдсэн байна.



7.2. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

2025 оны байдлаар хэвтэн эмчлүүлэх өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүнд:

- Амьсгалын тогтолцооны өвчин 480.3
- Зүрх-судасны тогтолцооны өвчин 297.2
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 265.8
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин 190.3
- Яс булчингийн тогтолцоо болон холбох эдийн өвчин 149.8

Хүснэгт 7.19. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2025 он

Үзүүлэлт	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин
Хүйс						
Эрэгтэй	2102.7	491.9	264.4	256.8	107.9	100.4
Эмэгтэй	3199.3	468.9	329.2	274.6	270.6	197.9
Насны бүлэг						
Эрэгтэй						
20 хүртэлх	1605.5	851.7	10.6	153.8	40.1	15.2
20-44	1335.8	155.4	117.3	223.1	86.7	78.8
45-64	3380.0	279.4	682.7	450.8	194.0	227.5
65 ба түүнээс дээш	7370.0	777.1	1994.2	647.4	534.0	516.8
Эмэгтэй						
20 хүртэлх	1488.6	779.0	9.8	135.6	41.7	14.3
20-44	3567.9	182.9	140.9	210.9	368.8	100.9
45-64	4057.7	299.0	671.2	460.6	653.2	438.5
65 ба түүнээс дээш	8183.9	687.5	653.2	789.1	626.1	956.1
Байршил						
Хот	3119.8	507.5	316.5	332.6	201.5	169.0
Хөдөө	2218.2	454.3	278.8	202.2	179.7	131.5
Бүсээр						
Баруун	2433.4	465.1	321.4	246.3	196.8	176.4
Хангайн	2199.0	405.6	335.0	212.2	206.4	104.5
Төв	2090.7	474.1	217.9	161.1	152.8	124.1
Зүүн	2169.6	516.8	193.5	189.5	140.2	137.6
Улсын дундаж	2658.2	480.3	297.2	265.8	190.3	149.8

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Эмнэлэгт хэвтэлтийн түвшин 10 000 эрэгтэй хүн амд 2102.7 10 000 эмэгтэй хүн амд 3199.3 ногдож, ойролцоогоор эмнэлэгт хэвтэж байгаа эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Байршилын хувьд авч үзвэл нийт өвчлөл 10 000 хүн амд Баруун бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр /2433.4/ байгаа хэдий ч улсын дунджаас 224.7-оор бага байна.

Өвчлөлийн бүтцээр харуулбал, амьсгалын тогтолцооны өвчин Зүүн бүсэд, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл Баруун бүсэд, шээс бэлгийн тогтолцоо болон зүрх судасны тогтолцооны өвчлөл Хангайн бүсэд өндөр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7.20. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүнд, 2016-2025 он

Өвчлөлийн шалтгаан	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	10 жилийн дундаж
Зүрх-судасны тогтолцооны өвчин	407.0	412.0	422.0	427.0	365.0	262.9	365.0	401.8	403.0	297.2	376.3
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	339.0	333.0	341.0	342.0	341.0	262.0	327.0	342.7	331.0	265.8	322.5
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	312.0	316.0	320.0	328.0	323.0	239.8	276.0	260.3	231.2	190.3	279.7
Амьсгалын тогтолцооны өвчин	465.0	432.0	466.0	478.0	298.0	160.6	508.0	513.3	501.7	480.3	430.3
Мэдрэлийн тогтолцооны өвчин	198.0	211.0	215.0	226.0	229.0	140.9	186.0	208.9	186.1	142.6	194.3
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	126.5	129.5	144.8	150.1	170.7	121.6	170.9	188.8	209.3	149.8	156.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Энэ онд 10 000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчлөл 480.3 байгаа нь 10 жилийн дунджаас 50.0-оор өндөр бөгөөд, өнгөрсөн оноос 21.4-оор буурч, зүрх-судасны тогтолцооны өвчин 297.2 байгаа нь 10 жилийн дунджаас 79.1-оор, харин өнгөрсөн оноос 105.8-оор тус тус буурсан байна.

Хоол боловсруулах тогтолцооны өвчний хувьд 10 жилийн дунджаас 56.6-оор, мэдрэлийн тогтолцооны өвчин 51.8-оор, харин шээс бэлгийн тогтолцооны өвчин 89.3-оор тус тус буурсан байна.

Хүснэгт 7.21. Зонхилон тохиолдох хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн бүтэц, хувиар, 2015-2024 он

Өвчний ангилал (ӨОУА-10)	Зонхилох шалтгаан	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	10 жилийн дундаж
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Бөөрний сувганцрын үрэвсэл (N10-N16)	63.0	63.1	62.9	63.1	59.3	63.1	57.4	55.8	55.6	52.1	59.5
Амьсгалын тогтолцооны өвчин	Хатгалгаа (J12-J18)	52.4	49.1	51.8	51.4	43.9	37.9	58.3	58.4	61.5	61.4	52.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Элэгний эмгэг (K70-K77)	26.0	25.5	23.2	23.6	19.6	18.3	21.9	22.6	22.9	18.0	22.2
	Мухар олгойн өвчин (K35-K38)	12.6	12.2	11.3	11.1	10.7	12.8	10.3	8.7	8.4	10.8	10.9
	Цэсний хүүдийн өвчнүүд (K80-K81)	13.4	13.5	14.3	13.8	14.9	14.4	14.5	12.8	11.7	18.0	14.1
Зүрх-судасны тогтолцооны өвчин	Даралт ихсэх өвчнүүд (I10-I15)	39.7	40.1	40.2	41.3	34.9	24.6	27.4	29.0	29.0	22.6	32.9
	Зүрхний ишеми өвчнүүд (I20, I23-I25)	24.3	24.1	23.3	22.5	24.4	31.3	21.6	16.8	12.5	13.5	21.4
Мэдрэлийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг (G50-G59)	36.4	37.2	38.9	40.4	40.7	31.9	29.4	28.8	27.9	31.5	34.3
	Эпилепси (G40-G41)	10.6	9.5	9.5	7.9	6.9	8.6	8.0	8.4	8.3	8.2	8.6
Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	Үрэвсэлт полиартропати / M05-M14/	23.1	21.7	21.2	21.8	20.4	21.9	22.9	32.6	32.6	29.4	24.8

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



2025 оны байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчлөлийг авч үзвэл: шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 52.1 хувийг бөөрний сувганцрын үрэвсэлт өвчин, амьсгалын тогтолцооны өвчний дотор уушгины хатгалгааны улмаас хэвтэн эмчүүлэгч 61.4 хувийг, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 18.0 хувийг, зүрх судасны тогтолцооны өвчний дотор даралт ихсэх өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 22.6 хувийг, зүрхний ишеми өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 13.5 хувийг тус тус эзэлж эдгээр өвчнүүд хүн амын дунд зонхилон тохиолдож байна.


Уушгины хатгалгаа өвчин 2016 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 52.4 хувийг эзэлж байсан бол 2025 онд 61.4 болж, 9.0 хувиар нэмэгдсэн байна.

2016 онд хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор 26.0 хувийг элэгний эмгэг, 13.4 хувийг цөсний өвчнүүд эзэлж байсан бол 2025 онд элэг болон эмгэг цөсний хүүдийн эмгэгүүд 18.0 хувь, болж буурсан байна.

Даралт ихсэх өвчин нь 2016 онд зүрх-судасны тогтолцооны өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн 39.7 хувийг эзэлж байсан бол 2025 онд 22.6 болж буурсан байна.

Хэвтэн эмчлүүлэгчдэд бүртгэгдсэн зүрх судасны өвчин нийт хэвтэж эмчлүүлэгчдийн өвчлөлийн 11.2 хувийг эзэлж байгаа нь 2016 онтой харьцуулахад 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зүрх судасны өвчлөл 2025 оны байдлаар 10 000 хүн амд 297.2 байгаа ба эрэгтэйд 264.4, 10 000 эмэгтэйд 329.2 байна. Байршлаар харуулбал орон нутагт 10 000 хүн амд ногдох өвчлөл 278.8, Улаанбаатарт 316.5 байна.


Зураг 7.14. Зүрх, судасны тогтолцооны өвчлөлийн түвшин, 10 000 хүнд, эзлэх хувь, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчлөлийг бүтцээр нь харуулбал: Артерийн даралт ихсэх өвчин хамгийн түгээмэл бүртгэгдсэн бөгөөд бөгөөд анхдагч даралт ихсэх өвчин 2.8 хувь, даралт ихсэх бусад өвчин 19.8 хувийг эзэлж байгаа бөгөөд нийтдээ өвчлөлийн 22.6 хувийг эзэлж байгаа ба тархинд цус харвалт 3.0 хувийг зүрхний ишеми өвчний тохиолдол нийт өвчлөлийн 13.5 хувийг эзэлж байна.

Зураг 7.15. Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтэц, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II


Хүснэгт 7.22. Хэвтэн эмчлүүлэгчдэд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчин, тэргүүлэх шалтгаанаар, 10 000 хүнд, 2016-2025 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Артерийн даралт ихсэх өвчлөлийн түвшин, (I11-I15) 10 000 хүнд										
Эрэгтэй	28.3	34.1	40.7	41.4	27.4	22.7	56.4	71	74.8	41.1
Эмэгтэй	51	62.2	69.9	71.8	49.4	41.9	107.8	135.7	141.4	76.2
Бүгд	39.8	48.4	55.5	56.8	38.5	32.4	82.5	103.8	108.6	58.8
Анхдагч даралт ихсэх өвчлөлийн түвшин, (I10) 10 000 хүнд										
Эрэгтэй	91.3	86.7	84.2	89.8	67.9	24.3	14	9.8	6.6	6.6
Эмэгтэй	151.8	145.5	143.3	149.3	109	40.1	21	15.4	9.8	10.2
Бүгд	122	116.6	114.2	119.9	88.7	32.3	17.5	12.6	8.2	8.4
Зүрхний бусад ишеми өвчлөлийн түвшин (I20, I23-I25), 10 000 хүнд										
Эрэгтэй	89.7	90.8	90.5	89	79.5	69.4	70.1	61.2	47.6	38.9
Эмэгтэй	108.2	107.6	105.9	102.9	98.1	94.7	87.7	73.3	53.0	41.0
Бүгд	99.1	99.4	98.3	96	88.9	82.2	79	67.3	50.3	40.0
Тархи судасны бусад өвчлөлийн түвшин (I64-I69), 10 000 хүнд										
Эрэгтэй	48.9	48.2	54.2	58.1	52.9	34.4	54.3	66.8	73.2	58.1
Эмэгтэй	64.5	65.9	76.4	79.8	76.1	51.8	88.3	102.9	112.6	88.0
Бүгд	56.8	57.2	65.4	69.1	64.7	43.2	71.6	85.1	93.2	73.2
Зүрхний хэм алдагдал ба дамжуулагчийн эмгэгүүд (I44-I49), 10 000 хүнд										
Эрэгтэй	1.5	2.16	2.64	3.22	3.72	5.02	3.99	9.56	14.6	10.2
Эмэгтэй	1.88	2.54	3.01	3.54	4.34	6.74	5.96	14.46	21.7	14.9
Бүгд	1.69	2.35	2.83	3.38	4.03	5.89	4.99	12.05	18.2	12.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II



Зураг 7.16. Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд бүртгэгдсэн тархинд цус харвалт (цус алдалттай, (I60-I62), 10 000 хүнд, эзлэх хувь, 2016-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-II

7.3. МЭС ЗАСЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын хэмжээнд 2025 онд 201 173 өвчтөнд мэс засал хийгдсэн бөгөөд 79.3 хувь нь Улаанбаатарт, 20.7 хувь нь хөдөө орон нутагт хийгджээ. Нийт мэс заслын 11.7 хувь нь дүрэнгийн мэс засал, 0.2 хувь нь давтан мэс засал байна. Мэс заслын дараах хүндрэлийн хувь 0.2, нас баралтын хувь 0.2 байна.

Хүснэгт 7.23. Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хийгдсэн мэс заслын тоо, 2025 он

Эрүүл мэндийн байгууллага	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Үүнээс		Мэс заслын хүндрэл		Нас барсан	
	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх нас	Дүрэнгийн мэс засал	Давтан хагалгаа	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх насны хүүхэд
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	12960	15	5324	63	57	0	102	0
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	5932	13	2350	31	69	0	32	0
Улсын гуравдугаар төв эмнэлэг	9687	349	187	11	21	2	94	7
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	13120	7420	498	45	51	37	16	14
Халдварт өвчин судлалын үндэсний төв	589	59	12	10	0	0	0	0
Хавдар судлалын үндэсний төв	3660	0	129	30	122	0	20	0
Гэмтэл согог судлалын үндэсний төв	15155	2712	703	9	12	1	126	8
Монгол Японы эмнэлэг	3448	175	1558	0	0	0	0	0
Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2	4522	1487	109	1	2	2		
АШУУИС-ийн төв эмнэлэг	446	7	0	0	0	0	0	0
ЭМЯ-ны харьяа хувийн эмнэлгүүд	17931	1083	2968	103	12	0	1	0
Нийслэлийн эрүүл мэндийн газар	72063	14323	5539	18	13	0	16	0
Бүгд	159513	27643	19377	321	359	42	407	29

Хүснэгт 7.24. Зонхилон хийгдсэн мэс засал, төрөл хувиар, 2025 он

Мэс заслын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо		Үүнээс		Мэс заслын хүндрэл	Нас барсан
	Бүгд	Үүнээс: 15 хүртэлх нас	Дурангийн мэс засал	Давтан хагалгаа		
Мэдрэлийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	1.6	0.7	0.0	4.6	3.1	23.1
Дотоод шүүрлийн бүлчирхайн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	0.4	0.0	0.2	0.5	0.5	0.5
Нүдэнд хийгдэх мэс заслууд	4.6	3.5	3.2	12.4	0.0	0.2
Чихэнд хийгдэх мэс заслууд	1.1	2.9	0.5	2.4	0.5	0.0
Хамар, ам, залгиурт хийгдэх мэс заслууд	25.2	52.8	1.8	3.4	2.6	0.5
Амьсгалын эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	0.8	0.5	0.5	1.5	2.8	4.8
Зүрх судасны тогтолцоонд хийгдэх мэс заслууд	4.1	1.5	2.2	2.9	4.9	17.9
Цус болон тунгалгийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	0.2	0.3	0.0	0.2	0.5	0.7
Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	19.6	11.7	57.9	42.7	64.6	35.7
Шээсний замд хийгдэх хагалгаанууд	2.0	0.8	8.8	3.8	3.6	2.5
Эр бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд	2.2	0.8	9.3	2.9	2.6	2.4
Эм бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд	1.8	4.1	2.8	1.0	0.8	0.2
Эм бэлэг эрхтэнд хийгдэх мэс заслууд	9.0	0.3	12.0	4.9	7.2	0.7
Эх барихын ажилбарууд	7.9	0.0	0.1	4.4	1.0	0.0
Яс, бүлчингийн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	14.9	14.4	9.5	7.0	5.4	6.2
Гадна эрхтэн тогтолцоонд хийгдэх мэс заслууд	6.3	6.6	0.0	9.2	3.4	7.1
Бүгд	100	100	100	100	100	100

7.4. ХОРТ ХАВДАР

ДЭМБ-ын статистик мэдээллээр 2022 онд 19.9 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9.7 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. Монгол Улс дэлхийд нийт хорт хавдрын нас баралт, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа тэргүүлж байна.

ДЭМБ-ын статистик мэдээлэлд зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлд хөх, түрүү булчирхай, уушиг, бүдүүн шулуун гэдэс, умайн хүзүүний хорт хавдрууд байна.

Монгол Улсын хүн амын дунд 2025 онд 8015 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн ба зонхилон байрлалын хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэгний хорт хавдар 26.9%, ходоодны хорт хавдар 16.7%, умайн хүзүүний хорт хавдар 6.9%, уушиг гүүрсан хоолой хорт хавдар 6.5%, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар 5.4% эзэлж байгаа ба нийт хорт хавдрын 62.4%-ийг дээрх хорт хавдрууд эзэлж байна.

Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушиг гүүрсан хоолой, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар, улаан хоолой, эмэгтэйчүүдийн дунд элэг, умайн хүзүү, ходоод, хөх, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар зонхилон эхний 5 шалтгаан болж байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин аль ч хүйсэнд хамгийн өндөр буюу 100 000 эрэгтэй хүн амд 68.4 тохиолдол, эмэгтэй хүн амд 57.4 тохиолдол байна.

2025 онд бүртгэгдсэн хорт хавдрын оношлогдох үеийн (TNM stage) авч үзвэл 40.2% нь эрт үе шатандаа, 59.8% нь хожуу үе шатандаа оношлогджээ. Монгол Улсад 2025 онд 0-19 насны 126



хүүхдэд хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми 37.3%, тархи мэдрэлийн 13.5%, яс зөөлөн эдийн 7.1%, бөөрний 6.3%, Ходжжины бус лимфома 4.8% бусад байрлал 31 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсад 2025 онд хорт хавдрын өвчлөлийн улмаас 32979 хяналтад байгаагийн 620 нь 0-19 (1.9 хувь) насны хүүхэд байна. Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 42 хувь нь 5 ба түүнээс дээш жил амьдарч байна.

7.4.1. ХОРТ ХАВДРЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН


2025 оны хорт хавдрын тайлангаар 8015 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 3967 эрэгтэй, 4048 эмэгтэй байна. Үүнээс 54 хувь нь орон нутаг, 46 хувь нь Улаанбаатарынх байна. Элэгний хорт хавдраар 2157 тохиолдол шинээр оношлогдсоны 53.7 хувь нь эрэгтэй, 46.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба нийт хорт хавдрын 26.9%-ийг эзэлж байна.

Хүснэгт 7.25. Зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөл, хүйсээр, 2025 он

№	ХОРТ ХАВДАР БҮГД			ЭРЭГТЭЙ			ЭМЭГТЭЙ		
	Хорт хавдрын байрлал	Бодит тоо	%	Хорт хавдрын байрлал	Бодит тоо	%	Хорт хавдрын байрлал	Бодит тоо	%
1	Элэг	2157	26.9	Элэг	1159	29.2	Элэг	998	24.7
2	Ходоод	1336	16.7	Ходоод	909	22.9	Умайн хүзүү	550	13.6
3	Умайн хүзүү	550	6.9	Уушги, гуурсан хоолой	411	10.4	Ходоод	427	10.5
4	Уушги, гуурсан хоолой	524	6.5	Бүдүүн шулуун гэдэс	229	5.8	Хөх	404	10.0
5	Бүдүүн шулуун гэдэс	430	5.4	Улаанхоолой	227	5.7	Бүдүүн шулуун гэдэс	201	5.0
6	Бусад байрлал	3018	37.6	Бусад байрлал	1032	26	Бусад байрлал	1468	36.2
Нийт		8015			3967(49.5)			4048(50.5)	

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

Зураг 7.17. Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

Хорт хавдрын нийт өвчлөлийн түвшин 100 000 хүн амд 233.4 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 234.1, эмэгтэйчүүдэд 232.8 байна. Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин 100 000 эрэгтэй хүн амд 68.4 тохиолдол, 100 000 эмэгтэй хүн амд 57.4 тохиолдол ногдож байна.

Зураг 7.18. Зонхилон тохиолдох 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

100 000 эрэгтэй хүн амд ногдох ходоодны хорт хавдар 53.7, уушигны хорт хавдар 24.3, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар 13.5, улаанхоолой хорт хавдар 13.4 тохиолдол тус тус байна. Харин эмэгтэй 100 000 хүн амд умайн хүзүүний хорт хавдар 31.6, ходоодны хорт хавдар 24.6, хөхний хорт хавдар 23.2, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар 11.6 тохиолдол ногдож байна

Хорт хавдар оношлогдох үеийн TNM үе шатаар:

Олон улсад цусны, булчирхай, тархины хорт хавдраас бусад байрлалын хорт хавдрыг TNM ангилалыг баримтлан үе шатыг тогтоодог. TNM ангиллын дагуу байран өмөн болон 0-2-р үе шатыг эрт үеийн хорт хавдар, 3 - 4 дүгээр үе шатыг хожуу үеийн хавдар гэж тооцсон. 2025 онд бүртгэгдсэн нийт хорт хавдрын 40.2% нь эрт үе шатандаа, 59.8% нь хожуу үе шатандаа оношлогджээ. Оношлогдсон хорт хавдруудаас уушиг гүүрсан хоолой (89.5%), нойр булчирхай (76.2%), улаан хоолойн (75.7%) ихэвчлэн хожуу үе шатандаа оношлогдож байгаа бол бамбайн (75.6%), бөөр (71.6%), хөх (67.5%), умайн хүзүүний (64.2%) хорт хавдрууд харьцангуй эрт үе шатандаа оношлогджээ.

Хүснэгт 7.26. Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), 2025 он, хувиар

№	Хавдрын байрлал	Байран	I	II	III	IV
1	Элэг	0.0	6.6	25.6	36.7	31
2	Ходоод	1.4	16.0	21.8	32.2	28.6
3	Уушиг, гүүрсан хоолой	0.2	1.7	8.6	40.6	48.9
4	Умайн хүзүү	14.9	19.1	30.2	30.0	5.8
5	Бүдүүн шулуун гэдэс	0.7	3.0	26.5	47.0	22.8
6	Хөх	5.2	16.7	45.6	26.4	6.2
7	Улаанхоолой	0.3	6.4	17.6	43.9	31.8
8	Бөөр	1.2	50.5	20.0	19.7	8.6
9	Нойр булчирхай	0.0	7.3	16.5	34.7	41.5
10	Бамбай булчирхай	0.9	38.0	36.6	20.2	4.2
Нийт хавдар (TNM)		1.8	13.2	25.3	34.2	25.6


Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”



7.4.2 ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДАР

Монгол улсад 2025 онд 0-19 насанд 126 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн байна. Үүний 52% (66) хөвгүүд, 48% (60) охид байна. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми тэргүүлж байгаа ба тархи мэдрэлийн, яс зөөлөн эдийн, бөөр, ходжкины бус лимфома хавдар удаалж байна.

Зураг 7.19. Зонхилон тохиолдох 10 байрлалын хорт хавдар, өвчлөлийн түвшин, хүйсээр, 100 000 хүн амд, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

7.4.3. ХОРТ ХАВДРЫН ХЯНАЛТ

Монгол улсад 2025 оны байдлаар 32979 хүн хорт хавдрын улмаас эмчийн хяналтад байгаагийн 36.8% (12121) нь эрэгтэй, 63.2%(20858) нь эмэгтэйчүүд байна. 0-19 насны 620 хүүхэд хорт хавдрын улмаас хяналтад байгаагийн 359 (57.9%) эрэгтэй, 261 (42.1%) охидууд байна.


Хүснэгт 7.27. Хорт хавдрын хяналт, Эхний 5 байрлалаар, 2025 он

Хорт хавдар	Хяналт буй хүний тоо	Эзлэх хувь
Элэг	7025	21.3
Умайн хүзүү	5149	15.6
Ходоод	4750	14.4
Хөх	2882	8.7
Бөөр	1919	5.8
Бүдүүн шулуун гэдэс	1638	5
Бусад	9616	29.2
Нийт хяналт тоо	32979	100

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

Хорт хавдар анх оношлогдож хяналтад орсон хугацааг амьдарч буй жилээр тооцоход 1 хүртэл жил дотроо 24.6%, 1-2 жил 11.3%, 2-3 жил 9%, 3-4 жил 7.2%, 4-5 жил 5.9%, 5-аас дээш жил 42%-ийг тус тус эзэлж байна.


Зураг 7.20. Хорт хавдрын хяналт, амьдарч буй хугацаагаар, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

Хорт хавдрын хяналтад орсоноос хойш 5 ба түүнээс дээш жил амьдарсан хувийг зонхилох байрлалын хорт хавдруудаар тооцоход умайн хүзүүний хорт хавдар 63.5%-тай байгаа нь бусад байрлалын хорт хавдруудаас өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 7.21. Хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсийн 5 ба түүнээс дээш жил амьдарч байгаа хувь, 2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан”

7.5. ОСОЛ ГЭМТЭЛ БА ЗАРИМ ГАДНЫ ШАЛТГААНЫ ҮР ДАГАВАР

Монгол улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар осол гэмтлийн шалтгаант өвчлөл 2021-2025 он хүртэл 1.6 дахин өссөн байна. 2025 онд өмнөх оноос 4.4 хувиар өссөн бөгөөд 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 676.6 байна.

Зураг 7.22. Осол гэмтлийн шинэ тохиолдол, 10 000 хүнд, 2021-2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”



Нийт тохиолдлын 138959 (59.8%) эрэгтэй, 93356 (40.2%) эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна. 2025 онд осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо эрэгтэйд 10-14 насанд, эмэгтэйд 0-4 насанд хамгийн их байгаа бол аль ч хүйсэнд 65-69 насанд хамгийн бага тохиолдол бүртгэгдсэн байна.

Зураг 7.23. Осол гэмтлийн шинэ тохиолдол, насны бүлэг, хүйсээр, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Сүүлийн 3 жилд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн тохиолдол нийт осол гэмтлийн тохиолдлын 9-11 хувийг эзэлж байна.


Хүснэгт 7.28. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтсэн хувиар, 2023-2025 он

Эрүүл мэндийн байгууллага	2023		2024		2025	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Нийт тохиолдлын тоо	210763	100	222564	100	232315	100
Үүнээс: Согтууруулах ундаа хэрэглэсэн	23216	11.0	21626	9.7	25740	11.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн тохиолдол 10-14 насанд 27317 (11.8%) хамгийн өндөр байна. Тухайн насны 10 000 хүн амд тооцоход 15-19 насанд /852.5/ тохиолдлын түвшин өндөр байна.

Зураг 7.24. Осол гэмтлийн шинэ тохиолдол, насны бүлгээр, 10 000 хүнд



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2021–2025 оны хугацаанд ихэнх осол гэмтлийн шалтгаанууд өсөх чиг хандлагатай байна. Ялангуяа зам тээврийн осол, амьгүй механик хүчинд өртөх, амьтай механик хүчинд өртөх, түлэгдэлт, хордолт, амьсгал боогдох шалтгаанууд тогтвортой нэмэгдэж байгаа нь нийгмийн болон орчны эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 7.29. Осол гэмтлийн шалтгаан, хувиар, 2021-2025 он

Осол гэмтлийн шалтгаан	ӨОУА-10	Тохиолдлын тоо					Нийт	Хувь
		2021	2022	2023	2024	2025		
Санамсаргүй осол гэмтэл								
Уналт	W00-W19	59839	84602	94550	94523	93247	426761	42.8
Амьгүй механик хүчинд өртөх	W20-W49	24963	30386	34000	40781	45489	175619	17.6
Зам тээврийн осол	V01-V99	15957	21128	23548	27660	30884	119177	12.0
Амьтай механик хүчинд өртөх	W50-W64	10945	15455	17675	19215	20720	84010	8.4
Түлэгдэлт	W85-X19	5637	6333	7004	7091	7630	33695	3.4
Тодорхойгүй осол	Y10-Y34	5051	6455	7301	5901	4676	29384	2.9
Санамсаргүй хордох	X40-X49	2845	3109	3857	4314	4786	18911	1.9
Бусад осол	X50-X59	1002	1310	1446	1579	2196	7533	0.8
Байгалийн хүчинд өртөх	X30-X39	701	999	1132	850	813	4495	0.5
Амьсгал боогдох	W75-W84	192	236	245	216	281	1170	0.1
Усанд живэх	W65-W74	147	112	106	134	104	603	0.1
Хорт амьтан ургамалд өртөх	X20-X29	112	115	180	70	121	598	0.1
Санаатай үйлдлээс үүдсэн осол гэмтэл								
Хүчирхийлэл	X85-Y09	13780	17284	18438	18769	19656	87927	8.8
Амиа хорлох	X60-X84	1271	1392	1281	1461	1712	7117	0.7

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтлийн шалтгааныг хүйсээр харвал аль ч хүйсэнд уналтын шалтгаан тэргүүлж байгаа бол эрэгтэйчүүдийн дунд хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн дунд амьд механик хүчинд өртөх шалтгаан 4 шалтгаан болж байна.



Зураг 7.25. Осол гэмтлийн шалтгаан, хүйсээр, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтэлд өртсөн тохиолдлын 20.9% нь толгойн гэмтлийн оноштой бол 30.4% нь дээд мөчдийн гэмтэл, 26.5% нь доод мөчдийн гэмтлийн оноштой байна.

Хүснэгт 7.30. Гэмтсэн эрхтний байршил, хувиар, 2025 он

Гэмтсэн эрхтний байршил	Тоо	Хувь
Толгойн гэмтэл S00-S09	48559	20.9
Хүзүүний гэмтэл S10-S19	1958	0.8
Цээжний гэмтэл S20-S29	13098	5.6
Хэвлийн гэмтэл S30-S39	12060	5.2
Мөр ба бугалганы гэмтэл S40-S49	12165	5.2
Тохой ба шууны гэмтэл S50-S59	27104	11.7
Бугуй ба сарвууны гэмтэл S60-S69	31346	13.5
Түнх ба гуяны гэмтэл S70-S79	7288	3.1
Өвдөг ба шилбэний гэмтэл S80-S89	24648	10.6
Шагай ба тавхайн гэмтэл S90-S99	29694	12.8
Биеийн олон хэсгийн гэмтэл T00-T09	337	0.1
Түлэгдэлт T20-T32	7634	3.3
Бусад болон тодорхойгүй хэсгийн гэмтэл T10-T14	7557	3.3
Биеийн сүвээр орсон гадны биет T15-T19	1485	0.6
Хүндрэл T90-T99	527	0.2
Эмийн бүс бэлдмэлийн хордлого T51-T65	4510	1.9
Бусад тодорхойгүй нөлөөлөл T66-T78	1245	0.5
Хөлдөлт T33-T35	452	0.2
Эм, эмийн бэлдмэлийн хордлого T36-T50	648	0.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан бүрт ямар эрхтэн илүү гэмтсэн байгааг авч үзэхэд зам тээврийн осол, унаж гэмтэх үед зөөлөн эдийн болон хугарал, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, хүчирхийллийн шалтгааны үед шархны онош тэргүүлсэн байна.


Хүснэгт 7.31. Осол гэмтлийн шалтгаан, оношоор, 2025 он

Осол гэмтлийн шалтгаан	Гэмтлийн онош				
	I	II	III	IV	V
Зам тээврийн осол (V01-V99)	Зөөлөн эдийн гэмтэл 28.1%	Хугарал 24.2%	Гавал доторх гэмтэл 23.2%	Шарх 10.4%	Бусад тодорхойгүй гэмтэл 5.8%
Уналт (W00-W19)	Зөөлөн эдийн гэмтэл 33.6%	Хугарал 30.6%	Мултрал, суналт 17.5%	Шарх 7.1%	Гавал доторх гэмтэл 6.5%
Амьгүй механик хүчинд өртөх (W20-W49)	Шарх 42.6%	Зөөлөн эдийн гэмтэл 23.3%	Хугарал 16.2%	Гавал доторх гэмтэл 6.2%	Мултрал, суналт 2.7%
Амьтай механик хүчинд өртөх (W50-W64)	Шарх 30.3%	Зөөлөн эдийн гэмтэл 27.4%	Хугарал 17.1%	Мултрал, суналт 15.9%	Гавал доторх гэмтэл 4.8%
Дайралт, халдлага / Хүчирхийлэл/ (X85-Y09)	Шарх 30.1%	Гавал доторх гэмтэл 23.8%	Хугарал 18.9%	Зөөлөн эдийн гэмтэл 16.6%	Бусад тодорхойгүй гэмтэл 7.1%

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтлийн шинэ тохиолдлын 27.8% зун, 26.4% хавар, 24.8% намар, 20.9% өвлийн улиралд бүртгэгдсэн бол 2025 онд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 5, 6, 7 саруудад хамгийн их /28.4%/, 1, 2, /13.7%/ саруудад хамгийн бага бүртгэгдсэн байна.

Зураг 7.26. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл бүртгэгдсэн улирал, сараар, хувиар 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 онд осол гэмтэл бүртгэгдсэн харьяаллаар харвал нийслэлд нийт тохиолдлын 194664 (83.8%) нь харин орон нутагт 37651 (16.2%) нь бүртгэгдсэн байна. 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин нийслэлд 1173.2, орон нутаг 214.2 байна.

2025 онд Завхан, Төв, Хөвсгөл аймгуудад зам тээврийн осол тэргүүлэх шалтгаан болсон бол үлдсэн аймгуудад уналтын шалтгаан харин Өмнөговь аймагт амьгүй механик хүчинд өртөх шалтгаант гэмтэл тэргүүлж байна.




Хүснэгт 7.32. Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан, аймгаар, 2025 он

Аймгийн нэр	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай	Уналт 25.7%	ЗТО 23.9%	Амьгүй механик хүчинд өртөх 18.5%	Хүчирхийлэл 11.2%	Амьтай механик хүчинд өртөх 9.0%
Баян-Өлгий	Уналт 40.5%	Амьгүй механик хүчинд өртөх 19.7%	ЗТО 17.4%	Түлэгдэлт 8.5%	Хүчирхийлэл 6.4%
Баянхонгор	Уналт 27.2%	ЗТО 19.8%	Санамсаргүй хордох 17.7%	Амьгүй механик хүчинд өртөх 15.8%	Хүчирхийлэл 6.8%
Булган	Уналт 27.4%	ЗТО 27.2%	Амьгүй механик хүчинд өртөх 17.8%	Хүчирхийлэл 9.4%	Амьтай механик хүчинд өртөх 9.1%
Говь-Алтай	Уналт 27.5%	ЗТО 24.4%	Амьгүй механик хүчинд өртөх 17.2%	Хүчирхийлэл 11.6%	Амьтай механик хүчинд өртөх 10.4%
Дорноговь	Уналт 31.4%	Амьгүй механик хүчинд өртөх 21.1%	ЗТО 19.5%	Хүчирхийлэл 13.0%	Амьтай механик хүчинд өртөх 5.9%
Дорнод	Уналт 37.0%	Амьгүй механик хүчинд өртөх 19.9%	ЗТО 18.5%	Амьтай механик хүчинд өртөх 8.0%	Хүчирхийлэл 7.8%
Дундговь	Уналт 28.1%	ЗТО 25.6%	Амьгүй механик хүчинд өртөх 13.8%	Хүчирхийлэл 13.4%	Амьтай механик хүчинд өртөх 9.1%
Завхан	ЗТО 23.8%	Уналт 23.6%	Амьгүй механик хүчинд өртөх 21.5%	Хүчирхийлэл 13.3%	Амьтай механик хүчинд өртөх 7.4%
Өвөрхангай	Уналт 26.3%	ЗТО 25.9%	Амьгүй механик хүчинд өртөх 15.0%	Санамсаргүй хордох 12.8%	Хүчирхийлэл 7.7%
Өмнөговь	Амьгүй механик хүчинд өртөх 30.2%	ЗТО 23.8%	Уналт 17.4%	Хүчирхийлэл 15.5%	Амьтай механик хүчинд өртөх 5.4%
Сүхбаатар	Уналт 29.5%	ЗТО 27.5%	Амьгүй механик хүчинд өртөх 11.8%	Хүчирхийлэл 11.4%	Амьтай механик хүчинд өртөх 7.5%
Сэлэнгэ	Уналт 21.3%	Амьгүй механик хүчинд өртөх 20.5%	Хүчирхийлэл 17.9%	ЗТО 17.8%	Амьтай механик хүчинд өртөх 6.4%
Төв	ЗТО 28.3%	Уналт 22.5%	Амьгүй механик хүчинд өртөх 16.4%	Хүчирхийлэл 11.3%	Санамсаргүй хордох 7.9%
Увс	Уналт 30.6%	ЗТО 23.0%	Амьгүй механик хүчинд өртөх 17.9%	Түлэгдэлт 7.8%	Хүчирхийлэл 6.4%
Ховд	Уналт 36.8%	ЗТО 26.8%	Амьгүй механик хүчинд өртөх 10.3%	Түлэгдэлт 8.4%	Хүчирхийлэл 4.9%
Хөвсгөл	ЗТО 26.9%	Уналт 21.4%	Амьгүй механик хүчинд өртөх 17.2%	Хүчирхийлэл 12.3%	Амьтай механик хүчинд өртөх 6.1%
Хэнтий	Уналт 30.8%	ЗТО 21.8%	Амьгүй механик хүчинд өртөх 19.4%	Хүчирхийлэл 13.2%	Амьтай механик хүчинд өртөх 6.7%
Дархан-Уул	Уналт 34.4%	Амьгүй механик хүчинд өртөх 21.6%	Хүчирхийлэл 17.1%	ЗТО 15.6%	Амьтай механик хүчинд өртөх 5.6%
Орхон	Уналт 49.0%	ЗТО 21.9%	Амьгүй механик хүчинд өртөх 10.2%	Хүчирхийлэл 7.2%	Түлэгдэлт 4.6%
Говьсүмбэр	Уналт 26.4%	Амьгүй механик хүчинд өртөх 23.7%	ЗТО 22.1%	Хүчирхийлэл 11.9%	Амьтай механик хүчинд өртөх 7.6%я

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 "Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан"

Аймгуудаас Дорноговь, Архангай, Өвөрхангай зэрэг аймгууд тохиолдлын тоо хамгийн өндөр байсан бол Говь-Сүмбэр, Ховд, Увс аймагт тохиолдол бага бүртгэгджээ.


Зураг 7.27. Осол гэмтлийн тохиолдлын түвшин, аймгаар, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 33.8% гудамж замд, 32.1% гэртээ гэмтсэн байгаа бол үлдсэн хувийг биеийн тамир спортын талбай, тоглоомын талбай, сургууль, цэцэрлэг, хөдөө зэрэг газрууд эзэлж байна.

Зураг 7.28. Осол гарах үеийн байршил, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Осол гэмтлийн тохиолдлын 91.6% нь эрүүл мэндийн байгууллагад өөрөө, 6.9% нь түргэн тусламжаар, 1.5% нь такси болон бусад аргаар эмнэлэгт ирсэн байна.



Зураг 7.29. Эмнэлгийн тусламж хэрхэн ирж авсан байдал, 2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

7.5.1. УНАЛТЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДОЛ /W00-W19/

2025 онд тухайн шалтгаанаар гэмтэж бэртсэн 93247 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба тохиолдлын түвшин 10 000 хүн амд 271.6 тохиолдол байна. 2025 онд тохиолдлын тоо өмнөх оноос 1.3 хувиар буурсан байна.


Зураг 7.30. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, 10 000 хүнд, 2021-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 онд уналтын шалтгаанаар бэртэж гэмтсэн тохиолдлыг хүйсээр авч үзвэл нийт тохиолдлын 51.8 хувь/48277/ нь эрэгтэй, 48.2 хувь/44970/ нь эмэгтэйчүүд байна.


Зураг 7.31. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, хүйсээр, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Насны бүлгээр авч үзэхэд тохиолдлын тоогоор 10-14 насанд бусад насны бүлгээс өндөр /12193/ үзүүлэлттэй байгаа бол 10 000 хүн амд тооцож үзэхэд 70-аас дээш насныханд хамгийн өндөр буюу тухайн насны 10 000 хүн тутамд 472.9 нь уналтын шалтгаанаар бэртэж гэмтсэн байна.

Зураг 7.32. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, насны бүлгээр, 10 000 хүнд, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 онд нэг түвшин дээр бүдэрч, тээглэж унах шалтгаан /56.6%/ тэргүүлж, шат гишгүүрээс унах, мөс, цасан дээр халтирч унах, нэг түвшнээс өөр түвшин рүү унах, тоглоомын ба спорт талбайн хэрэгслээс унаж гэмтэх шалтгаанууд тэргүүлэх 5 шалтгаанд багтсан байна.

Хүснэгт 7.33. Уналтын шалтгаант шинэ тохиолдлын тэргүүлэх шалтгаан хувиар, 2025 он

Гэмтсэн он	Уналтын тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
2025	Нэг түвшин дээр хальтирч, тээглэж, бүдэрч унах 56.6%	Шат, гишгүүрээс унах 11.1%	Нэг түвшин дээр мөс, цасан дээр унах 9.5%	Нэг түвшинээс өөр түвшин рүү унах 5.1%	Тоглоомын талбай ба спортын хэрэгслээс унах 4.2%

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Уналт дундаа хамгийн түгээмэл тохиолддог нэг түвшин дээр халтирч тээглэж, бүдэрч унах шалтгаан нь бүх насны бүлэгт тэргүүлж байгаа бол 0-4 насанд орноос унах тохиолдол цөөнгүй байна. Удаах шалтгаануудад шат гишгүүрээс унах болон цас мөсөн дээр халтирч унах багтаж байна.



Хүснэгт 7.34. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, насны бүлэг тэргүүлэх шалтгааны матриц, 2025 он

Насны бүлэг	Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 43.5%	Орноос ойчих 25.2%	Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 7.1%	Сандлаас унах 5.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.3%
5-9	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 45.4%	Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 21.9%	Тэшүүр, дугуйт хавтангаар гулгах үед 6.3%	Шат гишгүүрээс ойчих 6.2%	Орноос ойчих 5.9%
10-14	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 64.5%	Шат гишгүүрээс ойчих 9.2%	Тоглоом ба спортын талбайн хэрэгслээс унах 6.7%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.3%	Тэшүүр, дугуйт хавтангаар гулгах үед 4.7%
15-19	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 68.2%	Шат гишгүүрээс ойчих 10.6%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.6%	Тэшүүр, дугуйт хавтангаар гулгах үед 3.2%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 3.1%
20-24	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 60.2%	Шат гишгүүрээс ойчих 14.8%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 8.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.9%	Тэшүүр, дугуйт хавтангаар гулгах үед 3.6%
25-29	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 58.1%	Шат гишгүүрээс ойчих 14.2%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 11.2%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.9%	Тэшүүр, дугуйт хавтангаар гулгах үед 2.2%
30-34	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 56.1%	Шат гишгүүрээс ойчих 14.3%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 12.1%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 6.6%	Барилга, байгууламжаас ойчих 2.0%
35-39	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.6%	Шат гишгүүрээс ойчих 15.8%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 12.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.6%	Барилга, байгууламжаас ойчих 2.2%
40-44	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.2%	Шат гишгүүрээс ойчих 15.4%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 13.8%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 8.3%	Зөөврийн шатнаас унах 2.2%
45-49	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.6%	Шат гишгүүрээс ойчих 15.4%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 14.3%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 8.1%	Зөөврийн шатнаас унах 2.5%
50-54	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.3%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 16.0%	Шат гишгүүрээс ойчих 13.9%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 7.4%	Сандлаас унах 2.1%
55-59	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 56.9%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 16.7%	Шат гишгүүрээс ойчих 12.3%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.6%	Сандлаас унах 2.6%
60-64	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 58.2%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 16.9%	Шат гишгүүрээс ойчих 11.7%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.4%	Сандлаас унах 4.1%
65-69	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 61.0%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 16.6%	Шат гишгүүрээс ойчих 11.1%	Сандлаас унах 4.1%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 2.7%
70+	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 67.2%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 10.7%	Шат гишгүүрээс ойчих 8.9%	Орноос ойчих 4.9%	Сандлаас унах 4.5%

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I "Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан"

2025 онд унаж гэмтсэний улмаас тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлыг гэмтлийн байршлаар авч үзэхэд шагай ба тавхайн гэмтэл 21.9% /20458/, тохой ба шууны гэмтэл 15.8% /14741/, өвдөг ба шилбэний гэмтэл 15.2% /14202/, толгойн гэмтэл 12.7% /11862/-р тус тус тэргүүлж байна.


Хүснэгт 7.35. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, гэмтлийн байршил, 2025 он

Онош /Гэмтсэн эрхтний байршлаар/	2025	
	Тоо	Хувь
Толгойн гэмтэл	11862	12.7
Хүзүүний гэмтэл	502	0.5
Цээжний гэмтэл	5594	6.0
Хэвлийн гэмтэл	6378	6.8
Мөр ба бугалганы гэмтэл	6413	6.9
Тохой ба шууны гэмтэл	14741	15.8
Бугуй ба сарвууны гэмтэл	6447	6.9
Түнх ба гуяны гэмтэл	3615	3.9
Өвдөг ба шилбэний гэмтэл	14202	15.2
Шагай ба тавхайн гэмтэл	20458	21.9
Биеийн олон хэсгийн гэмтэл	101	0.1
Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл	2807	3.0
Хүндрэл	127	0.1
Нийт	93247	100.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Уналтын шалтгаант шинэ тохиолдлын 88.7 % /82 699/ нь нийслэлд бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл уналтын шалтгаанаар бэртэж, тусламж үйлчилгээ авч буй 10 хүн тутмын 9 нь нийслэлд 1 нь орон нутагт бүртгэгджээ. Уналтын шалтгаант осол гэмтэл төвийн бүс тэр дундаа Дорноговь аймагт өндөр байна.

Зураг 7.33. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, бүртгэгдсэн харьяаллаар, 2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”



Нийт тохиолдлын 32.5% гудамж, замд унаж бэртсэн байгаа бол гэртээ /хашаандаа/, спорт заал, сургууль цэцэрлэг дээрээ унаж бэртэх тохиолдлууд мөн түгээмэл байна.

Зураг 7.34. Уналтын шалтгаант шинэ тохиолдол, осол гэмтэлд өртөх үеийн байршил, 2025 он




Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

7.5.2. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/


2021-2025 онд нийт 119177 зам тээврийн ослын шалтгаант шинэ тохиолдол бүртгэгдсэн ба сүүлийн оны байдлаар 30884 тохиолдол бүртгэгдэж, тухайн шалтгаант осол гэмтэл өмнөх оноос 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2025 онд 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 90.0 тохиолдол байна.

Зураг 7.35. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, 10 000 хүнд, 2021-2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

Зураг 7.36. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, хүйсээр, 2025 он




2025 онд зам тээврийн ослын улмаас осол гэмтэлд өртсөн тохиолдлыг хүйсээр харвал нийт тохиолдлын 65.5% /20218/ эрэгтэй, 34.5% /10666/ % эмэгтэйчүүд байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-I “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”


Зам тээврийн осолд өртөж гэмтсэн тохиолдлыг насны бүлгээр харьцуулан харахад 15-19 насанд тохиолдлын тоо /4305/ болон тохиолдлын түвшин /156.3/ бусад наснаас өндөр байна.

Зураг 7.37. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, насны бүлгээр 10 000 хүнд, 2025 он




Суудлын машинтай явж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдлын 33.8%-д, ачааны машинтай явж байсан тохиолдлын 26.2% нь суудлын хамгаалах бүстэй байсан гэсэн өгүүлэмжтэй байгаа бол мориноос унасан тохиолдлын 3.0%, мотоциклтой явж байгаад унасан тохиолдлын 13.9%, дугуйтай явж байгаад зам тээврийн осолд орсон тохиолдлын 3.8% нь хамгаалах малгай хэрэглэсэн байна.

Зураг 7.38. Суудлын бүс хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар, 2025 он




Зураг 7.39. Хамгаалах малгай хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувиар, 2025 он






7.40. Зам тээврийн ослын согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, хувиар, 2025 он



Нийт тохиолдлын 7.6% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж гэмтсэн байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 "Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан"

Зураг 7.41. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн улирал, хувиар, 2025 он




Улирлаас хамаарсан ялгаа ажиглагддаг осол гэмтлийн шалтгааны нэг нь зам тээврийн осол юм. 2025 оны зам тээврийн ослын шалтгаант шинэ тохиолдлын 38% нь зуны улиралд тохиолдсон бол өвөл хамгийн бага байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 "Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан"

2025 онд зам тээврийн осолд өртсөний улмаас эмнэлэгт хандах тохиолдол 7 сард /13.6%/ бусад саруудтай харьцуулахад өндөр байжээ.


Зураг 7.42. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн сар, хувиар, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 "Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан"

Тухайн онд зам тээврийн осолд өртөх шалтгааны улмаас 7 хоногийн Даваа /15.3%/ гарагт харьцангуй их бүртгэгдсэн бол Лхагва, Пүрэв гарагт бага байна.

Зураг 7.43. Зам тээврийн ослын шинэ тохиолдол бүртгэгдсэн гараг, хувиар, 2025 он



Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 онд нийт зам тээврийн ослын 22342 (72.3%) нь нийслэлд бүртгэгдэж, 8542 (27.7%) тохиолдол бүртгэгдсэн байгаа бол нийслэлд тохиолдлын түвшин орон нутгаас 2 дахин өндөр байна.


Хүснэгт 7.36. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, бүртгэгдсэн газар, 2025 он


Бүртгэгдсэн газар	Шинэ тохиолдол		Тохиолдлын түвшин
	Бодит тоо	Хувь	
Нийслэл	22342	72.3%	133.3
Орон нутаг	8542	27.7%	48.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн бодит тоон эмхэтгэл-1 “Осол, гэмтэл гадны шалтгааны үр дагаварын тайлан”

2025 онд Өвөрхангай /859/, Архангай /820/ аймгуудад зам тээврийн ослын шалтгаант осолдох бүртгэгдсэн байгаа бол төвийн бү /3357/ бусад бүстэй харьцуулахад тохиолдол өндөр байна.

Зураг 7.44. Зам тээврийн ослын шинэ тохиолдол, бүртгэгдсэн харьяаллаар, 2025 он





БҮЛЭГ 8

ХҮН АМЫН
НАС БАРАЛТ



Сүүлийн 10 жилийн дундаж

17.4
мянга



Эрэгтэй
61.3%



Эмэгтэй
38.7%

Шалтгаанаар авч үзвэл



Зүрх судасны
тогтолцооны өвчин **32.7%**



Хавдар **24.7%**



Осол гэмтэл,
гадны шалтгаан **17.0%**

2025 оны нас баралт



17.9
мянга



10 жилийн
дундаас



+515 хүн
(3.0%)



Өмнөх оноос



+580 хүн
(3.2%)

Нас баралтын ерөнхий коэффициент



2025 онд
5.2



1000 эрэгтэй
хүн амд

6.6



1000 эмэгтэй
хүн амд

3.9

Тэргүүлэх 5 шалтгаан

10 000 хүн амд ногдох нас баралт



Зүрх судасны
тогтолцооны өвчин



16.7



Хавдар



12.8



Осол гэмтэл,
гадны шалтгаан



9.5



Хоол боловсруулах
тогтолцооны эмгэг



3.4



Амьсгалын
тогтолцооны эмгэг



2.8

БҮЛЭГ 8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

Монгол Улсад хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгаанд 1990 оноос өмнө амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1990 оноос хойш зүрх судасны шалтгаант өвчин тогтмол тэргүүлэн улмаар өсөх хандлагатай болсон. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 1950-иад онд 7.1 хувь, 1985 онд 23.4 хувь, 1995 оноос 30.8 хувийг эзэлж байсан ба 2025 оны байдлаар 32.0 хувь байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын дийлэнх хувийг артерийн даралт ихсэлт, зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлж байна.

8.1. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 17.4 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 61.3 хувь нь эрэгтэйчүүд, 38.7 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (32.7%), хавдар (24.7%), осол гэмтэл, гадны шалтгаан (17.0%) зонхилж байна.


8.1.1. НАС БАРАЛТЫН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТИЙН ӨӨРЧЛӨЛТ

Нас баралтын ерөнхий коэффициент 2025 онд 5.2 байгаа бөгөөд 1 000 эрэгтэй хүнд 6.6, эмэгтэй хүнд 3.9 тус тус байна. Хүйсийн ялгаа нь тогтмол хадгалагдаж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын коэффициент эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 1.7 дахин өндөр хэвээр байна.

Цаг хугацааны хандлагыг авч үзвэл 2020–2021 онд нийт коэффициент 4.9→6.1 болж өссөн нь COVID-19 цар тахлын нөлөөг тусгаж байна. 2022 оноос хойш нийт коэффициент 5.2–5.4 хооронд тогтворжсон байна. Эрэгтэйчүүдийн коэффициент 2021 онд 7.3 болж оргил цэгтээ хүрсний дараа аажмаар буурч 2025 онд 6.6 болсон. Нас баралтын ерөнхий коэффициентийн хүйсийн тогтмол зөрүү нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 9 жилээр богино байгаатай холбоотой бөгөөд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн дэмжлэг, урьдчилан сэргийлэлтийн үйлчилгээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатайг харуулсаар байна.

Хүн амын нас баралт 2025 онд 17.9 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 515 хүн (3.0%)-ээр нэмэгдэж, өмнөх оноос 206 (1.1%) хүнээр буурсан байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2025 онд 5.2 байгаа бөгөөд 1000 эрэгтэй хүн амд 6.6, эмэгтэй хүн амд 3.9 тус тус байна.

Зураг 8.1. Нас баралтын ерөнхий коэффициент, хүйсээр, 2016-2025 он




Нас баралтын өөр нэг үзүүлэлт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициент (НБНБК) бөгөөд хүйс тус бүрээр НБНБК-ийн дүрслэлийг 2025 оны байдлаар үзүүллээ. Манай



улсын хувьд нялхсын эндэгдэл өндөр биш тул доорх дүрслэл нь “J” хэлбэртэй байгааг харж болно. Мөн бүх насны бүлэг дээр эрэгтэйчүүдийн нас баралтын коэффициент өндөр байна.


Нас баралтын насны бүлгийн хуваарилалт нь хоёр тэргүүлэх чиглэлийг тодорхойлж байгаа бөгөөд нэгдүгээрт, нярай болон бага насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, хоёрдугаарт, дунд болон идэр насны эрэгтэйчүүдийн эрт нас баралтын шалтгааныг бууруулах чиглэлд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Зураг 8.2. Насны бүлэг дэх нас баралтын коэффициент, хүйсээр, 2025 он



Нас баралтын түвшний хүйсийн харьцааг 2025 оны байдлаар насны бүлэг тус бүрээр харахад 30-34 насанд өндөр буюу 3.3 байна. Тайлангийн жилд 30-34 насны бүлэгт нийт 465 тохиолдол бүртгэгдсэнээс 358 эрэгтэй, 107 эмэгтэй байгаа ба тухайн насны 10 000 эрэгтэй хүн амд харьцуулахад 26.8, эмэгтэй хүн амд 8.1 байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын шалтгаанд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг 62 хувийг эзэлж байна.

Зураг 8.3. Нас баралтын түвшний хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2025 он



Мөн 40-44, 50-54 насанд хүйсийн харьцаа 3.2 байгаа нь тухайн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдтэй харьцуулахад бусад насны бүлгээс өндөр байна. Нас баралтын шалтгаанаар авч үзвэл тухайн насны бүлгийн эрэгтэйчүүд осол гэмтэл, гадны шалтгаан, эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2.9-5.7 дахин их байгаа ба хамгийн түгээмэл шалтгаан нь архины хордлого, амиа хорлолт, зам тээврийн осол байна.

Мөн тухайн насны эрэгтэйчүүдийн зүрх судасны өвчний шалтгаант нас баралт эмэгтэйчүүдийн нас баралттай харьцуулахад 4 дахин өндөр байна

Нас баралтыг насны бүлэгт эзлэх хувиар харвал нас барсан эрэгтэйчүүдийн 45.7%, эмэгтэйчүүдийн 71.6% нь тэтгэврийн насандаа нас барсан байна. Эрэгтэйчүүдийн 48.7%, эмэгтэйчүүдийн 21.0% нь хөдөлмөр эрхлэх насандаа нас барсан байна. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс 2.3 дахин илүү байна.

8.1.2. НАС БАРАЛТЫН НАСНЫ БҮТЭЦ, ХҮЙСЭЭР


Нийт нас баралтын 62.4% нь эрэгтэйчүүд (11 177), 37.6% нь эмэгтэйчүүд (6 730) ийн нас баралт бүртгэгдсэн ба эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.7 дахин өндөр байна.

Энэ үзүүлэлт нийт нас баралтад тухайн насны бүлэг хэдэн хувийг эзэлж байгааг харуулж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралт дунд болон идэр насны бүлгүүдэд илүү өндөр хувийг эзэлж байна.

Тухайлбал 55–64 насны бүлэгт эрэгтэйчүүд нийт нас баралтынхаа 10.9-12.4%-ийг эзэлж байгаа нь эмэгтэйчүүдийн 7.2–9.4%-аас мэдэгдэхүйц өндөр байна. Энэ нь дунд насны эрэгтэйчүүдийн зүрх судасны өвчин, осол гэмтлийн эрт нас баралтын нөлөөг тод харуулж байна. Харин 85+ насны бүлэгт эрэгтэйчүүд 5.3% эзэлж байгаа нь эмэгтэйчүүдийн 16.1%-аас гурав дахин бага байна. Эмэгтэйчүүдийн нас баралт ахмад насны бүлгүүдэд илүү төвлөрч байна. 85+ насны бүлэгт эмэгтэйчүүд нийт нас баралтынхаа 16.1%-ийг эзэлж байгаа нь бүх насны бүлгийн хамгийн өндөр байна.

Эрэгтэйчүүдийн нас баралт дунд нас (40–69)-нд, эмэгтэйчүүдийнх ахмад нас (75+)-д төвлөрч байна. Энэ хэв маяг нь эрэгтэйчүүдийн эрт нас баралтыг бууруулахад дунд насны бүлгийг онцолсон урьдчилан сэргийлэлтийн бодлого чухал болохыг, харин эмэгтэйчүүдийн хувьд ахмад насны тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн хүртээмжийг сайжруулах шаардлагыг онцлон харуулж байна.

Зураг 8.4 Насны бүлэг дэх нас баралтын хувь, хүйсээр, 2025 он






8.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 10 000 хүн амд 16.7, хавдар 12.8, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 9.5, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 3.4, амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт 2.8 байгаа нь тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Зураг 8.5. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүнд, 2016-2025 он



Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг хүйсээр ялгаж харуулбал эрэгтэйчүүдийн нийт нас баралт (66.0) эмэгтэйчүүдийнхтэй (38.7) харьцуулахад 1.7 дахин өндөр байна. Бүх шалтгааны хувьд эрэгтэйчүүд давамгайлж байгаа нь онцлог бөгөөд ялангуяа осол гэмтэл, гадны шалтгааны хувьд эрэгтэй (15.1) эмэгтэйгийн (4.0)-өөс 3.8 дахин их байгаа нь хамгийн тод ялгаа юм. Зүрх судасны өвчнөөр эрэгтэй (21.0) эмэгтэйгийн (12.5)-өөс 1.7 дахин их байна.

Осол гэмтэл, гадны шалтгааны хувьд 20-44 насны эрэгтэйчүүдэд хамгийн өндөр буюу 18.3 байгаа нь бусад насны бүлгүүдтэй харьцуулахад онцгой өндөр үзүүлэлт юм. Энэ нь идэр насны эрэгтэйчүүдийн осол гэмтэл, амиа хорлолт, хордлогын өндөр эрсдэлийг тодоор харуулж байна.


Байршлаар харуулбал: хот (54.6) болон хөдөөгийн (49.8) нас баралтын ялгаа харьцангуй бага боловч шалтгааны бүтцэд зөрүү байна. Хотод зүрх судасны өвчин (15.9), хавдар (12.7) давамгайлж байхад хөдөөд мөн зүрх судасны өвчин (17.5) харьцангуй өндөр байна. Бүсийн харьцуулалтаар Хангайн бүс (52.3) хамгийн өндөр нийт нас баралттай байгаа бол Баруун бүс (43.0) хамгийн бага байна. Төвийн бүс (52.2) болон Зүүн бүс (50.5) улсын дундажтай (52.2) ойролцоо байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралт Хангайн (19.4) болон Баруун (16.9) бүсэд харьцангуй өндөр байна.

Нас баралтын түвшинг аймгуудаар харьцуулахад 1000 хүнд ногдох нас баралтын тохиолдол 5.2 байгаа бөгөөд аймгуудын хооронд харьцангуй жигд тархалттай, 4.5–5.5 хооронд байгаа ч бүс нутгаар харвал тодорхой зөрүү ажиглагдаж байна. 2025 онд Булган (6.1), Дорноговь (6.0) улсын дунджаас 1.0-оор өндөр, харин Ховд (3.5), Өмнөговь (3.8), Баян-Өлгий (4.1) хамгийн бага түвшинтэй байна. Ховд аймаг улсын дунджаас 1.7-оор доогуур байна.

Хүснэгт 8.1. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүнд, 2025 он

Үзүүлэлт	Нийт нас баралт	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Осол гэмтэл, гаднын шалтгаант	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
Хүйс						
Эрэгтэй	66.0	21.0	14.8	15.1	4.1	3.5
Эмэгтэй	38.7	12.5	10.8	4.0	2.8	2.2
Насны бүлэг						
Эрэгтэй						
20 хүртэлх	10.4	0.2	0.4	2.9	0.1	0.8
20-44	32.8	5.2	2.0	18.3	3.1	1.3
45-65	148.1	48.6	38.0	32.9	11.1	6.8
65 ба түүнээс дээш	493.5	221.2	151.5	25.4	19.2	31.2
Эмэгтэй						
20 хүртэлх	8.2	0.2	0.4	1.8	0.2	0.7
20-44	10.9	1.5	1.8	4.6	0.9	0.4
45-65	50.3	13.9	17.3	6.4	5.1	1.8
65 ба түүнээс дээш	307.6	130.5	92.7	5.7	19.3	19.9
Байршил						
Хот	54.6	15.9	12.7	11.2	3.9	3.0
Хөдөө	49.8	17.5	12.9	7.8	3.0	2.6
Бүсээр						
Баруун	43.0	16.9	11.8	4.3	2.1	1.9
Хангайн	52.3	19.4	12.7	8.6	2.6	2.5
Төв	52.2	16.7	12.5	9.9	3.9	3.4
Зүүн	50.5	15.2	16.0	7.1	3.8	2.7
Улсын дундаж	52.2	16.7	12.8	9.5	3.4	2.8

Зураг 8.6. Хүн амын нас баралтын түвшин, 1000 хүнд, 2025 он





8.3. ЗАЙЛСХИЙЖ БОЛОХ НАС БАРАЛТ

2025 онд нийт нас баралтын 17 907 тохиолдлоос 13 859 буюу 77.4% нь 75-аас доош насанд тохиолдсон байна. Нийт нас баралтаас зайлсхийж болох нас баралтыг аргачлалын дагуу тооцоолж үзэхэд 49.9%, 75-аас доош насанд 64.4% нь зайлсхийж болох нас баралт байна. Өөрөөр хэлбэл, 75-аас доош насны нас баралтын 3 тохиолдлын 2 нь урьдчилан сэргийлэх эсвэл цаг тухайд эмчлэх боломжтой байсан гэсэн үг юм.

Зайлсхийж болох нас баралтыг сэргийлж болох ба эмчлэгдэх боломжтой гэж 2 хэлбэрт хуваадаг 2025 оны байдлаар нийт нас баралтын тохиолдлын 42.9%, 75-аас доош насны тохиолдлын 55.5% нь урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр бууруулж болох байсан байна. Энэ бүлэгт зүрх судасны өвчин, хавдрын эрт илрүүлэлт, тамхи татахаас татгалзах, архидалт бууруулах, биеийн тамирын дасгал хийх зэрэг амьдралын хэв маягийн өөрчлөлт болон нийгмийн орчны сайжруулалтаар бууруулж болох нас баралтууд багтана.

2025 оны бүртгэгдсэн нас баралтын тохиолдлоос эмчлэгдэх боломжтой нас баралт нийт нас баралтын 28.4%, 75-аас доош насанд 36.7% нь эрүүл мэндийн тогтолцооны цаг алдалгүй, чанартай үйлчилгээгээр аврагдах боломжтой байсан байна. Нийт 75-аас доош насны нас баралтын 64.4% нь хүний амь нас зайлсхийж болох байсан гэдэг нь эрүүл мэндийн бодлого боловсруулагчдад хамгийн чухал дохио юм.

Ялангуяа сэргийлж болох нас баралт (7 686) нь нийгмийн орчин, амьдралын хэв маягийн өөрчлөлтийг дэмжих бодлогоор, эмчлэгдэх боломжтой нас баралт (5 080) нь эрүүл мэндийн тогтолцооны чанар, хүртээмжийг сайжруулах замаар бууруулах боломжтой байгаа нь эдгээр чиглэлд анхаарал хандуулах шаардлагыг тодорхой харуулж байна.

Хүснэгт 8.2. Зайлсхийж болох нас баралтын эзлэх хувь, 2025 он

Үзүүлэлт	Нийт нас баралтын тохиолдолд эзлэх хувь	75-аас доош насны тохиолдолд эзлэх хувь	Тайлбар
Зайлсхийж болох нас баралт	49.9%	64.4%	Сэргийлж болох + Эмчлэгдэх
Сэргийлж болох	42.9%	55.5%	Урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр
Эмчлэгдэх боломжтой	28.4%	36.7%	Цаг алдалгүй эмчилгээгээр
Зайлсхийх боломжгүй	27.5%	35.6%	75-аас доош, зайлсхийх боломжгүй


8.4. ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Зүрх судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5500-6000 хүн нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна.

Хүн амын нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 62.0% эрэгтэйчүүд, 38.0% нь эмэгтэйчүүд байна. Зүрх судасны тогтолцооны өвчнөөс зүрхний ишемит өвчин, тархины цус харвалт өвчний нас баралт 57.8 хувийг эзэлж байна. Эдгээр нийтлэг өвчин тус бүрд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6 дахин их байна.


Нас барсан хүмүүсийн насны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа нас барсан нь эрэгтэйчүүдийн дийлэнх нь 90.8 хувийг 45-аас дээш насныхан, эмэгтэйчүүдийн дийлэнх нь 86.5 хувийг 55-аас дээш настай байгаагаас харагдаж байна. Эрэгтэйчүүдийн 38.5%, эмэгтэйчүүдийн 13.1% нь хөдөлмөр эрхлэх насандаа зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан байна. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүнд 21.0, 10 000 эмэгтэй хүнд 12.5 ногдож байна.

Зураг 8.7. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин, нийт нас баралтад эзлэх хувь, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он



Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин Хангайн бүсийн аймгуудад 10 000 хүнд 19.4, Баруун бүсийн аймгуудад 16.9 байгаа нь улсын дунджаас өндөр харин Төвийн бүсийн аймгууд болон Улаанбаатарт улсын дундажтай ижил, Зүүн бүсийн аймгуудад улсын дунджаас бага байна.


Зураг 8.8. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, бүсээр, 2025 он




Булган аймагт 10 000 хүнд ногдох нас баралтын түвшин (24.0) байгаа нь улсын дунджаас 7.3-оор өндөр бөгөөд аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Мөн Дундговь (22.6), Архангай (21.5), Хөвсгөл (21.9) удаалж байна. Хангайн болон Төвийн бүсийн аймгуудад зүрх судасны өвчний нас баралт харьцангуй өндөр байна.



Зураг 8.9. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, аймгаар, 2025 он



Зураг 8.10. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, насны ангиллаар, хувь, 2025 он




Зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барсан хүмүүсийн 92.6 хувийг 45-аас дээш насныхан эзэлж байна. Зүрх судасны тогтолцооны өвчний дотор зүрхний шигдээс 41.3 хувь, тархинд цус харвах өвчин 18.2 хувийг эзэлж байна. Зүрх судасны тогтолцооны өвчний нас баралтыг байршлаар харвал Улаанбаатарт 45.3 хувь нь бүртгэгдсэн байна.

Зүрхний шигдээс өвчний шалтгаанаар нийт 2310 хүн нас барсан нь сүүлийн 10 жилийн дунджаас 184 тохиолдлоор, өмнөх

оноос 79 тохиолдлоор тус тус буурсан байна. 10000 эрэгтэй хүн амд 8.82, эмэгтэй хүн амд 4.7 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.9 дахин их байна.

Зураг 8.11. Зүрхний шигдээсээр нас баралтын түвшин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он



Хүснэгт 8.3. Тархинд цус харвалтын шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он

Тархинд цус харвах							
Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт нас баралт	4.52	3.97	4.28	4.03	3.42	3.10	2.92
20 хүртэлх	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.06
20-44	1.2	0.9	1.1	1.1	1.1	0.9	0.84
45-65	12.4	10.6	10.6	10.8	8.7	8.2	7.26
65 ба түүнээс дээш	41.8	37.4	39.9	34.4	28.4	23.6	20.33
Эрэгтэй	5.33	4.72	5.26	5.07	4.10	3.96	3.60
20 хүртэлх	0.1	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.07
20-44	1.7	1.2	1.5	1.6	1.4	1.4	1.26
45-64	16.8	15.0	14.2	16.1	12.6	11.9	10.07
65 ба түүнээс дээш	52.0	46.1	58.0	43.9	36.0	31.8	27.21
Эмэгтэй	3.73	3.25	3.32	3.03	2.75	2.27	2.27
20 хүртэлх	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.05
20-44	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.5	0.40
45-64	8.7	6.8	7.5	6.2	5.4	4.9	4.78
65 ба түүнээс дээш	35.2	31.8	28.3	28.2	23.7	18.4	16.02



Хүснэгт 8.4. Артерийн даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он

Артерийн даралт ихсэх өвчин							
Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт нас баралт	0.47	0.42	0.76	0.46	0.47	0.66	0.66
20 хүртэлх	0.00	0.01	0.00	0.00	0.00	0.00	0.00
20-44	0.04	0.02	0.07	0.02	0.02	0.04	0.04
45-64	0.53	0.53	1.00	0.45	0.46	0.58	0.60
65-аас дээш	8.60	7.09	12.13	8.06	7.59	9.99	9.14
Эрэгтэй	0.45	0.46	0.71	0.48	0.47	0.68	0.68
20 хүртэлх	0.00	0.02	0.00	0.00	0.00	0.00	0.00
20-44	0.06	0.02	0.11	0.05	0.02	0.07	0.05
45-64	0.66	0.75	1.39	0.87	0.66	0.99	1.03
65-аас дээш	9.40	9.14	11.81	8.51	8.72	11.29	10.49
Эмэгтэй	0.49	0.37	0.80	0.44	0.48	0.64	0.63
20 хүртэлх	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
20-44	0.02	0.02	0.02	0.00	0.02	0.02	0.03
45-64	0.42	0.34	0.66	0.09	0.29	0.22	0.22
65-аас дээш	8.08	5.77	12.34	7.78	6.88	9.17	8.30

Хүснэгт 8.5. Зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2019-2025 он

Зүрхний ишеми өвчин							
Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт нас баралт	7.75	6.78	8.89	7.70	7.38	6.99	6.73
20 хүртэлх	0.09	0.06	0.09	0.02	0.03	0.03	0.01
20-44	1.39	1.17	1.24	1.21	1.22	0.95	1.04
45-65	13.72	11.27	13.36	12.86	12.31	11.65	11.42
65 ба түүнээс дээш	112.32	97.24	130.73	102.44	91.11	82.00	71.61
Эрэгтэй	9.56	8.49	10.49	9.27	9.16	9.01	8.82
20 хүртэлх	0.11	0.06	0.09	0.04	0.03	0.06	0.00
20-44	2.06	1.88	1.90	1.95	1.92	1.57	1.74
45-64	23.37	19.76	22.69	21.87	21.05	20.52	20.36
65 ба түүнээс дээш	140.97	124.16	159.94	127.63	116.99	110.58	97.57
Эмэгтэй	5.99	5.11	7.34	6.15	5.65	5.02	4.69
20 хүртэлх	0.07	0.05	0.08	0.00	0.03	0.00	0.02
20-44	0.72	0.47	0.57	0.47	0.52	0.33	0.32
45-64	5.32	3.89	5.25	5.24	4.69	3.86	3.51
65 ба түүнээс дээш	93.74	79.91	112.04	86.98	74.71	64.01	55.38

8.5. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ТУСГАГДСАН ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Тогтвортой хөгжлийн зорилтын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг хэмжих нэг шалгуур үзүүлэлт нь 30-70 насны хүн амын дунд бүртгэгдсэн 4 гол шалтгаан болох зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтаар хэмждэг.

Эрүүл мэндийн статистикаар 2025 онд зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчнөөр нас барсан 30-70 насны шалтгаант нас баралтын 6608

тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 36.9 хувийг эзэлж байна. Эдгээр өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 2025 оны байдлаар тухайн насны 10 000 эрэгтэйд 61.1, эмэгтэйд 25.3 байна.

Үүнээс 30-70 насны хүн амын дунд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт нийт 3276 тохиолдол бүртгэгдэж, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад 21.1 байгаа нь өмнөх оноос 0.8-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлтийг хүйсээр харьцуулбал эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 3 дахин өндөр бүртгэгдсэн байна.


Зураг 8.12. 30-70 насны хүн амын дундах зүрх судасны өвчин, тухайн насны 10 000 хүнд, 2016-2025 он



Мөн тогтвортой хөгжлийн зорилтод дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын түвшинг 25 ба түүнээс дээш насны хүн амын дунд бүртгэгдсэн зүрхний ишеми, тархинд цус харвалтын шалтгаант нас баралтыг 100 000 хүнд харьцуулсан тооцооллоор хэмжиж харуулдаг.

2025 оны эрүүл мэндийн статистикаар Монгол улсын хүн амын дундах дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралтын шалтгаан болох зүрхний ишеми, тархинд цус харвалтын шалтгаант нас баралтыг 25 ба түүнээс дээш насанд бүртгэгдсэн тохиолдлыг тухайн насны 100 000 хүнд харьцуулан харууллаа.


Зураг 8.13. Зүрхний ишеми өвчний шалтгаант нас баралтын түвшин, 25 ба түүнээс дээш нас, тухайн насны 100 000 хүнд, 2016-2025 он



Тайлбар: Зураг 8.13-2024 оны тооцоололд засвар орсон болно.



Зураг 8.14. Тархинд цус харвалтын шалтгаант нас баралтын түвшин, 25 ба түүнээс дээш нас, тухайн насны 100 000 хүнд, 2016-2025 он




8.6. ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Хавдраас шалтгаалсан нас баралт 1990 оноос хойш нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр авч үзэхэд 58.0 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж, нас барж байна. Насны хувьд 40-өөс дээш насныхан 95.5 хувийг эзэлж байна.

Хавдрын шалтгаант нас баралт 2025 онд нийт нас баралтын 24.5 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүнд 14.8, 10 000 эмэгтэй хүнд 12.8 байна. Нас баралт хүйсийн хувьд 57.2% нь эрэгтэй, 42.8% нь эмэгтэй байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.3 дахин их байна. Хавдрын төрлийн хувьд дийлэнх буюу 62.6% нь элэг ба элгэн дэх цэсний сувгийн хорт хавдар, ходоодны хорт хавдар болон амьсгуурсны (бронхын) ба уушгины хорт хавдраас болж нас барсан байна.


Зураг 8.15. Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он



Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушги, гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, харин эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушги, гуурсан хоолойн хорт хавдрын нас баралт тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Элэгний өвчлөл өндөр байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн элэгний хорт хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна.

Зураг 8.16. Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025



8.7. ОСОЛ ГЭМТЭЛ, ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт нь монгол хүний нас баралтын 3 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд 2025 оны байдлаар нийт нас баралтын 18.1 хувийг эзэлж байна. Зам тээврийн осол, амиа хорлолт, үйлдвэрлэлийн осол, бусдад хорлогдсон, бусад осол, тодорхой бус гэсэн шалтгаануудаар эрэгтэй хүмүүсийн нас баралт эмэгтэйдээ харьцангуй их байна.


Хүснэгт 8.6. Хүн амын нас баралтын хэлбэр, хувиар сонгосон онуудаар

Хэлбэр	2010		2015		2020		2025	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Өвчлөл	81.6	97.2	75.6	75.6	75.6	90.4	83.6	92.8
Бусад осол	11.3	4.6	14.1	14.1	14.1	6.2	5.7	3.1
Зам тээврийн осол	3.8	1.8	3.2	3.2	3.2	1.5	3.6	2.0
Амиа хорлосон	3.9	1.1	4.1	4.1	4.1	1.1	4.3	1.2
Бусдад хорлогдсон	2.3	1.0	1.5	1.5	1.5	0.5	1.6	0.6
Тодорхой бус	0.7	0.2	0.9	0.9	0.9	0.2	1.2	0.3
Үйлдвэрийн осол	0.4	0.1	0.2	0.2	0.2	0.0	0.2	0.0

Улсын хэмжээнд 2025 онд 10-34 насны хүүхэд, залуучуудын нас баралтын шалтгааны 63.5 хувийг осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт эзэлж байгаа ба үүнээс 15-19 насныхны 69.5 хувь нь осол гэмтэл, гадны шалтгааны улмаас амиа алдсан байна. Мөн 10-14 насны хүүхдүүдийн 45.8 хувь, 20-24 насны залуучуудын 73.3 хувь, 25-29 насны залуучуудын 69.6 хувь нь гадны шалтгааны улмаас амь насаа алдсан байна.




Зураг 8.17. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, 10 000 хүнд, 2016-2025 он



8.7.1 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Зам тээврийн ослын шалтгаант нас баралт осол гэмтлийн нас баралтын 16.5 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаар 506 хүн нас барсан байна. Зам тээврийн ослоор 2025 онд 536 хүн нас барсан нь сүүлийн 10 жилийн дунджаас 30 тохиолдлоор, өмнөх оноос 8 тохиолдлоор тус тус өссөн байна. Эрэгтэйчүүдийн зам тээврийн осолд өртөж амь насаа алдах явдал эмэгтэйчүүдээс 2.9 дахин их байна.

Зураг 8.18. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүнд, 2016-2025 он




Зам тээврийн ослын шалтгаант нас баралтад бусад тээврийн осол 54.3%, мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орсон 16.6%, явган зорчигч зам тээврийн осолд орсон 28.2%-ийг тус тус эзэлж байна. Хүйсийн хувьд бусад тээврийн ослын улмаас нас барсан эрчүүд эмэгтэйчүүдээс 2.9 дахин их, явган зорчигч нас барсан тохиолдол 3.4 дахин их байгаа бол мотоциклтой зорчигч нас барсан тохиолдол эрэгтэйчүүд 17 дахин их байна.

8.19. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, 2025 он



2025 онд зам тээврийн ослоор нас барсан тохиолдлыг насны ангиллаар харуулбал: 15 хүртэлх насны хүүхэд 10.3 хувь, 15-29 насныхан 15.9 хувийг эзэлж байгаа ба 30-39 насныхан 20.5 хувь, 40-49 насныхан 25.6 хувь, 50-59 насныхан 18.7 хувийг эзэлж байгаа нь насны ангилал дотроо өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 8.20. Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, шалтгаанаар, хувь, 2016-2025 он




8.7.2. АМИА ХОРЛОЛТ

Амиа хорлож нас барсан тохиолдлын тоо 2025 онд 561 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 59, өмнөх онтой харьцуулахад 37 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. 10 000 хүнд харьцуулсан түвшин 1.6 байна. Шалтгаанаар авч үзвэл 90.6 хувь нь өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боомилох, амьсгал боох, 3.4 хувь нь өөрийгөө галт зэвсгээр хөнөөх, 2.0 хувь нь санаатайгаар өөрөө өндрөөс үсрэх, 0.5 хувь нь эмийн бодисоор өөрийгөө хордуулах, 3.2 хувь нь бусад аргаар өөртөө гэмтэл учруулж нас барсан байна.



Зураг 8.21. Амиа хорлож нас барсан тохиолдол, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он




8.7.3. БУСАД ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


Бусад ослын шалтгаант нас баралтаас архины хордлогын шалтгаант нас баралт 52.1 хувийг эзэлж байгаа ба ус, гал, хий, байгалийн хүчинд өртсөн осол 26.5 хувийг эзэлж байна.

Бусад осолд спиртэд хордох, байгалийн хүчинд өртөх, усанд живэх, амьсгал боох бусад аюултай осол, хий, ууранд санамсаргүй хордох, өртөх, барилга байгууламжаас унах, бусад өндрөөс унах, амьгүй механик хүчинд өртөх зэрэг ослууд орж байна. Эдгээр эрсдэлт ослуудын бүх төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их өртсөн байгаагаас спиртэд хордох, байгалийн хүчинд өртөх, амьгүй механик хүчинд өртөх гэсэн төрлүүдэд хамгийн их буюу эрэгтэйчүүд 80-88%-ийг эзэлж байна.

Зураг 8.22. Архи, спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдол, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он



Зураг 8.23. Нас баралтын бусад ослын шалтгаан, хувь, 2025 он




8.8. ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 2016 онд нийт нас баралтын 7.4 хувийг эзэлж байсан бол 2025 онд 1181 тохиолдол буюу 6.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар 1179 тохиолдол бүртгэгдсэн ба 2025 онд сүүлийн 10 жилийн дунджаас 2 тохиолдлоор нэмэгдэж, өмнөх оноос 46 тохиолдлоор буурсан байна.

Хүн амын нас баралтын дөрөвдөх тэргүүлэх шалтгаан болох хоол боловсруулах тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 59.2% эрэгтэйчүүд, 40.8% нь эмэгтэйчүүд байна.


Зураг 8.24. Хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүнд, хүйсээр, 2016-2025 он



Хоол боловсруулах тогтолцооны шалтгаант нас баралтын 52.5 хувийг элэгний цирроз ба фиброзын шалтгаант нас баралт эзэлж байна. Насны ангиллаар 35-69 насныхан 76 хувь буюу дийлэнх хувийг эзэлж, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй 1.2 дахин их байна.




Зураг 8.25. Элэгний циррозын шалтгаант нас баралт, хувь, хүйсээр, 2016-2025 он



8.9. АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Улсын хэмжээнд 2025 онд амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 968 тохиолдол бүртгэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаас 152 тохиолдлоор нэмэгдэж, өмнөх оноос 25 тохиолдлоор буурсан байна. Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын 61 хувь нь эрэгтэй, 39 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 8.26. Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, 2016-2025 он




Уушгины хатгалгааны шалтгаант нас баралт нийт амьсгалын тогтолцооны өвчний нас баралтад эзлэх хувь 2016 оны 61.4%-иас 2021 онд 60.7% болсон 2025 онд 48.0% болж буурсан нь үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын тал хувь нь уушгины хатгалгааны улмаас нас барж байна.

Хүйсээр ангилж харвал эрэгтэйчүүдийн нас баралт тогтмол өндөр байна. 2025 онд

эрэгтэй 282, эмэгтэй 183 байгаа нь 1.5 дахин ялгаатай байна.

Зураг 8.27. Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралт, 10 000 хүнд, 2016-2025 он






БҮЛЭГ 9

ЦУС СУДЛАЛЫН САЛБАРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮЗҮҮЛЭЛТ

БҮЛЭГ 9. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАР ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДЭМБ-ын 2025 оны үзүүлэлтээр дэлхийн 171 улсаас 123 нь цус сэлбэлтийн чиглэлээр үндэсний бодлоготой, 110 нь цус сэлбэлтийн аюулгүй байдал, чанарыг зохицуулах тусгай хуультай байна. Дэлхий дахинд 118.5 сая донор цусаа бэлэглэж байгаагаас дэлхийн нийт хүн амын 16%-ийг эзэлдэг өндөр хөгжилтэй орнуудад цусаа бэлэглэж буй донорууд нийт цусаа бэлэглэсэн доноруудын 40% (47.6 сая донор)-ийг бүрдүүлж байна. 1000 хүн амд ногдох цус өгөлтийн тоо улс, орнуудын эдийн засгийн түвшнээс хамааран харилцан адилгүй үзүүлэлттэй байна (Зураг 1).

Зураг 9.1. 1000 хүнд ногдох цус өгөлтийн тоо



Бүтэц зохион байгуулалт, санхүүжилтийг манай улстай хөрш зэргэлдээ зарим орнуудтай харьцуулж үзэхэд, судалгаанд хамрагдсан орнууд ЭМЯ болон Улаан загалмайн харьяанд үйл ажиллагаа явуулдаг ба санхүүжлтийн эх үүсвэр нь улсын төсөв, орон нутгийн төсөв, улаан загалмайн хамтарсан бүтэцтэй байна. Харин манай улсын хувьд ЦССҮТ нь ЭМЯ-ны харьяанд үйл ажиллагаа явуулдаг ба улсын төсөв, байгууллагын өөрийн төсөв бүрдүүлэлт зэрэг үндсэн 2 санхүүжилтийн эх үүсвэртэй байна (Хүснэгт 1).


Хүснэгт 9.1. Харьцуулсан үзүүлэлт

Улс	Харьяалал, бүтэц зохин байгуулалт	Донорын хэлбэр	Санхүүжилт	Хуульчлагдсан байдал
Япон	Японы Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн халамжийн яам Улаан загалмайн харьяаны Цусны 7 төв	“Сайн дурын”	Улсын төсөв + Улаан загалмай	1956 / 2002 Blood Law; Stable Supply Act
ОХУ	Эрүүл мэндийн яам ОХУ-ын Цусны Алба-Салбарууд оруулах	“Сайн дурын”	Улсын төсөв + бүс нутгийн төсөв	2000 Federal Blood Law
Хятад	Хятадын Улаан загалмайн Цусны Төвүүд	“Сайн дурын”	Улсын төсөв + Улаан загалмай	1998 Blood Donation Law
Солонгос	БНСУ-ын Өвчний Хяналт, Сэргийлэлтийн Агентлаг (KDCA) ын харьяанд Улаан загалмай (KRC)	“Сайн дурын”	Улсын төсөв + Улаан загалмай	2004 Blood Management Act
Монгол	Эрүүл мэндийн яам, ЦССҮТ	“Сайн дурын”	Улсын төсөв + Байгууллагын өөрийн төсөв бүрдүүлэлт	2000 Донорын тухай хууль



Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ) нь Улаанбаатар хотын хэмжээнд алслагдсан 2 дүүргийг оролцуулан нийт цус цуглуулах 5 суурин төв, орон нутагт 21 аймаг, 4 суманд нийт 27 Цусны салбар төв (ЦСТ)-тэй бөгөөд улсын хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ)-ий нөөц, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна (Зураг 2).

Зураг 9.2. Цусны салбар төвүүдийн байршил




ЦССҮТ нь улсын хэмжээнд цусны донор элсүүлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, цусны донороос цуглуулсан цусны нэгж бүрийг шинжлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах, цус, цусан бүтээгдэхүүнийг хадгалах, цусны аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжил арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхийг тусгай мэргэжлийн төв юм.

Мөн ЦССҮТ Олон улсын 3 стандарт хэрэгжүүлэгч **“АНХДАГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА”** юм.

- 2014 онд тусгай мэргэжлийн төвүүдээс анх удаа магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдаж, 2016, 2018, 2023, 2026 онуудад Магадлан итгэмжлэлд амжилттай хамрагдаж гэрчилгээгээ сунгуулсан.
- 2015 онд Эрүүл мэндийн байгууллагын лабораторийн чанар ба чадавхад тавигдах шаардлага ISO 15189:2012, (MNS ISO 15189:2015) үндэсний итгэмжлэх аудитад амжилттай хамрагдсан. 2016 онд шинэчилсэн хувилбарт шилжсэн ба 2017, 2021, 2025 онуудад тус тус 4 жилийн хугацаагаар итгэмжлүүлсэн.
- 2017 онд Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015 стандартаар баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан. 2018, 2019 онуудад магадлах, 2020 онд баталгаажуулах, 2021, 2022 онуудад магадлах, 2023 онд баталгаажуулах, 2024, 2025 онуудад магадлах аудитад тус тус хамрагдсан.
- 2018 онд ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны OHSAS 18001:2012 стандартаар баталгаажуулалт хийлгэж, 2019 онд магадлах, 2021 онд баталгаажуулах аудитад тус тус амжилттай хамрагдсан. 2022 онд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартаар баталгаажуулалт хийлгэж, 2023, 2024 онд магадлах, 2025 онд баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан.

9.1. ЦУСНЫ ДОНОР ЭЛСҮҮЛЭЛТ, УРАМШУУЛАЛ, АЛДАРШУУЛАЛТ

Олон улсын улаан загалмай нийгэмлэг, Улаан хавирга сар нийгэмлэгүүдийн холбоо (ОУУЗУХСНХ), ДЭМБ, Олон улсын цус сэлбэлтийн холбооны хандлага, зөвлөмжийг мөрдөж Монгол улсын Цусны алба 1994 оноос сайн дурын авлагагүй донорын эгнээнд нэгдсэн бөгөөд 2016 онд төрөл, төрөгсдийн донорын эзлэх хувь тэг (0%) болж сайн дурын, авлагагүй донорын эгнээнд 100% бүрэн шилжсэн.



“Цусны донорын дэлхийн өдөр”-ийг 2003 оноос эхлэн жил бүрийн 6 дугаар сарын 14-ний өдөр ДЭМБ, ОУУЗУХСНХ-той нэг урианы дор улс орон даяар жил бүр уламжлал болгон зохион байгуулж доноруудыг алдаршуулах, талархал илэрхийлэх олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.

“Сар бүрийн 3” цусаа бэлэглэх өдрийг 2015 оноос эхлэн сар бүрийн 3-ны өдөр төрийн болон төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулж байна.



“Цусаа бэлэглэх үндэсний өдөр”-ийг 2017 оноос эхлэн жил бүрийн 1 дүгээр сарын 3-ны өдөр МУЗН болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.




“Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Үндсэн Хуулийн 34 дүгээр зүйлийн 1, Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.1 дэх заалтыг үндэслэн 120 ба түүнээс дээш удаа цусаа хандивласан цусны “Хүндэт донор”-уудыг жил бүрийн 6 дугаар сарын 14-ний өдөр буюу “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Шударга журам” медалиар шагнаж байна /2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 169 дүгээр тогтоол/.




ЦССҮТ нь 2016 оноос эхлэн цусаа тогтмол өгсөн цусны донорыг цус өгөлтийн тооноос хамааран өргөмжилж, шагнаж урамшуулдаг болсон (Зураг 3).

Зураг 9.3. Цусны донор алдаршуулалтын төрөл



Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд цусны донор хадгалалт, алдаршуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсний үр дүнд нийт доноруудын дунд байнгын донорын эзлэх хувь нэмэгдэж байна. Байнгын доноруудын эзлэх хувь нэмэгдэх нь ЦЦБ-ий чанар, аюулгүй байдлыг хангах, тасралтгүй нөөц бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. 2015 онд нийт доноруудын дунд эзлэх байнгын донор 47%-ийг эзэлж байсан бол 2025 онд 70% болж сүүлийн 10 жилийн хугацаанд 23%-иар нэмэгдсэн байна (Зураг 4).

Зураг 9.4. Донорын төрөл



ДЭМБ-ын зөвлөмжөөр 1 саяас дээш хүн амтай хотод 6-8 цус цуглуулах төв ажилласан үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц хүрэлцээтэй, хэрэгцээ хангагдана гэж үздэг бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд Баянзүрх цус цуглуулах төв, Сүхбаатар цус цуглуулах төв, Дүнжингарав цус цуглуулах төв, нийслэлийн 2 алслагдсан дүүрэгт Налайх ЦСТ, Багануур ЦСТ зэрэг цус цуглуулах төвүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

ХОЁР. ЦУС ЦУГЛУУЛАЛТ

Цусны доноруудад үйлчилгээг ойртуулах зорилгоор цус цуглуулах төвийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд Улаанбаатар хотод:

**БАЯНЗҮРХ ЦУС
ЦУГЛУУЛАХ ТӨВ**

2016

01



БЗД, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө
-49, ЦССҮТ-ийн I байр

**СҮХБААТАР ЦУС
ЦУГЛУУЛАХ ТӨВ**

2018

02



СБД, 1-р хороо, С.Зоригийн гудамж-2,
ЦССҮТ-ийн II байр

**БАЯНГОЛ ЦУС
ЦУГЛУУЛАХ ТӨВ**

2015-2017

03



БГД-ийн ЭМТ-ийн 2 давхарт

**ДҮНЖИНГАРАВ
ЦУС ЦУГЛУУЛАХ**

2018

04



Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв
дотор




**World Health
Organization**
Representative Office
for Mongolia

Цаашид ДЭМБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх, өсөн нэмэгдэж буй ЦЦБ-ий хэрэгцээг хангахын тулд улсын хэмжээнд 2-3 суурин төвийг шинээр байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Цус сэлбэлт судлалын салбарын нийт цус цуглуулалт 2015 онд 30396 байсан бол 2025 онд 46723 болж 1.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2030 он хүртэл 58491 болж 2015 онтой харьцуулахад онтой харьцуулахад 1.9 дахин, 2025 онтой харьцуулахад 1.3 дахин тус тус нэмэгдэх төлөвтэй байна. 2025 оны байдлаар улсын хэмжээнд нийт цус цуглуулалтын 34626 (74%)-ийг ЦССҮТ-д, 12097 (26%)-ийг ЦСТ-д цуглуулсан үзүүлэлттэй байна (Зураг 5).




Зураг 9.5. Цус сэлбэлт судлалын салбарын цус цуглуулалт 2015-2025, 2030 он хүртэлх төлөв




2015 онд нийт цус цуглуулалтын дотор суурин хэлбэрээр цус цуглуулалт 57%-ийг эзэлж байсан бол 2025 онд 69% болж 12%-иар өссөн үзүүлэлттэй байна. Суурин төвүүдийг зорин ирж цусаа өгөх доноруудын тоо нэмэгдэх нь цусны донорын сургалт сурталчилгаа, цусны доноруудын мэдлэг, хандлагатай холбоотой. (Зураг 6).

Зураг 9.6. Цус цуглуулалтын хэлбэр, 2015-2025



Насны ангиллаар нь авч үзвэл 2025 онд цусаа бэлэглэсэн доноруудын дунд 25-44 насны донорууд 47,4%-ийг эзэлж байна (Зураг 7).

Зураг 9.7. Цусны доноруудын насны ангилал, 2025 он



9.2. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

1963 онд өнөөгийн Цус сэлбэлт судлалын салбарын Лабораторийн албаны эх суурь тавигдаж шинжилгээний хэсэг нь донорын тасагтай, чанарын хяналтын хэсэг нь үйлдвэрийн тасагтай хамт байгуулагдаж байсан.


2005 оноос эхлэн ЦССҮТ-ийн лабораторийн алба нь Гепатитын В, С вирус, ХДХВ-ийн халдварыг илрүүлэх шинжилгээнд 3-р үеийн ELISA урвалжийг ашигладаг болсон.

ДЭМБ-аас цусны албанд хэрэглэхийг зөвлөсөн Герман улсын Roche компанийн Cobas S201 PCR-ийн бүрэн автомат анализаторыг 2011 онд суурилуулж, 2012 оноос цус сэлбэлэтээр дамжих халдвар (ЦСДХ) илрүүлэх шинжилгээнд 100% нэвтрүүлж эхэлсэн.

ЦССҮТ-ийн Нэгдсэн лабораторийн алба (НЛА) нь эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхад тавигдах шаардлага MNS ISO 15189:2008 стандартаар 2015 онд анх удаа итгэмжлэгдэж улсын хэмжээнд энэхүү стандартыг хангасан 2 дах лаборатори болж байсан ба 2025 онд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2024 шинэчилсэн хувилбарын дагуу амжилттай хамрагдаж, 4 жилийн хугацаагаар итгэмжлэлийг сунгасан.

Цусаа бэлэглэсэн доноруудын сорьцод ЦСДХ болох Гепатит В, С болон тэмбүү, ХДХВ-ийг илрүүлэх шинжилгээг 100% хийдэг бөгөөд ЦСДХ ирүүлэх шинжилгээгээр хасагдалт 2015 онд 7.2% байсан бол 2025 онд 1.4% болж 5.1 дахин буурсан үзүүлэлттэй байна (Зураг 8).

Зураг 9.8. ЦСДХ илрүүлэх шинжилгээгээр хасагдалт, 2015-2025



Нэгдсэн лабораторийн алба нь 2025 оноос эхлэн донорыг цусаа өгөхийн өмнө гемоглобин метрийг ашиглан цус багадалтыг тодорхойлох, мөн цусны ерөнхий шинжилгээг хийх аргуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.


9.3. ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭ

ЦССҮТ нь 2015 онд 15 нэр төрлийн ЦЦБ үйлдвэрлэж байсан бол 2025 онд 36 нэр төрлийн ЦЦБ үйлдвэрлэж байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэнээр хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэл сүүлийн 10 жилийн хугацаанд 3.4 дахин, криопреципитатын үйлдвэрлэл 2.4 дахин, ялтаст эсийн өтгөрүүлгийн үйлдвэрлэл 13 дахин, угаасан улаан эсийн үйлдвэрлэл 2.7 дахин тус тус өссөн.

2015 онд ЦЦБ-ий үйлдвэрлэл 72.6 мян нэгж байсан бол 2025 онд 129.3 мян нэгж болж 1.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. ЦЦБ-ий үйлдвэрлэл 2030 онд 159.7 мянгад хүрч 2015 онтой харьцуулахад 2.2 дахин, 2025 онтой харьцуулахад 1.2 дахин тус тус нэмэгдэх төлөвтэй байна. 2025 оны байдлаар нийт ЦЦБ-ий 103,013 нэгж ЦЦБ (80%) нь ЦССҮТ-д, 26,303 нэгж ЦЦБ (20%) нь ЦСТ-үүдэд үйлдвэрлэсэн байна (Зураг 9).




Зураг 9.9. Цус сэлбэлт судлалын салбарын ЦЦБ-ий үйлдвэрлэл 2015-2025, 2030 он хүртэлх төлөв



ЦССҮТ-д шинээр нэвтрүүлсэн эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэх (Intercept Blood System, patogene reduction) технологи нь ЦЦБ-д агуулагдах бүрхүүлтэй, бүрхүүлгүй вирус, грам эерэг, сөрөг нян, протоза, спирохет зэргийг бүрэн идэвхгүйжүүлэх давуу талтай. Энэхүү технологийг дэлхийн 20 орны 100 гаруй Цусны албанд нэвтрүүлсэн байдаг.


ЦЦБ-ий хэрэглээ 2015 онд 52.2 мян.нэгж байсан бол 2025 онд 83.3 мян.нэгж болж 1.6 дахин өссөн байна. 2019 онд хийсэн Д.Оюунцэцэг нарын судалгаагаар ЦЦБ-ий нийт хэрэглээ 2030 он гэхэд 70 067 хүрэх төлөвтэй байсан хэдий ч хүн амын дундах өвчлөлийн байдал, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны тоо нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан 2015-2025 оны гүйцэтгэлд тулгуурласан таамаглалаар 104 240 хүрэх төлөвтэй байна (Зураг 10).

Зураг 9.10. Цус сэлбэлт судлалын салбарын ЦЦБ-ий хэрэглээ 2015-2025, 2030 он хүртэлх төлөв /нэгжээр/




МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2.15, 2.2.27-2.2.28-т заасны дагуу Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төвүүдийг байгуулахтай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ цаашид хурдтай нэмэгдэх төлөвтэй байна. Мөн түүнчлэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг 2024 оны байдлаар улсын хэмжээнд УНТЭ, ЭХЭМҮТ болон ХСҮТ-д хийдэг байсан бол 2025 оны байдлаар УХТЭ элэг шилжүүлэн суулгах, Цэргийн төв эмнэлэг бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг тус тус хийдэг болсноор ЦЦБ-ий хэрэглээ цаашид тасралтгүй нэмэгдэх төлөвтэй байна.

Зураг 9.11. ЦЦБ-ий хэрэглээ, өвчний төрлөөр, 2025 он




Бүтээгдэхүүний хэрэглээг өвчний төрлөөр нь авч үзвэл хавдар, гэмтэл, эрчимт эмчилгээ, дотрын өвчин болон төрөх эмэгтэйчүүдийн өвчлөлд 86%-ийг хэрэглэж байна (Зураг 11). Нийт ЦЦБ-ий захиалгын 66% нь төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэгт, 34% нь бусад эмнэлэг тус тус эзэлж байна (Зураг 12).

Зураг 9.12. ЦЦБ-ий хэрэглээ, эмнэлгийн төрлөөр, 2025 он



ЦССҮТ нь 2023 оноос Монголиан смарт дрон деливери ХХК, Япон улсын Ньюком групптэй хамтран эмнэлгүүдэд хүнгүй агаарын хөлөг (дрон)-өөр ЦЦБ-ий тээвэрлэлт хийх технологийг нэвтрүүлсэн. 2024 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын зөвшөөрөлтэй 3 эмнэлэг (ЭХЭМҮТ, АШУҮИС-МЯЭ, Нийслэлийн Амгалан амаржих газар)-т нийт 50 удаагийн нислэг хийж байсан бол 2025 онд 14 эмнэлэг (ЭХЭМҮТ-төрөх, ЭХЭМҮТ хүүхэд, АШУҮИС-МЯЭ, ХӨСҮТ, СБД-НЭ, Цэргийн төв эмнэлэг, Брилант, ГССҮТ, БГД эмнэлэг, ШУГТЭ, Мөнгөнгүүр, Ач, СХНЭ, СХЭМ)-т нийт 422 удаагийн нислэг хийж, өмнөх оноос 8.4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна (Зураг 13).

Зураг 9.13. ЦЦБ-ийг хүнгүй агаарын хөлгөөр тээвэрлэсэн нислэгийн тоо, 2025



2025 онд хүнгүй агаарын хөлгөөр 422 удаагийн хүргэлтээр хүлээн авсан ЦЦБ-ийг 639 өвчтөнд сэлбэснээс 434 (68%) яаралтай, 205 (32%) энгийн тээвэрлэлт байсан.



Зураг 9.14. Хүнгүй агаарын хөлгөөр тээвэрлэсэн ЦЦБ-ний тээвэрлэлтийн төрөл, 2025 он



9.4. ЦУСНЫ САЛБАР ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улаанбаатар хотын хэмжээнд алслагдсан 2 дүүрэг, орон нутагт 21 аймаг, 4 суманд нийт 27 цусны салбар төв үйл ажиллагаа явуулж байна. ЦСТ-үүд нь харъяалах нутаг дэвсгэртээ цусны донорын сургалт, сурталчилгаа, донор элсүүлэлт, хадгалалтыг удирдан зохион байгуулах, цус авах, цус цусан бүтээгдэхүүн бэлтгэх, нийлүүлэх болон цусны аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байна. 2025 оны 03 сард Дорноговь аймгийн Замын-үүд сумын Нэгдсэн эмнэлэгт цусны салбар төв шинээр байгуулагдсан ба Монгол улсад сумын түвшинд “АНХ УДАА” аферезын аппаратаар цусны донороос сийвэн цуглуулсан.




2025 онд хийсэн судалгаагаар нийт 8 ЦСТ бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. 19 ЦСТ-үүд онош зүй, эрчимт эмчилгээ, амбулатори, захиргаа, дэмжих үйлчилгээ зэрэг тасаг, нэгжүүдэд харъяалагдан үйл ажиллагаагаа явуулж байна (Зураг 15).

Зураг 9.15. ЦСТ-үүдийн бүтэц, зохион байгуулалт




ЦСТ-үүдийн нийт цус цуглуулалт 2015 онд 7024 байсан бол 2025 онд 12,097 болж 72%-иар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 16).

Зураг 9.16. ЦСТ-үүдийн нийт цус цуглуулалт, 2015-2025 он



2025 оны байдлаар ЦСТ-үүдэд 8-11 нэр төрлийн ЦЦБ үйлдвэрлэж байна. Сүүлийн 10 жилийн байдлаар ЦСТ-үүдийн нийт ЦЦБ-ий үйлдвэрлэл 2015 онд 14046 байсан бол 2025 онд 26303 болж 87%-иар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 17).

Зураг 9.17. ЦСТ-үүдэд үйлдвэрлэсэн ЦЦБ (нэгж), 2015-2025 он



Цус сэлбэлт судлалын салбарын өнгөрсөн оны ажлын үр дүн, ололт, амжилтыг дүгнэж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, цусны аюулгүй байдлыг хангахад орон нутгийн болон эмнэлгийн удирдлагын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах, холбогдох мэргэжилтнүүдийг нэгдсэн мэргэжил арга зүйгээр хангах, харилцан туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор жил бүрийн 3 дугаар сард “Цус сэлбэлт судлалын салбарын Үндэсний зөвлөгөөн”-ийг зохион байгуулдаг. Зөвлөгөөний төгсгөлд тухайн онд үйл ажиллагаагаараа тэргүүлсэн шилдэг ЦСТ-үүдийг шагнаж, урамшуулдаг ба 2025 оны үйл ажиллагаагаараа дараах ЦСТ-үүд тэргүүлсэн болно. Үүнд:





БҮЛЭГ 10

**ЭРХТЭН, ЭД, ЭС, ШИЛЖҮҮЛЭН
СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮЗҮҮЛЭЛТ**

БҮЛЭГ 10. ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Донорын тухай хууль анх 2000 онд батлагдан 2012 болон 2018 онд шинэчлэгдэн батлагдаж, 2022 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэчлэгдэн батлагдсаны дагуу 2018 онд Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Тус алба нь Эрүүл мэндийн сайдын 2018 болон 2019 оны тушаалаар батлагдсан зохицуулах журмууд болон бөөр, элэг, ясны чөмөг, нойр булчирхай шилжүүлэн суулгах заавар, аргачлалын дагуу эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажиллаж байна.

10.1. ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслыг дараах эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэж байна. Үүнд:

- Улсын нэгдүгээр төв эмнэлэгт бөөр, элэг, ясны чөмөг үүдэл эс, судас, шөрмөс шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- Хавдар судлалын үндэсний төвд элэг шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд элэг болон үр шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- Цэргийн төв эмнэлэгт бөөр шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- Улсын хоёрдугаар төв эмнэлэгт элэг шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- “Гэгээн мэлмий” эмнэлэгт нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ,
- “CLWH” үр шилжүүлэн суулгах төвд үр шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ,
- “RMC” үр шилжүүлэн суулгах төвд үр шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ,
- “Өөжинмед” үр шилжүүлэн суулгах төвд үр шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ,
- “Юнимэд интернэйшнл” эмнэлэгт үр шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ,
- “Эрүүл дөрвөн улирал” эмнэлэгт үүдэл эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт нойр булчирхай шилжүүлэн суулгах баг болон Улсын гуравдугаар төв эмнэлэгтэй хамтарсан Зүрх шилжүүлэн суулгах үндэсний баг тус тус байгуулагдан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Хүснэгт 10.1. Шилжүүлэн суулгасан бөөр, элэг, ясны чөмгөний үүдэл эсийн мэс засал/ хувиар/, 1996-2025 он

Үзүүлэлт			1996-2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	
Элэг	УНТЭ	Амьд донор	7	4	5	6	7	9	23	22	20	28	42	50	52	55	
		Амьгүй донор	-	-	-	-	2	0	0	4	3	3	1	1	3	-	
	ХСҮТ	Амьд донор	-	-	-	-	-	-	-	7	9	8	9	30	49	51	58
		Амьгүй донор	-	-	-	-	-	-	-	0	4	1	4	1	1	1	-
	ЭХЭМҮТ	Амьд донор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	2	2
		Амьгүй донор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
УХТЭ	Амьд донор															5	
Бөөр	УНТЭ	Амьд донор	56	12	18	15	16	18	23	18	23	14	36	35	40	55	
		Амьгүй донор	8	0	0	0	4	0	2	11	6	8	4	4	10	-	
	ЦТЭ	Амьд донор															5
Ясны чөмөг, үүдэл эс	УНТЭ	Ауто	-	-	1	1	2	3	7	6	4	0	6	2	4	1	
		Алло	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	1	-

Монгол улсад 1996-2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад нийт 1175 эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээ хийгдсэн. Үүнээс 87.8 хувийг эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, 3.2 хувийг ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ, 9.0 хувийг нүдний эвэрлэг болон шөрмөс шилжүүлэн суулгах мэс засал эзэлж байна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын 42.7 хувийг бөөр шилжүүлэн суулгах мэс засал, 57.3 хувийг элэг шилжүүлэн суулгах мэс засал эзэлж байна.

Олон улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээний үр дүнг амьдарсан хугацаа буюу амьдрах чадварыг 1 жил, 3 жил, 5 жил, 10 жилээр хэмждэг. Манай орны хувьд амьдрах чадвар, эмчилгээний үр дүн нь Дэлхийн дунджаас илүү үр дүнтэй, өндөр хөгжилтэй орнуудын үр дүнтэй ижил түвшинд байгаа болно.

10.2. ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОРООС ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсад 2008 оноос тархины үхэлтэй донорын илрүүлэг, менежмент, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаа хийгдэж байна. Тархины үхлийг тодорхойлох үйл явц MNS4621:2008 стандартын дагуу явагддаг. Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байгуулагдснаар 2025 оны жилийн эцсийн байдлаар 23 эрүүл мэндийн байгууллагад Тархины үхэл тодорхойлох баг энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэж


байна.

Зураг 10.1. Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Тархины үхэл тодорхойлох баг




2018 онд Тархины үхэл тодорхойлох анхны баг байгуулагдан 2019 онд 3, 2020 онд 5, 2021 онд 7 баг ажиллаж байсан бол 2025 онд Тархины үхэл тодорхойлох баг 3 дахин нэмэгдсэн байна. Эдгээр багийн дунджыг авч үзэхэд нэг Тархины үхэл тодорхойлох багт дунджаар 9.7 эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. Үүнээс хамгийн их буюу 15 эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй Тархины үхэл тодорхойлох баг Улсын гуравдугаар төв эмнэлэгт ажиллаж байгаа бол хамгийн бага буюу 5 эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй Тархины үхэл тодорхойлох баг Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажиллаж байна.

Зураг 10.2. Нийт тархины үхэлтэй донор илрүүлэх үйл ажиллагаа явуулж буй Тархины үхэл тодорхойлох багийн тоо, 2018-2025 он





Зураг 10.3. Амьд болон тархины үхэлтэй донороос хийгдсэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын тоо, 2006-2025 он



Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/198 дугаар тушаалын дагуу Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нь Тархины үхэл тодорхойлох багаар тархины үхэл нь батлагдсан тархины үхэлтэй боломжит донорын гэр бүлтэй уулзалт зохион байгуулан донор болох хүсэлтийг тавьдаг. Тархины үхэлтэй донорын зөвшөөрлийг гэр бүлийн 3 гишүүнээс авдаг.

2018 оноос хойш нийт 299 тархины үхэлтэй боломжит донор илрүүлэн, 78 гэр бүлтэй уулзалт хийж, 37 (47.4 хувь) гэр бүлээс зөвшөөрөл авсан. Үүнээс 31 нь бодит донор болж нийт 45 бөөр, 27 элэг амжилттай шилжүүлэн суулгаж 72 хүний амь насыг аварсан. Мөн 170 гаруй хүнд шөрмөс шилжүүлэн суулгаж амьдралын чанарыг сайжруулсан болно.

Зураг 10.2. Тархины үхэлтэй донорын үйл ажиллагааны тоон үзүүлэлт, 2018-2025 он

№	Үйл ажиллагааны хэлбэр	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Донор эмнэлгүүдээс мэдээлэл авсан тоо	132	1077	990	1128	725	2534	7227	8105
2	Донор эмнэлэгт очиж ажилласан тоо	10	152	90	78	80	25	35	30
3	Тархины үхэлтэй боломжит донор илрүүлсэн тоо	3	69	41	50	60	36	33	7
4	Шалгуурт тэнцээгүй боломжит донорын тоо	37	39	29	30	35	25	22	4
5	Шалгуурт тэнцсэн боломжит донорын тоо	1	18	10	11	13	11	11	3
6	Гэр бүлтэй уулзалт зохион байгуулсан тоо	1	18	10	11	13	11	11	3
7	Татгалзсан гэр бүлийн тоо	0	10	6	5	5	8	5	3
8	Зөвшөөрсөн гэр бүлийн тоо	1	8	6	8	4	4	6	0
9	Бодит донорын тоо	1	8	5	7	3	2	5	0
10	Суулгасан тоо	2	19	10	15	6	6	14	0


10.3. ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОРООС ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ИРГЭДИЙН ХҮЛЭЭХ ЖАГСААЛТ

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн санд улсын хэмжээгээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа хийж буй эрүүл мэндийн байгууллагын тоо мэдээллийг оруулан нэгдсэн дүнг хянан, удирдан зохицуулдаг.

2025 оны эхэнд тархины үхэлтэй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэдийн хүлээх жагсаалтад 1094 иргэн байсан бөгөөд шинээр 274 иргэн бүртгүүлсэн байна. Үүнээс 8.6 хувь нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг амьд донороос хийгдэж хүлээх жагсаалтаас хасагдсан бөгөөд энэ хугацаанд 2.5 хувь нь нас барсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар хүлээх жагсаалтад нийт 1044 иргэн байна.


Эдгээр иргэдийг өвчний шалтгаанаар авч үзэхэд хүн амын өвчлөлийн дөрөвдүгээр шалтгаан болсон шээс бэлгийн тогтолцооны өвчний улмаас бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх шаардлагатай болсон иргэд 63.2 хувь, элэгний вирус гепатит өвчлөл улмаас үүссэн элэгний хатуурал, элэгний хавдар, цөсний ерөнхий сүвгийн төрөлхийн битүүрэл шалтгаант элэг шилжүүлэн суулгах мэс засал шаардлагатай иргэд 20.6 хувь, цусны хорт хавдар өвчний улмаас ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгах шаардлагатай иргэд 1.4 хувь, шөрмөс, нүдний эвэрлэг шилжүүлэн суулгуулах шаардлагатай иргэд 14.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 10.4. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2025 он



2025 оны жилийн эцсийн байдлаар Тархины үхэлтэй донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр хүлээх жагсаалтад бүртгүүлсэн 215 үйлчлүүлэгч байгаа бөгөөд гепатит В, С халдварын улмаас элэгний хатуурлын шалтгаантай өвчлөл 71.6 хувь, мөн элэгний анхдагч хавдар 22.8 хувь, хүүхдийн цөсний ерөнхий сүвгийн төрөлхийн битүүрэл 5.6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 10.5. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалтад байгаа хүний тоо, 2025 он, хувиар






10.4. ГАДААД УЛСАД ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба нь гадаад улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах гэж буй иргэдийн донорын хамаарлыг шалган, бүртгэн тухай улсын элчин сайдын яаманд тодорхойлолт хүргүүлдэг.


2025 онд нийт 31 иргэн гадаад улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд орохоор тодорхойлолт авсан бөгөөд үүнээс 51.6 хувь нь БНЭУ-д, 22.6 хувь нь БНТУ-д, 16.1 хувь нь БНХАУ-д, 9.7 хувь нь БНСУ-д эмчилгээнд орохоор тодорхойлолт авсан байна.

Зураг 10.6. Гадаадад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд орохоор бүртгэн, тодорхойлолт авсан иргэдийн тоо, 2019-2025 он



2019-2025 оны хооронд нийт 179 иргэн БНСУ, БНЭУ, БНТУ-д эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийлгэхээр тодорхойлолт авсан бөгөөд үүнээс хамгийн их буюу 81.6 хувь нь элэг шилжүүлэн суулгах мэс заслыг гадаадад хийлгэхээр тодорхойлолт авсан байна.

Зураг 10.7. Гадаадад эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд явсан иргэдийн тоо, 2019-2025 он



10.5. ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БҮЙ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ

Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар сургалтыг Эрхтэн шилжүүлэн суулгах дэлхийн холбоо, БНСУ, БНТУ, Испани, Австрали, Франц, АНУ-ын нийгэмлэг холбоотой хамтран тогтмол зохион байгуулан эмч мэргэжилтний үр чадварыг нэмэгдүүлэн, судалгаа шинжилгээний ажлыг хамтран хийж байна.

Хүснэгт 10.3. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах чиглэлээр сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо, 2018-2025 он

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Гадаад сургалт	35	23	4	26	36	16	10	9
Дотоод сургалт	400	2020	600	250	650	310	630	850
Нийт	435	2043	604	276	686	326	640	859

2022 онд 36, 2024 онд 16, 2025 онд 9 эмнэлгийн мэргэжилтэн 3 хоногоос 30 хоногийн хугацаатай сургалтад хамрагдсан. Гадаад сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүд тухайн онд шинээр гарсан оношилгоо эмчилгээний шинэ технологи, менежмент суралцан мэдлэг, үр чадвараа нэмэгдүүлснээр эмнэл зүйн үйл ажиллагаанд нэвтрүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад чухал үүрэгтэй байдаг.

Дотоод сургалтаар 2018 оноос 2025 онд эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, анагаах ухааны их дээд сургуулийн оюутанд зориулан “Донор, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа”-ны талаар цогц ойлголтыг өгөн олон нийтэд таниулан сурталчилах чиглэлээр хамтран ажиллаж ирсэн. Энэ хугацаанд нийт 30 гаруй байгууллагын 5869 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, анагаах ухааны их, дээд сургуулийн оюутан сургалтад хамрагдсан байна.



1800-0119

ДУУДЛАГЫН УТАС

БҮЛЭГ 11

**ДУУДЛАГА ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ
ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГ ТОВЛОЛЫН
“1800-0119” ТУСГАЙ ДУГААРЫН
ДУУДЛАГЫН УТАСНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

БҮЛЭГ 11. ДУУДЛАГА ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГ ТОВЛОЛЫН “1800-0119” ТУСГАЙ ДУГААРЫН ДУУДЛАГЫН УТАСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн “1800-0119” тусгай дугаарын Эмчийн үзлэгийн цаг товлолын утас нь 2020 оны 9-р сараас эхлэн нийслэлийн Дүүргийн эрүүл мэндийн төвүүд, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрөлжсөн болон тусгай мэргэшлийн төв эмнэлгүүдийн амбулаторийн эмчийн үзлэгийн цаг авах гэж өглөө эрт ирж урт дараалал үүсгэдэг, олон дахин давтан ирдэг, чирэгдүүлдэг байдлыг бууруулах, нэгдсэн удирдлагаар ханган шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдан 5 дах жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

1800-0119 тусгай дугаарын утас нь 2025 онд нийт 38 эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилласан. Үүнд:

Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг /9/

Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг /8/

Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ /21/

Хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг /2/

Дуудлагын утасны үйлчилгээнд тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн ажлын дадлага, туршлагатай 30 цахим бүртгэгч нар үйлчилж, өдөрт дунджаар 3500-6000 орчим дуудлага хүлээн авдаг бөгөөд дуудлагын ажилтан бүр өдөрт дунджаар 200-300 дуудлага хүлээн авч байна. 1 дуудлагад зарцуулах хугацаа 2-3 мин орчим байна.

2025 оны байдлаар тус дуудлагын утсанд хандсан дуудлага 1300852, үүнээс 948955 дуудлагад амжилттай үйлчилсэн байна. Дуудлагын чанарын үзүүлэлтийг тооцвол 72.9% хүрсэн нь өмнөх оны дуудлагын чанарын үзүүлэлт (71.7%)-ээс 1.2%-иар өссөн байна.

Хүснэгт 11.1. Дуудлагын чанарын үзүүлэлт, 2025 он


Дуудлагын чанарын үзүүлэлтүүд /нийт өдрүүдээр/			Зорилт	Гүйцэтгэл	
*Чанарын стандарт	Eff=	Үйлчилсэн дуудлагах	100%	≥80%	72.9%
		Хандсан дуудлага			
**Үйлчилгээний стандарт	SL=	20 секундэд авсан дуудлагах	100%	≥80%	-
		Үйлчилсэн дуудлага			

*Efficiency-чанарын стандарт нь нийт хүлээн авсан дуудлагын хэдэн хувьд нь хариу өгч ажилласан чанарын үзүүлэлтийг илтгэнэ.

**Service Level-стандарт нь нэгж дуудлагыг 20 сек дотор авч, иргэдэд хүлээгдэлгүй үйлчилсэн байдлыг илтгэнэ.




Зураг 11.1. Дуудлагын чанарын үзүүлэлт, 2024 он



11.1. НИЙТ ХҮЛЭЭН АВСАН ДУУДЛАГЫН БҮТЭЦ

2025 оны байдлаар 1800-0119 тусгай дугаарын утсанд нийт 1300852 дуудлага хандсан байна. Дуудлагын бүтцийг 2024 онтой харьцуулахад нийт хандсан дуудлага 92790 буюу 7.1%-аар ихэссэн, амжилттай дуудлага 50037 буюу 5.3%-иар тус тус бүүрсан үзүүлэлтэй байна.

Зураг 11.2. Нийт хандсан дуудлага, 2020-2025 он




2025 оны байдлаар нийт хандсан дуудлагаас амжилттай дуудлага 948955 буюу 72.9%, давхардсан буюу амжилтгүй дуудлага 232474 буюу 17.9%, ажлын бус цагийн дуудлага 119423 буюу 9.2%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 11. 2. Дуудлагын бүтцээр, 2020-2025 он

Дуудлагын төрөл	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт хандсан дуудлага:	412479	1152561	2033155	1383098	1393642	1300852
Амжилттай дуудлага	221154	943182	1024172	1067403	998992	948955
	53.60%	81.80%	50.4%	77.2%	71.7%	72.9%
Давхардсан буюу амжилтгүй дуудлага	187404	146896	997850	300237	384544	232474
	45.40%	12.80%	49.1%	21.7%	27.6%	9.2%
Ажлын бус цагийн дуудлага	3921	62483	11133	15458	10106	119423
	1.0%	5.40%	0.5%	1.1%	0.7%	9.1%

Нийт 948955 амжилттай дуудлагыг бүтцээр задалж харуулбал, эмчийн үзлэгийн цаг товлон Эмчийн үзлэгийн цаг товлон 492968(51.9%), зөвлөгөө, мэдээ мэдээлэл 20776 (2.2%)%, бусад дуудлага 492968 (45.9%) тус тус эзлэж байна.

Зураг 11.3. Нийт үйлчилсэн дуудлага 2020-2025 он



11.2. ЭМЧИЙН ҮЗЛЭГИЙН ЦАГ ТОВЛОСОН ДУУДЛАГЫН БҮТЭЦ


“Үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад хүлээж буй цаг хугацаа нь эрүүл мэндийн тогтолцооны хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэхийг хэмжих үндсэн шалгууруудын нэг” гэж ДЭМБ-аас тодорхойлосон байдаг.

Нийслэлийн төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, дүүргийн ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ-үүдээр үйлчлүүлэгч нь 4 төрлөөр буюу өөрөө биеэр ирэх, “1800-0119” дуудлагын утсанд хандах, давтан үзлэг бол шууд эмчээс, онлайн (e-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал) -аар үйлчилгээний цаг авах гэсэн хэлбэрээр амбулаторийн эмчийн үзлэгт хамрагдаж байна.


2025 онд 1800-0119 тусгай дугаарын “Эмчийн үзлэгийн цаг товлон” дуудлагын утас нь нийт 492968 дуудлагад эмчийн үзлэгийн цаг товлосон байсан байна. Үүнийг эрүүл мэндийн байгууллагаар задалбал: Төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 191296 (38.8%), Дүүргийн эрүүл мэндийн төв 252280 (51.2%), Аймгийн БОЭТ, НЭ 49392 (10%) эзэлж байна.




Зураг 11.4. Эмчийн үзлэгийн цаг товллын дуудлагын бүтэц 2020-2025 он



Зураг 11.5. Эмчийн үзлэгийн цаг товлал, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв тус бүрээр, 2020-2025 он




Зураг 11.6. Эмчийн үзлэгийн цаг товлал /Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээр, 2020-2025 он



2025 онд Дуудлага зохицуулах алба нь 1800-0119 тусгай дугаарын утасны “Эмчийн үзлэгийн цаг товлол” дуудлагын үйлчилгээг хөдөө орон нутгийн нийт 23 эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилласан.

Зураг 11.7. Эмчийн үзлэгийн цаг товлол, аймгаар, 2021-2025 он





БҮЛЭГ 12

**ЭМГЭГ СУДЛАЛЫН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ**

БҮЛЭГ 12. ЭМГЭГ СУДЛАЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Эмгэг судлалын тусламж үйлчилгээг MNS ISO 9001:2016, эмгэг судлалын тусламж үйлчилгээний түгээмэл үйлдэл MNS 7015:2023, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 18-ны А/447 тоот тушаалаар батлагдсан “Эмгэг судлалын шинжилгээ хийх журам”, “Амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийх журам” зэргийг мөрдлөг болгон эмгэг судлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, чанарын гадаад болон дотоод үнэлгээг тогтмол хийх, төгсөлтийн дараах сургалтыг тасралтгүй явуулах зорилготой ажиллаж байна.

Амьд сорьцын шинжилгээний оношийг баталгаажуулах, ялган оношлох, халдвар илрүүлэх зорилгоор 15 нэр төрлийн хистохимийн шинжилгээ, хүүхэд ба насанд хүрэгчдийн хортой, хоргүй хавдрыг ялган оношлох, хавдрын эд гарвал, тавилан тодорхойлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах зорилгоор иммунохистохимийн шинжилгээний 96 гаруй маркер ашиглан анхдагч болон эцсийн оношийг баталгаажуулж байна. FISH шинжилгээ нь молекулын түвшинд хромосомын өөрчлөлт, генийн хомсдол, олшрол болон дахин зохион байгуулалтыг нарийвчлан илрүүлэх өндөр мэдрэг, нарийн аргачлал юм. Энэхүү FISH (Fluorescence In Situ Hybridization буюу Байран туяаралт эрлийзжүүлэг) шинжилгээний аргыг эмнэлзүйн практикт 2024 оноос эхлэн Эмгэг Судлалын Үндэсний Төв үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.

FISH шинжилгээ нь HER2, ALK, ROS1 хавдрын рецептор үнэлэх, мутац илрүүлэхэд зориулсан нийт 10 пробуудыг түргэвчилсэн, уламжлалт FISH шинжилгээний 5 проб аргачлалуудыг ашиглан түршилт, дадлага хийснээр инноваци бүхий оношилгооны хүртээмж, эмчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх, цаашид гадаад орныг зорьж эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн үрсгалыг багасгах зэрэгт чухал ач холбогдолтой байна.

Телепатологийн тусламж, үйлчилгээг ашиглан Япон улсын анатомийн эмгэг судлаач эмч, зөвлөх мэргэжилтнүүдтэй холбогдон цахим зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, оношийг баталгаажуулж байгаа нь иргэдэд санхүүгийн дарамт чирэгдэл үүсгэх эрсдэлээс сэргийлсэн чухал ач холбогдолтой юм.

Эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт “Нас барагчийн цогцост үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зорилгоор эмгэг судлалын шинжилгээ хийнэ” гэж заасны дагуу эмгэг судлалын шинжилгээг хийж, оношийн зөрөө, эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдлыг тодорхойлж байна.


Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2025 оны А/420 дугаар тушаалаар Эхийн эндэгдлийн тохиолдолд лавлагаа төвөөс мэргэшсэн анатомийн эмгэг судлаач эмч томилон ажиллуулж онош, дүгнэлт гаргахаар зохицуулагдсан бөгөөд эмгэг судлалын шинжилгээ хийгдэж тохиолдлыг дахин давтагдахаас сэргийлэх, хожимдлыг арилгах чиглэлээр бодлогын шийдвэр гаргахад оролцож байна.

12.1 АМЬД СОРЬЦЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Улсын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад мэс заслаар тайрагдсан амьд сорьцын шинжилгээ нь 14.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 12.1. Амьд сорьцын шинжилгээ, 2025 он



12.1.1. АМЬД СОРЬЦЫН ШИНЖИЛГЭЭГЭЭР ХОРТ ХАВДАР ОНОШЛОГДСОН ТОХИОЛДОЛ

2025 онд амьд сорьцын шинжилгээгээр оношлогдсон зонхилох байрлалын хорт хавдрын нэгдүгээрт ходоод 21.9%, эмэгтэйчүүдийн дунд хөх 19.4%, эрэгтэйчүүдийн дунд ходоодны хорт хавдар 31.1%-ийг эзэлж байна.

Хүснэгт 12.1. Амьд сорьцын шинжилгээгээр зонхилон тохиолдох хорт хавдар оношлогдсон тохиолдол, 2025 он

№	Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь	Эмэгтэй			Эрэгтэй		
				Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь	Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь
1	Ходоод	1173	21.9%	Умайн хүзүү	338	11.5%	Ходоод	754	31.1%
2	Элэг	658	12.3%	Хөх	566	19.4%	Элэг	377	15.5%
3	Умайн хүзүү	344	6.4%	Ходоод	419	14.3%	Улаан хоолой	151	6.2%
4	Хөх	572	10.7%	Элэг	281	9.6%	Бөөр	193	8.0%
5	Улаан хоолой	229	4.2%	Бүдүүн гэдэс	116	3.9%	Бүдүүн гэдэс	154	6.3%
6	Бүдүүн гэдэс	270	5.0%	Улаан хоолой	78	2.6%	Уушги	140	5.7%
Нийт		5337	100	Нийт	2916	100%	Нийт	2421	100

12.1.2. АМЬД СОРЬЦЫН ШИНЖИЛГЭЭГЭЭР ХОРГҮЙ ХАВДАР ОНОШЛОГДСОН ТОХИОЛДОЛ

2025 онд амьд сорьцын шинжилгээгээр оношлогдсон хоргүй хавдрын нэгдүгээрт өөхний хоргүй хавдар 12.3%, эмэгтэйчүүдийн дунд өндгөвч 11.9%, эрэгтэйчүүдийн дунд

өөхний хоргүй хавдар 19.3% тус тус өндөр хувийг эзэлж байна.


Хүснэгт 12.2. Амьд сорьцын шинжилгээгээр зонхилон тохиолдох хоргүй хавдар оношлогдсон тохиолдол, 2025 он

№	Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь	Эмэгтэй			Эрэгтэй		
				Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь	Хорт хавдрын байрлал	Тоо	Хувь
1	Өөхний	1075	12.3%	Өөхний	580	9.4%	Өөхний	495	19.3%
2	Өндгөвч	761	8.7%	Өндгөвч	734	11.9%	Бамбай булчирхай	57	2.2%
3	Бамбай булчирхай	288	3.3%	Бамбай булчирхай	231	3.5%	Ходоод	255	9.9%
4	Ходоод	472	5.4%	Умайн хүзүү	270	4.3%	Арьс	134	5.2%
5	Арьс	224	2.5%	Цусны судас	120	1.9%	Улаан хоолой	106	4.1%
6	Улаан хоолой	227	2.6%	Ходоод	217	3.5%	Холбох ба бусад зөөлөн эдийн	70	2.7%
Нийт		8714	100%	Нийт	6156	100%	Нийт	2558	100%

12.2. ЭСИЙН ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2025 онд нийт 105182 эсийн эмгэг судлалын шинжилгээ хийгдсэнээс эмэгтэйчүүдийн (умайн хүзүүний) 101913, эмэгтэйчүүдийн бус 3269 хийгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад 5.53 хувиар ихэссэн үзүүлэлттэй байна.


Зураг 12.2. Умайн хүзүүний эсийн эмгэг судлалын шинжилгээ, улсаар 2015-2025 он



2025 онд улсын хэмжээнд нийт 93406 /92.2%/ шинжилгээ сөрөг, 1635 /1.2%/ шинжилгээ шаардлага хангахгүй, 6872 /6.4%/ шинжилгээ хавдрын урьдал эмгэг оношлогдсон. Хавдрын урьдал эмгэг: ASC-US 2423 /45.3%/, ASC-H 391 /7.2%/, LSIL 2559 /21.2%/, HSIL 1453 /24.5%/,



SCC 4 /0.4%/, AGC-NOS 1 /0.9%/, AGC-favor neoplastic 6 /0.1%/, Adenocarcinoma 0 /0.0%/, тус тус оношлогдсон байна.




Зураг 12.3. Эсийн эмгэг судлалын шинжилгээ, оношийн төрлөөр, 2025 он

12.3. ЭМГЭГ СУДЛАЛЫН ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2025 онд эмнэлгийн нас баралт өнгөрсөн онтой харьцуулахад 23.6 хувиар өссөн ба бүртгэгдсэн эмнэлгийн нас баралтын 37 хувьд эмгэг судлалын шинжилгээ хийгдсэн байна.


Зураг 12.4. Эмгэг судлалын задлан шинжилгээ, улсын дүнгээр, 2015-2025 он




12.4. ҮНДСЭН ОНОШИЙН ЗӨРҮҮ

2025 онд эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдсэн тохиолдлуудын 8.6%-д нь үндсэн оношийн зөрөө илэрсэн.

Зураг 12.5. Үндсэн оношийн зөрөө, зөрөөний хувь, аймагаар, 2025 он





БҮЛЭГ 13

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
СҮҮЛИЙН 10 ЖИЛЭЭР**

Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	102.2	0.0	115.1	58.5	122.0	242.4	0.0	0.0	0.0	0.0
2	Баян-Өлгий	35.3	35.1	0.0	0.0	174.6	68.3	72.1	0.0	0.0	0.0
3	Баянхонгор	101.7	0.0	0.0	0.0	0.0	53.8	59.6	0.0	70.5	78.9
4	Булган	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Говь-Алтай	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	101.7	0.0	0.0
6	Говь-Сүмбэр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Дархан-Уул	40.2	0.0	83.1	0.0	0.0	136.7	0.0	0.0	0.0	111.1
8	Дорноговь	0.0	0.0	0.0	0.0	68.4	68.6	80.0	93.1	0.0	116.0
9	Дорнод	0.0	0.0	0.0	51.9	0.0	167.6	0.0	0.0	73.7	0.0
10	Дундговь	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
11	Завхан	0.0	150.5	0.0	0.0	0.0	75.2	0.0	0.0	0.0	0.0
12	Орхон	0.0	0.0	0.0	0.0	0.0	39.7	0.0	0.0	0.0	0.0
13	Өвөрхангай	74.8	0.0	0.0	38.4	41.2	45.3	50.3	0.0	58.1	0.0
14	Өмнөговь	212.9	76.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
15	Сүхбаатар	158.5	78.4	0.0	77.5	0.0	0.0	90.1	82.4	104.7	0.0
16	Сэлэнгэ	108.9	0.0	58.6	56.2	0.0	123.2	0.0	0.0	90.7	100.9
17	Төв	82.1	0.0	0.0	0.0	0.0	177.1	125.0	0.0	0.0	0.0
18	Увс	0.0	49.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	57.3	61.5	73.2
19	Ховд	90.1	45.2	127.4	43.8	44.0	147.4	110.8	0.0	0.0	59.0
20	Хөвсгөл	101.2	0.0	34.7	70.6	73.3	37.7	130.5	0.0	0.0	0.0
21	Хэнтий	0.0	69.2	0.0	0.0	0.0	0.0	77.0	0.0	0.0	0.0
22	Аймгийн дундаж	56.0	22.3	24.4	21.6	32.9	70.9	42.8	13.3	22.8	28.6
23	Улаанбаатар	41.8	31.2	29.5	24.3	27.7	118.1	28.4	37.9	22.3	33.7
24	Улсын дундаж	48.6	26.9	27.1	23.0	30.2	94.9	35.1	26.4	22.5	31.4

Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	18.9	16.8	19.6	15.2	13.4	9.7	13.4	10.6	18.7	16.0
2	Баян-Өлгий	27.9	13.3	17.8	20.7	16.4	16.4	14.4	17.7	12.2	16.7
3	Баянхонгор	23.9	15.5	11.6	12.8	8.8	8.6	9.5	8.0	12.0	6.3
4	Булган	13.8	10.8	16.6	18.3	14.5	14.3	14.7	18.3	10.6	15.2
5	Говь-Алтай	16.2	16.4	16.3	14.6	8.5	17.7	13.4	11.2	13.9	13.5
6	Говь-Сүмбэр	15.6	7.2	2.1	11.7	6.8	2.1	10.6	8.7	3.1	10.5
7	Дархан-Уул	12.5	10.6	10.8	7.5	9.3	9.6	10.5	7.9	6.6	10.0
8	Дорноговь	14.6	12.8	11.7	7.4	8.9	8.9	9.6	11.2	10.9	15.1
9	Дорнод	11.1	13.4	4.1	7.3	15.5	7.8	8.2	5.3	5.9	6.4
10	Дундговь	16.8	9.1	7.7	7.4	7.8	14.0	11.8	10.1	1.8	7.8
11	Завхан	15.5	16.6	13.3	16.1	13.9	19.5	11.9	14.1	17.4	10.8
12	Орхон	12.6	5.0	6.5	8.3	8.6	12.3	6.5	8.1	9.9	7.7
13	Өвөрхангай	20.6	16.1	15.0	14.6	8.2	10.9	14.6	14.2	12.8	17.4
14	Өмнөговь	19.2	16.1	14.8	21.3	11.9	11.0	15.1	10.0	17.5	13.5
15	Сүхбаатар	22.2	17.3	10.7	10.1	7.4	5.1	8.1	4.9	7.3	9.8
16	Сэлэнгэ	14.7	11.0	10.6	9.6	8.5	10.5	9.7	13.0	7.3	11.1
17	Төв	20.5	10.0	18.3	15.4	11.2	15.1	21.3	12.7	20.0	18.0
18	Увс	21.6	18.7	14.1	13.6	13.8	10.2	13.7	8.6	14.8	20.5
19	Ховд	18.9	16.7	14.9	18.0	11.9	18.2	15.5	12.2	6.5	10.6
20	Хөвсгөл	28.3	22.0	18.0	18.0	13.6	13.6	16.1	10.6	17.9	18.1
21	Хэнтий	15.3	19.4	11.6	16.0	8.2	9.8	12.3	8.5	16.3	10.2
22	Аймгийн дундаж	18.8	14.5	13.1	13.8	11.2	12.0	12.3	10.8	11.9	12.9
23	Улаанбаатар	15.0	12.7	13.6	12.9	11.8	11.1	12.5	13.7	12.4	14.3
24	Улсын дундаж	16.8	13.6	13.4	13.3	11.5	11.6	12.4	12.3	12.2	13.6

Перинаталь эндэгдэл /1000 нийт төрөлтөд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	12.7	10.5	13.2	7.0	7.9	7.2	11.9	11.3	11.1	14.8
2	Баян-Өлгий	16.8	13.2	12.2	11.0	10.8	14.2	11.5	11.0	9.8	11.0
3	Баянхонгор	10.6	11.4	9.1	9.5	9.2	6.4	7.7	6.2	5.6	3.9
4	Булган	12.5	7.2	16.5	14.3	17.0	10.7	11.7	11.6	6.3	17.2
5	Говь-Алтай	15.2	14.7	13.1	12.4	9.9	15.3	8.6	13.1	5.8	8.6
6	Говь-Сүмбэр	6.6	4.8	2.1	13.9	0.0	4.2	10.5	8.7	3.1	17.3
7	Дархан-Уул	8.4	9.3	9.9	10.0	11.1	9.5	11.4	9.4	8.8	8.9
8	Дорноговь	11.1	14.3	11.6	8.1	9.5	5.5	4.8	13.0	7.9	9.2
9	Дорнод	10.1	13.3	6.6	7.2	7.5	13.3	10.6	9.2	4.4	7.9
10	Дундговь	16.7	9.0	5.5	8.4	5.6	9.3	13.2	4.3	5.4	3.9
11	Завхан	10.5	16.5	9.1	15.3	9.4	15.7	5.5	11.4	11.9	12.0
12	Орхон	11.4	8.9	8.3	8.3	8.6	13.4	8.2	8.0	12.3	8.2
13	Өвөрхангай	10.8	11.1	12.8	9.6	8.2	9.0	13.5	9.1	7.5	11.2
14	Өмнөговь	13.4	14.5	12.2	18.2	11.8	12.7	11.9	11.4	12.5	10.7
15	Сүхбаатар	13.4	11.7	9.1	9.2	10.3	7.2	7.2	3.3	5.2	13.4
16	Сэлэнгэ	7.1	7.0	7.6	10.6	12.0	10.4	6.7	10.7	5.4	11.0
17	Төв	21.1	9.2	10.4	18.0	8.3	19.3	13.6	8.8	9.3	12.0
18	Увс	14.1	15.6	9.4	8.9	12.2	13.9	12.4	7.4	9.8	11.7
19	Ховд	15.2	15.7	14.3	10.9	9.6	12.2	9.9	3.7	8.8	9.4
20	Хөвсгөл	16.8	12.9	14.2	11.2	13.5	14.2	10.8	5.5	12.6	8.5
21	Хэнтий	8.5	11.0	10.9	8.9	6.9	7.9	10.7	7.0	12.4	6.1
22	Аймгийн дундаж	12.6	11.9	10.8	10.6	9.9	11.4	10.2	8.6	9.0	9.8
23	Улаанбаатар	13.2	12.9	12.8	11.4	12.2	12.1	11.4	11.9	10.6	11.0
24	Улсын дундаж	12.9	12.4	11.9	11.0	11.1	11.8	10.8	10.4	9.8	10.5

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	27.6	20.5	25.3	21.7	18.9	13.3	18.6	15.9	23.3	23.0
2	Баян-Өлгий	32.1	17.9	25.0	25.1	19.9	18.4	20.9	22.2	17.3	19.2
3	Баянхонгор	30.0	18.0	18.8	17.6	13.2	11.3	12.5	10.5	14.8	11.0
4	Булган	16.1	13.2	22.9	21.0	15.8	14.3	22.1	20.0	21.1	21.7
5	Говь-Алтай	20.4	19.7	19.4	19.0	9.2	21.6	20.1	12.2	17.4	17.2
6	Говь-Сүмбэр	20.0	14.4	6.4	11.7	11.3	2.1	13.2	8.7	6.3	13.9
7	Дархан-Уул	15.3	12.8	13.7	9.6	12.5	10.9	13.5	10.4	7.7	12.8
8	Дорноговь	16.7	13.6	16.0	12.5	10.3	12.3	13.6	13.0	15.9	19.7
9	Дорнод	15.4	18.1	6.6	10.4	19.5	10.1	12.0	8.6	9.6	7.2
10	Дундговь	21.0	15.9	13.2	9.5	10.0	15.2	11.8	14.5	3.6	7.8
11	Завхан	19.0	17.3	20.3	21.3	19.0	24.8	16.4	17.6	23.9	19.3
12	Орхон	14.5	5.4	9.5	10.6	10.2	13.9	6.9	9.4	10.4	8.3
13	Өвөрхангай	28.4	20.2	19.1	17.7	9.9	13.1	16.6	17.8	16.3	21.8
14	Өмнөговь	24.1	20.0	16.1	24.9	14.3	12.2	17.5	10.7	19.2	18.9
15	Сүхбаатар	27.7	20.4	16.1	13.2	12.6	5.8	11.7	9.1	10.5	11.1
16	Сэлэнгэ	19.1	15.1	12.3	12.4	12.7	14.8	15.7	16.8	11.8	17.2
17	Төв	30.4	17.5	26.2	20.9	20.5	21.3	30.0	21.5	26.7	27.0
18	Увс	27.0	22.1	19.9	17.8	15.8	11.8	18.5	12.6	17.8	27.1
19	Ховд	23.4	22.2	19.1	21.5	15.4	21.1	20.5	13.8	9.5	13.0
20	Хөвсгөл	32.4	26.3	23.6	22.6	17.2	18.1	17.8	16.5	22.1	24.9
21	Хэнтий	23.2	24.9	15.1	20.4	13.3	13.1	16.2	12.4	22.1	14.3
22	Аймгийн дундаж	23.7	18.1	17.7	17.6	14.6	14.7	16.2	14.1	15.5	16.9
23	Улаанбаатар	18.2	15.4	16.1	14.9	13.4	13.1	14.9	15.7	14.9	16.9
24	Улсын дундаж	20.8	16.7	16.9	16.1	14.0	13.9	15.5	14.9	15.2	16.9

Халдварт өвчин / 10 000 хүнд /

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	159.7	53.3	61.2	55.6	37.7	1371.8	594.6	77.2	91.6	80.4
2	Баян-Өлгий	61.8	33.1	30.5	38.9	29.4	1074.1	218.1	36.9	52.8	73.9
3	Баянхонгор	268.8	134.3	167.2	183.1	149.8	2070.0	912.8	108.8	141.7	90.5
4	Булган	125.5	80.0	56.6	88.7	85.6	1967.2	515.8	53.2	60.5	43.4
5	Говь-Алтай	171.7	140.0	83.8	71.2	49.9	2258.5	1147.4	86.2	109.7	85.3
6	Говь-Сүмбэр	176.7	141.6	150.7	95.4	40.1	3097.3	1447.2	162.1	98.7	139.3
7	Дархан-Уул	313.8	93.0	114.2	148.0	96.4	1268.0	229.6	139.4	120.1	101.5
8	Дорноговь	266.9	105.3	108.1	160.6	129.6	2883.2	1282.8	230.8	136.3	143.2
9	Дорнод	337.1	381.2	354.5	268.6	194.8	2398.4	1029.4	313.7	233.6	207.6
10	Дундговь	144.7	110.5	89.0	87.3	65.6	2650.0	772.2	91.5	65.0	113.2
11	Завхан	112.8	65.4	63.6	97.8	88.2	1656.4	926.5	72.9	58.4	87.2
12	Орхон	138.6	66.8	84.9	87.8	62.8	1138.0	457.2	101.3	72.7	91.3
13	Өвөрхангай	196.0	99.2	88.0	77.3	48.9	1511.7	498.7	73.4	70.0	81.4
14	Өмнөговь	158.6	115.8	96.8	106.3	127.8	2502.9	2728.4	220.7	192.9	185.7
15	Сүхбаатар	218.3	216.1	110.9	154.5	80.0	2230.0	819.5	117.6	78.7	130.4
16	Сэлэнгэ	174.0	72.9	73.5	67.6	90.4	1431.8	742.1	154.7	49.7	59.4
17	Төв	133.5	88.9	70.4	76.6	60.6	1778.8	853.6	130.9	124.9	129.6
18	Увс	88.3	88.0	74.3	75.3	73.3	1740.8	633.1	64.4	62.8	60.7
19	Ховд	146.0	61.8	72.8	85.7	61.8	2241.4	943.2	67.3	74.8	88.2
20	Хөвсгөл	172.8	119.5	184.4	170.0	102.7	1427.5	403.3	87.8	104.0	89.9
21	Хэнтий	157.4	95.0	84.3	69.0	57.0	1901.5	632.3	65.6	56.7	92.4
22	Аймгийн дундаж	177.5	106.8	105.1	108.4	83.3	1795.9	768.7	113.6	97.3	100.5
23	Улаанбаатар	287.7	190.2	164.4	181.5	127.2	1706.6	1206.0	129.9	121.6	210.1
24	Улсын дундаж	227.8	144.9	132.4	141.8	103.5	1754.6	973.9	121.4	109.1	154.0

Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид /10 000 хүнд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	134.7	129.9	132.4	135.2	135.7	132.8	137.0	137.9	142.5	144.2
2	Баян-Өлгий	121.5	125.1	128.4	139.3	143.9	146.5	150.1	155.6	160.9	156.8
3	Баянхонгор	138.2	135.7	136.7	145.9	139.7	137.3	145.2	160.0	162.2	164.4
4	Булган	126.8	125.3	123.1	134.4	143.1	133.2	130.8	131.1	128.7	130.3
5	Говь-Алтай	195.9	192.8	189.4	190.6	196.7	198.7	207.4	209.2	213.3	204.4
6	Говь-Сүмбэр	148.3	152.6	159.9	155.7	156.8	168.7	163.6	165.4	167.3	169.5
7	Дархан-Уул	138.6	137.8	135.1	133.0	141.8	152.6	156.2	159.3	168.1	166.0
8	Дорноговь	158.2	165.4	167.0	158.0	172.5	168.1	168.3	167.6	176.2	169.4
9	Дорнод	132.7	131.0	129.9	129.8	131.2	134.5	137.9	139.8	140.6	135.1
10	Дундговь	156.7	154.3	152.8	156.8	152.2	157.4	148.6	154.3	162.7	166.4
11	Завхан	158.3	155.7	154.1	157.6	156.1	155.7	151.7	157.9	161.0	156.3
12	Орхон	150.3	148.7	155.3	157.3	161.6	173.0	188.9	196.0	197.4	194.5
13	Өвөрхангай	123.6	125.4	124.7	131.8	137.4	141.3	143.8	147.9	156.0	157.1
14	Өмнөговь	132.0	126.5	136.8	141.7	138.9	141.8	143.4	150.6	157.8	155.3
15	Сүхбаатар	133.6	128.9	129.7	129.6	132.9	131.5	130.5	127.3	128.9	129.7
16	Сэлэнгэ	116.9	121.8	119.2	126.0	117.0	116.4	129.7	132.0	136.4	135.8
17	Төв	139.5	143.4	139.4	140.4	147.0	146.3	138.9	143.3	146.6	146.7
18	Увс	141.2	133.8	137.8	141.1	144.6	146.9	157.2	167.3	166.0	169.8
19	Ховд	138.8	141.5	141.5	149.4	152.3	152.7	159.6	165.7	172.6	182.3
20	Хөвсгөл	117.0	115.7	118.9	115.7	115.0	118.8	124.0	125.4	133.1	132.1
21	Хэнтий	139.2	135.7	133.8	136.4	133.1	132.0	134.0	143.6	146.6	141.6
22	Аймгийн дундаж	137.2	136.6	137.3	140.5	142.5	144.3	148.2	152.7	157.1	156.3
23	Улаанбаатар	178.0	195.3	199.5	208.2	213.6	218.9	236.5	243.0	253.4	238.0
24	Улсын дундаж	156.0	163.1	165.5	171.4	175.2	178.8	189.6	195.9	203.9	196.2

Их эмч / 10 000 хүнд /

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	19.9	18.3	19.4	21.6	22.0	21.3	21.7	22.8	24.8	26.3
2	Баян-Өлгий	18.6	20.2	20.7	22.9	24.3	24.9	26.3	28.6	30.1	29.2
3	Баянхонгор	20.6	21.7	23.0	24.2	22.9	21.6	23.5	25.5	26.3	28.6
4	Булган	19.9	19.8	17.9	21.8	23.9	22.2	18.4	21.0	20.6	21.8
5	Говь-Алтай	31.4	32.8	33.4	32.0	35.4	35.2	36.1	37.2	37.8	37.0
6	Говь-Сүмбэр	31.1	33.2	36.1	37.9	32.2	39.8	37.6	39.3	38.4	41.1
7	Дархан-Уул	28.0	27.2	26.3	27.3	29.7	29.6	31.2	33.9	36.0	36.8
8	Дорноговь	33.9	32.9	35.1	35.7	38.6	37.3	36.0	37.7	40.3	37.0
9	Дорнод	22.6	23.3	23.2	24.4	23.8	24.0	24.2	26.8	27.2	26.6
10	Дундговь	28.7	30.7	29.4	32.8	34.3	31.6	29.8	31.7	34.7	35.8
11	Завхан	25.9	25.3	24.5	25.1	25.3	25.3	24.5	27.1	26.8	29.3
12	Орхон	32.1	31.9	33.6	35.9	33.8	36.9	41.4	42.7	44.8	45.0
13	Өвөрхангай	22.6	22.5	22.8	24.6	25.5	25.0	26.0	28.8	31.3	29.8
14	Өмнөговь	29.1	29.2	29.2	32.7	33.3	34.1	33.2	34.1	35.2	37.2
15	Сүхбаатар	25.6	25.2	25.3	23.3	25.8	24.5	24.1	23.2	24.5	25.0
16	Сэлэнгэ	22.0	22.8	23.0	22.9	21.4	21.4	23.3	24.8	25.4	26.7
17	Төв	21.9	23.3	22.9	22.9	26.2	25.3	24.7	25.7	28.2	27.8
18	Увс	21.0	20.6	21.8	23.7	23.6	24.8	25.9	27.8	28.0	29.5
19	Ховд	24.8	26.8	27.2	29.9	32.2	30.6	33.6	35.6	37.4	39.7
20	Хөвсгөл	18.6	19.0	19.5	20.4	19.4	21.1	21.4	20.8	22.9	24.4
21	Хэнтий	22.6	24.1	23.4	25.0	26.6	26.5	26.5	27.1	26.4	26.8
22	Аймгийн дундаж	24.0	24.4	24.7	26.1	26.8	26.8	27.5	29.0	30.4	31.0
23	Улаанбаатар	42.2	46.0	48.2	49.9	52.4	54.2	58.1	60.9	64.0	63.5
24	Улсын дундаж	32.4	34.1	35.4	37.0	38.5	39.5	41.9	44.3	46.7	46.9

Сувилагч /10 000 хүнд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	29.8	29.0	30.0	31.5	29.7	29.7	30.8	29.8	32.2	32.8
2	Баян-Өлгий	30.7	31.5	31.9	34.8	35.9	36.5	37.0	40.2	41.7	39.4
3	Баянхонгор	34.6	34.0	33.9	34.7	32.9	33.7	33.6	36.0	38.4	38.4
4	Булган	32.2	31.5	30.9	33.4	37.0	34.5	33.2	33.9	34.8	36.2
5	Говь-Алтай	44.9	44.5	44.1	46.1	44.0	45.6	46.3	44.6	46.4	46.9
6	Говь-Сүмбэр	37.1	39.0	37.3	33.3	29.3	32.6	32.0	33.7	35.1	35.1
7	Дархан-Уул	36.6	35.6	35.5	43.0	43.1	44.0	44.9	45.2	47.3	46.6
8	Дорноговь	34.3	37.7	36.3	33.9	38.4	35.0	36.3	35.3	39.3	39.2
9	Дорнод	35.6	35.2	34.5	35.1	36.0	35.7	36.9	36.3	37.0	37.1
10	Дундговь	34.1	32.4	33.0	33.5	33.6	35.0	29.3	31.9	33.4	33.5
11	Завхан	39.9	38.1	38.7	39.4	38.6	38.5	38.5	42.0	42.6	41.4
12	Орхон	41.3	41.3	42.6	40.0	40.1	40.9	45.9	47.9	48.4	47.7
13	Өвөрхангай	29.1	28.6	28.6	30.2	32.6	35.4	33.8	34.9	37.9	38.5
14	Өмнөговь	29.0	27.1	27.9	27.3	29.1	26.6	27.1	30.1	32.0	32.1
15	Сүхбаатар	36.0	35.4	35.8	35.2	36.0	37.4	36.5	35.8	35.2	36.8
16	Сэлэнгэ	27.7	30.6	29.9	30.4	30.2	29.2	32.9	34.6	35.9	36.0
17	Төв	32.4	31.5	30.7	31.8	32.6	33.2	33.8	32.7	32.5	32.8
18	Увс	34.6	31.6	34.2	35.2	37.1	37.0	38.4	40.9	40.8	40.6
19	Ховд	33.7	34.6	34.2	35.7	36.3	36.8	40.1	42.0	42.8	45.5
20	Хөвсгөл	27.9	28.2	29.8	29.4	30.9	32.6	35.1	34.8	37.8	36.2
21	Хэнтий	32.4	31.0	31.4	32.0	30.9	32.3	32.7	35.8	35.2	34.9
22	Аймгийн дундаж	33.4	33.1	33.4	34.3	34.9	35.3	36.3	37.4	38.8	38.7
23	Улаанбаатар	41.6	45.1	45.9	46.8	47.4	47.7	48.0	48.8	50.2	49.5
24	Улсын дундаж	37.2	38.5	39.1	40.0	40.7	41.0	41.8	42.8	44.3	44.0

Эмнэлгийн орны тоо / 10 000 хүнд/


№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	56.0	55.0	54.3	54.6	58.2	161.4	57.7	62.9	63.6	64.4
2	Баян-Өлгий	72.7	77.1	76.9	76.1	90.5	88.3	89.1	92.6	90.5	91.1
3	Баянхонгор	62.2	63.4	67.3	67.1	74.8	214.3	76.8	77.6	78.4	78.8
4	Булган	62.3	60.4	60.7	61.6	58.3	158.1	53.9	50.6	50.6	51.0
5	Говь-Алтай	77.8	78.7	78.6	81.4	83.1	83.9	83.1	85.3	88.9	86.2
6	Говь-Сүмбэр	70.6	72.2	71.1	70.1	75.6	159.8	93.9	97.4	96.5	94.9
7	Дархан-Уул	73.2	73.6	73.9	73.9	75.2	51.8	52.6	52.8	81.1	81.0
8	Дорноговь	66.5	68.8	71.3	72.6	74.1	79.9	79.8	81.5	77.1	75.2
9	Дорнод	69.8	69.9	68.8	67.4	68.5	41.8	41.5	43.5	63.8	59.5
10	Дундговь	67.5	65.5	66.3	66.3	74.7	279.1	133.4	135.6	75.8	76.0
11	Завхан	81.7	82.1	78.8	76.1	92.6	180.0	85.9	87.2	88.0	78.6
12	Орхон	64.2	63.4	70.8	83.1	85.5	85.1	85.4	89.0	89.0	88.6
13	Өвөрхангай	63.5	72.7	71.7	74.0	80.3	137.2	90.0	89.7	79.6	83.1
14	Өмнөговь	71.4	102.5	99.3	100.1	98.5	208.2	102.3	102.2	93.7	87.2
15	Сүхбаатар	61.4	66.7	67.1	73.6	86.3	84.6	80.1	80.4	80.3	79.9
16	Сэлэнгэ	66.2	65.7	73.5	77.8	75.4	76.4	75.8	82.2	82.1	85.2
17	Төв	57.4	53.8	53.5	55.1	60.8	136.7	61.9	61.1	66.5	66.1
18	Увс	70.5	67.2	70.7	70.7	73.0	67.8	65.3	65.9	66.4	65.2
19	Ховд	67.4	66.8	64.0	68.8	86.2	92.1	93.8	90.7	93.3	85.7
20	Хөвсгөл	61.2	59.7	67.0	65.6	66.1	67.4	72.4	73.6	76.7	65.3
21	Хэнтий	67.5	63.0	63.6	63.3	71.7	129.9	73.9	76.0	76.1	76.2
22	Аймгийн дундаж	66.6	68.1	69.6	71.2	76.3	113.3	77.8	79.2	78.7	76.8
23	Улаанбаатар	83.4	88.1	89.8	91.4	92.9	100.9	101.1	95.6	98.0	95.3
24	Улсын дундаж	74.3	77.1	78.8	80.4	84.0	107.6	88.7	87.0	88.1	85.8

Хэвтэн эмчлүүлэгчид /10 000 хүнд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	2255.0	2128.3	2179.0	2038.6	2041.8	2528.8	2044.7	1978.1	2088.2	1760.9
2	Баян-Өлгий	2916.3	2724.3	2642.4	2753.0	2556.4	2829.4	2881.9	3183.0	3093.5	2524.5
3	Баянхонгор	2442.3	2308.3	2380.4	2625.2	2688.9	3438.1	2909.4	2831.3	2829.3	2320.7
4	Булган	2039.9	1919.0	2028.2	1950.0	1773.4	2500.2	1801.1	2048.2	2024.1	1666.7
5	Говь-Алтай	2586.3	2517.4	2464.9	2350.3	2298.9	3225.5	2413.7	2526.5	2685.6	2072.3
6	Говь-Сүмбэр	3003.5	2826.4	2948.3	2780.5	2461.9	3982.2	3301.0	3634.5	3494.6	2810.0
7	Дархан-Уул	3010.9	2976.8	3018.8	2975.7	2713.3	3443.3	3032.8	2929.4	2890.8	2289.7
8	Дорноговь	2415.8	2381.9	2453.7	2493.1	2390.4	2876.7	2692.7	2702.4	2738.4	2205.9
9	Дорнод	2528.0	2416.5	2368.2	2329.1	2166.9	2830.1	2309.1	2396.5	2421.0	1955.6
10	Дундговь	2548.0	2403.5	2385.9	2321.1	2158.9	2837.1	2232.2	2197.6	2418.2	1934.8
11	Завхан	2457.3	2279.4	2371.1	2409.1	2302.6	2783.9	2673.6	2877.8	2909.1	2429.4
12	Орхон	2197.5	2248.2	2451.7	2634.7	2451.8	3469.8	3607.3	3592.4	3488.3	2930.6
13	Өвөрхангай	2241.1	2111.6	2114.1	2160.8	2003.9	2386.9	2405.9	2668.5	2705.4	2426.3
14	Өмнөговь	2174.1	2105.9	2236.1	2273.4	2182.0	2552.4	2523.2	2393.7	2398.2	2028.2
15	Сүхбаатар	2242.6	2168.3	2187.5	2190.5	2125.5	2479.9	2338.8	2516.6	2727.5	2269.7
16	Сэлэнгэ	2196.7	2105.7	2132.0	2172.3	1825.2	2202.2	2202.4	2407.8	2464.2	2109.1
17	Төв	1826.9	1663.9	1640.7	1662.6	1448.6	2071.3	1813.5	1835.9	2019.4	1742.5
18	Увс	2592.1	2635.7	2529.1	2493.5	2273.7	2560.4	2668.5	2636.4	2702.7	2291.8
19	Ховд	2758.1	2647.7	2701.0	2588.8	2692.5	2944.4	3155.7	3176.1	3161.8	2683.7
20	Хөвсгөл	2280.2	2139.7	2233.6	2251.0	2100.7	2380.6	2171.1	2207.4	2202.2	1887.6
21	Хэнтий	2297.8	2085.4	2159.2	2248.2	2198.8	2978.0	2633.4	2592.4	2736.9	2313.5
22	Аймгийн дундаж	2406.7	2302.3	2340.8	2359.2	2224.4	2764.8	2553.5	2619.1	2656.5	2218.2
23	Улаанбаатар	3151.6	3307.7	3479.6	3558.3	3026.3	2945.0	3528.9	3588.3	3447.9	3119.8
24	Улсын дундаж	2748.8	2756.4	2856.7	2906.8	2593.0	2848.2	3011.3	3082.8	3040.6	2658.2

Амбулаторид бүртгэгдсэн хүн амын өвчлөл, /10 000 хүнд/

№	Аймаг, Хот	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Архангай	9203.9	10178.0	9686.9	10094.1	7902.2	7254.7	9650.7	11003.4	10824.1	10167.7
2	Баян-Өлгий	4573.3	5408.8	6040.1	8582.6	5436.4	8292.9	9186.2	12212.6	11249.9	10973.3
3	Баянхонгор	9799.2	10745.8	12146.8	12803.5	9373.1	8915.7	9510.0	9477.2	10300.5	9380.4
4	Булган	8347.8	10707.1	9119.7	10038.1	4660.3	10144.8	12846.4	15015.8	16681.2	16390.3
5	Говь-Алтай	6819.7	7442.8	8198.2	12127.1	10010.5	9546.5	11363.3	11227.9	10895.4	10984.5
6	Говь-Сүмбэр	6337.6	6338.3	6770.8	5910.9	2540.8	5421.9	6136.2	4275.0	3198.9	3025.0
7	Дархан-Уул	8334.3	8945.2	8779.5	9854.2	4242.9	4797.8	5603.3	6409.8	8570.8	6624.9
8	Дорноговь	9302.9	13795.3	13643.6	15268.8	12312.4	13060.3	15386.5	16148.2	16129.0	13385.5
9	Дорнод	7419.5	7837.1	7736.5	8080.6	4823.5	8032.0	11281.8	12143.0	11416.1	12643.6
10	Дундговь	6353.6	5926.6	7403.3	9705.7	7450.5	7686.9	8986.6	11442.8	10760.4	10356.9
11	Завхан	6545.3	8723.5	9295.7	10288.9	8351.4	9749.0	15630.5	16844.0	15147.9	16163.1
12	Орхон	6556.9	5959.4	5075.3	8105.1	5776.6	6386.3	7483.4	7344.7	6228.3	5824.8
13	Өвөрхангай	7129.5	7804.1	7334.2	8181.9	4906.4	5200.4	6401.9	5322.1	4162.0	4882.7
14	Өмнөговь	11227.6	10970.7	11884.0	13863.9	11509.4	10362.9	16055.1	14609.4	13220.6	13803.9
15	Сүхбаатар	7876.5	7478.0	7417.0	9009.5	5902.1	6158.2	7057.6	7235.3	7104.5	6807.2
16	Сэлэнгэ	4661.9	5046.2	5291.5	6320.3	4011.8	4888.3	6598.3	7463.5	8548.3	8280.0
17	Төв	9053.2	9041.8	10587.1	12726.8	9076.1	8081.7	11543.7	12539.2	14249.0	12553.9
18	Увс	7853.6	8278.3	8990.5	10157.6	8106.3	9755.4	11607.0	11116.5	9461.5	7111.6
19	Ховд	5913.1	7297.1	9417.6	9640.4	7350.4	9566.9	9281.9	13507.0	13377.1	13548.6
20	Хөвсгөл	6498.2	8001.0	7998.7	9481.1	7050.8	7166.2	10153.1	10305.2	7811.2	8143.6
21	Хэнтий	7039.9	7298.4	7692.8	10033.1	7414.0	9543.1	11899.2	12668.1	11990.7	12047.0
22	Аймгийн дундаж	7392.0	8198.5	8508.6	9963.1	7013.4	7934.1	10002.9	10762.6	10412.2	10027.0
23	Улаанбаатар	9250.5	10770.4	10953.7	12886.3	8468.5	9083.6	11467.1	11801.6	11481.1	10868.2
24	Улсын дундаж	8245.4	9360.1	9616.2	11298.2	7682.3	8466.1	10690.1	11259.7	10930.9	10437.6



БҮЛЭГ 14

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД



ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2025 ОН

Өвчний бүлэг ӨОУА-10	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Бодит тоо	10000 хүнд	Бодит тоо	10 000 хүнд	Бодит тоо	10000 хүнд
Зүрх-судасны тогтолцооны өвчин	5732	16.69	3555	20.98	2177	12.52
Хавдар	4396	12.80	2515	14.84	1881	10.82
Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт	3247	9.46	2553	15.07	694	3.99
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1181	3.44	699	4.13	482	2.77
Амьсгалын тогтолцооны өвчин	968	2.82	591	3.49	377	2.17
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	417	1.21	238	1.40	179	1.03
Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин	389	1.13	211	1.25	178	1.02
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	378	1.10	181	1.07	197	1.13
Халдварт ба шимэгчит зарим өвчин	344	1.00	238	1.40	106	0.61
Мэдрэлийн тогтолцооны өвчин	267	0.78	138	0.81	129	0.74
Бусад	588	1.71	258	1.52	330	1.90
Бүгд	17907	52.16	11177	65.97	6730	38.7

НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН /АЙМГААР/, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	10 000 хүнд				
		Зүрх судасны тогтолцооны өвчин	Хавдар	Осол гэмтэл, гаднын шалтгаант нас баралт	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
1	Архангай	21.5	14.0	11.1	1.3	3.5
2	Баян-Өлгий	14.5	11.2	2.8	2.9	1.7
3	Баянхонгор	17.2	11.1	6.3	4.0	3.1
4	Булган	24.0	17.3	11.7	2.2	2.2
5	Говь-Алтай	20.0	11.5	5.0	0.9	2.1
6	Говь-Сүмбэр	15.4	11.0	9.3	3.8	6.0
7	Дархан-Уул	17.9	15.1	5.5	4.1	3.0
8	Дорноговь	11.6	13.3	14.3	5.3	6.3
9	Дорнод	17.0	15.7	10.3	5.1	3.2
10	Дундговь	22.6	12.4	7.8	2.8	1.7
11	Завхан	19.8	10.7	3.5	2.8	2.7
12	Орхон	15.9	14.0	4.8	3.1	1.4
13	Өвөрхангай	17.4	10.6	8.8	2.9	2.6
14	Өмнөговь	12.1	6.2	6.9	3.1	2.8
15	Сүхбаатар	13.0	16.4	3.9	3.2	2.6
16	Сэлэнгэ	18.5	13.0	11.8	4.2	2.6
17	Төв	18.7	14.4	13.0	3.5	3.1
18	Увс	20.3	15.5	6.3	1.7	2.5
19	Ховд	12.5	10.3	4.3	1.7	0.9
20	Хөвсгөл	21.9	11.8	9.8	2.2	2.3
21	Хэнтий	15.2	15.9	6.2	3.0	2.3
22	Аймгийн дундаж	17.5	12.9	7.8	3.0	2.6
23	Улаанбаатар	15.9	12.7	11.2	3.9	3.0
24	Улсын дундаж	16.7	12.8	9.5	3.4	2.8



НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ, 2025 ОН

№	Аймаг,хотын нэр	Перинаталь эндэгдэл (амьд,амьгүй төрсөн 1000 хүүхдэд)	Амьгүй төрөлт (амьд, амьгүй төрсөн 1000 хүүхдэд)	Нярайн эндэгдэл (амьд төрсөн 1000 хүүхдэд)	Нярайн эрт үеийн эндэгдэл (амьд төрсөн 1000 хүүхдэд)	Нярайн хожуу үеийн эндэгдэл (амьд төрсөн 1000 хүүхдэд)
А	Б	1	2	3	4	5
1	Архангай	14.8	11.9	6.0	3.0	3.0
2	Баян-Өлгий	11.0	4.1	10.6	6.9	3.7
3	Баянхонгор	3.9	2.4	2.4	1.6	0.8
4	Булган	17.2	8.6	8.7	8.7	0.0
5	Говь-Алтай	8.6	6.1	7.4	2.5	4.9
6	Говь-Сүмбэр	17.3	6.9	10.5	10.5	0.0
7	Дархан-Уул	8.9	2.8	7.8	6.1	1.7
8	Дорноговь	9.2	4.6	10.4	4.6	5.8
9	Дорнод	7.9	7.1	2.4	0.8	1.6
10	Дундговь	3.9	3.9	1.9	0.0	1.9
11	Завхан	12.0	3.6	8.4	8.4	0.0
12	Орхон	8.2	4.6	5.7	3.6	2.1
13	Өвөрхангай	11.2	1.2	12.4	9.9	2.5
14	Өмнөговь	10.7	3.6	12.6	7.2	5.4
15	Сүхбаатар	13.4	6.1	7.4	7.4	0.0
16	Сэлэнгэ	11.0	5.0	7.1	6.1	1.0
17	Төв	12.0	4.5	10.5	7.5	3.0
18	Увс	11.7	3.6	13.9	8.1	5.9
19	Ховд	9.4	5.9	4.7	3.5	1.2
20	Хөвсгөл	8.5	1.7	11.3	6.8	4.5
21	Хэнтий	6.1	4.1	4.1	2.0	2.0
22	Аймгийн дундаж	9.8	4.4	8.1	5.4	2.7
23	Улаанбаатар	11.0	4.8	8.8	6.2	2.6
24	Улсын дундаж	10.5	4.6	8.5	5.9	2.6

ХАЛДВАРТ ӨВЧИН, 10 000 ХҮНД /2021-2025 ОН/

Халдварт ба шимэгчид зарим өвчин	10 000 хүнд				
	2021	2022	2023	2024	2025
Балнад	0.0	0.0	0.0	0.0	0.0
Сальмонеллэз	0.1	0.7	1.0	2.3	2.0
Цусан суулга	2.2	5.1	7.1	8.5	4.0
Сүрьеэ	6.9	6.9	7.0	6.4	5.9
Тарваган тахал	0.0	0.0	0.0	0.0	0.0
Боом	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бруцеллэз	0.1	0.2	0.3	0.1	0.2
Улаан эсэргэнэ	0.1	0.4	4.1	1.5	2.1
Менингококкт халдвар	0.0	0.0	0.0	0.0	0.0
Салхинцэцэг	0.9	10.2	35.1	34.9	32.0
Улаанбурхан	0.0	0.0	0.0	0.0	39.1
Улаанууд	0.0	0.0	0.0	0.0	0.0
Вируст гепатит	0.4	0.6	0.8	0.6	0.6
Вируст гепатит А	0.1	0.0	0.0	0.0	0.0
Вируст гепатит В	0.2	0.3	0.4	0.2	0.0
Вируст гепатит С	0.1	0.2	0.4	0.3	0.3
Гахай хавдар	0.1	0.2	0.6	0.9	0.5
Мөөгөнцөр	4.3	6.1	4.4	4.3	4.1
Тэмбүү	10.8	11.9	12.4	15.0	12.3
Заг хүйтэн	9.1	11.4	10.6	11.4	10.1
Трихомониаз	7.9	8.1	7.2	8.2	6.8



**ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН ТАРХАЛТ, ТОХИОЛДЛЫН ТОО,
НАС БАРАЛТ, 2025 ОН**

Хорт хавдар	№	Тархалт		Тохiolдлын тоо						Нас баралт					
		Бодит тоо	10 000 хүнд	Бодит тоо			10 000 хүнд			Бодит тоо			10 000 хүнд		
				Бүгд	Эрэгэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгэй	Эмэгтэй
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Уруул амны хөндий, залгиур	1	1941	5.7	342	121	221	1.0	0.7	1.3	104	65	39	0.3	0.4	0.2
Улаан хоолой	2	1291	3.8	358	227	131	1.0	1.3	0.8	284	170	114	0.8	1.0	0.7
Ходоод	3	5835	17.0	1336	909	427	3.9	5.4	2.5	752	512	240	2.2	3.0	1.4
Бүдүүн гэдэс	4	1516	4.4	319	170	149	0.9	1.0	0.9	147	68	79	0.4	0.4	0.5
Шулуун гэдэс, хошног	5	480	1.4	118	61	57	0.3	0.4	0.3	55	30	25	0.2	0.2	0.1
Элэг	6	9423	27.4	2157	1159	998	6.3	6.8	5.7	1656	927	729	4.8	5.5	4.2
Нойр бүлчирхайн өмөн	7	658	1.9	248	121	127	0.7	0.7	0.7	205	103	102	0.6	0.6	0.6
Хоол боловсруулах замын бусад	8	198	0.6	55	29	26	0.2	0.2	0.1	34	18	16	0.1	0.1	0.1
Төвөнх	9	203	0.6	28	25	3	0.1	0.1	0.0	27	25	2	0.1	0.1	0.0
Хамрын хөндийн дайвар	10	97	0.3	16	9	7	0.0	0.1	0.0	14	9	5	0.0	0.1	0.0
Уушги	11	1282	3.7	524	411	113	1.5	2.4	0.6	477	383	94	1.4	2.3	0.5
Амьсгалын эрхтний бусад	12	91	0.3	22	14	8	0.1	0.1	0.0	16	13	3	0.0	0.1	0.0
Яс ба үений мөгөөрс	13	329	1.0	40	19	21	0.1	0.1	0.1	22	15	7	0.1	0.1	0.0
Арьсны меланома ба бусад	14	519	1.5	70	19	51	0.2	0.1	0.3	39	17	22	0.1	0.1	0.1
Гялтан ба зөөлөн эд	15	536	1.6	136	58	78	0.4	0.3	0.4	47	26	21	0.1	0.2	0.1
Хөх	16	3134	9.1	406	2	404	1.2	0.0	2.3	107		107	0.3	0.0	0.6
Умайн хүзүү	17	5608	16.3	550		550	1.6	0.0	3.2	171		171	0.5	0.0	1.0
Умай	18	436	1.3	57		57	0.2	0.0	0.3	17		17	0.0	0.0	0.1
Өндгөвч	19	997	2.9	181		181	0.5	0.0	1.0	77		77	0.2	0.0	0.4
Эм бэлэг эрхтний бусад	20	217	0.6	22		22	0.1	0.0	0.1	12		12	0.0	0.0	0.1
Эр бэлэг эрхтэн	21	485	1.4	98	98		0.3	0.6	0.0	53	53		0.2	0.3	0.0
Давсаг	22	483	1.4	105	80	25	0.3	0.5	0.1	41	37	4	0.1	0.2	0.0
Бөөрний	23	2060	6.0	325	181	144	0.9	1.1	0.8	88	53	35	0.3	0.3	0.2
Шээсний замын бусад	24	69	0.2	8	2	6	0.0	0.0	0.0	7	5	2	0.0	0.0	0.0
Нүд ба түүний дайврын	25	114	0.3	7	5	2	0.0	0.0	0.0	4	3	1	0.0	0.0	0.0
Тархины	26	483	1.4	98	53	45	0.3	0.3	0.3	72	42	30	0.2	0.2	0.2
Лейкеми, лимфолейкеми	27	655	1.9	170	83	87	0.5	0.5	0.5	95	48	47	0.3	0.3	0.3
Бусад	28	971	2.8	219	111	108	0.6	0.7	0.6	124	73	51	0.4	0.4	0.3
Бүгд	29	40111	116.8	8015	3967	4048	23.3	23.4	23.3	4747	2695	2052	13.8	15.9	11.8

**Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төвийн тайлан, 2025*

**ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН ТАРХАЛТ, ТОХИОЛДЛЫН ТОО,
НАС БАРАЛТ, АЙМГААР, 2025 ОН**

№	Аймаг, хотын нэр	Тархалт		Тохiolдлын тоо						Нас баралт					
		Бодит тоо	10 000 хүнд	Бодит тоо			10 000 хүнд			Бодит тоо			10 000 хүнд		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Архангай	1100	119.3	233	124	109	25.3	26.7	23.8	163	97	66	17.7	20.9	14.4
2	Баян-Өлгий	915	83.2	226	125	101	20.6	22.7	18.4	124	73	51	11.3	13.3	9.3
3	Баянхонгор	825	93.5	195	82	113	22.1	18.8	25.3	110	56	54	12.5	12.9	12.1
4	Булган	854	143.2	171	96	75	28.7	31.6	25.6	118	73	45	19.8	24.0	15.4
5	Говь-Алтай	772	136.6	131	78	53	23.2	27.5	18.9	93	57	36	16.5	20.1	12.8
6	Говь-Сүмбэр	190	104.2	39	16	23	21.4	17.5	25.3	25	14	11	13.7	15.3	12.1
7	Дархан-Уул	1565	149.2	312	157	155	29.7	30.6	28.9	196	113	83	18.7	22.0	15.5
8	Дорноговь	733	100.5	164	86	78	22.5	22.8	22.1	116	61	55	15.9	16.2	15.6
9	Дорнод	1052	124.9	228	134	94	27.1	31.5	22.6	158	93	65	18.8	21.9	15.6
10	Дундговь	513	111.4	110	59	51	23.9	25.4	22.3	65	38	27	14.1	16.4	11.8
11	Завхан	1045	147.8	194	102	92	27.4	29.0	25.9	103	65	38	14.6	18.4	10.7
12	Орхон	1773	166.7	328	127	201	30.8	24.3	37.1	180	94	86	16.9	18.0	15.9
13	Өвөрхангай	1380	120.7	197	101	96	17.2	17.8	16.7	148	79	69	12.9	13.9	12.0
14	Өмнөговь	712	89.7	105	50	55	13.2	12.2	14.3	60	36	24	7.6	8.8	6.2
15	Сүхбаатар	767	115.6	159	91	68	24.0	27.2	20.7	123	80	43	18.5	23.9	13.1
16	Сэлэнгэ	1648	157.2	293	147	146	28.0	27.6	28.4	192	118	74	18.3	22.1	14.4
17	Төв	1277	138.1	274	151	123	29.6	31.3	27.8	187	112	75	20.2	23.2	17.0
18	Увс	1005	118.7	261	151	110	30.8	35.4	26.2	155	97	58	18.3	22.8	13.8
19	Ховд	1031	113.8	201	98	103	22.2	21.6	22.8	116	75	41	12.8	16.5	9.1
20	Хөвсгөл	1432	105.1	316	179	137	23.2	26.4	20.0	183	110	73	13.4	16.2	10.6
21	Хэнтий	1187	150.2	218	102	116	27.6	25.4	29.8	140	76	64	17.7	18.9	16.5
22	Аймгийн дундаж	21776	123.9	4355	2256	2099	24.8	25.5	24.0	2755	1617	1138	15.7	18.3	13.0
23	Улаанбаатар	18335	109.4	3660	1711	1949	21.8	21.1	22.5	1992	1078	914	11.9	13.3	10.6
24	Улсын дундаж	40111	116.8	8015	3967	4048	23.3	23.4	23.3	4747	2695	2052	13.8	15.9	11.8

* Эх сурвалж: Хавдар судлалын үндэсний төвийн тайлан, 2025

АМБУЛАТОРИД БҮРТГЭГДСЭН ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	10 000 хүнд																										
		Амьсгалын тогтолцооны өвчин						Хоол боловсруулах тогтолцооны өвчин						Шээс бэлгийн тогтолцооны эмгэг						Зурх судасны тогтолцооны өвчин						Гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмгэг		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй						
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15												
1	Архангай	2419.7	2227.9	2614.3	1731.2	1363.6	2104.3	989.6	528.3	1457.8	1434.1	1072.2	1801.5	714.8	916.9	509.6												
2	Баян-Өлгий	1918.3	1790.6	2046.1	2443.8	2155.9	2731.9	937.0	533.6	1340.5	1292.7	1108.0	1477.4	177.3	232.3	122.3												
3	Баянхонгор	2050.7	1980.6	2118.9	1401.7	1158.0	1638.7	1162.7	680.5	1631.8	1359.9	955.6	1753.2	364.4	472.7	259.1												
4	Булган	3239.5	2767.7	3729.8	4319.5	3390.1	5285.1	1338.8	783.1	1916.2	4439.3	3178.5	5749.2	308.0	382.2	230.8												
5	Говь-Алтай	1810.0	1650.2	1971.4	2374.0	1991.3	2760.8	1344.3	687.5	2008.1	1506.9	1159.5	1858.0	841.8	1024.3	657.4												
6	Говь-Сүмбэр	707.2	671.8	742.6	386.2	323.3	449.3	302.3	88.8	516.3	324.8	295.9	353.7	229.3	320.0	138.4												
7	Дархан-Уул	2191.4	2176.0	2206.0	901.2	774.0	1022.6	550.9	248.6	839.9	466.8	360.0	568.9	213.3	275.7	153.7												
8	Дорноговь	3517.1	3290.3	3759.6	2956.9	2471.2	3476.3	1124.6	411.3	1887.5	1108.3	861.6	1372.1	460.9	607.5	304.0												
9	Дорнод	3136.3	3084.1	3189.6	2896.4	2452.2	3350.2	1031.8	515.8	1559.0	1051.8	768.9	1341.0	203.9	269.3	137.1												
10	Дундговь	2154.2	1932.8	2379.3	1676.7	1381.3	1977.1	1333.7	497.2	2184.3	1229.2	811.3	1654.1	701.3	865.6	534.1												
11	Завхан	2932.4	2725.0	3138.2	3639.0	2981.1	4292.2	1852.3	938.6	2759.4	2294.5	1766.0	2819.2	547.8	685.2	411.4												
12	Орхон	1389.7	1367.3	1411.2	1047.7	876.6	1212.5	891.2	446.4	1319.3	531.9	382.6	675.6	91.2	121.1	62.4												
13	Өвөрхангай	1234.5	1166.6	1301.7	627.5	486.3	767.3	398.1	233.7	560.8	704.3	519.7	887.0	425.1	557.8	293.7												
14	Өмнөговь	4130.7	3768.4	4515.2	2145.5	1721.0	2596.0	1088.8	518.9	1693.5	1151.4	894.8	1423.7	223.1	328.8	110.9												
15	Сүхбаатар	3385.8	3063.0	3715.2	872.4	672.4	1076.5	361.1	170.4	555.8	454.9	357.8	553.9	237.8	328.0	145.6												
16	Сэлэнгэ	1646.4	1594.1	1700.6	1212.0	1002.6	1428.9	711.9	360.5	1075.6	1120.8	827.5	1424.4	510.6	624.4	392.9												
17	Төв	3641.3	3280.4	4035.4	1663.5	1223.5	2144.1	1303.7	427.0	2261.4	1988.8	1311.2	2729.0	447.2	534.8	351.5												
18	Увс	1620.7	1477.1	1766.2	1144.5	854.4	1438.3	818.1	341.0	1301.4	1275.9	881.8	1675.1	79.3	104.7	53.5												
19	Ховд	2245.5	2101.8	2390.1	3363.0	2771.1	3958.7	1283.8	578.8	1993.3	1714.0	1344.6	2085.6	228.9	267.4	190.2												
20	Хөвсгөл	1568.4	1467.0	1668.5	2096.5	1694.3	2493.8	577.1	319.2	832.0	1275.8	916.3	1630.9	85.0	112.9	57.3												
21	Хэнтий	3187.5	2954.2	3428.4	1735.9	1404.6	2078.0	977.2	457.5	1514.1	1670.7	1296.6	2057.2	261.6	346.9	173.4												
22	Аймгийн дундаж	2353.6	2203.1	2505.9	1909.2	1563.0	2259.3	946.9	460.1	1439.2	1317.9	981.6	1657.8	328.9	421.0	235.9												
23	Улаанбаатар	1332.7	1291.8	1371.1	1696.7	1433.3	1943.4	1158.6	564.0	1715.7	1108.9	852.2	1349.4	1293.5	1537.6	1064.8												
24	Улсын дундаж	1855.4	1767.2	1941.4	1805.5	1500.9	2102.2	1050.2	509.8	1576.7	1215.9	919.7	1504.4	799.7	955.2	648.2												

ӨВЧЛӨЛИЙН БҮТЭЦ, 2025 ОН

№	ӨОУА-10 нэршил	Хүн амын өвчлөл			Стационарын өвчлөл		
		Бодит тоо	10 000 хүнд	Нийт тох.д эзлэх хувь %	Бодит тоо	10 000 хүнд	Нийт тох.д эзлэх хувь %
1	Амьсгалын тогтолцооны өвчин	637035	1855.4	17.8	164893	480.3	18.1
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	619892	1805.5	17.3	91271	265.8	10.0
3	Зүрх-судасны тогтолцооны өвчин	417465	1215.9	11.6	102036	297.2	11.2
4	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	360583	1050.2	10.1	65348	190.3	7.2
5	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	274555	799.7	7.7	43682	127.2	4.8
6	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	197058	573.9	5.5	24230	70.6	2.7
7	Мэдрэлийн тогтолцооны өвчин	190290	554.2	5.3	48944	142.6	5.4
8	Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	174410	508.0	4.9	51432	149.8	5.6
9	Нүд ба түүний дайврын өвчин	172490	502.4	4.8	10908	31.8	1.2
10	Бусад	539832	1572.3	15.1	309908	902.6	34.0
11	Бүгд	3583610	10437.6	100.0	912652	2658.2	100.0



ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Нийт хяналтад авсан			6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Өсвөр насны охидын жирэмслэлтийн эзлэх хувь	Хожуу жирэмслэлтийн эзлэх хувь
		Эхний 3 сартайд	4-6 сартайд	7 ба түүнээс дээш сартайд				
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	91.3	7.3	1.4	83.2	2.0	4.0	23.1
2	Баян-Өлгий	93.9	5.9	0.2	93.4	8.7	0.8	24.7
3	Баянхонгор	91.2	8.2	0.7	91.5	3.8	6.7	23.1
4	Булган	93.7	5.9	0.4	67.2	2.8	3.4	25.6
5	Говь-Алтай	94.2	4.9	1.0	85.4	0.0	2.5	24.9
6	Говь-Сүмбэр	97.6	1.6	0.8	85.0	0.8	6.5	33.1
7	Дархан-Уул	96.4	3.1	0.4	75.8	6.4	4.5	24.2
8	Дорноговь	89.9	8.6	1.5	88.4	6.0	4.8	25.8
9	Дорнод	94.8	5.1	0.2	80.7	5.0	5.0	24.6
10	Дундговь	97.0	2.6	0.4	93.2	0.8	3.2	25.8
11	Завхан	92.3	7.2	0.5	88.4	1.9	2.1	28.9
12	Орхон	99.0	0.9	0.1	93.8	3.0	3.7	28.6
13	Өвөрхангай	95.7	3.8	0.6	76.7	2.8	3.5	22.6
14	Өмнөговь	91.1	8.1	0.8	92.2	1.1	4.8	21.0
15	Сүхбаатар	89.9	9.5	0.6	91.3	7.7	3.8	25.8
16	Сэлэнгэ	91.8	7.5	0.7	79.5	0.9	5.0	28.1
17	Төв	94.9	4.4	0.7	93.7	1.1	4.0	24.5
18	Увс	94.5	4.4	1.0	82.4	2.5	2.1	24.3
19	Ховд	94.8	4.7	0.5	87.8	2.9	1.8	22.8
20	Хөвсгөл	89.7	9.5	0.8	90.3	0.8	5.2	23.5
21	Хэнтий	94.9	4.8	0.4	77.0	0.6	2.8	26.7
22	Аймгийн дундаж	93.7	5.7	0.6	86.1	3.4	3.7	24.8
23	Улаанбаатар	92.7	6.4	0.9	85.9	3.8	6.1	24.6
24	Улсын дундаж	93.2	6.1	0.8	86.0	3.6	5.0	24.7

**ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭДЭГ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2025 ОН**

№	Аймаг, хотын нэр	ЖСАХ хэрэглэдэг эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Үүнээс					
			Бэлдмэл (эм)	Тариа	Норлант	Бэлгэвч	Ерөндөг	Стерилизаци
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Архангай	34.96	16.82	7.19	4.68	4.43	55.37	7.93
2	Баян-Өлгий	42.75	15.15	19.61	3.00	26.32	29.09	1.25
3	Баянхонгор	54.13	10.67	5.34	4.83	7.92	61.56	4.75
4	Булган	32.92	17.61	6.98	5.38	22.18	43.15	2.38
5	Говь-Алтай	52.98	13.89	10.69	9.07	14.71	45.04	2.54
6	Говь-Сүмбэр	45.32	33.57	11.28	8.30	16.09	17.99	5.79
7	Дархан-Уул	67.81	29.21	20.47	5.44	18.95	10.55	1.57
8	Дорноговь	51.64	22.89	7.06	8.13	20.03	26.18	2.64
9	Дорнод	59.00	14.04	9.35	9.15	10.45	41.71	5.32
10	Дундговь	38.98	15.12	11.15	6.03	31.60	30.00	2.42
11	Завхан	48.24	15.28	14.94	4.81	12.77	40.86	3.39
12	Орхон	63.74	17.66	9.88	5.21	27.57	30.84	2.59
13	Өвөрхангай	59.88	13.80	5.32	6.76	11.91	52.56	3.76
14	Өмнөговь	50.76	19.55	16.90	10.31	26.40	14.55	8.10
15	Сүхбаатар	59.58	8.95	6.75	2.11	4.57	69.91	6.76
16	Сэлэнгэ	50.89	18.15	14.37	10.89	16.48	30.30	7.44
17	Төв	35.80	24.33	11.21	5.54	18.45	33.25	3.36
18	Увс	38.61	20.53	11.65	10.64	16.12	29.42	2.17
19	Ховд	44.90	19.97	16.91	7.27	27.79	16.26	7.11
20	Хөвсгөл	49.90	11.87	12.56	10.96	8.16	48.99	6.72
21	Хэнтий	32.46	20.02	10.03	4.83	14.07	46.82	2.63
22	Аймгийн дундаж	49.32	17.40	11.75	6.92	16.61	37.16	4.35
23	Улаанбаатар	49.71	17.37	6.98	6.00	31.59	18.87	1.93
24	Улсын дундаж	49.52	17.38	9.34	6.45	24.18	27.92	3.13



ҮР ХӨНДӨЛТ, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Үр хөндөлт		Бүгд	Үр хөндөлт насаар				Хожуу үр хөндөлт	
		Төрөх насны 1000 эмэгтэйд /15-49 нас/	1000 амьд төрөлтөд		20 хүртэлх насны		35 ба дээш насны		Бодит тоо	1000 амьд төрөлтөд
					Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь		
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	Архангай	11.0	239.2	239	8	3.3	109	45.6	8	8.0
2	Баян-Өлгий	5.2	56.8	139	5	3.6	68	48.9		0.0
3	Баянхонгор	4.8	82.0	104	13	12.5	35	33.7	17	13.4
4	Булган	4.7	137.0	63	5	7.9	28	44.4	13	28.3
5	Говь-Алтай	6.9	116.9	95	13	13.7	21	22.1	10	12.3
6	Говь-Сүмбэр	2.1	31.4	9	0	0.0	5	55.6		0.0
7	Дархан-Уул	15.0	206.7	372	19	5.1	123	33.1	13	7.2
8	Дорноговь	16.0	322.5	278	23	8.3	72	25.9	11	12.8
9	Дорнод	12.6	194.2	243	15	6.2	84	34.6	27	21.6
10	Дундговь	8.8	182.9	94	10	10.6	34	36.2	2	3.9
11	Завхан	0.8	16.9	14	2	14.3	5	35.7		0.0
12	Орхон	11.4	148.2	287	30	10.5	112	39.0	10	5.2
13	Өвөрхангай	4.4	74.6	120	14	11.7	47	39.2		0.0
14	Өмнөговь	20.5	349.5	389	28	7.2	121	31.1	6	5.4
15	Сүхбаатар	7.9	151.1	123	5	4.1	50	40.7	4	4.9
16	Сэлэнгэ	3.1	75.7	75	4	5.3	33	44.0	7	7.1
17	Төв	6.7	198.2	132	9	6.8	57	43.2	8	12.0
18	Увс	6.0	89.3	122	4	3.3	50	41.0	7	5.1
19	Ховд	1.0	13.0	22	2	9.1	10	45.5		0.0
20	Хөвсгөл	1.2	23.2	41	30	73.2	8	19.5	31	17.6
21	Хэнтий	3.7	68.4	67	2	3.0	27	40.3		0.0
22	Аймгийн дундаж	7.3	123.8	3028	241	8.0	1099	36.3	174	7.1
23	Улаанбаатар	20.8	295.5	8769	381	4.3	3123	35.6	352	11.9
24	Улсын дундаж	14.1	217.9	11797	622	5.3	4222	35.8	526	9.7

**ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕД ҮЗҮҮЛСЭН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
/АЙМГААР/, 2025 ОН**

№	Аймаг, хотын нэр	Төрөлтийн эзлэх хувь				Эмнэлгийн тусламжгүй төрсөн төрөлтийн эзлэх хувь	20-иос доош насны төрөлтийн эзлэх хувь	35-аас дээш насны төрөлтийн эзлэх хувь	2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь
		Аймаг, хотын нэгдсэн эмнэлэгт	Хувийн эмнэлэгт	Сумын эрүүл мэндийн төв	Гэртээ				
А	Б	1	2	3	4	5	6	7	8
1	Архангай	89.8	0.0	10.0	0.2	0.2	4.5	19.4	3.7
2	Баян-Өлгий	89.5	0.0	10.2	0.2	0.1	0.8	19.4	4.6
3	Баянхонгор	97.7	0.0	2.1	0.2	0.1	5.9	22.4	2.3
4	Булган	88.5	0.0	10.8	0.7	0.0	5.0	24.3	3.0
5	Говь-Алтай	94.8	0.0	4.7	0.5	0.1	4.0	18.0	4.2
6	Говь-Сүмбэр	99.7	0.0	0.0	0.3	0.0	5.9	24.7	2.8
7	Дархан-Уул	99.6	0.0	0.1	0.3	0.2	4.1	25.8	2.7
8	Дорноговь	80.2	0.0	19.6	0.2	0.2	4.8	22.9	2.8
9	Дорнод	97.6	0.0	2.1	0.3	0.1	4.4	28.3	3.1
10	Дундговь	96.5	0.0	3.3	0.2	0.0	6.1	18.0	2.7
11	Завхан	62.9	0.0	36.8	0.2	0.0	3.3	20.5	2.8
12	Орхон	99.7	0.0	0.1	0.2	0.1	4.0	27.4	3.5
13	Өвөрхангай	85.8	0.0	14.0	0.2	0.1	4.3	20.6	4.1
14	Өмнөговь	86.2	0.0	13.6	0.2	0.1	4.5	21.1	4.8
15	Сүхбаатар	96.4	0.0	3.2	0.4	0.1	4.3	26.1	3.9
16	Сэлэнгэ	53.7	0.0	46.2	0.1	0.1	5.1	26.3	3.8
17	Төв	88.8	0.0	10.9	0.3	0.3	5.9	25.5	4.2
18	Увс	90.9	0.0	8.6	0.5	0.3	2.6	20.1	3.0
19	Ховд	91.5	0.0	8.5	0.0	0.0	2.2	21.2	4.1
20	Хөвсгөл	87.9	0.0	11.9	0.2	0.1	5.1	21.2	3.7
21	Хэнтий	82.7	0.0	17.2	0.1	0.0	5.6	23.5	4.4
22	Аймгийн дундаж	89.3	0.0	10.4	0.2	0.1	4.0	22.6	3.6
23	Улаанбаатар	93.6	6.2	0.0	0.2	0.1	3.5	27.4	5.9
24	Улсын дундаж	91.6	3.4	4.7	0.2	0.1	3.8	25.3	4.9



1 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Хамрагдсан хувь			
		СХТ + Геп В +ХиВ-ийн тавт вакцин	Улаанбурхан, гахай хавдар, улаанууд	А.Гепатит	СТ-ийн хоргүйсгүүр
А	Б	1	2	3	4
1	Архангай	99.1	99.6	99.3	69.2
2	Баян-Өлгий	92.0	91.9	92.1	74.0
3	Баянхонгор	98.9	99.5	99.3	70.0
4	Булган	99.0	99.7	99.6	70.5
5	Говь-Алтай	97.7	99.5	98.6	67.3
6	Говь-Сүмбэр	100.0	99.8	99.7	94.3
7	Дархан-Уул	98.5	99.7	99.4	86.2
8	Дорноговь	96.0	97.0	95.1	80.2
9	Дорнод	99.3	99.7	99.6	79.9
10	Дундговь	97.7	99.3	98.7	69.5
11	Завхан	96.7	99.9	99.9	75.6
12	Орхон	99.9	99.8	99.8	97.1
13	Өвөрхангай	98.4	98.8	98.0	72.2
14	Өмнөговь	98.5	99.2	98.0	88.1
15	Сүхбаатар	99.2	99.7	99.4	66.4
16	Сэлэнгэ	100.0	100.0	100.0	78.9
17	Төв	95.9	96.8	96.8	64.7
18	Увс	96.5	98.9	98.2	82.8
19	Ховд	95.9	95.1	93.7	64.9
20	Хөвсгөл	95.9	98.6	98.1	81.0
21	Хэнтий	95.1	99.1	97.4	75.3
22	Аймгийн дундаж	97.3	98.4	98.0	76.6
23	Улаанбаатар	95.2	97.5	95.1	69.7
24	Улсын дундаж	96.3	98.0	96.7	73.3

ТАЙЛБАР: ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН ХУВИЙН ТУХАЙН ВАКЦИНД ХАМРАГДВАЛ ЗОХИХ ХҮҮХДИЙН ТООНООС ТООЦОЖ ГАРГАСАН БОЛНО.

Эх сурвалж: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын тайлан, 2025 он

10 000 ХҮНД ИХ ЭМЧИЙН ТОО, АЖЛЫН БАЙРАНДАА ТУХАЙН МЭРГЭЖЛЭЭРЭЭ /МЭРГЭШИЛ/ АЖИЛЛАЖ БАЙГАА, 2025 ОН

Аймаг, хотын нэр	№	Мэргэшийн төрлөөр																			Уламжлалт анагаахын	Шүдний																		
		Бүгд	Хүний их эмч -Бүгд	Ерөнхий мэргэжлийн	Анатомын эмгэг судлал	Арсны	Гэмтлийн	Дотрын	Хөнгөчлөхийн	Дүрс оношилгооны	Ерөнхий мэргэжлийн	Зоонозын өвчний	Мэдрлийн	Мэс заслын	Хүүхдийн	Мэдээлжүүлэг	Хүүхдийн	Насты	Нүдний	Өрхийн эмч			Сүрьеэгийн	Сэтгэцийн	Сэргэн засахын	Хавдрын	Харшын	Халдварын	БЭД/ХДВ/ДОХ-ын	Хүүхдийн	Нарайн перинаталь	Чихэр хөдөө	Эмзлүүжлийн лаборатори	Эх бэртэмчлүүдийн	Эринт эмчлээ	Хүүхдийн	Яаралтай тусламжийн	Хүүхдийн	Бүсэд	
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	
Архангай	1	26.3	19.5	4.2	0.1	0.2	0.2	2.9	0.0	1.1	0.1	0.2	0.4	0.9	0.0	0.2	0.1	0.1	0.1	0.0	0.2	0.3	0.2	0.3	0.0	0.4	0.1	2.5	0.3	0.3	0.5	2.1	0.4	0.2	0.4	0.0	0.9	3.8	2.9	
Баян-Өлгий	2	29.2	24.5	8.0	0.2	0.5	3.5	0.0	1.2	0.2	0.2	0.3	0.7	1.1	0.0	0.4	0.0	0.1	0.5	0.2	0.3	0.3	0.3	0.0	0.3	0.0	0.5	2.1	0.5	0.2	1.9	0.2	0.0	0.6	0.0	0.3	2.0	2.7		
Баянхонгор	3	28.6	21.0	8.5	0.0	0.2	0.5	2.0	0.0	0.1	0.0	0.0	0.7	0.9	0.1	0.8	0.1	0.1	0.3	0.0	0.2	0.3	0.2	0.3	0.1	0.9	0.2	1.9	0.2	0.3	0.5	1.5	0.1	0.0	0.2	0.0	0.1	4.4	3.2	
Булган	4	21.8	16.6	8.2	0.2	0.2	0.3	1.0	0.2	0.5	0.0	0.0	0.5	0.8	0.0	0.2	0.0	0.2	0.2	0.0	0.3	0.0	0.2	0.2	0.0	0.7	0.2	0.8	0.2	0.2	1.3	0.3	0.0	0.2	0.0	0.0	0.0	2.5	2.7	
Говь-Алтай	5	37.0	32.6	9.0	0.5	0.4	0.9	3.9	0.0	1.4	0.0	0.5	0.9	1.1	0.2	0.4	0.2	0.0	0.2	0.7	0.4	0.4	0.4	0.4	0.0	1.1	0.4	2.7	0.4	0.5	1.1	1.9	0.4	0.2	1.1	0.0	2.7	1.8	2.7	
Говь-Сүмбэр	6	41.1	35.7	12.6	0.0	0.0	0.5	3.8	0.0	1.1	0.0	0.0	1.6	1.6	0.0	1.1	0.0	0.5	0.5	0.0	0.5	0.5	0.5	1.1	0.0	1.1	0.0	2.2	0.5	0.0	1.1	2.2	1.1	0.0	0.5	0.0	1.1	1.6	3.8	
Дархан-Уул	7	36.8	27.7	3.9	0.0	0.3	0.7	2.9	0.1	1.5	0.2	0.1	1.1	1.3	0.0	0.8	0.1	0.2	0.5	1.9	0.5	0.8	0.4	0.3	0.1	0.7	0.2	2.3	0.3	0.8	1.4	2.5	0.4	0.2	0.5	0.0	1.9	3.0	6.1	
Дорноговь	8	37.0	31.8	9.7	0.4	0.3	0.7	2.5	0.0	1.6	0.0	0.0	1.4	1.1	0.0	0.7	0.1	0.1	0.5	0.5	0.5	0.4	0.7	0.3	0.0	1.0	0.4	2.9	0.7	0.4	1.0	2.5	0.7	0.1	0.8	0.0	1.1	2.5	2.7	
Дорнод	9	26.6	22.0	5.7	0.2	0.6	0.7	2.6	0.1	1.9	0.0	0.0	0.7	0.6	0.1	0.6	0.1	0.1	0.5	0.4	0.4	0.4	0.4	0.2	0.4	0.0	0.7	0.4	1.8	0.4	0.4	0.5	1.7	0.4	0.0	0.1	0.0	0.6	1.8	2.9
Дундговь	10	35.8	27.6	15.6	0.0	0.2	0.2	1.7	0.0	0.7	0.0	0.0	0.4	0.7	0.0	0.4	0.0	0.0	0.2	0.0	0.2	0.4	0.0	0.2	0.0	0.2	0.0	1.5	0.7	0.2	0.2	2.0	0.7	0.2	0.7	0.0	1.1	4.8	3.5	
Завхан	11	29.3	22.8	4.2	0.1	0.3	0.4	3.7	0.1	0.7	0.0	0.1	1.1	0.7	0.1	0.7	0.1	0.1	0.3	0.4	0.7	0.1	0.3	0.1	0.1	0.8	0.3	3.1	0.7	0.4	0.4	1.8	0.7	0.1	0.6	0.0	0.4	3.3	3.3	
Орхон	12	45.0	33.1	6.3	0.2	0.4	0.9	4.2	0.1	2.4	0.5	0.0	1.4	1.5	0.2	0.9	0.1	0.1	1.0	0.6	0.4	0.5	0.5	0.3	0.0	0.5	0.2	2.4	0.5	0.8	1.0	2.5	0.8	0.1	1.1	0.0	1.9	4.7	7.2	
Өвөрхангай	13	29.8	19.4	4.8	0.1	0.2	0.7	2.1	0.1	1.0	0.4	0.0	0.8	0.8	0.2	0.8	0.1	0.0	0.3	0.2	0.2	0.3	0.2	0.1	0.0	0.4	0.3	1.9	0.3	0.3	0.3	1.9	0.7	0.2	0.2	0.0	0.6	7.4	3.0	
Өмнөговь	14	37.2	29.2	9.8	0.1	0.5	0.9	3.0	0.0	0.9	0.0	0.1	0.8	0.6	0.1	0.6	0.0	0.1	0.6	0.1	0.4	0.4	0.1	0.3	0.1	0.6	0.1	3.5	0.6	0.8	0.8	2.5	0.4	0.0	0.5	0.0	0.6	3.9	4.0	
Сүхбаатар	15	25.0	21.9	5.6	0.2	0.3	0.5	2.3	0.0	1.1	1.1	0.0	0.5	0.5	0.3	0.8	0.2	0.0	0.3	0.0	0.3	0.5	0.2	0.5	0.0	0.6	0.2	2.3	0.6	0.3	0.5	1.8	0.3	0.0	0.8	0.0	1.2	2.3	0.9	
Сэлэнгэ	16	26.7	19.9	6.7	0.0	0.3	0.4	2.0	0.0	0.8	0.0	0.0	0.7	0.9	0.0	0.7	0.0	0.0	0.3	0.3	0.5	0.2	0.1	0.2	0.0	0.4	0.1	1.9	0.6	0.6	0.5	1.8	0.4	0.1	0.1	0.0	0.5	3.4	3.3	
Төв	17	27.8	21.4	8.7	0.2	0.2	0.3	1.7	0.0	0.6	0.0	0.0	0.9	0.6	0.0	0.3	0.0	0.0	0.3	0.1	0.5	0.3	1.0	0.1	0.1	0.6	0.2	1.2	0.1	0.2	0.6	1.4	0.2	0.0	0.4	0.0	0.5	4.9	1.5	
Увс	18	29.5	23.9	7.8	0.2	0.5	0.4	2.6	0.0	1.3	0.0	0.5	0.6	0.8	0.1	0.6	0.2	0.1	0.5	0.0	0.2	0.2	0.1	0.2	0.0	0.6	0.2	2.2	0.4	0.4	0.7	1.8	0.4	0.1	0.2	0.0	0.0	3.1	2.6	
Ховд	19	39.7	31.2	8.9	0.4	0.6	0.9	3.1	0.0	1.3	0.1	0.3	1.0	1.1	0.1	0.8	0.0	0.1	0.7	0.7	0.2	0.2	0.2	0.4	0.0	0.6	0.1	2.9	0.0	0.6	0.8	2.6	0.4	0.1	0.4	0.0	1.9	3.6	4.9	
Хөвсгөл	20	24.4	17.9	5.0	0.1	0.1	0.3	2.1	0.0	1.0	0.0	0.1	0.6	0.5	0.0	0.4	0.0	0.0	0.1	0.3	0.2	0.3	0.2	0.1	0.0	0.2	0.0	2.2	0.1	0.2	0.5	1.7	0.1	0.1	0.1	0.0	1.2	3.6	2.9	
Хэнтий	21	26.8	20.9	6.7	0.4	0.0	0.5	1.6	0.0	1.0	0.0	0.1	0.6	1.1	0.1	0.6	0.1	0.3	0.3	0.1	0.3	0.1	0.4	0.1	0.0	0.6	0.3	1.5	0.0	0.4	0.6	1.5	0.3	0.0	0.4	0.0	1.3	3.5	2.4	
Аймгийн дундаж	22	31.0	24.1	7.1	0.2	0.3	0.5	2.6	0.0	1.1	0.1	0.1	0.8	0.9	0.1	0.6	0.1	0.1	0.4	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.0	0.6	0.2	2.2	0.4	0.4	0.6	2.0	0.4	0.1	0.4	0.0	0.9	3.6	3.4	
Улаанбаатар	23	65.5	48.1	6.3	0.3	1.3	1.7	6.2	0.2	2.4	0.5	0.1	2.1	3.6	0.2	1.5	0.2	0.1	1.2	2.1	0.4	0.9	1.1	0.6	0.2	1.0	0.3	3.0	0.5	1.3	1.1	4.2	1.2	0.2	1.0	0.1	2.9	4.6	10.7	
Улсын дундаж	24	46.9	35.8	6.7	0.2	0.8	1.1	4.4	0.1	1.8	0.3	0.1	1.4	2.2	0.2	1.0	0.1	0.1	0.8	1.2	0.4	0.6	0.7	0.4	0.1	0.8	0.3	2.6	0.4	0.9	0.9	3.1	0.8	0.1	0.7	0.1	1.9	4.1	7.0	

10 000 ХҮНД НОГДОХ СУВИЛАГЧИЙН ТОО, АЖЛЫН БАЙРАНДАА ТУХАЙН МЭРГЭЖЛЭЭРЭЭ /МЭРГЭШИЛ/ АЖИЛЛАЖ БАЙГАА, 2025 ОН

Аймаг, хотын нэр	№	Үүнээс																	Бүгд	Уламжлалт анагаахын сувилалч	Ерөнхий мэргэжлийн	Нүүр амны нян сувилагч					
		Сувилалч-бүгд	Арсны	Гэмтэл, соргогын	Мэдрэлийн	Мэдээллийн жижүүр	Мэс заслын	Нүдний	Өрхийн	Сэтгэцийн	Сэргээн засахын	Цус, хавдарын	Харшлын	Халдварын	Дархлаажуулалтын	Хүүхдийн	Нарийн	Хөнгөвчлөх эмчлээний					Чих, хамар, хоолойн	Эх, хүүхдийн	Эрчимт эмчлээний	Яаралтай тусламжийн	Бүсэд
A	5	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
Архангай	1	12.8	0.1	0.1	0.2	0.8	1.5	0.1	0.0	0.2	1.0	0.3	0.0	0.5	1.5	1.5	1.3	0.2	0.1	0.0	0.8	1.5	1.0	17.8	1.6	0.5	32.8
Баян-Өлгий	2	16.3	0.1	0.1	0.9	0.8	1.6	0.1	0.2	0.4	1.8	0.1	0.0	0.4	2.1	1.9	1.2	0.9	0.1	0.2	0.6	1.3	1.5	21.0	1.2	0.9	39.4
Баянхонгор	3	19.8	0.1	0.2	0.5	1.1	1.9	0.2	0.1	0.7	1.1	0.7	0.0	0.7	3.2	1.2	1.1	0.3	0.2	0.0	1.1	1.2	4.0	16.0	1.9	0.7	38.4
Булган	4	8.9	0.2	0.7	0.2	0.7	1.2	0.2	0.0	0.7	0.2	0.0	0.0	0.8	0.2	0.8	0.7	0.2	0.2	0.0	0.7	0.7	0.8	25.5	1.5	0.3	36.2
Говь-Алтай	5	30.8	0.2	1.4	0.9	0.9	1.8	0.2	0.2	0.7	2.3	0.4	0.0	1.4	3.7	4.1	1.1	1.6	0.2	0.2	1.1	1.2	7.4	13.6	1.9	0.5	46.9
Говь-Сүмбэр	6	23.0	0.0	0.5	0.0	1.1	2.2	0.0	2.2	0.0	0.5	1.1	0.0	0.0	3.3	1.1	1.1	0.5	0.0	0.0	2.2	0.5	6.6	11.5	0.0	0.5	35.1
Дархан-Уул	7	27.3	0.1	1.0	1.0	2.0	1.3	0.2	2.2	1.5	2.5	0.1	0.0	1.2	0.6	2.9	1.1	0.7	0.3	0.9	1.0	1.2	5.3	14.0	3.0	2.4	46.6
Дорноговь	8	25.6	0.0	0.7	1.0	1.1	2.3	0.1	0.5	0.0	3.6	0.1	0.0	1.0	3.4	1.4	1.0	0.8	0.1	0.0	1.5	1.9	5.1	12.1	1.1	0.4	39.2
Дорнод	9	19.0	0.0	0.5	0.1	1.3	2.3	0.2	0.0	0.5	1.5	0.4	0.0	0.7	2.5	1.7	0.6	0.6	0.4	0.0	0.4	0.8	4.6	17.2	0.6	0.2	37.1
Дундговь	10	15.6	0.0	0.0	0.2	1.1	2.0	0.2	0.0	0.0	0.7	0.2	0.0	0.9	1.5	1.7	1.7	0.0	0.0	0.0	0.9	1.3	3.3	16.5	1.1	0.2	33.5
Завхан	11	26.6	0.1	0.7	0.4	1.4	2.4	0.1	0.6	0.6	1.7	1.0	0.6	0.8	4.4	2.7	1.8	0.7	0.3	0.0	1.4	2.3	2.5	12.3	1.8	0.7	41.4
Орхон	12	24.6	0.3	0.6	0.2	2.1	1.9	0.1	1.4	0.4	1.4	0.3	0.0	0.1	1.2	0.8	0.9	0.8	0.2	0.2	1.6	1.5	8.7	19.7	1.9	1.4	47.7
Өвөрхангай	13	19.1	0.1	0.5	0.1	1.0	1.7	0.2	1.1	0.3	0.3	0.1	0.0	0.5	2.2	1.9	0.6	0.4	0.2	0.0	0.8	1.2	5.6	16.9	1.7	0.8	38.5
Өмнөговь	14	19.5	0.1	0.9	0.5	0.9	1.6	0.1	0.1	0.3	1.0	0.0	0.0	0.6	2.5	1.5	2.1	0.4	0.3	0.3	0.8	0.8	4.8	10.0	0.5	2.1	32.1
Сүхбаатар	15	20.4	0.2	0.2	0.5	0.8	1.8	0.2	0.0	0.9	2.0	0.3	0.0	0.3	2.9	1.8	1.1	0.2	0.2	0.2	1.4	1.4	4.5	15.8	0.2	0.5	36.8
Сэлэнгэ	16	18.5	0.2	0.5	0.3	0.7	1.6	0.3	0.3	0.6	1.1	0.1	0.0	0.8	1.8	2.1	1.3	0.2	0.2	0.0	0.5	1.1	4.9	14.8	2.1	0.6	36.0
Төв	17	13.2	0.1	0.0	0.5	0.3	0.6	0.3	0.0	0.1	2.1	0.2	0.0	0.5	2.5	0.6	0.6	0.2	0.2	0.0	0.8	0.5	2.8	18.0	1.3	0.3	32.8
Увс	18	25.4	0.6	0.9	0.6	1.4	2.6	0.2	0.1	0.6	0.6	0.2	0.0	0.8	3.3	4.5	1.4	0.6	0.2	0.0	1.4	2.1	3.1	12.3	2.2	0.7	40.6
Ховд	19	23.7	0.6	0.8	0.7	1.5	1.7	0.2	0.1	0.9	1.1	0.0	0.0	0.9	2.1	2.1	2.1	0.2	0.2	0.0	1.8	1.9	5.0	19.1	2.0	0.7	45.5
Хөвсгөл	20	20.2	0.0	0.7	0.7	0.8	1.5	0.1	0.4	0.6	1.5	0.3	0.0	1.2	3.1	3.1	1.0	0.1	0.1	0.0	0.6	0.7	3.7	13.9	1.2	0.8	36.2
Хэнтий	21	15.2	0.1	0.3	0.3	1.4	1.4	0.1	0.1	0.3	1.4	0.1	0.0	0.5	2.9	1.0	1.1	0.0	0.1	0.0	0.0	1.0	3.0	18.3	1.1	0.3	34.9
АЙМГИЙН ДУНДАЖ	22	20.2	0.2	0.5	0.5	1.1	1.7	0.2	0.5	0.5	1.4	0.2	0.0	0.7	2.4	2.0	1.2	0.5	0.2	0.1	0.9	1.3	4.2	16.2	1.5	0.8	38.7
Улаанбаатар	23	32.1	0.4	0.4	0.6	2.0	4.1	0.5	2.1	0.7	1.9	0.7	0.1	0.8	1.4	1.9	0.9	0.3	0.5	0.5	2.2	1.6	8.3	15.4	0.7	1.4	49.5
Улсын дундаж	24	26.0	0.3	0.5	0.5	1.6	2.9	0.3	1.3	0.6	1.6	0.5	0.0	0.8	1.9	2.0	1.1	0.4	0.4	0.3	1.6	1.4	6.2	15.8	1.1	1.1	44.0

ДУНДАЖ ОР ХОНОГ, ТАСГААР, 2025 ОН

Аймаг, хотын нэр	№	Эмнэлийн тасгаар																			Бүгд		
		Дотор	Мас засал	Төрөх	Эмэгтгүүд	Хүүхэд	Халдагт	Арьс харшил	Сүрьеэ	Мэдрэл	Сэтгэл	Невролог	Үрэлт	Эрчимт эмчилгээ, сэхээг амьдруулах	Нүд	Чих, хамар хоолой	Эрүүл нүүр	Хавдар	Уламжлалт эмчилгээ	Хөнгөвчлөх эмчилгээ		Бусад	
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
Архангай	1	7.0	6.5	4.1	6.6	7.0	8.7	0.0	15.6	9.1	9.1	6.8	0.0	0.0	3.5	6.9	5.6	5.2	5.8	6.8	0.0	0.0	6.9
Баян-Өлгий	2	7.1	6.0	4.7	6.0	6.8	9.4	7.5	31.3	7.6	8.2	7.1	0.0	0.0	3.0	6.7	6.4	6.4	3.1	8.0	7.3	7.0	6.8
Баянхонгор	3	6.7	7.5	8.1	4.0	7.1	8.6	6.5	17.8	6.9	7.1	7.0	0.0	0.0	11.1	7.0	5.4	8.4	5.6	7.0	0.0	6.5	6.8
Булган	4	6.9	5.9	6.2	6.3	7.6	7.3	7.7	13.2	9.0	8.1	7.1	0.0	0.0	2.9	0.0	7.0	6.1	6.8	7.1	0.0	0.0	7.1
Говь-Алтай	5	7.1	5.6	4.2	5.4	7.0	7.3	7.6	16.2	8.0	9.2	6.6	0.0	0.0	3.3	3.7	5.6	4.7	0.0	7.1	6.6	7.1	6.8
Говь-Сүмбэр	6	7.1	6.9	5.3	6.7	7.1	7.3	7.2	16.3	7.1	7.1	6.8	0.0	0.0	7.3	0.0	6.6	0.0	0.0	0.0	7.5	7.4	7.1
Дархан-Уул	7	7.4	4.3	3.6	5.3	7.1	7.3	7.1	21.0	7.1	8.2	8.5	0.0	0.0	6.7	3.9	5.1	4.7	2.8	6.9	6.7	6.2	6.7
Дорноговь	8	7.6	4.6	4.5	6.4	7.6	8.7	0.0	28.3	7.4	7.8	6.4	0.0	0.0	4.5	0.0	5.5	0.0	0.0	7.2	6.5	0.0	7.0
Дорнод	9	7.1	4.7	4.5	4.3	7.4	7.1	6.9	38.7	7.8	8.6	6.9	0.0	0.0	11.1	0.0	0.0	0.0	5.0	7.0	0.0	3.1	6.8
Дундговь	10	7.5	4.7	5.1	4.5	7.8	7.7	7.8	21.5	8.4	8.4	6.2	0.0	0.0	0.8	4.8	4.8	0.0	0.0	7.9	7.7	0.0	7.0
Завхан	11	6.8	4.1	6.6	3.7	7.1	7.3	7.3	17.1	7.2	7.6	5.1	0.0	0.0	10.2	1.8	4.5	4.1	0.0	6.1	0.0	0.0	6.6
Орхон	12	6.6	4.1	4.9	5.9	7.4	6.6	0.0	51.9	6.4	7.6	6.8	0.0	0.0	14.2	0.0	6.1	0.0	0.0	6.7	6.1	6.2	6.4
Өвөрхангай	13	6.8	6.4	2.9	7.2	7.4	6.9	6.7	18.3	6.9	7.3	7.9	0.0	0.0	18.0	6.9	6.2	6.5	4.2	7.0	7.1	7.4	6.8
Өмнөговь	14	6.7	5.6	3.0	4.0	7.3	6.1	7.0	12.8	7.0	6.3	6.2	0.0	0.0	3.7	5.9	5.2	0.0	0.0	6.9	6.5	0.0	6.3
Сүхбаатар	15	7.4	6.5	3.7	6.1	7.7	7.6	8.4	18.1	8.7	8.9	7.1	0.0	7.0	6.4	8.7	7.0	7.3	0.0	8.5	0.0	7.5	7.5
Сэлэнгэ	16	7.0	7.1	4.3	5.7	7.4	7.7	7.2	48.8	7.2	7.0	0.0	0.0	0.0	13.1	0.0	6.8	0.0	0.0	7.0	6.4	11.2	7.1
Төв	17	7.2	6.9	7.1	7.3	6.9	7.6	7.7	31.4	7.1	7.2	7.2	0.0	0.0	13.4	4.6	6.8	0.0	6.9	7.0	10.0	0.0	7.4
Увс	18	6.9	5.5	4.4	6.0	7.4	8.4	7.0	15.0	7.0	7.9	6.5	0.0	0.0	5.2	3.3	3.4	6.3	5.9	7.1	0.0	0.0	6.7
Хөвд	19	7.4	5.3	3.4	6.4	7.4	7.2	7.6	13.7	8.5	15.0	7.7	0.0	0.0	3.8	4.8	5.7	6.0	0.0	8.3	5.2	7.6	7.3
Хөвсгөл	20	6.8	5.1	2.6	6.5	6.6	7.1	7.1	37.5	6.9	10.9	0.0	0.0	0.0	4.4	0.0	6.2	0.0	3.8	7.1	0.0	12.3	6.5
Хэнтий	21	6.9	6.6	5.6	8.7	7.2	8.3	7.8	19.4	8.3	8.1	7.6	0.0	0.0	2.9	0.0	6.5	0.0	4.8	7.3	7.2	7.7	7.2
Аймгийн дундаж	22	7.0	5.5	4.5	5.9	7.2	7.5	7.3	22.7	7.4	8.3	7.0	0.0	7.0	7.5	5.6	5.8	6.0	5.1	7.2	6.2	7.3	6.9
Улаанбаатар	23	5.8	5.2	5.0	6.1	6.1	7.4	6.9	16.7	8.0	16.6	7.2	8.0	5.2	14.7	2.9	4.9	4.8	2.8	6.0	5.6	7.8	6.4
Улсын дундаж	24	6.5	5.3	4.8	6.0	6.6	7.4	7.1	19.4	7.8	12.5	7.1	8.0	5.2	12.3	3.3	5.2	5.1	3.5	6.5	5.8	7.6	6.6

ЭМНЭЛГИЙН ОРНЫ АШИГЛАЛТ, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Бүгд				Аймаг, хотын нэгдсэн эмнэлэг				Сум, тосгоны эмнэлэг			
		Ор ашиглалт	Ор ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт	Ор ашиглалт	Ор ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт	Ор ашиглалт	Ор ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Архангай	187.3	51.3	6.9	27.3	190.9	52.3	7.0	27.2	182.0	49.9	6.6	27.5
2	Баян-Өлгий	189.3	51.9	6.8	27.7	210.7	57.7	7.0	30.3	136.4	37.4	6.4	21.2
3	Баянхонгор	201.2	55.1	6.8	29.5	207.8	56.9	6.9	30.0	188.1	51.5	6.6	28.4
4	Булган	232.3	63.7	7.1	32.7	275.6	75.5	7.5	36.7	189.1	51.8	6.6	28.7
5	Говь-Алтай	163.8	44.9	6.8	24.0	192.9	52.8	6.8	28.3	122.5	33.6	6.9	17.8
6	Говь-Сүмбэр	209.0	57.2	7.1	29.6	250.1	68.5	7.1	35.1	91.9	25.2	6.6	14.0
7	Дархан-Уул	190.1	52.1	6.7	28.5	189.0	51.8	6.6	28.5	204.0	55.9	7.1	28.9
8	Дорноговь	206.2	56.5	7.0	29.4	214.2	58.7	7.0	30.5	193.2	52.9	7.0	27.5
9	Дорнод	222.6	61.0	6.8	33.0	223.7	61.3	6.7	33.4	219.3	60.1	6.9	31.6
10	Дундговь	178.2	48.8	7.0	25.4	211.7	58.0	7.2	29.6	119.3	32.7	6.6	18.0
11	Завхан	203.4	55.7	6.6	30.9	223.8	61.3	6.7	33.5	179.4	49.1	6.4	27.8
12	Орхон	212.6	58.3	6.4	33.1	213.1	58.4	6.4	33.2	176.3	48.3	7.0	25.0
13	Өвөрхангай	197.5	54.1	6.8	29.2	200.4	54.9	6.9	29.0	193.0	52.9	6.5	29.5
14	Өмнөговь	146.3	40.1	6.3	23.3	148.6	40.7	6.2	24.1	141.5	38.8	6.5	21.6
15	Сүхбаатар	211.6	58.0	7.5	28.4	231.4	63.4	7.6	30.4	173.0	47.4	7.1	24.5
16	Сэлэнгэ	176.3	48.3	7.1	24.7	195.9	53.7	7.1	27.7	163.5	44.8	7.2	22.8
17	Төв	194.5	53.3	7.4	26.4	221.8	60.8	7.6	29.2	167.3	45.8	7.1	23.6
18	Увс	235.7	64.6	6.7	35.0	258.9	70.9	6.8	38.2	200.5	54.9	6.6	30.2
19	Ховд	227.4	62.3	7.3	31.2	243.1	66.6	7.4	32.8	195.8	53.6	7.0	28.2
20	Хөвсгөл	188.9	51.7	6.5	29.0	189.4	51.9	6.5	29.1	187.5	51.4	6.5	28.8
21	Хэнтий	220.8	60.5	7.2	30.5	223.6	61.3	7.5	29.9	216.6	59.3	6.9	31.3
22	Аймгийн дундаж	198.1	54.3	6.9	28.9	209.8	57.5	6.9	30.4	175.2	48.0	6.8	25.9
23	Улаанбаатар	210.8	57.8	6.4	33.0	210.7	57.7	6.4	32.9	238.3	65.3	6.8	35.2
24	Улсын дундаж	205.0	56.2	6.6	31.1	210.4	57.6	6.6	32.0	176.0	48.2	6.8	26.0

ЭМНЭЛГИЙН ОРНЫ ТОО, ТАСГААР, 10 000 ХУНД, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Эмнэлгийн тасгаар																			Бүгд		
		Дотор	Мас засал	Төрөх	Эмэгтэчүүд	Хүүхэд	Халдварт	Арьс харшил	Сүрьеэ	Мэдрэл	Сэтгэл	Гэмтэл	Невролог	Уролог	Эринт эмчлгээ, сэхээн амьдруулах	Нүд	Чих, хамар хоолой	Эрүү нүүр	Хавдар	Уламжлалт эмчлгээ		Хөнгөвчлөх эмчлгээ	Бусад
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
1	Архангай	25.7	3.0	6.3	2.5	9.8	4.1	0.0	1.1	2.6	2.1	1.1	0.0	0.0	0.4	0.1	0.2	0.3	1.7	3.4	0.0	0.0	64.4
2	Баян-Өлгий	31.9	5.3	6.9	3.7	10.0	2.7	1.0	1.0	6.2	1.4	1.0	0.0	0.0	1.0	1.0	1.1	1.1	0.5	7.1	0.9	7.2	91.1
3	Баянхонгор	21.9	3.9	9.2	3.4	11.8	4.0	1.2	1.6	4.1	2.0	1.7	0.0	0.0	0.6	1.6	0.2	0.2	1.1	5.3	0.0	5.0	78.8
4	Булган	15.9	2.3	5.9	2.2	8.9	4.5	1.0	1.0	2.5	1.3	1.3	0.0	0.0	0.5	0.2	0.5	0.2	1.2	1.3	0.0	0.2	51.0
5	Говь-Алтай	28.7	3.2	8.3	4.2	12.4	6.4	1.2	1.4	1.8	1.8	2.8	0.0	0.0	0.9	0.4	0.5	0.4	0.0	8.0	2.1	1.8	86.2
6	Говь-Сүмбэр	29.1	7.7	4.4	4.9	14.3	4.9	1.1	2.2	9.3	2.2	2.2	0.0	0.0	1.6	0.5	1.6	0.0	1.1	1.1	3.3	3.3	94.9
7	Дархан-Уул	20.0	3.7	4.1	3.7	9.1	2.1	1.5	1.6	6.0	3.1	3.4	0.0	0.0	1.0	0.5	1.7	0.4	0.3	14.2	1.9	2.6	81.0
8	Дорноговь	17.7	5.1	5.8	3.4	12.1	4.2	0.1	1.5	8.6	2.2	1.9	0.0	0.0	1.8	0.1	0.3	0.0	0.0	6.3	1.6	2.5	75.2
9	Дорнод	16.3	3.6	4.5	2.5	8.6	3.7	0.7	1.8	3.6	3.6	3.1	0.0	0.0	0.7	0.0	0.0	0.0	1.2	4.8	0.0	1.1	59.5
10	Дундговь	25.2	3.0	8.7	3.0	13.0	5.6	0.4	1.1	2.2	1.3	1.1	0.0	0.0	0.9	0.2	0.2	0.2	0.2	6.5	2.0	1.1	76.0
11	Завхан	23.0	4.8	7.5	2.5	10.3	5.8	2.0	0.7	4.7	1.4	1.1	0.0	0.0	0.7	0.3	0.7	0.3	0.8	8.5	1.4	2.0	78.6
12	Орхон	24.4	4.0	6.7	2.4	5.5	3.8	0.0	1.7	9.2	3.9	3.4	0.0	0.5	1.2	0.8	3.2	0.0	0.0	14.1	2.1	1.7	88.6
13	Өвөрхангай	22.4	4.4	5.0	4.7	14.4	3.2	0.5	0.5	2.5	1.4	2.2	0.0	0.0	1.0	0.3	0.5	0.5	0.9	15.0	1.0	2.4	83.1
14	Өмнөговь	23.7	4.3	6.3	6.7	10.6	4.2	1.3	1.0	3.8	3.8	2.5	0.0	0.0	0.6	0.3	0.4	0.1	0.9	11.5	1.0	4.4	87.2
15	Сүхбаатар	19.6	3.2	4.8	6.2	12.8	5.1	0.6	1.8	3.3	2.3	2.3	0.0	0.3	0.6	0.3	0.3	0.3	0.5	5.4	0.8	9.5	79.9
16	Сэлэнгэ	33.5	3.7	5.1	3.9	14.8	4.0	0.6	2.9	5.3	1.0	0.0	0.0	0.0	0.6	0.1	0.6	0.1	0.1	8.3	0.5	0.3	85.2
17	Төв	19.5	2.1	6.6	3.5	13.0	5.5	1.1	1.6	5.3	1.3	1.2	0.0	0.0	0.6	0.1	0.2	0.1	0.4	2.6	0.3	1.1	66.1
18	Увс	23.4	3.0	7.8	2.7	11.7	3.8	1.2	1.3	2.4	1.2	1.5	0.0	0.0	0.4	1.3	0.2	0.1	0.9	2.4	0.0	0.0	65.2
19	Ховд	20.8	4.9	6.8	4.5	12.3	5.1	2.0	1.4	7.3	1.9	1.9	0.0	0.0	1.0	0.2	0.8	0.2	1.1	8.2	0.3	5.1	85.7
20	Хөвсгөл	24.8	2.6	3.7	2.4	11.2	3.2	0.5	0.9	3.3	2.2	1.6	0.0	0.0	0.5	0.0	0.4	0.0	0.7	4.0	0.0	3.1	65.3
21	Хэнтий	16.7	6.5	7.7	2.9	11.9	5.4	0.8	1.5	3.3	1.9	2.3	0.0	0.0	0.8	0.0	0.8	0.0	0.4	10.3	1.8	1.4	76.2
22	Аймгийн дундаж	23.1	3.9	6.2	3.5	11.2	4.1	0.9	1.4	4.6	2.1	1.9	0.0	0.0	0.8	0.4	0.7	0.2	0.7	7.5	0.9	2.7	76.8
23	Улаанбаатар	21.3	9.4	5.1	4.4	12.7	2.3	1.3	1.6	8.2	3.9	5.3	0.8	0.5	2.3	0.5	1.0	0.3	0.9	7.8	2.0	3.7	95.3
24	Улсын дундаж	22.2	6.6	5.7	3.9	11.9	3.2	1.1	1.5	6.3	3.0	3.6	0.4	0.3	1.5	0.5	0.8	0.3	0.8	7.7	1.4	3.2	85.8

АЙМАГ ХОТЫН НЭГДСЭН ЭМНЭЛГҮҮДЭД ХИЙГДСЭН ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭ, ҮНДСЭН ОНОШИЙН ЗӨРҮҮНИЙ ХУВЬ, 2025 ОН

№	Аймаг, хотын нэр	Нийт нас баралт	Эмгэг судлалын задлан шинжилгэний тоо	Задлан шинжилгэний хувь	Үндсэн оношлын нийцоно зөрүү	Үндсэн оношлын зөрүүлсэн хувь
A	Б	1	2	3	4	5
1	Архангай	58	14	28.0%	3	21.0%
2	Баян-Өлгий	47	13	28.0%	5	38.0%
3	Баянхонгор	64	18	33.0%	4	22.0%
4	Булган	32	9	28.0%		11.0%
5	Говь-Алтай	29	12	41.0%	2	8.0%
6	Говь-Сүмбэр	38	1	15.0%	0	0.0%
7	Дархан-Уул	225	23	13.0%	4	17.0%
8	Дорноговь	79	29	28.0%	6	21.0%
9	Дорнод	116	18	18.0%	2	11.0%
10	Дундговь	37	9	27.0%	0	0
11	Завхан	31	7	23.0%	1	14.0%
12	Орхон	143	57	41.0%	3	5.0%
13	Өвөрхангай	90	31	36.0%	1	5.0%
14	Өмнөговь	72	21	31.0%	2	10.0%
15	Сүхбаатар	34	12	35.0%	3	25.0%
16	Сэлэнгэ	54	14	35.0%	3	21.0%
17	Төв	91	22	28.5%	5	22.5%
18	Увс	53	29	57.0%	5	24.0%
19	Ховд	43	21	48.8%	0	0.0%
20	Хөвсгөл	115	21	18.3%	2	10.0%
21	Хэнтий	50	17	34.0%	1	6.0%
22	Аймгийн дундаж	1440	480	33.3%	63	13.0%
23	Улаанбаатар	3589	964	26.8%	43	4.4%
24	Улсын дундаж	5029	1444	28.7%	106	7.3%

ХАГАЛГААНЫ ДАРААХ ХҮНДРЭЛ, НАС БАРАЛТЫН ХУВЬ, 2025 ОН


№	Аймаг, хотын нэр	Мэс засал хийлгэсэн хүний тоо	Хүндрэлийн хувь	Нас баралтын хувь
A	Б	1	2	3
1	Архангай	1278	0.0	0.0
2	Баян-Өлгий	3031	0.0	0.0
3	Баянхонгор	1593	0.0	0.1
4	Булган	882	0.1	0.0
5	Говь-Алтай	1167	0.0	0.4
6	Говь-Сүмбэр	417	0.2	0.2
7	Дархан-Уул	3433	0.0	0.0
8	Дорноговь	2179	0.0	0.0
9	Дорнод	2547	0.0	0.0
10	Дундговь	1084	0.6	0.2
11	Завхан	1481	0.0	0.0
12	Орхон	5254	0.2	0.0
13	Өвөрхангай	3216	0.2	0.0
14	Өмнөговь	1820	0.1	0.0
15	Сүхбаатар	1058	0.0	0.0
16	Сэлэнгэ	1471	0.1	0.0
17	Төв	1437	0.0	0.0
18	Увс	1971	0.0	0.0
19	Ховд	2267	0.0	0.0
20	Хөвсгөл	2173	0.0	0.0
21	Хэнтий	1901	0.1	0.2
22	Аймгийн дундаж	41660	0.1	0.0
23	Улаанбаатар	159513	0.2	0.3
24	Улсын дундаж	201173	0.2	0.2

АМБУЛАТОРИД БҮРТГЭГДСЭН ХҮН АМЫН ӨВЧЛӨЛ (10 000 ХҮНД), 2025 ОН


№	Аймаг, хотын нэр	Бүгд	Халдварт ба шимтгэлд зарим өвчин	Кавдар	Цус, цус төлжүүлэх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан эмтгэл	Дотоод шүүрэл, төмөрлөлийн ба бодисын солилцооны өвчнүүд	Сэтгэцийн ба зан төрхийн эмтгэл	Мэдрэлийн тогтолцооны өвчин	Нүд ба гүүний дайрын өвчнүүд	Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	Элрх-сүдэсний тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Арвс ба арван доорх эсгэлтийн өвчин	Яс-бүлчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмтгэл	Жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе	Перинаталь үед үүссэн зарим эмтгэл	Төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмтгэл	Өөр бүлэгт ангилгаагүй шинж тэмдэг, зөвийр, эмнэлэгийн ба лабораторийн хэвийн бус үзүүлэлтүүд	Гэмтэл, хордлого ба гаднын шалтгаант бусад тодорхой эмтгэл	Шалтгаан нь тодорхойгүй шинэ өвчин /U00-U49/	Уламжлалт анагаах ухаанаар оношлогдсон өвчөл /TM/
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	130	14	15	16	17	18	19	20	21	22
1	Архангай	10167.7	80.4	68.7	30.1	411.8	137.6	427.8	363.7	226.8	1434.1	2419.7	1731.2	435.1	375.7	989.6	62.1	14.1	25.2	0.3	714.8	0.0	219.2
2	Баян-Өлгий	10973.3	73.6	204.3	61.1	352.7	41.2	770.7	587.2	1292.7	1918.3	2443.8	488.4	488.4	718.7	937.0	35.8	6.2	50.3	17.8	177.3	0.0	268.4
3	Баянхонгор	9380.4	90.5	82.8	29.3	245.8	210.1	504.6	495.4	125.1	1359.9	2050.7	1401.7	366.8	457.5	1162.7	97.1	57.7	125.7	7.7	364.4	0.0	144.8
4	Булган	16390.3	50.2	130.5	48.3	375.7	183.8	444.0	260.5	121.9	4439.3	3239.5	4319.5	439.8	333.1	1338.8	15.4	17.9	7.2	0.3	308.0	0.0	316.5
5	Говь-Алтай	10984.5	85.3	164.9	37.2	372.3	232.5	489.2	532.2	273.7	1506.9	1810.0	2374.0	520.7	234.8	1344.3	49.9	9.4	44.9	4.8	841.8	0.0	55.9
6	Говь-Сүмбэр	3025.0	139.3	27.4	6.6	49.9	103.7	109.2	162.4	91.6	324.8	707.2	386.2	227.7	151.4	302.3	1.6	2.7	1.6	0.0	229.3	0.0	0.0
7	Дархан-Уул	6624.9	101.5	107.7	22.3	182.0	149.6	261.0	610.0	238.9	466.8	2191.4	901.2	410.2	162.1	550.9	3.0	26.9	13.3	1.3	213.3	0.0	11.6
8	Дорноговь	13385.5	143.2	73.9	18.6	329.0	54.1	806.5	630.0	364.9	1108.3	3517.1	2956.9	803.3	648.5	1124.6	54.1	47.8	37.4	3.3	460.9	0.0	203.0
9	Дорнод	12643.6	207.3	22.6	63.3	292.9	139.8	443.1	997.8	479.8	1051.8	3136.3	2896.4	796.1	657.2	1031.8	136.0	22.2	37.6	4.6	203.9	0.2	22.9
10	Дундговь	10356.9	113.2	43.0	19.1	397.1	126.4	676.3	34.5	310.2	1229.2	2154.2	1676.7	625.4	627.2	1333.7	79.3	17.6	19.6	4.1	701.3	0.0	168.8
11	Завхан	16163.1	87.2	111.0	35.5	613.1	208.2	1355.5	656.7	254.5	2294.5	2932.4	3639.0	605.2	506.8	1852.3	69.1	57.7	249.9	2.0	547.8	0.0	84.7
12	Орхон	5824.8	91.3	136.2	18.0	154.5	40.0	189.4	415.1	77.2	531.9	1389.7	1047.7	418.6	319.7	891.2	3.9	4.7	4.3	0.2	91.2	0.0	0.0
13	Өвөрхангай	4882.7	81.3	73.1	10.1	81.2	81.5	344.8	115.9	97.8	704.3	1234.5	627.5	319.4	160.2	398.1	24.7	10.9	21.5	3.4	425.1	0.0	67.2
14	Өмнөговь	13803.9	186.6	133.8	44.7	357.0	95.2	743.5	718.7	422.6	1151.4	4130.7	2145.5	797.1	640.9	1088.8	123.2	75.1	27.8	16.3	223.1	0.0	682.0
15	Сүхбаатар	6807.2	130.4	19.9	12.5	192.8	104.8	269.0	141.3	77.2	454.9	3385.8	872.4	300.8	224.7	361.1	0.0	5.7	12.4	3.9	237.8	0.0	0.0
16	Сэлэнгэ	8280.0	59.4	44.0	19.9	580.6	45.6	556.3	458.9	197.0	1120.8	1646.4	1212.0	442.3	270.6	711.9	55.8	17.1	4.4	0.3	510.6	0.0	325.9
17	Төв	12553.9	129.6	87.0	21.4	267.6	86.2	481.4	523.9	287.9	1988.8	3641.3	1663.5	551.6	437.3	1303.7	135.3	13.0	23.8	1.2	447.2	0.0	462.3
18	Увс	7111.6	59.5	56.3	18.5	284.5	116.1	522.0	120.8	253.9	1275.9	1620.7	1144.5	429.8	264.4	818.1	6.4	13.0	13.9	12.6	79.3	1.1	0.0
19	Ховд	13548.6	88.1	146.7	71.3	441.4	175.3	640.3	819.6	548.5	1714.0	2245.5	3363.0	685.9	772.8	1283.8	222.0	49.4	46.1	6.1	228.9	0.0	0.0
20	Хөвсгөл	8143.6	89.9	48.4	29.9	184.1	33.6	694.5	471.4	219.5	1275.8	1568.4	2096.5	363.7	347.4	577.1	9.5	5.9	35.1	7.9	85.0	0.0	0.0
21	Хэнтий	12047.0	92.4	109.2	36.7	274.1	144.6	786.1	504.5	506.2	1670.7	3187.5	1735.9	725.5	898.2	977.2	72.3	10.0	53.7	0.6	261.6	0.0	0.0
22	Аймгийн дундаж	10027.0	100.7	92.6	31.9	304.6	111.6	553.8	478.6	276.0	1317.9	2353.6	1909.2	508.2	439.1	946.9	59.9	22.8	40.3	5.1	328.9	0.1	145.0
23	Улаанбаатар	10868.2	212.0	302.3	67.8	485.0	117.5	554.6	527.3	299.1	1108.9	1332.7	1696.7	642.9	580.2	1158.6	146.0	85.4	125.9	25.2	1293.5	0.0	106.6
24	Улсын дундаж	10437.6	155.0	195.0	49.4	392.7	114.5	554.2	502.4	287.3	1215.9	1855.4	1805.5	573.9	508.0	1050.2	101.9	53.3	82.0	14.9	799.7	0.0	126.3

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


10 000 ХҮНД НОГДОХ ИХ ЭМЧИЙН ТОО




Нэг их эмчид ногдох хүний тоо



10 000 ХҮНД НОГДОХ СУВИЛАГЧИЙН ТОО




Их эмч, сувилагчийн харьцаа




ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд




Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд



Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд




Амьгүй төрөлт /1000 амьд, амьгүй төрөлтөд/




ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Перинаталь эндэгдлийн түвшин /амьд, амьгүй төрсөн 1000 хүүхдэд/




2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь



Хожуу нярайн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд/




Эрт нярайн эндэгдлийн түвшин /амьд төрсөн 1000 хүүхдэд/




ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН, 10 000 ХҮНД


Амьсгалын тогтолцооны өвчин




Хоол боловсруулах тогтолцооны өвчин



Шээс бэлгийн тогтолцооны өвчин




Зүрх-судасны тогтолцооны өвчин




ЗАРИМ ХАЛДВАРТ ӨВЧИН, 10 000 ХҮНД


Вируст гепатит




Салхин цэцэг



Сүрьеэ




Улаанбурхан




ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАР, 10 000 ХУНД


Заг хүйтэн



Тэмбүү




Трихомоноиаз




ХОРТ ХАВДРЫН НАС БАРАЛТ, 10 000 ХҮНД


Элэгний хорт хавдрын нас баралт




Ходоодны хорт хавдрын нас баралт



Улаан хоолойн хорт хавдрын нас баралт



Уушгины хорт хавдрын нас баралт



*Эх сурвалж: Хөвдөр судлалын үндэсний төвийн тайлан, 2025



